		1.3.5	Газрын харилцаа, кадастр	100	100	597.0	581.1	Барилга дэд бүтцийн чиглэлээр 18 зорилтын хүрээнд 24 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгаснаас 6 арга хэмжээ 100 хувь, 1 арга хэмжээ 90 хувь, 3 арга хэмжээ 70 хувь, 1 арга хэмжээ 50 хувь, 6 арга хэмжээ 30 хувь, 7 арга хэмжээ хэрэгжээгүй 0 хувь, дунджаар 66.4 хувь байна.
		1.3.6	Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ /Хууль зөрчсөн болон хохирогч хүүхэд хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үзүүлсэн үйлчилгээний үр дүн, шийдвэрлэлтийн хувь	100	75	406.6	389.3	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр 2 зорилтын хүрээнд 4 арга хэмжээ тусгаснаас 2 арга хэмжээ 100 хувь, 1 арга хэмжээ 70 хувь, 1 арга хэмжээ 30 хувь, дунджаар 75 хувьтай байна.
2	**БАЯН-ӨЛГИЙ**					**96,487.7**	**88,446.4**	
	2.1	**Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа**				**1,193.4**	**1,102.7**	

№	Төсвийн ерөнхийлөн захирагч. түүний хэрэгжүүлэх хөтөлбөр. хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар. танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт. бодлогын зорилтын хэрэгжилт. түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт. хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт. тасарсан бол шалтгаан/
		2.1.1	Аймгийн ИТХ-ын үйл ажиллагаа /	Нутгийн өөрөө удирдах ёсыг бэхжүүлж, түүний хэрэгжилтийг хангаж, тэргүүлэгчдийн хуралдааныг товлон зарлах, хэлэлцэх асуудлыг оруулж, хэлэлцүүлж гарсан шийдвэрийг байгууллагуудад танилцуулах, Засгийн газраас болон аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх үйл явцын талаар болон түүний биелэлтийн талаарх тайлан мэдээллийг ИТХ-ын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх	Аймгийн ИТХ нь 2020 онд 4 удаа, ИТХ-ын тэргүүлэгчид 9 удаа хуралдсан байна.	1,173.4	1,087.6	2020 оны хувьд УИХ болон орон нутгийн ээлжит сонгуулийг зохион байгуулж явуулсан, аймгийн ИТХ-ын төлөөлөгчид шинээр сонгогдсон, аймгийн удирдлагуудыг шинээр томилсон түүхэн жил болж өнгөрөв. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдээс бүрэн эрхийн хугацаанд баримталж ажиллах хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрх, чиг үүргийг хэрэгжүүлж аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх бодлогыг тодорхойлон, түүнийг хэрэгжүүлэхэд аймгийн иргэдийн санаачилга, ролцоонд тулгуурлан, үйл ажиллагаандаа ардчилсан шударга ёсыг баримтлан, аймгийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын хэмжээнд урьд онд дэвшүүлсэн зорилтын биелэлт, үйл ажиллагааны Үндсэн чиглэл зэргийг харгалзан 2020 онд аймаг, сумдын ИТХ-аас дэвшүүлэн тавьсан Үндсэн чиглэлийг бүрэн хэрэгжүүлж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, чиглэлийг бариталж ажиллах зорилтыг дэвшүүлэн зорилтын хүрээнд Аймгийн ИТХ-ын үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлж, Тэргүүлэгчид, Хурлын хороод, төлөөлөгчдийн үйл ажиллагаг нэгтгэн зангидаж, Төлөөлөгчдийн сонгогдсон тойрогтоо болон иргэдийн дунд ажиллах ажиллагаг сайжруулж, хурлаас гарсан бодлого, шийдвэрийг сурталчлах, Сумдын ИТХ-ын дотоод ажлыг сайжруулан зөвлөмж арга зүйгээр хангах, ИТХ-ын Хороодын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хурлын байгууллага иргэд сонгогчдын эргэх холбоог бэхжүүлэх, Багийн ИНХ-ыг үр дүнтэй хуралдуулж аймаг, сумын болон тухайн багийн нийгэм эдийн засаг, хөгжлийн гол тулгамдсан асуудлуудыг хэлэлцэн, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, багийн ИНХ-ын хэлэлцүүлэг зохион байгуулахад анхаарч ажиллалаа. Дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлэхийн тулд ажлаа жил, улирал, сараар төлөвлөн аймгийн ИТХ-ын хуралдаан, Хороодын хурал, Тэргүүлэгчдийн хуралдаан, хяналт шалгалтын ажил болон бусад ажил гэсэн чиглэлтэйгээр нийт 4 бүлэг, 138 ажил төлөвлөн хэрэгжүүлж ажиллалаа.
		2.1.2	ГХУСАЗЗ-ийн үйл ажиллагаа /гэмт хэргийн бууралт/	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуулийн дагуу сурталчлан таниулах ажлыг тогтмолжуулж, гэмт хэргийн тоог бууруулна.	"Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр"-ийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор батлуулан, хэрэгжүүлсэн	20.0	15.1	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэн, хуулийн этгээдийн оролцоог нэмэгдүүлэх, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, дэмжих, урамшуулах зорилгоор аймгийн төв Өлгий суманд үйл ажиллагаа явуулдаг 76 төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийг цагдаагийн газрын алба хаагчдад хариуцуулж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулсан байна. Эдгээр алба хаагчид гэмт хэрэг, зөрчлийн гаралтад гол нөлөөлж байгаа архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгаар хариуцсан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулсан. Зохион байгуулсан ажлын дэлгэрэнгүй материалыг ирүүлсэн 20 байгууллага, аж ахуйн нэгж, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль тогтоомж, архины хор хөнөөлийг ажилчин, алба хаагчдад сурталчлан таниулах, танин мэдэхүйн чиглэлээр "АХА" тэмцээн зохион байгуулах, архидан согтуурах явдлыг бууруулах чиглэлээр байгуллага дотооддоо хэлэлцүүлэг зохион байгуулах, байгуллагынхаа нийтийн ээмшлийн танхимд сурталчилгааны материал, шторк бэлттэж иргэдэд хүргэх ажлыг хэрэгжүүлэн ажилласан. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэргийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор Дэлхийн Зөн Монгол олон улсын байгууллагын орон нутаг дахь салбараас төсөв хөрөнгийг шийдвэрлүүлэн Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг "Монгол өрх" сэтгэл зүйн хүрээлэн сургалт зохион байгуулсан.
	2.2	**Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ**				**18,237.2**	**17,570.5**	
		2.2.1	Иргэдэд үзүүлэх засаг захиргааны болон төрийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Засгийн газрын болон аймгийн Засаг дарга, ИТХ-аас гаргасан бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, сум, хэлтэс агентлагийн үйл ажиллагааг уялдуулах, аймаг, сумдын ЗДТГ-ын ажилтнуудад нутгийн удирдлагын чиглэлээр мэргэжлийн зөвлөгөө өгч сургалт семинарыг зохион байгуулж, мэдээллээр хангах, хууль, тогтоомж засгийн газрын тогтоол, засгийн газрын мөрийн хөтөлбөр, засаг даргын мөрийн хөтөлбөрийн биелэлт, үр дүнгийн мэдээллийг холбогдох газарт хүргүүлэх	Төлөвлөсөн ажил бүрэн хэрэгжсэн байх, ажлын үр дүн сайжрах. Биелэлт гаргах тогтоол шийдвэрийн тоо, хэрэгжилтийн байдалд ахиц гарсан	5,862.5	5,574.5	Засгийн газрын болон аймаг орон нутгийн удирдах байгууллагаас гарсан, гарч байгаа бодлого шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Аймаг сумдын болон агентлаг байгууллагуудын удирдах ажилтны цугларалтыг зохион байгуулахын зэрэгцээ Удирдлагын академийн богино хугацааны сургалтад 26 албан хаагч бусад сургалт зөвлөгөөн, бүсчилсэн сургалтуудад 265 албан хаагч хамрагдаж цаг үеийн олон ажлуудыг шийдвэрлэн ажиллаж байна. 2020 онд холбогдох хууль журам, сайдтай байгуулсан гэрээ, улсын ЭЗНХҮЧ, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл зэрэг хяналтад авч хэрэгжүүлэх эрх зүйн баримт бичиг, тогтоол шийдвэрийн заалтуудын биелэлт, үнэлгээ дүгнэлтийг гарган 94.3 хувьтай биелүүллээ.
		2.2.2	Орон нутгийн засаг захиргааны бодлогын хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа	Засаг даргын Үйл ажиллагааны хөтөлбөр, болон үндсэн чиглэлийн биелэлтийг 90-ээс дээш хувьд хүргэн ажиллах	Засаг даргын Үйл ажиллагааны хөтөлбөрийг 93 хувьд хүрсэн.	2,110.9	2,026.7	Аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу үнэлгээ хийж, ЗГХЭГ-т 2 дугаар сард тайлагнасан. Аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан 269 арга хэмжээнээс 214 арга хэмжээ 100%-тай, 36 арга хэмжээ 70.0%-тай, 11 арга хэмжээ 40.0%-тай хэрэгжсэн ба үнэлэх боломжгүй 6 арга хэмжээ байна. Мөн 3 арга хэмжээ санхүүгийн асуудлаас болоод хэрэгжээгүй байна.Үндсэн чиглэлийн биелэлт 93.0 хувьтай үр дүнтэй биелсэн гэж дүгнэгдсэн.
		2.2.3	Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ	Нэн ховор, ховор амьтан, ургамлын нөөц бухий зарим газар нутгийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад хамруулах үндэслэл, судалгаг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах	ТХГН-ийн хэмжээ 30 хувьд хүрсэн байна.	579.9	559.6	2019 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн сумын ИТХ-ын шийдвэрээр Улаанхус сумын Хатуугийн эх, Хүрэн уул, Цэнгэл хайрхан нэрэтэй газруудыг орон нутгийн тусгай хамгаалалтад авсан. Ингэснээр тус аймгийн хувьд тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ 30.2 хувьд хүрээд байна.
					Булаг шанд рашааны эхийг тохижуулах	6 булаг шандын эхийг хамгаалсан байна.		5 дугаар сард нийт 10 удаа үүлэнд зориудаар нөлөөлж, хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулав. Эхний харвалтаа 05 дугаар сарын 01 ний өдөр Улаанхус сумын Хөхөтөл багт, Буянт сумын Өмнө голд, мөн Толбо нуурын, нуурын хөвөөнд явуулснаар нутгийн баруун болон баруун өмнөд хэсгээр 00-3,0мм-ийн тунадас оров. Дараагийн үйл ажиллагаг 05 дугаар сарын 06 ны өдөр Улаанхус сумын Хулжаа баг, Цэнгэл сумын Шар нуур багт, Сагсай сумын Даян нуурын хөвөөнд явуулснаар нутгийн өмнөд болон баруун хэсгээр 0,1-5,0 мм-ийн хэмжээтэй тунадас унав. Дараагийн харвалтыг 18ны өдөр Дэлүүн сумын уулын бэл, Толбо сумын нуурын хөвөөнд үйлдсэнээр нутгийн баруун өмнөд хэсгээр 0,4-11мм-ийн тунадас оров. Энэ сарын сүүлчийн үйл ажиллагаг 21, 22-нд Сагсай сумын Зост, Баяннуур сумын Уушгийн улаанд явуулснаар нийт нутгаар 0,1-27,0мм-ийн хэмжээтэй хур тунадас орж 5 дугаар сард үүлэнд зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагаа маань ийнхүү амжилттай хийгдсэн.
		2.2.4	Орон нутгийн мал эмнэлгийн үйлчилгээ	Мал эмнэлэг үржлийн нэгжийн материаллаг баазыг бэхжүүлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэх	Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд орон нутгийн тесвөөс 223.8 сай төгрөг, мөн мал эмнэлгийн үйлчилгээний зардалд ОНХСангаас 337.0 сая төгрөгийг хуваарилан олгож санхүүжүүлсэн	560.8	560.8	Бүх 13 сумын МЭ-ийн тасгийг зөөврийн мал угаах вана, унааны мотоцикл, малын эмчгний шиф унших төхөөрөмжөөр хангасан. Мөн МЭҮНэгжүүдийг ариутгал хийх моторт автомакс, автомат тариур, бүсад багаж хэрэгцээтэй болгов. Түүнчлэн 7 Үржлийн үйлчилгээний нэгжийг ээмэгжүүлэгч бахь, палкметр, пүүгээр ханган ажиллаж байна.
		2.2.5	Замын сан	Аймгийн төвийн авто зам, зогсоолуудын шинэчлэл	Аймгийн төвийн авто зам сайжирч, шинээр авто зогсоолуудтай болсон байна.	315.0	297.1	Хот доторх 10.4 км авто замыг шинээр буюу шинэчлэн барьж дуусгасан, шинээр буюу шинэчлэн барьсан зам дагуух бүх бүх зогсоолыг шинэчилж байна. Тухайн ажлыг Жол ХХК нь гүйцэтгэж байна. Мөн Орон нутгийн чанартай нийт19 чиглэлийн зам, 6 гүүр тавих болон засварын ажил хийгдсэн
		2.2.6	Жолоочийн даатгалын сангийн үйл ажиллагаа					
		2.2.7	Нийтлэг үйлчилгээний алба					
		2.2.8	**Хот тохижуулах газар**			**187.1**	**212.4**	
		2.2.8.1	Хот тохижилт, үйлчилгээний үйл ажиллагаа	Өлгий хотын иргэдийн ая тухтай ажиллаж амьдрах орчин нөхцөлийг сайжруулах ажлыг батлагдсан төсвийн хүрээнд зохион байгуулна.	Батлагдсан төсвийн хүрээнд айл өрх ААНБайгууллагын хог хаягдлыг зайлуулах, нийтийн ээмшлийн зам талбайг цэвэрлэх, ногоон байгуламжийг усалгаа, арчилгаа, гэрэлтүүлгийн засварын ажлыг аймгийн Хот тохижилтын алба хийж гүйцэтгэв.	187.1	212.4	Аймгийн цэвэрлэх байгууламжийн барилгыг шинээр бариулахаар зураг төсөв хийлгэж барилга барих хөрөнгийг холбогдох байгууллагуудад удаа дараа тавьж хөөцөлдсөний ачаар Засгийн газрын тогтоол гаргуулж, Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газрын нөхцөлт зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд улсын хэмжээнд 50.0 сая еврогийн зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр болж, түүнээс манай аймагт 3.45 сая евро шийдвэрлүүлэв. Үүний дагуу 2 удаа тендер зарлагдаж, нэг компани материал ирүүлсэн. Польш улстай байгуулсан хэлэлцээрийг УИХ-аар дахин батлуулаад Польш улс руу хүргүүлсэн.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч. түүний хэрэгжүүлэх хөтөлбөр. хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар. танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт. бодлогын зорилтын хэрэгжилт. түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт. хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт. тасарсан бол шалтгаан/
		2.2.8.2	Гудамжны гэрэлтүүлэг, цэвэрлэгээ	Сумдын гудамжны гэрэлтүүлгийг сэргээгдэх эрчим хүчээр хангах	Аймгийн гэр хороллын болон хөдөө сумын төвийн гудамж гэрэлтүүлэгтэй болсон			Сумдын гудамжны гэрэлтүүлгийг дэс дараатай шийдвэрлэж байна. Тухайн жилд Барилга, хот байгуулалтын сайдын багцын хөрөнгөөс санхүүжилттэй Аймгийн төвийн гудамж, талбайн гэрэлтүүлгийн ажлыг 1223.8 сая төгрөгөөр Алтай байдаг конструкшн ХХК нь нийт барилгын ажлын 90 хувийг хийж гүйцэтгээд байна. Мөн аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр Сагсай сумын төвийн гэрэлтүүлгийн ажлыг 30.0 сая төгрөг, Бугат сумын гэрэлтүүлгийн ажлыг 60.0 сая төгрөг, Өлгий сумын 13 дугаар багийн гэрэлтүүлгийн ажлыг 28.0 сая төгрөгөөр тус тус гүйцэтгэж байна.
		2.2.8.3	Ногоон байгууламжийн үйл ажиллагаа					
		2.2.8.4	Хот хөдөөгийн тэжээрлэлт, усалгаа, дарах					
		2.2.9	Аймгийн орон нутгийн өмчийн газар	Орон нутгийн өмчит байгууллагуудад үйлчилгээ үзүүлнэ. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээг чанартай зохион байгуулна.	Худалдан авалтыг зохих хууль, журмын дагуу зохион байгуулан хэрэгжүүлсэн	183.0	171.6	2020 онд нийт 123 төсөл арга хэмжээ төлөвлөгдөж 100 хувь цахим хэлбэрээр зарлагдсан. Үнээс харьцуулалтын аргаар 50 хувь, шууд худалдан авалт 33 хувь, нээлттэй тендер шалгаруулалт 17 хувь байна. Худалдан авах ажиллагааны тайланг улирал, жилийн мэдээг Сангийн сайдын 2018 оны 281 тушаалаар батлагдсан тайлагнах журмын дагуу Сангийн яам болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлэн, тайлагнаж ажиллав. Аймгийн Засаг даргад тухай бүр тайлагнаж байсан ба дээд шатны байгууллага, бусад холбогдох байгууллагууд худалдан авах ажиллагааны мэдээ тайланг хүргүүлж ажилласан. Компаниудад тоон гарын үсгийг олгож, шаардлагатай мэдээ мэдээллээрханган, арга зүйн зөвлөмж үзүүлэн ажиллаж байна. Үлсын төсвөөс 24 төсөл, арга хэмжээ эрх шилжиж ирсэн болно.
		2.2.10	ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардал	Байгууллагуудын хэвийн үйл ажиллагаг хангах	Хэвийн үйл ажиллагаагаар хангагдсан	4,485.8	4,272.2	Орон нутгийн төсвөөс байгууллагуудын хэвийн үйл ажиллагаг хангах зорилгоор ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардлыг санхүүжүүлэн ажилласан болно
		2.2.11	Аймгийн Улсын асрамжийн газар	Асрамжийн үйлчилгээний чанарын шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлж, хүртээмжийг дээшлүүлнэ	Асруулагч нарыг нийгэмшүүлэх	136.8	136.8	Харьяа асрамжийн газар болон хамтран ажилладаг асрамжийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж, асруулагчдын сэтгэл ханамжийн судалгаа авч, холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлсэн байна. Асрамжид хамрагдах хүсэлт гаргасан иргэдийн материалыг үнэн зөв бүрдүүлж асруулагчаар авч ажиллаж байна. Асруулагчдын санал хүсэлтийг цаг хугацаанд шийдвэрлэж ажиллав.
		2.2.12	Сум дундын ойн анги	Ойжуулалт ойн зурвас байгуулах ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, аж ахуй нэгж байгууллагыг тарьц суулгацаар хангах ажлыг хийж гүйцэтгэх.	Ойжуулалт ойн зурвас байгуулах ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, аж ахуй нэгж байгууллагыг тарьц суулгацаар хангах ажлыг хийж гүйцэтгэсэн.	63.2	59.9	Дэлүүн сумын нутаг дэвсгэрт орон нутгийн төсвийн 4.0 сая төгрөгийн хөрөнгөөр 2 га талбайд ойжуулалтын ажил хийгдлээ. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баяннуур суманд 10 га-д 20.0 сая, Дэлүүн суманд 5 га-д 10.0 сая төгрөгөөр ойн зурвас байгуулах ажил хийгдэж байна. Мөн Цамбагарав уулын БЦГазрын хязгаарлалтын бус болох Цэцэгтийн хавцалд 2017,2018 онуудад хийгдсэн ойжуулалтын талбайн 9 га ойг хамгаалах, нөхөн сэргээх, усалгаа хийх зорилгоор орон нутгийн төсвөөс 3,5 сая төгрөг зарцуулан усалгааны толгойн барилгыг бүрэн хийж дуусгав.
		2.2.13	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт /сая.төг/					
		2.2.14	Аймгийн халамжийн сан	Олон нийтийн оролцоотой үйл ажиллагааг дэмжиж, аймгийн зорилтот бүлгийн айл өрх, иргэдийн амьжиргааг дээшлүүлнэ.	3720 ахмад настныг хамруулсан.	153.0	153.0	2020 онд орон нутгийн төсвөөс Амьжиргаг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмжид 128.6 сая төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 24.4 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Амьжиргаг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмжид , олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг тус тус үзүүллээ.
		2.2.15	Биеийн Тамир спортын газар	Улс, олон улс, тив дэлхийн тэмцээнд баг тамирчдыг зохион байгуулалттай оролцуулах тамирчдын амжилтыг өсгөх, медалийн тоог нэмэгдүүлэх	Нийтийн биеийн тамирын талаарх иргэдийн мэдлэг, хандлага нэмэгдсэн байна.	490.9	496.8	Аймгийн Засаг даргын дэргэдэх Өсвөр үеийн шигшээ багийн тамирчдыг тогтмол бэлтгэл сургалтад хамруулан, Олон улс, улс, бүсийн чанартай уралдаан тэмцээнд оролцох шигшээ баг бүрдсэн. Шигшээ багийн тамирчид 2019 оны байдлаар олон улс, улс бүсийн тэмцээнээс нийт 58 медаль хүртсэн.
		2.2.16	Аймгийн ХДТеатр , сумдын Соёлын төв	Орон нутгийн үндэстэн ястны ёс заншлыг судлах, сурталчлах" Соёл урлагийг хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр"-ийг баталж хэрэгжүүлэх	Хөтөлбөрийг баталж хэрэгжүүлсэн	2,217.4	2,172.9	Орон нутгийн үндэстэн ястны ёс заншлыг судлах, сурталчлах" Соёл урлагийг хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр"-ийг батлуулан ажиллаж байна. Орон нутгийн үндэстэн ястны ёс заншлыг судлах 6 чиглэл тогтоогдож түүнд уган бичгийн хөтлөлт, хурим наадмын үйл ажиллагаа, ань авлагаа хийх үйл ажиллагаа мөн эрт дээр үеийн соёлын өвийг судлан тогтоох шинжлэх ухааны Экспедиция үйл ажиллагаа гэх мэт төрлөөр явагдсан байна. Мөн Алтай таван богд ууланд "Төрийн тахилга" хийгдэж баруун бүсээс 250 гаруй шашин соёлын зүтгэлтнүүд оролцсон байна. Түүнчлэн БНКаз улсын ШУ-ны академиас Баян-Өлгий аймгийн адууны гарал угсаат 20 гаруй жил судалсан судалгааны ном хэвлэгдэж аймгийн номын сангийн 70-жилийн ойн баяраар тус бүтээлийг бэлэглэсэн юм.
		2.2.17	Аймгийн Музей	Соёлын хадгалалт, хамгаалалтыг сайжруулах		229.8	228.9	Тус аймгийн Музейн гадна дотно тохижилтыг орчин үеийн шаардлагад нийцүүлэн тохижуулах талаар Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 150.0 сая гаруй төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. Нийт сумын хэмжээнд 500 гаруй аймгийн хэмжээнд 140 гаруй СББӨ тэгц бүртгэгдэж 1000 гаруй домборчин хүүхэд, 50 биелээч, 9 морин хуурын тоглолт шинээр явагдаж, сумын Соёлын төвүүд өөрсдийн сан хөмрөгөө 3-5 төрлөөр баяжуулан нийт 75 гаруй соёлын өв шинээр хамгаалалтад авагдсан байна.
		2.2.18	Аймгийн номын Сан	Номын фондыг баяжуулж, уншигчдын тоог нэмэгдүүлэх	2019 оны эхний хагас жилийн байдлаар 112ш номыг 1354850 төгрөгөөр худалдан авч, 1463860 төгрөгийн 309ш номыг хандив болон бэлгээр авч фондоо баяжуулав. 7821 уншигчдад шинээр карт нээж, 19569 ирэгсдэд 38693 ном олгон ашиглуулав. Уншигчдын тоо жилээс жилд нэмэгдэж байна.	260.0	253.6	Их зохиолч Абай Хунанбаевийн яруу найргаас "Уран уншлага -2019" уралдааны 6 дахь жилдээ зохион байгуулав. Уралдаанд аймгийн төвийн болон сумдын БДС –ийн нийт 34 сурагч 2 насны ангиллаар идэвхтэй оролцож, эхний байр эзэлсэн 8 сурагчийг 400.0 мянган төгрөгийн хичээлийн хэрэглэгдэхүүнээр шагнан урамшуулав. "Хүүхдийн уншлагыг дэмжин дэлгэрүүлье" сарын аяллыг алслагдсан хөдөө сумын сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд номын ач тусыг мэдрүүлэх, танин мэдэхүйн чиглэлээр мэдээлэл хүргэх, багийн төвийн хүүхдүүдэд зөөврийн номын сан ажиллуулж уншлагыг дэмжих, хүүхдүүдийн оролцоог нэмэгдүүлэх, хүүхдүүдэд хурч ажиллах, хүүхдүүдийн сайн сайхны төлөө номын сангийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор 2019 оны 2-р сарын 11 нээс 11 хоног нийт 8 сум 3 багаар тойрон аялав. Энэхүү арга хэмжээнд ДЗОУБ-ын хөрөнгө оруулалт хийв. Уг арга хэмжээнд нийт 2600 гаруй хүүхэд хамрагдав. Мөн "Хүүхэд бүр уншигч" аян зохион байгуулав. Үүнд нийт 800 гаруй сурагч хамрагдаж, 4 насны ангиллаар оролцсон сурагчид болон удирдагчийг 500 000 төгрөгийн номоор шагнан урамшуулав.
		2.2.19	Аймгийн Олон нийтийн Радио телевиз	Орон нутгийн чанартай мэдээ, мэдээллийг цаг хугацаандаа хүргэж ажиллах, мэдээллийн бодит байдлыг хангах	Орон нутгийн чанартай мэдээ, мэдээллийг цаг хугацаандаа хүргэж ажилласан	281.7	280.3	ОНОНРТ нь удирдах 1 , Гүйцэтгэх ажилтан 16, үйлчлэх ажилтан 1 нийт 18 орон тоо батлагдсан Засаг даргын 2020 оны 07 сарын 07-ны өдрийн А/529 тоот захирамжаар бүтэц орон тоо шинэчилж баталснаар 2 ажилтан нэмэгдсэн. Шилэн дансны тухай хуулийн дагуу 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн өөрийн байгууллагын вөб болон www.shilendans.gov.mn сайтад 2020 оны батлагдсан төсөв, түүний сар улирлын хуваарь, 7 хоног тутам холбогдох мэдээллийг шинэчлэн байршуулж байна..
		2.2.20	Санхүүгийн хяналт, аудитын алба /зөрчлийн бууралт/	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлж, төсвийн ил тод байдлыг хангана.	Зөрчлийн хувь буурч, санхүүгийн ил тод байдал хангагдсан	119.4	113.4	2020 онд шилэн дансны хэрэгжилт 88 хувьтай дүгнэгдэж өмнөх оноос өссөн үзүүлэлттэй гарсан байна. Шилэн дансны мэдээлэл дутуу байршуулсан, хугацаа хоцроодог, тайлангаа илгээдэггүй зөрчлийг удаа дараа гаргаж зарим сумууд болон байгууллагуудад хариуцлага тооцуулах зөвлөмжийг хүргүүлэн ажилласан байна.
	2.3	**Улсын төсвөөс авах тусгай зориулалтын шилжүүлгээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ**				**77,057.1**	**69,773.2**	
		2.3.1	Сургуулийн өмнөх боловсрол /цэцэрлэгт хамрагдалтын хувь/	70	70.2%	16,498.9	14,440.9	2020 онд шинээр 4 цэцэрлэг шинээр нэгдэж, СӨБ-д 325 хүүхэд хамрагдаж боловсрол эзэмших боломж бүрдсэн Нийт 2682 хүүхэд бэлтгэл бүлэг төгсөж, ЕБСургуульд хамрагдсан.Монголын эмэгтэйчүүдийн сангийн дэмжлэгтэйгээр 356 удирдах ажилтан, багш, эцэг эх нарт "Бага насны хүүхдийг хүчирхийллээс ангид байлгах нь" сэдэвт сургалтыг зохион байгуулсан. 2020 онд СӨБ-ын хүүхдүүдэд зориулж, 132 төле хичээлийг казак хэлэнд олны орчуулж хүртээл болгосон. Бага насны хүүхдийг хүчирхийллээс ангид байлгах зорилгоор 2500 ширхэг ном, 2500 ширхэг хүүхэлдэйн киног казах хэл дээр орчуулан СӨБ-ын багшийн болон бүлгийн тоогоор хүртээл болгосон.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч. түүний хэрэгжүүлэх хөтөлбөр. хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар. танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт. бодлогын зорилтын хэрэгжилт. түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт. хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт. тасарсан бол шалтгаан/
		2.3.2	Ерөнхий боловсрол /сургуульд хамрагдалтын хувь/	91.5	91.8%	44,934.9	42,102.1	БМДИ-тэй хамтран англи хэлний 29 багшид "Сургалтын хөтөлбөрийг дэмжих арга зүй" сэдэвт онлайн сургалтыг зохион байгуулж, сургалтын явцад тулгамдаж буй асуудлын талаар харилцан ярилцсан болно. Сургалтын явцад багш нар хөтөлбөрт тулгамдаж асуудлыг шийдвэрлэж буй арга замуудын талаар ярилцан харилцан туршлага солилцсон. Монгол дахь АНУ-ын Элчин Сайдын яамнаас зохион байгуулж буй "Massive Open Online Course" арга зүйн сургалтад англи хэлний 32 багш, казах хэлний 1 багшийг хамруулан орон нутагт мэргэжлүүлэх ажлыг байгуулсан. Норвегийн Тусламжийн Байгууллагатай хамтран Өлгий сумын ЕБСургуулийн удирдлага, нийгмийн ажилтнууд, СӨБ-ын багш, арга зүйч нарыг чадваржуулах сургалтад нийт 141 хүн хамрагдсан. Багш, эцэг эх, ажилчдыг чадваржуулах 2 удаагийн сургалтыг Норвегийн тусламжийн байгуллагатай хамтран зохион байгуулсан. БШУЯ, Боловсролын хөрөнгө оруулалтын хамтран аймгийн ЕБСургуулийн казах, тува хүүхдүүдэд зориулсан 1000 гаруй теле хичээлийг бэлтгэж, орон нутгийн телевиз, үндэсний МНВ сувгуудаар цацаж, олны хүртээл болгосон. Дэлхийн банкны санхүүжилтээр БШУЯамнаас хэрэгжүүлж буй Боловсролын чанарын шинэчлэл төслөөс аймгийн ЕБСургуулийн бага ангийн сурагчдад зориулсан 13 641 ширхэг 146,6 сая төгрөгийн өртөгтэй казах хэл дээрх хүүхдийн танин мэдэхүй, уран зохиолын номыг нийлүүлж, сургуулийн номын сангуудад хүргүүлсэн.
		2.3.3						
		2.3.4	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ	"Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" дэд хөтөлбөрийг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх	ЭХ, хүүхдийн эндэгдэл гараагүй	5,610.9	5,610.9	Аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх "Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах дэд хөтөлбөрийг ИТХ-ын хуралдааны тогтоолоор батлуулан хэрэгжүүлж байна. Энэ хөтөлбөр хэрэгжсэнээр халдварт өвчнөөс сэргийлэх тухай сурталт сурталчилгаат орон нутгийн хэвлэл мэдээлэл, радио, телевизээр 14 удаа хийж,"Хоолны хордлого болон суулгалт өвчнөөс урьдчилан сэргийлэх", А гепатит өвчнөөс сэргийлэх, Тэмбүү өвчнөөс сэргийлэх, Сүрьеэ өвчнөөс сэргийлэх, Томуу, томуу төст өвчний дэгдлтээс сэргийлэх, үйл ажиллагаат эрчимжүүлэх зэрэг сурталтуд хийгдсэн. Албан байгууллага, иргэд, сургуулиудад давхардсан тоогоор 25 удаа сурталт сурталчилгаа хийгдсэн. Ковид-19 цар тахалтай тэмцэх ажлын хэсэг байгуулагдан , сум бүрд тусгааралх байр бэлтгэн тогтмол ажиллуулж байна. Аймгийн онцгой комиссын шийдвэрээр аймагт орж гарах хөдөлгөөнд хяналт хийж байнгын пост ажиллуулсан.
		2.3.5	Газрын харилцаа, кадастр	0	0%	522.2	479.2	ГХБХБГ-н 2020 оны үйл ажиллагааны гол зорилт нь аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд геодези зураг зүй суурь судалгаа, газрын мониторинг, газар зохион байгуулалт, газрын кадастр, хот байгуулалт барилгын салбарын талаарх бодлого хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж иргэдийн амьдрах болон баялаг бүтээх эрхийг хэрэгжүүлэн баталгаажуулах нөхцөлийг бүрдүүлэхэд орших ба 2020 онд уг зорилтыг бүрэн хэрэгжүүлж ажилласан болно. ГХБХБГазар нь улсын төсвөөс санхүүжиж, бие даан санхүүгийн тайлан гаргаж, санхүүгийн тайлангаа Газар зохион байгуулалт, Геодези зураг зүйн газарт тушаадаг. Баян-Өлгий аймгийн ГХБХБГазар нь 2020 онд удирдах ажилтан 1, гүйцэтгэх ажилтан 27, үйлчлэх ажилтан 3, гэрээт ажилтан 2 нийт 33 орон тоогоор үйл ажиллагаа явуулсан.
		2.3.6	Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ /хамрагдалт/	96	97%	264.6	251.8	Монгол улсын Засгийн газрын болон аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөрийн 3.4.5 дахь зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд уран бүтээлч хүүхдүүдийг олон нийтэд таниулан суртапчлах зорилгоор аймгийн 6-18 хүртэлх насны хүүхдийн дунд "Ирээдүйн одод" Хүүхдийн урлагийн их наадам аймгийн Засаг даргын Тамгын газар, Боловсрол, соёл, урлагийн газар, Хөгжимт драмын театр, Дэлхийн зөн Монгол ОУБ-ын орон нутаг дахь хөтөлбөртэй хамтран аймгийн 2019 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр амжилттай зохион байгуулагдаж, авьяаслаг 300 гаруй хүүхэд оролцлоо. Урлагийн их наадамд оролцогчдын 30% нь зорилтот бүлгийн хүүхдүүд байна.
3	**БАЯНХОНГОР**					**94,238.1**	**87,309.3**	
	3.1	**Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа**				**2,348.3**	**2,294.2**	
		3.1.1	Аймгийн ИТХ-ын үйл ажиллагаа	Хурлын хуралдааныг 2-с доошгүй, Тэргүүлэгчдийн хуралдааныг 7, хороод тус бүрийн хурлыг 2 удаа хуралдуулж шийдвэр гаргана.	Орон нутгийн хэмжээнд баримтлах бодлого чиглэл, хөтөлбөр төлөвлөгөөг батлан гаргаж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа.	2,175	2,121	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит болон ээлжит бус хуралдаан 4 удаа хуралдаж, 19 тогтоолыг батлан гаргасан. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаан 13 удаа хуралдаж, 127 тогтоолыг батлан хэрэгжүүлж байна. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 5 хороотойгоор ажилласан бөгөөд хороод тус бүр 2 удаа хуралдаж, дүгнэлт гарган аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдэд саналаа дүгнэлтээ оруулж хэлэлцүүлсэн.
		3.1.2	ГХУСАЗЗ-ийн үйл ажиллагаа	Аймгийн ГХУСАЗЗ-ийн ажлыг нэгдсэн төлөвлөгөөг баталж биелэлтийг хангуулах	10 бүлэг, тусгай арга хэмжээний хүрээнд 44 заалтыг төлөвлөгөөг батлан хэрэгжүүлсэн.	170.0	170.0	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төсөвт Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд 2020 онд 170.000.000 сая төгрөгийг төсөвлөн үйл ажиллагаа явуулсан байна. Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн хурлыг 2020 оны 03 дугаар сарын 17, 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрүүдэд хуралдуулж, ажлын төлөвлөгөөг 10 бүлэг 44 заалттайгаар, салбар зөвлөлийн хурлыг мөн 2020 оны 08 дугаар сарын 19-ний өдөр хуралдуулж сүүлийн хагас жилд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг 7 бүлэг 20 заалттайгаар тус тус батлсан. Мөн 2020 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хурлын 68 дугаар тогтоолоор Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлсан болно.
		3.1.3	ЦАУЗБСК-ийн үйл ажиллагаа	Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчийн дурсгалыг хүндэтгэх, тэдний үр хүүхэд, ач зээ нарт хуульд заасан дэмжлэг үзүүлэх, Улс төрийн хэлмэгдэгдийн дурсгал мөнхжүүлэх, 10 иргэн дэмжлэг үзүүлэх	Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчийн дурсгалыг хүндэтгэх, тэдний үр хүүхэд, ач зээ нарт хуульд заасан дэмжлэг үзүүлсэн	3.0	2.9	Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.7, Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2014 оны 66/39 тоот зөвлөмж, Монгол Улсын Их хурлын 1996 оны 33 дугаар тогтоолоор Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдрийг жил бүрийн 9 дүгээр сарын 10-нд орон даяар тэмдэглэж байхаар шийдвэрлэсэн шийдвэр, тухайн өдөр зохион байгуулах ажлын талаар сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нарт чиглэл хүргүүлж ажиллалаа."Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай" хуульд 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр орсон зарим өөрчлөлтүүдийн дагуу нөхөх олговор авахаар материалаа бүрдүүлж буй иргэдэд болон нийт иргэдэд дээрх хуулийг сурталчлан таниулах ажлыг гарын авлага материалаар хангах болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэглэгчдэдээр тусгай нэвтрүүлэг зохион байгуулж сурталчиллаа.
	3.2	**Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ**				**31,353.4**	**27,352.8**	
		3.2.1	Иргэдэд үзүүлэх засаг захиргааны болон төрийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа	ИТХ-ын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах	Монгол Улсын хууль, УИХ, Засгийн газар, тогтоолыг орон нутагт хэрэгжүүлэн ажилласан.	16,416.4	15,831.9	Монгол Улсын хууль, УИХ, Засгийн газар, тогтоолыг орон нутагт хэрэгжүүлэн ажилласан. Аймгийн ИТХ-аас Засаг даргад даалгаг гаргасан 56 тогтоолыг хяналтад авч хэрэгжилтийг хангах, явц үр дүнг тайлагнан 2020 оны хэрэгжилт 90 дээш хувьтай.
		3.2.2	Орон нутгийн засаг захиргааны стратегийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаа	Засаг даргын харьяа агентлаг, сумдын ЗДТГ-уудыг бодлого, удирдлагаар хангах.	Орон нутгийн бодлого үйл ажиллагаат үр дүнтэй хэрэгжүүлэх талаар гэрээ байгуулан, гэрээг бүтэн жилээр дүгнэн ажилласан.	11,215.7	7,863.6	Аймгийн Засаг дарга эрхлэх хүрээний асуудлын 20 агентлагуудтай орон нутгийн бодлого үйл ажиллагаат үр дүнтэй хэрэгжүүлэх талаар гэрээ байгуулан, гэрээг бүтэн жилээр дүгнэн ажилласан. 2020 оны гэрээний хэрэгжилт 90-аас дээш хувьтай хэрэгжиж амжилттай сайн ажилласан. Мөн 20 сумын Засаг даргатай гэрээ байгуулан гэрээг хагас бүтэн жилээр дүгнэн хэрэгжилт, явц үр дүнг тооцон ажилласан
		3.2.3	Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ	17 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ	16 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн	341.0	340.9	17 төсөл, арга хэмжээнд 341.000 мянган төгрөг зарцуулахаас 16 төсөл арга хэмжээнд 340.948.3 мянган төгрөг зарцуулан ажилласан
		3.2.4	Орон нутгийн мал эмнэлгийн үйлчилгээ	20 суманд мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх	Төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан	709.3	709.3	20 сумын мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлдэг 46 аж ахуй нэгжид 709.306 төгрөгийн санхүүжилт олгосон.
		3.2.5	Замын сан	Замын сангийн хөрөнгө оруулалтаар 11 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Замын сангийн хөрөнгө оруулалтаар 11 төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн.	740.7	728.5	Замын сангийн хөрөнгө оруулалтаар 11 төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн.
		3.2.6	Хот тохижуулах газар	төлөвлөгөөг хэрэгжүүлэх	төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан	640.6	615.6	"Баянхонгор-тохижилт үйлчилгээ" ОНТҮГ-ын 18 зам талбайн үйлчлэгч Баянхонгор аймгийн нийтийн эзэмшлийн 96370.9 м2 авто зам , 21349.8 м2 явган зам, 9705.3 м2 хайс хамгаалалт, 78339.1 м2 парк цэцэрлэгт хүрээлэн, эрдэнэмандал хайрханы шат ,зогсоолын талбай зэрэг нийт 218632.5 м2 талбайн халтиргаа гулгаат арилгаж, цэвэрлэгээ үйлчилгээг чанартай хийж гүйцэтгэж байна. Мөн шинээр нэмэгдсэн 71400 м2 17500м 2 авто замын цэвэрлэгээг тогтмолжуулан ажиллаж байна.
				Нийтийн эзэмшлийн 138439,5 м^2 талбайд цэвэрлэгээ үйлчилгээ хийнэ.	100%			"Баянхонгор-Тохижилт Үйлчилгээ" орон нутгийн төсөвт үйлдвэрийн газрын 19 зам талбайн үйлчлэгч Баянхонгор аймгийн нийтийн эзэмшлийн 96370.9 м2 авто зам, 21349.8 м2 явган зам, 9705.3 м2 хайс хамгаалалт, 78339.1 м2 парк цэцэрлэгт хүрээлэн, эрдэнэмандал хайрханы шат, зогсоолын талбай зэрэг нийт 424502м2 талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хийж гүйцэтгэж байна.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч. түүний хэрэгжүүлэх хөтөлбөр. хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар. танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт. бодлогын зорилтын хэрэгжилт. түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт. хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт. тасарсан бол шалтгаан/
		3.2.6.1	Хот тохижилт, үйлчилгээний үйл ажиллагаа	Мазаалай, Гурван бүс, Ахмадын цэцэрлэгт хүрээлэн, Гандангийн өмнөх талбай, ногоон байгууламжийн хайс, Автобусны буудал, замын бродиур будах, Эрдэнэмандал хайрханы өнгө үзэмжийг сэргээх, засварлана	100%	**481.9**	**479.0**	Мазаалай, Гурванбүс паркуудын шат, сандал сүүдрэвч, зарим баримал хөшөөг будах ажлыг 2020 оны 06 сарын 01 өдрөөс өмнө гүйцэтгэж усан оргилуур усан толионы засвар үйлчилгээг хийж хэвийн ажиллагаат ханган ажиллаж ирлээ. Мөн ногоон байгууламжийн хайс хамгаалалтыг угаах ажлыг зохион байгуулж Гандангийн өмнөх талбайд 490 метр хамгаалах хайс хийж сүүдрэвч сандлуудын бүрэн бүтэн байдлыг ханган засварлан хайс хамгаалалтыг хийн ажиллалаа. Эрдэнэмандал хайрхны зогсоол, Ахмадын садны сандал сүүдрэвч зэргийн засвар үйлчилгээг ханган ажиллаж байна.
				Нэгдэлчний уулзвараас Онцгой байдлын уулзвар хүртэл зорчих хэсгийн 2 талаар, Гурван бүс паркийн урдуур, Номгон ахлах сургуулийн урд талын мод бут сөөгийн услалтын системийг сайжруулж сэлбэх	100%			Нэгдэлчний уулзвараас Онцгой байдлын уулзвар хүртэл зорчих хэсгийн 2 талаар 590 метр, Номгон ахлах сургуулийн хажуугийн замын зорчих хэсгийн баруун талаар 350 метр болон гандангийн өмнөх талбайд 735 метр усалгааны системийг тавин услалтыг жигдрүүлэн ажиллаж байна.
				Явган хүний зам засварын ажлыг 35 м2 талбайд хийгдэнэ.	100%			Явган хүний зам засварын ажлыг 35 м2 талбайд бүрэн хийв.
		3.2.6.2	Гудамжны гэрэлтүүлэг, цэвэрлэгээ	Нийтийн ээзмшлийн парк, гудамж талбайг гэрэлтүүлнэ.	100%	**56.9**	**56.9**	Баянхонгор-Эрчим хүч ХХК-тай хамтран Мазаалай, Гурванбүс паркуудын гэрэлтүүлгийг бүрэн асааж мөн Гандангийн өмнөх талбай, Эрдэнэмандал хайрхны гэрэлтүүлгийг асааганд байна.
		3.2.6.3	Ногоон байгууламжийн үйл ажиллагаа	Одоо байгаа 11235ш мод, 17180м2 зүлэгжүүлсэн талбайн арчилгааг хийж 17000ш цэцэг тарьж зам талбайд байршуулна мөн 2000м2 талбайд зүлэг нөхөн тарина. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд шаардлагатай хөрс бор шороог бэлдсэн байна.	100%	101.8	79.7	Баянхонгор хотод таригдсан мод бут сөөгийн арчилгаа усалгаат услалтын системээр болон усалгааны машинаар хийж гүйцэтгэн ургах нөхцөлийг ханган ажиллаж байна Нийтийн ээзмшлийн талбайн төв замын тусгаарлах зуррас доторх нийт 16 цэцгийн мандалд 5-6 навчтай бүюу бүрэн цэцэглэсэн 7000-8000 ширхэг цэцгийг 2020 оны 6 сарын 15-ны өдрөөс эхлэн ил талбайд шилжүүлэн суулган тариалсан мөн Төв замын тусгаарлах зуррасын нөхөн тарилт мөн 24 ширхэг цэцгийн мандалд зүлгийн нөхөн тарилтыг аюулгүйн тойрог Мазаалай парк зэрэг газруудад 2300 гаруй м2 газарт нөхөн тарилтыг хийсэн. Мод бут сөөг тарихад ориулан шаардлагатай бор шороо, элс, бууцыг бэлтгэхээс гадна цэцгийн үрслэгээний хөрс зэргийг бэлтгэн тарилтыг хийгээд байна.
		3.2.6.4	Аймгийн орон нутгийн өмчийн газар	Улс, орон нутгийн төсвийн худалдан авах ажиллагаат 100% цахимаар зохион байгуулж, гүйцэтгэчийг сонгон шалгаруулна.	100%	186.0	185.2	Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд орсон болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл арга хэмжээнүүдийн худалдан авах ажиллагаат 100% төрийн худалдан авах ажиллагааны цахим систем болох tener.gov.mn-ээр зохион байгуулж, гүйцэтгэчийг сонгон шалгаруулсан.
				Төрийн өмч ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, бодлогоор удирдлагаар хангах, Орон нутгийн өмчийн дуудлага худалдаа зохион байгуулах	100%			Орон нутгийн өмчит 242 байгууллагын 2019 оны санхүүгийн тайлан, үндсэн хөрөнгийн тодруулга тайлан, үндсэн хөрөнгийн тодруулга тайлан, хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийг 100% гаргуулж 242 байгууллагын өмч ээзмшлийн гэрээг дугнэж 1 жилээр сунгалаа мөн өмч хамгаалах байнгын зөвлөлийг холбогдох хуулийн дагуу байгуулсан эсэх, өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2019 оны тайлан, 2020 оны төлөвлөгөөнд хяналт тавьж мэргэжил арга зүйгээр хангасан. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 14 хөрөнгийн нээлттэй дуудлага худалдааг амжилттай зохион байгуулж орон нутгийн орлогод 38.5 сая төгрөг, акталсан хөрөнгө худалдан борлуулсан, дэнчин хүчингүй болсон зэрэг 23.2 сая төгрөгийн орлого нийт 61.7 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүллээ.
		3.2.7	Орон нутгийн ахмад настанд үйлчлэх кабинет төв	10 ахмад настанд асрамжийн үйлчилгээ үзүүлнэ.	10 ахмад настанд асрамжийн үйлчилгээ үзүүлсэн.	142.7	138.4	2020 жилийн эцсийн байдлаар 11 ахмад настанд асрамжийн үйлчилгээ үзүүлсэн.
		3.2.8	Байгаль орчны газар	Байгаль орчны багц хууль болон дүрэм журам төрийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх	Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх, иргэдэд сурталчлах, аймгийн Засаг даргын 2020 оны 03 дугаар арын 13-ны өдрийн А/159 дугаар захирамжийг хэрэгжүүлэхээр ЗДТГ-ын даргаар "Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг сурталчлах, иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх" аяны хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөө гаргаж батлуулав.	582.7	565.7	Аяны хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөнд 25 ажлыг төлөвлөж хэрэгжүүлсэн. Сурагчдын экологийн боловсрол олгох чиглэлээр сургалт-24, Хамрагдсан хүүхдийн тоо-2800, Эко аялал зохион байгуулсан сургалт-6, Хамрагдсан хүүхдийн тоо-112, Иргэдийн экологийн боловсрол олгох сургалт125, Хамрагдсан хүний тоо-9800, Иргэд тогтвортой хөгжлийн боловсрол олгох цахим сургалт-13, Үзсэн хүний тоо -9100, Мазаалай бахархалт өдрийн талаар цахим сургалт-1, Үзсэн хүний тоо-2800, Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг зохион байгуулсан цахим хичээл-2, Зурагт мэдээлэл -35, Үзсэн хүний тоо-5000, 21 төрлийн гарын авлага бэлтгэн 3290 иргэдэд тараасан.
		3.2.9	Сум дундын ойн анги	10 төрлийн бут жимсний модны суулгац иргэд болон ААН-д борлуулна. Өөрийн байгууллагын 2 га газарт тариалалт хийнэ.	100%	69.8	66.4	2020 оны хавар, намрын тариалалтаар 10 нэр төрлийн 600 ширхэг тарьц, суулгацыг иргэн ААН-д худалдан борлуулсан. Хавар мод өржүүлгийн талбайдаа улиас, бургасны нийт 5000 мянган ширхэг үр үрсэлгээ бэлтгэж тариалалт хийсэн.
		3.2.10	Аймгийн халамжийн сан	Баянхонгор аймгийн 854 иргэнд Олон нийтийн оролцоонд тушиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлнэ	2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 7 ТББ-тай гэрээ байгуулан зорилтот бүлгийн нийт 530 иргэнд 65,6 сая төгрөгийн үйлчилгээ үзүүлсэн.	65.8	64.7	Олон нийтийн оролцоонд тушиглэсэн халамжийн үйлчилгээг орон нутгийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмаар нээлттэй тендерийг 60.000.000 төгрөгийн 6 багц үйлчилгээг үзүүлэхээр зарлаж шалгарсан 7 ТББ, аж ахуй нэгжтэй гурвалсан гэрээг байгуулан 520 иргэнд Сэргэн засах үйлчилгээ, Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ба хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өдрийн үйлчилгээ, тур байрлуулан асрамжлах үйлчилгээг үзүүлсэн. Мөн зорилтод бүлгийн иргэдийг бүлгийн зохион байгуулалтад оруулан төсөл хөтөлбөрөөр дэмжих арга хэмжээг удирдамжийн дагуу зохион байгуулж 10 иргэний 5 бүлгийн төслийг дэмжиж нийт 530 иргэд 65.572.500 төгрөгийн үйлчилгээ үзүүлэн ажилласан.
				Баянхонгор аймгийн 174 иргэнд амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж үзүүлнэ	Мөнгөн тусламж үзүүлсэн	85.9	85.9	Аймгийн хэмжээнд 71 иргэнд 85.200.000 төгрөгийг амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламжид хамруулж ажилласан.
		3.2.11	Санхүүгийн хяналт, аудитын алба	Өмнөх хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг бууруулах тал дээр арга зүйн зөвлөгөө өгч ажиллана. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг 99%-д хүргэнэ.	100%	156.9	156.7	Өмнөх хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг бууруулахаар хяналт шалгалтад хамрагдаж байгаа байгуллагын удирдлага, нягтлан бодогч, холбогдох албан тушаалтан нарт сургалтыг илэрсэн зөрчил тулгуурлан тухай бүр сургалтын зохион байгуулж, зөвлөн туслах үйл ажиллагааг хэрэгжүүлж ажилласан. Мөн шилэн дансны тухай хуулийн дагуу улирал бүр төсөвт байгууллагын шилэн дансны хэрэгжилтэд хяналт шалгалтын хийж, зөрчил дутагдлыг илрүүлж хуулийн хугацаанд холбогдох байгуллага, албан тушаалтанд хүргүүлж ажилласан. Сумдын Санхүүгийн албаны дарга, төсөвт байгуллагын нягтлан бодогч, нарт шилэн дансанд илэрсэн зөрчил дутагдлын талаар, түүнийг хэрхэн бууруулах талаар мэдээлэл хийсэн.
	Улсын төсвөөс авах тусгай зориулалтын шилжүүлгээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ					**60,536.4**	**57,662.3**	
		3.3.1	Сургуулийн өмнөх боловсрол	Хүүхдийн тоо 7911, Хамрагдалтын хувь 95.7, 5 настай хүүхдийн СӨБ-д хамрагдалт 100,0 хувь,	100	14,376.9	13,548.2	Сургуулийн өмнөх боловсролын хамрагдсан хүүхдийн тоо 7597, Хамрагдалтын хувь 94.6, 5 настай хүүхдийн СӨБ хамрагдалтын хувь 96.7 хувьтай байна.
		3.3.2	Ерөнхий боловсрол	19306 суралцагч, Бага боловсролын хамран сургалтын хувь 99,2, Суурь боловсролын хамран сургалтын хувь 94,8, 6 настай хүүхдийн сургуульд хамрагдалтын хувь 97,2 дотуур байранд хүсэлт гаргасан хүүхдийн хамрагдалтын хувь 96,8-д хүргэнэ.	100%	32,136.4	30,389.5	Сургуулийн өмнөх боловсролын хамрагдсан хүүхдийн тоо 7597, Хамрагдалтын хувь94.6, 5 настай хүүхдийн СӨБ хамрагдалтын хувь 96.7 хувьтай байна.
		3.3.3	Эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ	Баянхонгор сумын 10 багийн 32,936 иргэнд эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлнэ.	Төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан	8,052.1	7,944.1	Баянхонгор сумын 10 багийн 35,876 иргэнд эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлсэн. .
				Соёл урлагийн бүтээлийг төв, хөдөө орон нутагт чанартай хүргэх		4,306.8	4,224.1	Шинэ уран бүтээл 2, сэргээн тавьсан уран бүтээл 1, уралдаан тэмцээн 3, өөрийн тоглолт 70, шторк 10, контент 10, галерей, богино хэмжээний кино 3, үзэгч 6749, онлайнаар үзэгч 2027000, орлого 23.261.230 бусад соёл урлагийн арга хэмжээ төлбөртэй 1, үзэгч 500, орлого 300.000 үнэ төлбөргүй арга хэмжээ 100 үзэгч 50000 нийт 224 арга хэмжээ зохион байгуулсан.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч. түүний хэрэгжүүлэх хөтөлбөр. хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар. танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт. бодлогын зорилтын хэрэгжилт. түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт. хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт. тасарсан бол шалтгаан/
		3.3.4	Соёлын үйлчилгээ	Баянхонгор аймгийн байгалийн үзэсгэлэнт газруудыг уран зураг буулган олон улсад сурталчлах зориллоор "Монгол салхи" -3 олон улсын зураач, урчуудын пленер үзэсгэлэнг зохион байгуулна. /Монгол улс, ОХУ, Буриад улс, БНСУ, БНХАУ-ын ӨМӨЗО, Бразил, Япон/	"Монгол салхи" -3 олон улсын зураач, урчуудын пленер үзэсгэлэнг зохион байгуулсан.	434.7	430.8	Олон улсын зураачдын пленерт оролцсон Израйль, Солонгос, ОХУ, Буриад, Казакстан, БНХАУ, Монгол гэсэн 7 улсын 150 зураачдын бүтээлээр "Гэр галерей" байгуулж нээлтээ хийн пеленер үзэсгэлэнг зохион байгуулсан.
		3.3.5	Газрын харилцаа, кадастр	Шинэ суурьшлын бүсийн ерөнхий төлөвлөгөөг аймгийн ИТХ-аар батлуулж, 900 иргэнд эдлэн газартай, амины орон сууцны газар өмчлүүлнэ. иргэдийн газар эзэмших гэрээг дүгнэх замаар Орон нутгийн төсвийн орлогод 710,0 сая төгрөгийг төлбөрийн төвлөрүүлнэ.	676.5 сая төгрөг төвлөрүүлсэн	545.3	545.3	Газар болон барилга хот байгуулалтын чиглэлийн хууль тогтоомж, дүрэм журмыг хэрэгжүүлэн ажиллана. 20 сумд 106 нэгж талбарт газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээт дуудлага худалдааг зохион байгуулж, гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 66 га талбайг 872 иргэнд өмчлүүлнэ.
				Баянхонгор аймагт баригдаж байгаа 65 барилга, байгууламжид техник, хяналт хийж ажиллана.	Төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан	35.7	35.7	Баянхонгор аймагт баригдаж байгаа 30 барилга, байгууламжид техник, хяналт хийж ажиллана.
	3.3	3.3.6	Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ	Хүүхдийн эрхийн тухай хууль, хүүхэд хамгааллын тухай хууль, хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийг ханган ажиллах.	100%	648.5	544.6	Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 20 сум 75 байгууллагад хүргүүлсэн. Хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд 8 арга хэмжээг зохион байгуулсан. Мөн хуулийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг газрын даргаар батлуулан ажилласан.
				Хүүхдийн төлөө Зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, арга зүй, зөвлөмжөөр хангах	80.90%			Хүүхдийн төлөө зөвлөл жилийн эцсийн байдлаар 2 удаа 70%-ийн ирцтэй хуралдсан. Төлөвлөгөөг 5 зорилт 35 арга хэмжээний хүрээнд төлөвлөн Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүнээр батлуулан сумдад хүргэсэн.
				Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, хуулийг дагаж гарсан журмуудын хэрэгжилтийг хангах	100%			Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг 5234 хүнд сурталчилсан.
				Хүүхдийн эрсдэлийн түвшнийг тогтоох программыг ажиллуулах, эрсдэл өндөртэй хүүхдийн аюулгүй байдлын хангах, 8-10 хүүхэд	Төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан			Баянхонгор аймгийн өндөр эрсдэлтэй 4388 хүүхдээс 0-5 насны 1016 хүүхдүүдийн дархлаг дэмжих зорилгоор витаминжуулах ажлыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтнүүд сумдын Засаг даргын тамгын газартай хамтран зохион байгууллаа. Үүнд: Баянговь-85, Баянцагаан-73, Баянлиг-22, Бууцагаан-3, Богд-109, Галуут-14, Заг-32, Баянхонгор-320, Шинэжинст-31, Баян-Өндөр-12, Жаргалант-34, Өлзийт-79, Баян-Овоо-23, Баацагаан-27, Баянбулаг-10, Гурванбулаг-1, Эрдэнэцогт-73, Бөмбөгөр-68 тус тус байна. Хүрээмарал, Жинст сумуудад 0-5 насны өндөр эрсдэлтэй хүүхэд байхгүй.
				Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүдийг чадавхжуулж, эрсдэл арга хэмжээг зохион байгуулах. /2 сургууль/	90%			Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо нь жилийн эцсийн байдлаар 5 удаа хуралдсан.. Хууль зүйн хорооны гишүүдийн нуцын баталгаат шинэчилсэн байгуулсан. Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо нь 16 кейс дээр ажилласан байна. Гэмт хэргийн хохирогч болсон 8 хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр томилогдон хүүхдийн эрхийг хамгаалан ажилласан.
				Хүүхдийн хөгжил, оролцооны жишиг сургуулийг чадваржуулах, сургалт арга хэмжээг зохион байгуулах. /2 сургууль/	Төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан			Эрдэнэцогт сумын сургууль, аймгийн Эрдэнэмандал сургууль жишиг сургуулиар сонгогдсон. 100 эцэг эх, 150 хүүхэд, 80 багшид 1 удаагийн чадавхжуулах сургалтыг зохион байгуулсан.
				Хамтарсан багийн үйл ажиллагааг өргөжүүлэх	100%			Орон нутагт ажиллаж байгаа 29 хамтарсан багт 2019 оны үйл ажиллагаа, бичиг баримт, хурлын тэмдэглэл, хүүхэд, гэр бүлийн кейс, хамтарсан баг орон нутгийн иргэдэд хүрч ажилласан байдал зэрэгт үнэлгээ хийж зөвлөмж хүргүүлсэн. Үнэлгээний явцад 348 гишүүнд хүрч ажилласан. Кейс конференсийг 2 удаа цахимаар зохион байгуулж арга зүйг тухай бүр нь утсаар өгч ажиллаж байна. Хамтарсан багаас зохион байгуулсан арга хэмжээнд хамрагдсан хүүхдийн тоо 5846, насанд хүрэгчдийн тоо 12289 байна. Хамтарсан багийн үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо өмнөх оноос 10%-иар өссөн, насанд хүрэгчдийн тоо 11%-иар буурсан үзүүлэлттэй байна.
				ХӨУЦ-ийн идэвхтэй сонгуультнуудад зориулсан аргазүйн зөвлөгөө өгөх сургалт зохион байгуулах	Нэгдсэн зохион сургалт зохион байгуулна байгуулсан.			АХНЗ-ийн жилийн төлөвлөгөөг 13 арга хэмжээтэйгээр төлөвлөн батлуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилт 90% байна. АХНЗ-ийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг 2 удаа зохион байгуулсан.
				Гэр бүлийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Угийн бичиг хэтлэх бүх нийтийн аяныг 1 удаа өрнүүлсэн. Үндэсний хэмжээний 2, орон нутгийн 20 сургагч багш бэлтгэгдсэн.			Гэр бүлийн хөгжлийг дэмжих хөтөлбөрт нийт 270 өрхийн 1295 гишүүн байгаагаас 620 хүүхэд нь хүүхэд байна. Үүнээс хөдөлмөр эрхэлж буй 259, сургуульд суралцдаг 420 сурагч, СӨБ-д хамрагддаг 110 хүүхэд байна. Түүнчлэн энэ хөтөлбөрт шилжин суурьшсан 4, тур хугацаагаар тусдаа амьдарч буй 16, хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй 37, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 16, дахин гэрлэсэн 17, архины хамааралтай 70, хүчирхийлэлтэй 38, ядуу 102, эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхэдтэй 65, хорих ангиас суллагдсан 13, өрөөсгөл 10 гэр бүл тус тус хамрагдаж ниймийн үйлчилгээг авч байна. Энэхүү хөтөлбөрт хамрагдаж буй 270 өрхийг нийгэм сэтгэл зүйн болон халамжийн үйлчилгээнд 100 хувь хамруулж гэр бүлийг дэмжин ажилласан байна. Мөн дундаж орлоготой гэр бүлийн тоонд шилжсэн 86 гэр бүл буюу хөтөлбөрт хамрагдсан нийт өрхийн 31.8% нь дундаас дээш орлоготой болсон байна.
				Угийн бичиг хэтлэх бүх нийтийн аяныг өрнүүлэн, угийн бичиг хөтөлдөг гэр бүлийн тоог нэмэгдүүлэх, цус ойртолтоос урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулах, сургагч 20 багш бэлтгэх	Угийн бичиг хэтлэх бүх нийтийн аяныг 1 удаа өрнүүлсэн. Үндэсний хэмжээний 2, орон нутгийн 20 сургагч багш бэлтгэгдсэн.			Ураг, удам, уламжлалын "Хонгор" холбоотой хамтран 2020 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр Аймгийн ЗДТГ-ын хурлын тэнхимд "Угийн бичиг-улсын үндэс" аймгийн анхдугаар зөвлөгөөнийг зохион байгуулсан. Тус зөвлөгөөнд 16 сумын Ураг, удам, уламжлалын "Хонгор" холбооны салбар холбооны гишүүд, Аймгийн Ахмадын хорооны тэргүүлэгчид, гудамж хариуцсан идэвхтэнд зэрэг нийт 103 хүн оролцсон болно. Ураг удам, уламжлалын "Хонгор" холбооны салбар хороодыг 20 сумд байгуулсан. "Эх нутаг өв соёлоо эрхэмлэн дээдэлье" аяныг зохион байгуулах ажлын хөтөлбөр удирдамж боловсруулан аймгийн Засаг даргаар батлуулж захирамж гаргасан. "Эх нутаг өв соёлоо эрхэмлэн дээдэлье" аяныг зохион байгуулах ажлын хөтөлбөр удирдамж боловсруулан аймгийн Засаг даргаар батлуулж захирамж гаргасан. Ураг удам, уламжлалын "Хонгор" холбооны 8 тэргүүлэгч нарт 12 сарын 3-нд Угийн бичиг хэтлэх арга зүй сургалтыг зохион байгуулж арга зүйгээр хангасан.
4	**БУЛГАН**					**71,674.5**	**64,097.3**	
	4.1	**Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа**				**542.2**	**497.8**	
		4.1.1	Аймгийн ИТХ-ын үйл ажиллагаа	Аймгийн ИТХ-ын хуралдаан /өдрөөр/ 4, тэргүүлэгчдийн хурал /өдрөөр/ 20, ИТХ-ын төлөөлөгчийн тойрогт ажиллах хоног /1 төлөөлөгчийн/ 28	төлөвлөгөөнд хүрч ажилласан	452.2	410.2	Аймгийн ИТХ-ын хуралдааныг 3 удаа хуралдуулж 17 асуудал хэлэлцэж 23 тогтоол, тэргүүлэгчдийн хурлыг 17 удаа хуралдаж 130 асуудал хэлэлцэж 65 тогтоол батлан гаргаж, ИТХ-д хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлж, нутаг дэвсгэрийн хэмжээнд мөрдөх бодлого, шийдвэр, дүрэм журмыг хуулийн хүрээнд бие дааж шийдвэрлэв. Аймгийн ИТХ нь 2020 онд үйл ажиллагааны төлөвлөгөөндөө 90 асуудал тусган хэрэгжүүлж 92.2 хувийн биелэлттэй байна. Төлөөлөгчдийг сонгогдсон тойрогтоо ажиллахад нь 2.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, нийт 75.7 сая төгрөг зарцууллаа. Аймгийн ИТХ-ын 2019 онд гаргасан шийдвэрийн эмхэтгэл, аймгийн ИТХ-ын 2020 оны ажлын төлөвлөгөө, аймгийн ИТХ-ын 2016-2020 онд баримтлан ажиллах чиглэлийн хэрэгжилтийн талаар товхимол хэвлүүлэн төлөөлөгч, Bulgan.khural.mn сайт, "Булганы мэдээ" сонин, "Сайхан монгол" ТВ-тэй хамтран ажиллаж, хуралдааныг шууд дамжуулж, хурлын үйл ажиллагаат тогтмол мэдээлж олонд түгээж ажилласан.
		4.1.2	ГХУСАЗЗ-ийн үйл ажиллагаа	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийх сургалт /цагаар/ 48, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх /цагаар/ 32	төлөвлөгөөнд хүрч ажилласан	90.0	87.6	Тодорхой төрлийн буюу Архидан согтууралтай тэмцэх, Гэр бүлийн хүчирхийлэл, Хүүхэд хамгааллын арга хэмжээ, Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Хулгай, малын хулгай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аймгийн Цагдаагийн газар санаачилж, ЭМГ, БСУГ, МХГ, ШШГГ-тай 2020 онд хамтран ажиллах САНАМЖ БИЧИГ үзэглэж ажиллалаа. ГХУСАЗЗ-ээс Сайхан монгол ТВ-тэй хамтран гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 2 зорилтот нэвтрүүлэг, 17 шторк, 34 мэдээ бэлтгэн иргэдэд хүргэв. Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд нийт 40 гаруй нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж ажилласан байна.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч. түүний хэрэгжүүлэх хөтөлбөр. хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар. танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт. бодлогын зорилтын хэрэгжилт. түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт. хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт. тасарсан бол шалтгаан/
		4.1.3	ЦАУЗБСК-ийн үйл ажиллагаа	Иргэдийн хуулийн мэдлэг дээшилж, иргэд хуулийн дагуу цагаатгалын нөхөх олговор авна.	төлөвлөгөөнд хүрч ажилласан			Цагаатгалын хуульд орсон нэмэлт өөрчлөлтийг хэрэгжүүлэх, хүний эрхийг хангахтай холбоотой хууль тогтоомжийг иргэдэд суртал чилх. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх ёдрийг нийт суманд тэмдэглэлээ. 30 гаруй иргэнийг хүлээн авч уулзан холбогдох зөвлөгөө өгч, 10 иргэн тус бүрд 80.0 сая, 7 иргэн тус бүрд 40.0 сая, нийт 17 иргэнд 1080.0 сая төгрөгийн нөхөх олговрыг олгов. ЦАУЗБУК-оос 6 албан бичиг, Сум дундын шүүхийн шийдвэр 17, лавлагаа авах тухай 4, сумдаас 16 албан бичиг хүлээн авч, 39 албан бичгийг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна.
		4.1.4	Иргэний танхимын үйл ажиллагаа	Хэлэлцүүлэг, уулзалт, сургалт, хурал, ярилцлага зохион байгуулна.	төлөвлөгөөнд хүрч ажилласан			Иргэний танхимаар 8 хэлэлцүүлэг, 5 сургалт, 4 уулзалт, 4 зүүм хурал, ярилцлага, өглөөний цай арга хэмжээг зохион байгуулж 2500 гаруй иргэн хамруулж 100 гаруй санал хүсэлт гаргаж хурлын шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хангаж ажиллалаа. "Хүүхдийн мөнгөн тэтгэмж", "Хариуцлагатай бичил уррхай", "Монгол хэлэлцүүлэг, Экологио хамгаалан сэргээж, инновацаар хамтдаа хөгжье уулзалт, Хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийллийн өнөөгийн нөхцөл байдал цаашид анхаарах асуудал цахим хэлэлцүүлэг, "Дотоодын шилжилт хөдөлгөөнийг ойлгож удирдах нь", "Сайн сургуулиас сайхан амьдрал эхэлнэ" сэдэвт фокус бүлгийн сургалт хэлэлцүүлэг, Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн төсөл, 2020 оны ОНХС-ийн төсөвт санал авах ажил, Тендер гэж юу вэ, ОНХСанг хэрхэн төлөвлөж тайлагнах вэ, Хүний эрхийн хамгаалагчид гэж хэн бэ, төсөл хэрхэн бичиж санхүүгийн дэмжлэг авах вэ зэрэг сургалтуудыг цахимаар болон танхимаар зохион байгуулсан байна.
	4.2	**Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ**				**10,241.4**	**9,725.3**	
		4.2.1	Иргэдэд үзүүлэх засаг захиргааны болон төрийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Аймгийн Засаг даргын "Хөгжлийн хөтөч" үйл ажиллагааны хөтөлбөрийн дэд хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлнэ. Аймгийн Засаг даргын шийдвэр гаргах үйл ажиллагаанд бүхий л төрлийн дэмжлэг үзүүлсэн байна.		1,830.0	1,779.9	Булган аймгийн Засаг даргын Тамгын газар нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх эрх зүй, зохион байгуулалтын орчин бүрдүүлэн ажиллах, Засаг дарга, түүний тамгын газар, агентлаг үйл ажиллагаагаа тасралттүй, хэвийн үргэлжлүүлэхэд шаардлагатай орчин, нөхцөлөөр хангах, үзүүлэх үйлчилгээг сайжруулах чиглэлээр ажиллалаа. Ажиллагсадтай холбогдсон цалин, хөлсний зардалд 1003.7 мянг төгрөг, байр ашиглалттай холбоотой зардалд 225,1 мянг төгрөг, ажил олгочоос олгох тэтгэмж, тэтгэвэрт гарахад олгох тэтгэмжийн зардалд нийт 104.3 мянг төгрөг, албан томилолтын зардалд 38,1 мянг төгрөг, хангамж, бараа материалын зардалд 130,0 мянг төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 278,7 мянг төгрөг тус тус зарцуулсан байна.
		4.2.2	Орон нутгийн засаг захиргааны стратегийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаа	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын бодлого, шийдвэрийг боловсруулах, хуралдаанд бэлтгэх болон харьяа агентлагийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, энэ чиглэлээр цаг үеэ олсон, шуурхай зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх				Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны сонгуулийн үр дүнд сонгогдсон аймгийн ИТХ-ын 2020 оны II хуралдаанаас "Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020-2024 онд баримтлан ажиллах чиглэл", аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны "Шинэ хөгжлийн зам" хөтөлбөрийг баталан хэрэгжүүлж эхлэхэд байна. Үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр агентлаг, хэлтсийн дарга нартай хамтран ажиллах гэрээ байгуулсан.
		4.2.3	Орон нутгийн засаг захиргааны бодлогын хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа	Аймгийн Засаг дарга, нутгийн өөрөө удирдах байгууллага, сумдын удирдлагыг мэргэжлийн цаг үеэ олсон зөвлөгөө, дэмжлэгээр шуурхай хангах, тэдгээрийн үр нөлөөтэй, хэвийн үйл ажиллагааны эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх				Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийгэм, эдийн засгийн үндсэн салбаруудын бодлогыг тодорхойлсон 5 бүлэг 70 зорилтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд 379 арга хэмжээг тусган, эдгээр зорилт, арга хэмжээг жигд бүрэн хангахад удирдлага зохион байгуулалтын ажлаа чиглүүлэн хөтөлбөрийн заалт бүрийг холбогдох сум, агентлаг, хэлтсүүдэд хариуцуулан зөвлөгөөгөөр, бүтээн байгуулалтын шинжтэй чухал асуудлуудыг хэрэгжүүлэх арга хэмжээг жил, улирлын ажлын төлөвлөгөөнд тусган биелэлтийг тооцон ажиллав. Хөтөлбөрийн хэрэгжилт 2020 оны өссөн дүнгээр 92.2 хувь буюу "үр дүнтэй" хэрэгжсэн байна гэж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас дүгнэсэн. Энэ нь өмнөх оноос 5.9 хувиар өссөн дүнтэй байна.
		4.2.4	Орон нутгийн засаг захиргааны хяналт шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаа	Хууль, тогтоомж, Засгийн газрын тогтоол шийдвэрийн биелэлт, аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт, үйл ажиллагааны үр дүнгийн мэдээллийг хагас, бүтэн жилээр хийх				Булган аймгийн Засаг даргын Тамгын газар нь 2020 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний www.unelgee.gov.mn цахим санд байршуулсан аймгийн Засаг даргад хэрэгжүүлж ажиллахаар үүрэг болгосон 96 шийдвэрийн 191 заалтыг хяналтад авч, холбогдох журмыг баримтлан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тус санд хугацаанд нь байршуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр хяналтад авсан 96 шийдвэрийн 191 заалтын 173 /90.5 хувь/ нь бүрэн хэрэгжсэн, 10 /5.2 хувь/ нь хэрэгжих шатанд, 4 /2.0 хувь/ нь хэрэгжилт хангалттүй болон хэрэгжээгүй, 4 /2.0хувь/ нь хэрэгжилт тооцох хугацаа болоогүй заалт байгаа ба биелэлтийн дүнг дунджаар авч үзвэл 96.1 хувьтай буюу 4.80 оноотой үнэлгдэв. Хөрөнгийн эх үүсвэр шийдэгдээгүйн улмаас 1 заалт тасарч, 2 заалт хэрэгжээгүй байна. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн явцад хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хэрэгжилт удааширсан, эрчимжүүлэх шаардлагатай ажлуудыг илрүүлэн, гүйцэтгэлийг сайжруулан ажиллаж байгаа нь тайлангийн чанар сайжирсан зөрэг үр дүн гарч байна.
		4.2.5	Урьдчилан төлөвлөх, нарийвчлан тооцож төсөвт тусгах боломжгүй, Засаг даргад хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой цаг үеийн арга хэмжээ	ИТХ-аас баталсан төлөвлөгөөний дагуу зориулалтын дагуу зарцуулна.		390.2	371.8	Засаг даргын нөөц хөрөнгийн төсвийн гүйцэтгэл 371.8 сая төгрөг, үүнээс шагнал урамшуулал, буцалтгүй тусламжийн зардалд 70,2 сая, цэрэг татлагын зардалд 12,0 сая, мал тооллогын зардалд 3.5 сая, Ахмадын хорооны санхүүжилтэд 41,6 сая, гамшиг ослын үр дагаврыг арилгахад 18.0 сая, бусад болзошгүй зардалд 226.5 сая төгрөгийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж 93 захирамжийг үндэслэн зарцуулсан байна.
		4.2.6	Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ			4,882.9	4,592.7	Аймгийн Байгаль хамгаалах сангаас ойжуулалтыг нэмэгдүүлэх, цөлжилтийг бууруулах, усны нөөцийг хамгаалах, усан хангамжийг сайжруулах, газар, газрын хэвлийг хамгаалах, орчны бохирдлыг бууруулах, хог хаягдлыг багасгах, биологийн төрөл зүйлийг хамгаалах чиглэлээр 62 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр 4882.9 сая төгрөг батлуулж хэрэгжилт 4592.7 сая төгрөг буюу 94.0 хувь байна. Булган сумын гэр хорооллын 200 айл өрхөд боловсон, соруулдаг жорлон барих 184.5 сая төгрөгийн ажлын гэрээг байгуулсан боловч гүйцэтгэл 0%, ойжуулалтын ажлын гүйцэтгэл 50%, ой хэзрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлын гүйцэтгэл 38%, цаг агаарт зориудаар нөлөөлөх ажлын гүйцэтгэл 60%, идэвхтэн байгаль хамгаалагч морин эргүүл ажиллуулах ажлын гүйцэтгэл 66%-тай байна.
		4.2.7	Орон нутгийн мал эмнэлгийн үйлчилгээ	Урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад давхардсан тоогоор 745600 толгой мал хамруулна		607.2	600.0	Энэ онд 44 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжтэй гэрээ байгуулан ажилласан ба аймгийн хэмжээнд 39 малын их эмч, 15 малын бага эмч ажиллаж, нэг мал эмнэлэгт 82.7 мянган толгой мал, нэг малын эмчид 67.4 мянган толгой мал тус тус ноогдож байна. Орон нутгийн төсвийн санхүүжилтээр 6 төрлийн 5.5 тонн вакциныг 139.7 сая төгрөгөөр худалдан авч 731.4 мянган толгой мал, амьтан хамруулсан. Малчдын санхүүжилтээр 3 төрлийн 6.4 сая төгрөгийн 180.6 литр шингэн вакцин, 30.1 мянган тун хуурай вакциныг "Биокомбинат" төрийн өмчит үйлдвэрийн газраас авч 35.8 мянган толгой малыг хамруулав.
		4.2.8	Замын сан	Төлөвлөгдсөн төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна. Автотээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг автозамын санд 100 хувь төвлөрүүлнэ.		325.5	237.2	Аймгийн авто замын сангаас нийт 325,5 сая төгрөгийн 7 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталж 237,2 сая төгрөгийн ажил хийгдсэн байна. Булган-Мөрөн чиглэлийн улсын чанартай авто зам дагуу Түлүүгийн давааны авто зогсоолын талбайн нэмэлт ажил, Булган, Сайхан, Хишиг-Өндөр сумын төвийн зам засвар, Сэлэнгэ сумын Ороохын даваа Шаварын гармын гүүрний засвар, Рашаант сумын 1-р багийн нутаг дахь нийтийн эзэмшлийн авто зогсоолын талбайн засвар арчлалт, Баян-Агт сумын Хануйн ангархайн авто замын засвар, Сэлэнгэ, Хутаг-Өндөр сумын урагц тээврийн авто зам, гүүрний засварын ажлууд хийгдэж 176.8 сая төгрөг, зураг төсөв шинэчлэх, боловсруулах ажилд 51.3 сая төгрөг, зам тээврийн хяналтын төвийн урсгал зардалд 9.1 сая төгрөгийг тус тус зарцуулжээ. 2020 онд АТӨЯХАТ-аар 295.0 сая төгрөг оруулахаар төлөвлөж 376.7 сая төгрөг төвлөрүүлж гүйцэтгэл 127.7% байна. Зам ашигласны хураамжийн орлогоор 60.0 сая төгрөг оруулахаар төлөвлөж гүйцэтгэл 93.0 сая төгрөг буюу 155.0% байна.
		4.2.9	Нийтлэг үйлчилгээний алба Нийтийн тээвэрт олгох татаас	Булган сумын ахмад болон сургуулийн сурагчдад нийтийн тээврийн хөнгөлөлттэй үйлчилгээ үзүүлсэн байна.		12.0	2.0	Орон нутгийн төсвөөс 2.0 сая төгрөгийн санхүүжилт авч нийтийн тээврийн үйлчилгээгээр давхардсан тоогоор 52 ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хөнгөлөлт үзүүлсэн байна. Сар бүрийн Мягмар гаригт Буриадын хороо, Байшинт чиглэлд өглөө 9.30, орой 16.00 гэсэн цагийн хуваариар явж иргэдэд үйлчилгээ үзүүлсэн. Зуны улиралд сурагчид амардаг тул автобус үйлчилгээнд яваагүй, Ковид-19 цар тахлын улмаас үйлчилгээгээ зогсоосон тул 2020 оны 02, 11 дүгээр саруудад үйлчилгээнд явсан байна.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч. түүний хэрэгжүүлэх хөтөлбөр. хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар. танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт. бодлогын зорилтын хэрэгжилт. түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт. хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт. тасарсан бол шалтгаан/
	4.2.11	**Хот тохижуулах газар**			**546.8**	**530.3**	
	4.2.14.1	Хот тохижилт, үйлчилгээний үйл ажиллагаа			45.0	45.0	Булган сумын орон нутгийн чанартай авто замын засвар үйлчилгээний ажлыг дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. 1. Авто замын нөхөөсийг Булган сумын орон нутгийн чанартай 14208 метр хатуу хучилттай авто замын 35 ширхэг байршилд 66 ширхэг шуудай буюу 2000 кг хүйтэн асфальтаар 48 м2 талбайн нөхөөс хийж дагтаршуулан. 2. Авто замын гагнаасыг Авто замын гагнаас: Төв магсаржав гудамж, 3в-5а, 3в-3б, 3а-2в хоорондох 3000 метр гаруй авто замын гагнаасыг 60/90 маркийн 560 кг витумаар хийсэн. 3. Төвийн авто замын хөвөөний 5000 метр бродюрыг шохойдож дуусгасан. 4. Цэцэгжин захын зүүн талын явган хүний зам дагуу авто машин нэвтрүүлэхгүйгээр хаалт, хашлага хийсэн. 5. Авто замын хэвтээ тэмдэг тэмдэглэгээг Магсаржав гудамж дагуу, дэвд 4 замаас – MCYT – ALL март хүртэл 2510 метр авто замын хэвтээ тэмдэг тэмдэглэгээ 262 м2, 18 ширхэг явган хүний гарцыг 182 м2 нийт 444 м2 талбайг 151 литр авто замын резинэн будгаар тодруулсан. 6. Авто замын босоо тэмдэг тэмдэглэгээг материал ирсэн суулгахад бэлэн болгосон. 7. Замын хөвөөний дүүргэлтийн ажлуудыг хийсэн.
	4.2.14.2	Гудамжны гэрэлтүүлэг, цэвэрлэгээ			328.9	326.5	Булган сумын засаг даргын 2020 оны 07-р сарын 29-ны өдрийн А/115 захирамжаар Булган сумын 5-р багийн 1-р гудамжны урд талын авто замын гэрэлтүүлэг, явган хүний замын ажлын төсөв нь 15,7 сая төгрөг, гэрэлтүүлгийн ажил 19,0 төсөвт өртөгтэй. Энэхүү ажил нь 182 м урттай 1,2 м өргөнтэй цутгамал бетон явган зам, 4 ш гэрэлтүүлгээс бүтсэн гэрлийн чадал 80-150 вт болсон. Булган сумын ХХҮГ-ын хөдөлмөр эрхэлтийг дэмжих сангийн дэмжлэгээр нийтийн эзэмшлийн талбай, САЦХ-ийн хог ургамлыг цэвэрлэлээ. Ажил хөдөлмөр эрхэлдэггүй 10 иргэнийг 7 хоног өдрийн 8 цагаар түр ажлын байр бий болгож, явган зам, дугуйн зам, орчин тойрны нийт 10 га талбайн шарилж, хог ургамлыг тармуурдаж овоолж, хог ургамал, шарилжийг цэвэрлэж ачиж тээвэрлэн ХХНЦ-т буулгаж ажилласан.
	4.2.14.3	Ногоон байгууламжийн үйл ажиллагаа			46.5	42.2	Орхон аймгийн "Хөвөнтөн ой" ХХК-иас 660ш нарс модыг хүлээн авч тарьснаас 40ш нарс мод гаднын нөлөөгөөр хугарч гэмтсэн байна. Бусад бүх мод ороён нахиа хөвсөн, цэнэг усалгаа, арчилгаа хийсэн 90%-ийн ургалттай мод хүлээн авсан. Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжид мал орохоос хамгаалж байгууллагын ажилтан албан хаагчдыг хамруулан цаг үеэтэйгээ холбогдуулан мал хаших хуваарь гарган эзлж гарган малыг туулгаж ажилласан. 2020-02-03-ны өдрөөс эхлэн Нийтийн эзэмшлийн зам талбай, цэцгийн мандлуудыг цэцэгжүүлэх үр өржүүлэх өрөө тасалгааг бэлтгэж хөрсийг халааж, тавиурыг гаднуулж, хоовонг ариутган цэвэрлэж үрсэлгээ хийх бэлтгэл ажлыг ханган, САЦХ-ийн тасалгаанд 10000ш мандлын цэцгийн үрсэлгээг хийж усалгаа арчилгаат хийж бойжуулан, хоовонгоос бортогонд шилжүүлэх, бордох, сийрүүлэх, зэрлэг хог ургамлыг түүх зэрэг ажлуудыг тогтмол хийж, 4-р сараас 2 хүлэмжийг барьж хүлэмжид гаргаж ажилласнаар 10000ш тарьснаас 90%-ийн ургалттай ургасан.
	4.2.14.4	Хог хаягдлын тээвэрлэлт, устгах, дарах үйлчилгээ			126.4	116.6	Хог хаягдлын нэгдсэн цэгийн хогийг 2020 оны 4-р улиралд 56 удаагийн түрэлтээр хуурай хог хаягдал буулгах нөөц талбайг бэлтгэн ажилласан. Айл өрхийн хогийг графикийн дагуу, дуудлагаар ачиж зөөвөрлөж байна.
	4.2.12	Аймгийн орон нутгийн өмчийн газар	Орон нутгийн өмчит 130 байгууллагад үйлчилгээ үзүүлнэ. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг амжилттай зохион байгуулсан байна.		122.6	119.7	Орон нутгийн өмчийн байгууллагуудын өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтад хяналт тавьж, 2020 онд 27 байгууллагын 95 нэр төрлийн 4128.9 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хасах, 16 байгууллагын 23 нэр төрлийн 42.7 сая төгрөгийн хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдан борлуулах, 23 байгууллагын 45 нэр төрлийн 11764.6 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд авах, 14 байгууллагын 122.9 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэх, 12.0 сая төгрөгийн үнэлгээтэй 1 барилгыг актлах шийдвэрийг цуцалж иргэнд түрээслүүлэхээр шийдвэр гаргуулж, нийт 16071.1 сая төгрөгийн хөрөнгийн асуудлыг хэлэлцэж, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоол гаргуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Орон нутгийн өмчит байгууллагуудтай өмч зөөмшлийн гэрээ байгуулж ажиллалаа. 2020 онд 69 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаог зохион байгуулахаар төлөвлөн аймгийн Засаг даргаар батлуулж, 2020 онд 63 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг Цахим системээр нээлттэй ил тод зохион байгуулж үйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. Нээлттэй дуудлага худалдааны зар мэдээг Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, bulgan.gov.mn сайт, байгууллагын мэдээллийн самбарт байршуулан, 9 удаагийн нээлттэй, 8 удаагийн хязгаартай дуудлага худалдаа зохион байгуулж, 16 тэвэрийн хэрэгсэл, 1 орон сууцны байшинг борлуулах дуудлага худалдаанд нийт 37 оролцогч оролцсон.
	4.2.13	Орон нутгийн ахмад настанд үйлчлэх кабинет төв					Улсын төсвийн 1.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар ахмад настнуудад зориулсан эрүүл мэнд, сэтгэл зүй, нийгмийн цогц үйлчилгээг түргэн шуурхай хүргэх зорилгоор "Ахмадын өргөө" цогцолбор төвийг барьж, байгуулах ажлыг эхлүүлсэн ба барилгын ажил 80.0 хувьтай байна.
	4.2.14	Байгаль орчны газар	Ойжуулах, ойг нөхөн сэргээх /га/ 300, Ойн хортон шавжтай тэмцэх ажил хийх талбай /мянган га/ 30.9, Ой бүхий сумдад ойн хортны судалгааны ажил /мянган га/ 500, Үлийн цагаан оготнын устгал хийх талбай /мянган га/ 120		537.9	528.2	"Байгаль орчин тогтвортой хөгжлийн санаачилга" төрийн бус байгууллага ой бүхий сумдын нутагт ойн хортон шавжийн судалгааны ажлыг 500.0 мянган га талбайд хийсэн нь өмнөх жилээс 2.5 дахин их, "Гранд форест", "Залуу төгөл" ХХКиуд 30.8 мянган га талбайд хортонтой тэмцэх ажлыг 92.0 хувийн үр дүнтэй зохион байгуулж ажиллалаа. Төлүүгийн даваа, Дондогийн булгийн түр буудаллах цэгт Байгаль орчин, аялал жуулчлалын яамны санхүүжилтээр боловсон бие засах газар, байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас хамгаалалтын хашаа, хогийн савны асуудлыг шийдвэрлэж аялагч, жуулчдын тав тухтай байдлыг хангалаа.
	4.2.15	Сум дундын ойн анги					
	4.2.16	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	Төлөвлөгдсөн төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.		637.8	636.5	Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж ажлууд бүрэн хэрэгжсэн байна. Сэлэнгэ сумын цэцэрлэгийн өргөтгөлийн барилгын дуусгал 480.9 сая, цэнгэлдэх хүрээлэнгийн засвар, шинэчлэлийн ажлын нэмэлт санхүүжилт 54.3 сая, Хутаг-Өндөр сумын Уньт багийн эмнэлгийн барилгын өргөтгөл 68.8 сая, ЭӨЦС-ийн барилгын их засварын оролцоо 23.6 сая, Хишиг-Өндөр сумын эмнэлгийн шүдний эмчилгээний бор машин 8.9 сая төгрөгийн ажлууд хийгдсэн байна.
	4.2.17	Аймгийн халамжийн сан	Олон нийтийн оролцоонд тушиглэсэн халамжийн үйлчилгээнд 50 хүн, онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид 46 хүн тус тус хамруулна.		79.2	64.4	ОНОТХУ-ний төсөв 39,2 сая төгрөг батлагдсанаас 17 суманд ОНОТХУ-г үзүүлэхээр төсөвлөж үүнийг зорилтот бүлэгт чиглүүлэн, ядуурлаас гаргах ерхтэй холбон ажиллахаар зорилт тавин ажиллалаа. 2020 онд 7 сумын 21 төслийг дэмжиж 18,9 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон ба дээрх төслүүдэд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, зорилтот бүлгийн 50 иргэнийг хамруулсан. Онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжид 40,0 сая төгрөгийн санхүүжилт авч 14 иргэнд дараах үйлчилгээнүүдийг үзүүлсэн байна.
	4.2.18	Санхүүгийн хяналт, аудитын алба	Санхүүгийн хяналт шалгалт хийх байгууллагын тоо 54, дотоод аудит хийх байгууллагын тоо 2		124.2	122.2	2020 онд нийт 53 байгуллагын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 81 актаар 60055,5 мянган төгрөгийн төлбөр тогтоож, 39663,9 мянган төгрөгийн 23 албан шаардлага хүргүүлж албан шаардлагын биелэлт 100 хувьтай байна. Өмнөх оны актын үлдэгдэл 43086,9 мянган төгрөг үүнээс хуулийн байгууллагад 13871,5 мянган төгрөг, тайлант оны актын үлдэгдэл 21187,7 мянган төгрөг байна. Хутаг-Өндөр, Тэшиг, Могод, Хишиг-Өндөр, Гурванбулаг, Орхон, Бугат сумын төсвийн байгууллагын төсөв санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж ажилласан. Аймгийн ИТХ-тай хамтран 5 сумын тусгай зориулалтын сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын байдалд хяналт шалгалт хийж дунг аймгийн ИТХ-д мэдээлсэн. Хишиг-Өндөр сумын Цэцэрлэгийн ажилтны хүсэлтийн дагуу хяналт шалгалт хийхэд хуурамч баримт бүрдүүлэн хүнсэнд зарцуулсан 1114,7 мянган төгрөгийн зөрчилд төлбөр тогтоон бүрэн барагдуулсан.
	4.2.19	Хүүхдийн сувилал	40 хүүхэд сувиллын асаргаанд хамрагдаж, 10 хүүхэд хүнс тэжээлийн дутагдал, жингийн алдагдлаас гарсан байна.		145.1	140.4	2019-2020 оны хичээлийн жилд 1-2 насны 40 хүүхдийг бүртгэн яслидаа хамруулаад байна. Үүнд: Өрхийн амьжиргааны түвшингээс доогуур орлоготой өрхийн 26 хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэний 2 хүүхэд, өрх толгойлсон эхийн 4 хүүхэд, нарийн мэргэжлийн эмчийн тодорхойлолттой 8 хүүхэд байна. Эдгээр 40 хүүхдийг хоёр бүлэгтэв нас хүйс, хөгжлийн онцлогийг харгалзан хувиарлалт хийсэн. Эрүүл мэндийн сайдын тушаалын дагуу хүүхдийн нас биеийн онцлогт тохирсон илчлэг калорийн хэмжээт тодорхойлсон хоолны цэсийг 7 хоногоор зохиож хоол тэжээлийг олгож байна. 14 хүүхдийг жингийн алдагдлаас гарган ердийн цэцэрлэгт шилжүүлсэн.
	4.3	**Улсын төсвөөс авах тусгай зориулалтын шилжүүлгээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ**			**60,890.9**	**53,874.2**	
	4.3.1	Сургуулийн өмнөх боловсрол	Төрийн өмчийн 22 цэцэрлэгт 4315 хүүхэд хамруулж, хамран сургалтын бохир жин 80,0% хүрсэн байна.		9,901.5	8,712.1	Төрийн өмчийн 22 цэцэрлэгт 4137 хүүхэд хамрагдаж хамран сургалтын бохир жин 76,6 хувьд хүрсэн. Нэг бүлэгт байх хүүхдийн норм 25 байдаг боловч одоогоор 35.5 байна. Ковид-19 халдварт өвчний улмаас цэцэрлэгийн зуны бүлгийг ажиллуулаагүйтэй холбоотой СӨБ-ын хамрагдалт буурсан байна. Цэцэрлэгийн тоо хэвээрээ байгаа боловч бүлэг нэмэгдсэн.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч. түүний хэрэгжүүлэх хөтөлбөр. хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар. танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт. бодлогын зорилтын хэрэгжилт. түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт. хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт. тасарсан бол шалтгаан/
		4.3.2	Ерөнхий боловсрол	Хөтөлбөрийн хүрээнд 22 ЕБСургууль үйл ажиллагаа явуулж, 10672 хүүхэд суралцуулна. Хамран сургалтыг 89 хувь болгоно. Дотуур байранд 1867 хүүхэд, үдийн цай хөтөлбөрт 5654 хүүхэд хамруулна.		23,555.8	21,924.1	Хөтөлбөрийн хүрээнд 22 сургууль үйл ажиллагаа явуулж 111128 хүүхэд суралцсан. Сургуульд суралцаж буй хүүхдийн тоо өнгөрсөн жилтэй харьцуулахад 4.3 хувиар өссөн үзүүлэлттэй байна. ЕБС-д суралцагчдын хамран сургалт 87.2 хувьтай байна. Өнгөрсөн онд Хутаг-Өндөр, Тэшиг сумдад 240 хүүхдийн суудалтай өргөтгөлийн арилга ашиглалтад орсноор хамран сургалт өнгөрсөн жилтэй харьцуулахад 2.3 хувиар өссөн байна. Дотуур байрын хүртээмжийг нэмэгдүүлснээр дотуур байранд суух хүүхдийн тоо өссөн байна. Дотуур байранд 1890 хүүхэд хамрагдсан. Тухайлбал Рашаант, Бүрэнхангай сумдад нийт 200 ортой дотуур байрны өргөтгөл ашиглалтад орсон байна. Үдийн цай хөтөлбөрт 5675 хүүхэд хамрагдсан.
		4.3.3	Насан туршийн болон албан бус боловсролын үйлчилгээ	Албан бус боловсролд 265, тасралтгүй боловсролын сургалтад 15000 хүн хамруулна.		94.2	92.9	2020-2021 оны хичээлийн жилд дүйцсэн хөтөлбөрийн сургалтаар 192 суралцагч сурч байна. Энэ хичээлийн жилд өөр аймаг, сум руу нийт 9 суралцагч шилжиж, ЕБС-д 4 сурагчийг шилжүүлэн сургасан. Хөгжлийн бэрхшээлтэй 4 суралцагч сурах боломжгүй болсон. Дүйцсэн хөтөлбөрийн сургалтаас эрүүл мэндийн шалтгаанаар гарсан. 2019-2020 оны хичээлийн жилд 209 суралцагч суралцсан. НТБ-ын төв болон сумдын НТБ-ын нэгжээс 2020 оны эхний хагас жилийн байдлаар нийт 6687 иргэнд сургалт зохион байгуулсан байна. 2020 оны 2-р хагас жилийн байдлаар 4153 иргэнд сургалт зохион байгуулсан. 2020 онд 10840 иргэнд сургалт зохион байгуулж ажиллаж байна. Хол хорионы дэглэмтэй хамааралтайгаар 2020 онд зохион байгуулахаар төлөвлөсөн сургалт 72 хувьтай зохион байгуулагдсан.
		4.3.4	Соёлын үйлчилгээ	Соёл урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчийн тоо 73%, нийтийн номын сангийн байнгын уншигч 8.3%, музейн үзмэрийн тоо 4485, соёлын байгууллагуудын суудлын тоо 3650		2,841.2	2,731.3	Соёл урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчийн тоо /хүн амд эзлэх хувиар/ 50%-соёл олон нийтийн арга хэмжээ цөөн явагдсан, нийтийн номын сангийн байнгын уншигч /хүн амд эзлэх хувиар/ 2.0-хорио цээрийн дэглэмээс шалтгаалж ном олгох үйлчилгээ хаагдсан, жилийн эцэст хүрсэн байх музейн үзмэрийн тоо 4000-музейн үйлчилгээ үнэ төлбөргүй болсон учир үйлчлүүлэгчид нэмэгдсэн, соёлын байгууллагуудын суудлын тоо 3650-өөрчлөгдөөгүй
		4.3.5	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ	•Эхийн эндэгдлийн түвшин (100000 амьд төрөлтөд) 0, Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд) 16.2, Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд) 14.2, Зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралт (10000 хүн амд) 22.0, Хорт хавдраас шалтгаалсан нас баралт (10000 хүн амд) 6.2, Товлолт дархлаажуулалтын хамралтын хувь 99.0, Вируст гепатитын өвчлөл (10000 хүн амд) 1.3, Сүрьеэгийн тохиолдлын түвшин (10000 хүн амд) 9.7, Артерийн даралт ихсэх өвчнийг эрт илрүүлэх үзлэгийн хамрагдалт 80.0, Чихрийн шижин өвчнийг эрт илрүүлэх үзлэгийн хамрагдалт 80, Умайн хүзүүний хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэгийн хамрагдалт 80.0, Хөхний өмөнгийн хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэгийн хамрагдалт 50, Хачигт энцефлитын дархлаажуулалтын хамралтын хувь /голомттой бус нутагт/ 4, Жирэмсний эхний 3 сартайд хяналтад орсон эхний эзлэх хувь 88.0, Зонхилон тохиолдох бэлгийн замаар замжих халдварын түвшин /10000 хүн амд/ 35.8, Амьгүй төрөлтийн түвшин /1000 нийт төрөлтөд/ 2.0	•Эхийн эндэгдлийн түвшин (100000 амьд төрөлтөд) 0, Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд) 15.8, Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд) 14.5, Зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралт (10000 хүн амд) 19.1, Хорт хавдраас шалтгаалсан нас баралт (10000 хүн амд) 13.2, Товлолт дархлаажуулалтын хамралтын хувь 95.3, Вируст гепатитын өвчлөл (10000 хүн амд) 0.3, Сүрьеэгийн тохиолдлын түвшин (10000 хүн амд) 5.2, Артерийн даралт ихсэх өвчнийг эрт илрүүлэх үзлэгийн хамрагдалт 80.5, Чихрийн шижин өвчнийг эрт илрүүлэх үзлэгийн хамрагдалт 80, Умайн хүзүүний хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэгийн хамрагдалт 65.5, Хөхний өмөнгийн хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэгийн хамрагдалт 82, Хачигт энцефлитын дархлаажуулалтын хамралтын хувь /голомттой бус нутагт/ 85, Жирэмсний эхний 3 сартайд хяналтад орсон эхний эзлэх хувь 91.1, Зонхилон тохиолдох бэлгийн замаар замжих халдварын түвшин /10000 хүн амд/ 47.6, Амьгүй төрөлтийн түвшин /1000 нийт	6,167.1	6,080.6	Эхийн эндэгдлийн түвшин (100000 амьд төрөлтөд) 0, Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд) 15.8, Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд) 14.5, Зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралт (10000 хүн амд) 19.1, Хорт хавдраас шалтгаалсан нас баралт (10000 хүн амд) 13.2, Товлолт дархлаажуулалтын хамралтын хувь 95.3, Вируст гепатитын өвчлөл (10000 хүн амд) 0.3, Сүрьеэгийн тохиолдлын түвшин (10000 хүн амд) 5.2, Артерийн даралт ихсэх өвчнийг эрт илрүүлэх үзлэгийн хамрагдалт 80.5, Чихрийн шижин өвчнийг эрт илрүүлэх үзлэгийн хамрагдалт 80, Умайн хүзүүний хорт хавдрыг эрт илрүүлэх үзлэгийн хамрагдалт 82, Хачигт энцефлитын дархлаажуулалтын хамралтын хувь /голомттой бус нутагт/ 85, Жирэмсний эхний 3 сартайд хяналтад орсон эхний эзлэх хувь 91.1, Зонхилон тохиолдох бэлгийн замаар замжих халдварын түвшин /10000 хүн амд/ 47.6, Амьгүй төрөлтийн түвшин /1000 нийт төрөлтөд/ 6.5
		4.3.6	Газрын харилцаа, кадастр	Кадастрын нэгдсэн мэдээллийн системийн холболт, үйлчилгээнд нэвтрүүлэх ажлын хэрэгжилт 100%, шинээр барих болон их засвар хийгдэх барилга, байгууламжийн техник хяналт хийх 100%		536.6	505.7	2020 онд шинээр эрх зүйн харилцаа үүссэн 289 газар өмчлөгч, 5298 эзэмшигч, ашиглагчийн мэдээллийг нөхөн бүрдүүлж газрын кадастрын мэдээллийн сан оруулж аймгийн хэмжээнд өссөн дүнгээр нийт 27719 газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийг мэдээллийн санд бүртгэж 1016.96 сая төгрөгийн газрын төлбөрийн, 6142.3 мянган төгрөгийн газрын татварын нэхэмжлэхийг үүсгэн 877.3 сая төгрөгийг аймаг орон нутгийн дансанд төвлөрүүлээд байна. Мөн аймгийн хэмжээнд газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 82 нэгж талбарын дуудлага худалдаат зохион байгуулж аймаг орон нутгийн дансанд 232557.2 мянган төгрөгийг төвлөрүүлэн ажилласан. Аймгийн хэмжээнд улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд 49 төсөл арга хэмжээ хэрэгжиж байна. Монгол улсын Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолын дагуу улсын болон орон нутаг, хувийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 50 барилга байгууламжид ашиглалтад оруулах комисс ажиллалаа. Улсын төсвөөс 13 барилга байгууламж, засвар шинэчлэлтийн 10 ажил хэрэгжиж байна. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 23 төсөл арга хэмжээ байгаагаас шинээр 18 барилга байгууламж, засвар шинэчлэлтийн 5 ажил, Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар 1, дэлхийн банкны төслөөр 1, Японы өвсний үндэс буцалтгүй тусламжаар 1 арга хэмжээ хэрэгжлээ. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 оны Монгол улсын Засгийн газрын 68, 171 дүгээр тогтоолын дагуу Барилгын ажил, эхлүүлэх үргэлжлүүлэх зөвшөөрлийг 29 барилга байгууламжид олголоо.
		4.3.7	Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ	Хүүхэд хамгааллын анхан шатны үйлчилгээ авах хүүхдийн тоо /нийт хүүхдэд эзлэх хувь/-5.5%, хүүхдийн асуудлаар хүлээн авсан өргөдөл гомдлын шийдвэрлэлт 92%, гэр бүлийн хөгжлийн төвөөр үйлчлүүлэх хүний тоо 300, залуучуудын хөгжлийн төвөөр үйлчлүүлэх хүний тоо 4000		312.4	306.1	Булган аймаг нь 2019 оны жилийн эцсийн статистик мэдээгээр 62219 хүн амтай. Түр хамгаалах байранд жилийн эцсийн байдлаар 18 үйлчлүүлэгч 76 хоногийн үйлчилгээ авсан байна. Хүүхдийн төлөө зөвлөлийн гишүүн байгууллагуудын үйл ажиллагаагаар нийт хүүхдийн 10.2% буюу 2206 хүүхдэд хамгааллын үйлчилгээг үзүүлсэн. Хүүхдийн тусламжийн 108 утсанд хүүхэдтэй холбоотой 45 дуудлага ирснээс 40 дуудлагад хамгааллын үйлчилгээ бүрэн үзүүлж 5 дуудлага сумдын хамтарсан багийн хяналтад байна. Сэтгэлзүйн зөвлөгөө өгөх танхимаар 246 үйлчлүүлэгч үйлчлүүлсэн байна. Цахим хэлбэрээр гэр бүлд зөвлөгөөг 71 удаагийн зөвлөгөө мэдээллийг давхардсан тоогоор 16040 хүнд хүргэлээ. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн танилцуулга мэдээллийг 461, залуучуудын урлаг, спортын урлаган тэмцээнд 311, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ажилд буюу тур болон байнгын ажилд зуучлагдсан 144, залуу малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сургалтад 25, бичил бизнесийг дэмжих арга хэмжээнд 46, хамтын оффист 140, мэргэжил сонголтын сургалтад 163, эрүүл мэндийн сургалтад 298, эрүүл мэндийн үзлэгт 1660, амьдрах ухааны модуль сургалтад 481, уулзалт зөвлөгөөнд 165, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1250, сонирхлын клуб, сайн дурын ажилтан 50, илгээлтийн өдөр арга хэмжээнд 62, мэргэжил сонголтын подкастыг цахим орчинд үзсэн 15-17 насны 3605 залуусыг хамруулж, нэгдсэн дүнгээр 8861 залуучуудад хүрч ажилласан байна.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч. түүний хэрэгжүүлэх хөтөлбөр. хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар. танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт. бодлогын зорилтын хэрэгжилт. түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт. хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт. тасарсан бол шалтгаан/
		4.3.8	Нийтийн биеийн тамир	Нийтийн биеийн тамираар хичээллэгчийн тоо /хүн амд эзлэх хувиар/ 60, Олон улсын болон тив, дэлхийн чанартай тэмцээнээс авах медалийн тоо 3, улсын чанартай тэмцээнээс авах медалийн тоо 150		830.1	802.8	Булган аймгийн спортын салбарт 2020 онд нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх, тэр дундаа үндэсний спортыг тулхүү хөгжүүлэх бодлого барьж ажилласан. 2017 оноос эхлэн хэрэгжүүлж ажилласан "Монгол нум сум" дэд хөтөлбөрийн хүрээнд жил бүр сурын харваагаар хичээллэгсдийг чадавхжуулах сургалтыг тогтмол явуулж хэвшсэн бөгөөд 2020 оны хувьд тус спортоор хичээллэгсдийн тоо 900 гаруйд хүрээд байна. Булган аймгийн баг тамирчид улсын аварга шалгаруулах тэмцээнд спортын 6 төрлөөр оролцож, 20 медаль, өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээн, бус, нэрэмжит тэмцээнд спортын 12 төрлөөр 112 тамирчин оролцож, 52 медаль хүртсэн амжилтыг үзүүллээ. Австрийн Инсбург хотод болсон ахмад мастеруудын өвлийн олимпод Нийтийн тамир, спортын газрын тэшүүрийн дасгалжуулагч Б.Базарсад Монгол улсаа төлөөлөн гүйлтийн тэшүүрийн 5000, 10000 метрийн зайд тус бүр 3-р байрт шалгарч, хүрэл медаль хүртсэн байна. Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх чиглэлээр "Мөнгөн өвөл-2020" цас мөсний баяр, Булган лигийн аварга шалгаруулах Сагсан бөмбөгийн тэмцээн, "Отго сурын харваа", "Дэлхийн алхалтын өдөр", Булган сумын "Ахмадын спортын наадам" зэрэг спортын арга хэмжээг зохион байгуулж, нийтийг хамарсан арга хэмжээнд давхардсан тоогоор 5619 иргэнийг хамруулав.
5	ГОВЬ-АЛТАЙ					72,832.3	64,822.1	
	5.1.	Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа				1,936.5	1,870.7	
		5.1.1	Аймгийн ИТХ-ын үйл ажиллагаа	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	Төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан	1,936.5	1,870.7	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 3 удаа хуралдаж 14 асуудал хэлэлцэн шийдвэрлэлээ. Аймгийн ИТХ, Тэргүүлэгчдийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 6 бүлэг 111 асуудал төлөвлөсөн. 2020 онд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдааны 25 удаа хуралдаж, 77 тогтоол гаргаж, 21 асуудалд хуралдааны тэмдэглэлээр үүрэг чиглэл өгсөн.
		5.1.2	ГХУСАЗЗ-ийн үйл ажиллагаа					
		5.1.3	ЦАУЗБСК-ийн үйл ажиллагаа					
	5.2	Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ				22,356.1	17,643.4	
		5.2.1	Орон нутгийн засаг захиргааны бодлогын хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа			11,302.5	10,650.7	Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр сумдын ЗДТГ, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлагуудын хариуцан хэрэгжүүлэх холбогдох арга хэмжээнүүдийг картлан хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавин зөвлөмж чиглэл өгч ажиллалаа. Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем /unelgee.gov.mn/-д байршуулсан 99 арга хэмжээний хэрэгжилтийг хянан үнэлгээ хийж, 85.81 хувийн хэрэгжилттэй Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүллээ. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 132 зорилтын, 432 арга хэмжээний 2020 оны жилийн эцсийн биелэлт 91.5 хувийн хэрэгжилттэй байна.Аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд 21 зорилтын 151 арга хэмжээг төлөвлөж хэрэгжилт 85.57 хувьтай байна. Тайлант онд аймгийн 31 дэд хөтөлбөрийн нийт 939 арга хэмжээг хэрэгжүүлж хэрэгжилтийн дундаж 84.6 хувьтай байна.
		5.2.2	Аймгийн орон нутгийн өмчийн газар			166.4	156.0	2020 оны байдлаар орон нутгийн өмчит нийт 166 байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Орон нутгийн өмчит хуулийн этгээдүүдээс 2017-2020 оны байдлаар давхардсан тоогоор нийт 16 байгууллагын илүүдэлтэй байр талбайг бусдад түрээслэн, түрээсийн орлогоос 74,5 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн. "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д 2019 оны жилийн эцсийн байдлаар нийт 165 байгууллагаас 149 байгууллагын 170561004216,8 төгрөгийн үндсэн хөрөнгө шивэгдсэн ба цахим системийн ашиглалт жил бүр сайжирч байна.Жил бүр орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлэх өмч хувьчлалын орлогын төлөвлөгөө батлуулан ажилладаг бөгөөд 2017-2020 онуудад нийт 11 барилга, 17 сумын эмийн эргэлтийн сангийн хөрөнгө, 55 суудлын автомашиныг ТБОНӨ-ийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.3 дахь заалтын дагуу хувьчлан, худалдан борлуулж өмч хувьчлалын орлогоос нийт 273,8 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүллээ.
		5.2.3	Байгаль орчны газар			629.7	605.7	Булаг шандын эхийг хамгаалах, усан сан бүхий газруудад энгийн хамгаалалтын бүс тогтоох, салхинаас хамгаалах ойн зурвас байгуулах, цаг агаар хүндэрсэн үед биотехникийн арга хэмжээ авах, тусгай хамгаалалттай газруудад загвар хамтын менежментийн эвлэл байгуулах, орон нутгийн тусгай хамгаалалттай газруудыг нэмэгдүүлэх, орчны бохирдлыг бууруулах чиглэлээр ажил гүйцэтгэж байгуллагын үйл ажиллагаанд 629652.0 мянган төгрөгийн төсөв зарцуулж ажиллалаа. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр 34 нөхөрлөл, 38 эко клуб, 149 идэвхтэн байгаль хамгаалагчийн үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллалаа.
		5.2.4	Сум дундын ойн анги			267.2	226.7	Сум дундын ойн анги нь нийтдээ 14 сумын 1.673.470 мянган га нутаг дэвсгэрийн ойн санг хамгаалж, мод үржүүлгийн үйл ажиллагааг эрхлэн ажилладаг. Үүнд: Заган ой бүхий 10 сумын 1664.6 мянган га, шинэсэн ой бүхий 4 сумын 10 мянган га талбай хамрагдаж байна.Ногоон байгууламжийн тасаг нь аймгийн төвийн ногоон байгууламжийн 21,6 га талбайн усалгаа, арчилгаа, хамгаалалтыг хариуцан ажилладаг.ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 09 дугаар сарын 09-ний өдөр 58-р тогтоолоор Жаргалан сумд 20га талбайд 140м3, Халиун сумд 30га талбайд хэрэглэз 10га 160м3, түлээ 20га 480м3, Есөнбулаг сумд 10га талбайд 160м3 түлээний мод бэлтгэхээр батлуулан 2020 оны 09 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн, 2020 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл инженер Б.Нандинцэцгээр ахлуулсан ажлын хэсэг 14 хоногийн хугацаанд хийж гүйцэтгэлээ.Дэлгэр сумын Гуулин тосгоны мод үржүүлгийн талбайн 240м2 талбайтай 2 хүлэмжийг ажилчдын хүчээр буулган авч ирж Есөнбулаг сумд байрлах мод үржүүлгийн талбайд барьж хөрс боловсруулалтын ажлыг хийн үрээр хайлаас моддыг тариаллаа. Хөхморьт сумыг цөлжилттэй тэмцэх загвар сумаар сонгож, цөлжилтийг сааруулах зорилгоор 2020 онд туршилтын журмаар 200 ш бортоготой тарьцыг Монгол элсний хамгаалалтын захиргаатай хамтран тариалсан нь 80 хувийн ургалттай байна.
		5.2.5	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт			7,966.4	5,004.8	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 4,7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 46 төсөл арга хэмжээ хэрэгжихээр батлагдсанаас 31 төсөл арга хэмжээ хэрэгжсэн, 15 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна. ОНХС-ийн 2020 онд төлөвлөгдсөн санхүүжилт 70 хувийн гүйцэтгэлтэй байгаа. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 497,9 сая төгрөгийн төсөвт өртгөөр 9 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр батлагдсан. 8 төсөл арга хэмжээ хэрэгжиж бүрэн дууссан. Он дамжин хэрэгжих 1 төсөл арга хэмжээ байна. Нийт гүйцэтгэл 86 хувьтай байна. Орон нутгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 310,0 сая төгрөгийн төсөвт өртгөөр 9 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр батлагдсан. Үүнээс хэрэгжиж дууссан 2, гүйцэтгэгч сонгон шалгаруулсан 2, огт хэрэгжээгүй 5 төсөл арга хэмжээ байна. Нийт гүйцэтгэл 42 хувь байна.
		5.2.6	Аймгийн халамжийн сан			105.0	71.6	Амьжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 45 иргэнд 55,0 сая төгрөг, Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 210 иргэнд 50,0 сая төгрөгийн үйлчилгээг үзүүлсэн.
		5.2.7	Санхүүгийн хяналт, аудитын алба			123.8	122.9	Аймгийн Засаг даргын батлсан "Байгууллагын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-д тусгасны дагуу тухайн жилд аймгийн төвийн болон сумдын нийт 67-н байгууллага, тусгай зориулалтын сангийн 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийхээр төлөвлөж хэрэгжилтийг хангаж ажиллалаа. Хяналт шалгалтаар нийт 274272.5 мянган төгрөгийн дүн бүхий зөрчил илрүүлж, 15420.7 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 258851.8 мянган төгрөгийн дүн бүхий 400-н заалттай 81-н албан шаардлага хүргүүлэв. Төлөгдөөл зохих нийт актын төлбөрөөс 14706.2 мянган төгрөгийн дүн бүхий төлбөрийн актыг бүрэн барагдуулж, 95.36% -ийн биелэлттэй байгаагаас гадна биелэлтийн хугацаа хэтэрсэн 714.5 мянган төгрөгийн төлбөрийн актыг шүүхэд шилжүүлэхээр материалыг бүрдүүлж байна.
		5.2.8	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих			1,708.8	748.9	18 сумын сум хөгжлийн сангийн үйл ажиллагааны зардалд 6571.8 мянган төгрөг, 742350.0 мянган төгрөгийн зээл олгосон. Аймгийн ЖДҮ дэмжих сангаас 2020 онд зээл болон зардал гараагүй.
		5.2.9	Мал аж ахуйг хөгжүүлэх			30.3	0.0	Санхүүжилт гаргаагүй
		5.2.10	Газар тариалан хөгжүүлэх			56.0	56.0	40 сая төгрөгийн 8 тариаланч иргэнд зээл олгож, 16.0 сая төгрөгийг 2020 оны хаврын тариаланчдад үрийн үнэнд зарцуулсан.
	5.3	Улсын төсвөөс авах тусгай зориулалтын шилжүүлгээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ				48,539.7	45,308.0	

№	Төсвийн ерөнхийлөн захирагч. түүний хэрэгжүүлэх хөтөлбөр. хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар. танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт. бодлогын зорилтын хэрэгжилт. түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт. хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт. тасарсан бол шалтгаан/
		5.3.1	Сургуулийн өмнөх боловсрол			10,145.8	8,773.0	2020-2021 оны хичээлийн жилд 30 улсын цэцэрлэг сургалтын үйл ажиллагаа эрхэлж байна. Есөнбулаг сумд 2 цэцэрлэг баригдаж үйл ажиллагаагаа эхлэхээр төлөвлөснөөс 1 цэцэрлэг ашиглалтад орж, 1 цэцэрлэг бэлтгэл ажил хийгдэж байна. Байршлаар авч үзвэл сумд 19 цэцэрлэг буюу 63,4 хувь, аймгийн төвд 11 цэцэрлэг буюу 36,6 хувь байдаг. Сургуулийн өмнөх боловсролын 30 цэцэрлэгийн 146 бүлэгт 4114 хүүхэд хүмүүжиж байгаагаас 3466 нь цэцэрлэгийн ангид, 648 нь хувилбарт сургалтаар суралцаж байна. Энэ хичээлийн жилд 1893 хүүхэд шинээр элсэж, халамж эдэлдэг 14, хөгжлийн бэрхшээлтэй 30, хагас өнчин 39 хүүхэд хүмүүжиж байна. Сургуулийн өмнөх боловсролын өдрийн ангийн бүлэг дүүргэлт 27 болж өмнөх оноос 3-аар буурсан байна.
		5.3.2	Ерөнхий боловсрол			25,766.3	24,366.4	2020-2021 оны хичээлийн жилд төрийн 28 сургууль, Насан туршийн боловсролын төв 1 нийт 29 сургуульд өдрийн ангийн 530 бүлэгт 11901, дүйцэн хөтөлбөрөөр 321, нийт 12222 сурагч суралцаж байна. Энэ хичээлийн жилд нэгдүгээр ангид 1167, аравдугаар ангид 659 суралцагч элсэн суралцаж байна. Аймгийн хэмжээнд бага боловсрол эзэмшүүлэх 3, суурь боловсрол эзэмшүүлэх 2, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх 22, цогцолбор сургууль 1, Насан туршийн боловсролын төв 1 ажиллаж байна. Ерөнхий боловсролын сургуульд 5682 малчны, 152 хөгжлийн бэрхшээлтэй, 36 бүтэн өнчин хүүхэд суралцаж байна. 21 сургуулийн 2602 орны хүчин чадалтай стандартын 24, стандартын бус 5 дотуур байранд 1258 сурагч амьдрах хүсэлт гаргаж, бүрэн хамрагдлаа. Дотуур байранд амьдарч байгаа хүүхдийн 1152 нь малчны хүүхэд байгаа нь байранд амьдарч буй сурагчдын 91,6 хувийг эзэлж байна.
		5.3.3	Соёлын үйлчилгээ			4,346.9	4,208.8	Соёлын тухай хууль, соёлын өвийг хамгаалах тухай хууль иргэдэд соёл, урлагийн үйлчилгээний хүрээ хүртээмжийг ахиулж,хүний хөгжлийн эрэлт хэрэгцээнд чиглүүлнэ.Үндэсний соёлын өвөө хадгалж хамгаалах,сэргээн засварлах, уламжлан хөгжүүлэх, сурталчлан таниулах үйл ажиллагаг шинэ түвшинд гаргасан.
		5.3.4	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ			6,275.4	6,077.2	Халдварт бус өвчинтэй тэмцэх, Нөхөн үржихүйн эрүүл мэнд, Амны хөндийн эрүүл мэнд, Элэг бүтэн-Алтай, Эрүүл хүүхэд-Алтай ирээдүй, Төрөөс баримтлах эрүүл мэндийн бодлого аймгийн дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг ханган ажиллалаа. Коронавируст халдвар (COVID-19) өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургаж дадлагажуулах, аймгийн шуурхай штабын үйл ажиллагааг бэхжүүлэх ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Тус ажлын хүрээнд аймгийн Гамшгийн сангаас 86,9 сая төгрөгийн, Эрүүл мэндийн яамнаас 345,3 сая төгрөгийн хөрөнгө, бараа материал хүлээн авч, харьяа эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилан эмнэлгийн тусламж үйлчилгээний нөөцийн бэлэн байдлыг хангалаа.
		5.3.5	Газрын харилцаа, кадастр			522.6	512.1	Аймгийн хэмжээнд газар эзэмших хүчинтэй 11684 нэгж талбар, газар өмчлөлийн хүчинтэй 6776 нэгж талбар, ашиглах эрхийн 28 нэгж талбарын газрын төлбөр, татварын ногдуулалтыг хийж нийт хүчинтэй гэрээний 98 хувьд нь ногдуулалтыг хийсэн байна. Ногдуулалт үүсгэснээс нэгж талбаруудаас дундын эрх мэдэллийн системээр дамжуулан 21669 газрын эзэмшигч, өмчлөгчийн газрын төлбөрийн нэхэмжлэхийг үүсгэж 4407 газар эзэмшигч, ашиглагчийн төлөлт системд бүртгэгдсэн байна. Газрын төлбөр, татварын системээр 1115 тэмдэгтийн хураамжийн нэхэмжлэхийг үүсгэж татварын удирдлагын нэгдсэн системд илгээгдсэн бөгөөд орон нутгийн төсөвт 8,85 сая төгрөгийг бүрдүүлсэн байна.
		5.3.6	Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ			723.8	694.9	Коронавирусийн халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн орчинд хүүхдийн аюулгүй байдал, болзошгүй осол гэмтэл, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, дэмжлэг тусламж, үйлчилгээ үзүүлэх зорилгоор 6 төрлийн гарын авлага, боршуу, зөвлөмж, сэрэмжлүүлэг зэргийг 3000 ширхгийг хэвлэн гаргаж, аймаг хөдөө сумдын иргэд олон нийтэд түгээж халдвар, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, улс аймаг орон нутгийн гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэн хүүхдийнхээ аюулгүй байдлыг ханган ажилласан. Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 01 дугаэр сарын 29-ний 1/290 дугаэр чиглэл болон Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 01 дугаэр "Хүүхдийн эрхийг хамгаалах эрсдэлээс урьдчилан сэргийлэх тухай" албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллах чиглэлийг сумын Хүүхдийн төлөө эвлелд хүргүүлэн хэрэгжилтийг хангуулан арга зүй удирдлагаар ханган ажиллаж байна. Эрсдэлт нөхцөл дэх хүүхдүүдийн судалгааг нарийвчлан гаргаж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эвлөмж, уриалгыг сум бүрд хэвлэн хүргэн ажиллаж байна. Эрсдэлт ерхийн гишүүд болон ерхөд амьдарч буй хүүхдүүдийн дархлаат дэмжин 3000 витамин, 1000 ширхэг амны хаалтыг аймаг сумдын зорилтот ерх, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тусламж болгон өглөө.
		5.3.7	Нийтийн биеийн тамир			759.0	675.7	Нийтийн биеийн тамирын төлөвлөгөөнд тусгагдсан 23 арга хэмжээнээс 2020 оны байдлаар 6 тэмцээн төлөвлөгдсөн хугацаандаа явагдаж 1512 хүн хамрагдлаа. Үүнд: - Монгол улсад шинэ үндсэн хуулийн өдөрт зориулсан сумын цолтой болон залуу бөхчүүдийн барилдаанд 32 бөх. - Монгол улсад шинэ үндсэн хууль батлагдсаны өдөрт зориулсан ШШГА-ны нэрэмжит хууль, хяналт, хүчний байгууллагуудын дунд волейболын тэмцээнд 182 тамирчин. - "Мөнгөн Өвөл-2020" мөсний баярын арга хэмжээнд 33 байгууллагын 924 ард иргэд хамрагдлаа. - "Мөрөн-Алтай" ХХК-ын нэрэмжит шилдэг багуудын волейболын тэмцээнд 13 багийн 120 тамирчин хамрагдлаа. - Дэлхийн алхалтын өдрийн хүрээнд зохион байгуулагдсан "Алхалт-Эрүүл мэнд" уриатай идэвхтэй алхалтын аянд 254. Биеийн тамир, спортын газраас ажлын байранд хийх дасгалыг шинэчлэн зохион байгуулж аймгийн төвийн 10 албан байгууллага, аймаг дахь салбар сургуулийн сурагчдыг өдрийн гимнастик, дасгал хөдөлгөөнийг тогтмол хийж хэвшүүлэн нийт 540 төрийн албан хаагч, 4260 сурагчид хамрагдлаа.
6	**ГОВЬСУМБЭР**					**20,554.8**	**18,712.6**	
	6.1	**Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа**				**331.5**	**310.1**	
		6.1.1	Аймгийн ИТХ-ын үйл ажиллагаа	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	Төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан	254.5	236.8	4790.7 мян/төг орон тоо дутуу, 3947.1 мян/төг томилолт, МУГДасгалжуулагчийн нэрэмжит уралдаан тэмцээний - 5000.0 мян/төг хэмнэсэн. ОН байцаагч 2020.05 сар хүртэл орон тоо дутуугаас -3519.7 мян/төг, 2020 онд иргэний зөвлөл ажиллаагүй 2970.0 мян/төг хэмнэсэн.
		6.1.2	ГХУСАЗЗ-ийн үйл ажиллагаа	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	Төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан	47.0	46.8	
		6.1.3	ЦАУЗБСК-ийн үйл ажиллагаа					
		6.1.4	Аймгийн ИТХ-ын хяналт шалгалтын ажил	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	Төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан	30.0	26.5	
	6.2	**Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа**				**8,146.0**	**6,949.3**	
		6.1.1	Иргэдэд үзүүлэх засаг захиргааны болон төрийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Иргэдэд үзүүлэх засаг захиргааны болон төрийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Төсвийн орлогыг 100-аас доошгүй хувиар биелүүлнэ.	2,976.6	2,772.1	Аймгийн 2020 оны орон нутгийн төсвийн орлого 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 5 618.2 сая.төгрөгийн төлөвлөгөөтэй ба гүйцэтгэл 6 457.0 сая.төгрөг буюу 110.8 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна. Сангийн сайдын тушаалаар батлагдсан аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийг захиран зарцуулах журмын хэрэгжилт нь бүрэн хэрэгжүүлж ажиллалаа. Аймгийн төвийн нийт орлогын төлөвлөгөө 4836.8 сая.төгрөг ба үүнээс 5520.4 сая.төгрөгийн гүйцэтгэлтэй, 114.1 хувийн биелэлтэй байна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын төсөв 2020 онд 1353,9 сая.төгрөгөөр батлагдсан ба үүнээс 1233,2 сая.төгрөгийг зарцуулж 120,7 сая.төгрөгийг хэмнэж ажилласан байна.
		6.1.2	Хотын нийтийн тээвэрт олгох татаас	Хотын нийтийн тээвэрт олгох татаас	Аймгийн ахмад болон ХБИргэдэд хөнгөлөлт үзүүлсэн байна	2,500.0	1,850.0	Аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настнуудын Улаанбаатар хотод нийтийн тээвэрээр үнэ төлбөргүй зорчсоны хөлсөнд холбогдох газраас нэхэмжилсэн 1,9 сая.төгрөгийг 100 хувь бүрэн төвлөрүүлсэн ба 0,6 сая.төгрөгийн хэмнэлт үүссэн байна
		6.1.3	Авто замын сан	Авто замын сан	Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг авто санд 100 хувь төвлөрүүлнэ	159.5	124.9	Аймгийн 2020 оны АТБОЯХАТ-ын орлого 105,0 сая.төгрөг батлагдаж 113,3 сая.төгрөгийн гүйцэтгэлтэй байсан. 2020 онд Авто замын санд 159,4 сая.төгрөг батлагдаж, 124,9 сая.төгрөгийг зарцуулсан ба 1 ажил он дамжин хэрэгжихээр шилжсэн болно. Авто замын сангийн 55.5 сая төгрөгөөр Хөдөлмөр халамж үйлчилгээний газар хүртэлх авто замын ажил, Авто зам засвар арчлалтын зардалд 59.5 сая төгрөг, Авто зам засвар, арчилгааны материал, нормын хувцасны зардалд 11.3 сая төгрөг, Авто замын татвар, авто зам ашигласны төлбөр хураах шатахууны зардалд 0.4 сая төгрөгийг тус тус зарцуулсан.

		15.2.16	Байгаль орчны газар	Байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх боломжийг бүрдүүлэх, байгальд эзлэгдэй тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар хүрээлэн байгаа орчны тогтвортой байдлыг хадгалж, ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх, байгаль орчны чиглэлийн орон нутгийн байгууллагуудын салбар дундын зохицуулалтыг уялдуулах, сургалт нөлөөллийн ажил хийх	Холбогдох сургалтуудыг зохион байгуулсан. Аялал жуулчлалыг хөгжүүлэх, байгаль орчныг нөхөн сэргээх, байгууллагуудын уялдаа холбоог хангах болзолт ураладаан зэргийг зарлаж дүгнэсэн. БХСангийн зардлаар гүйцэтгэл 97.2%	382.5	381.3	Малчид иргэд ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сургалтыг 2 удаа 1500 хүнд БОА, Скайтел, УЦУОШГарартай хамтран зохион байгуулсан.Түймрийн эрсдэл бүхий Асгат, Дарьганга, Эрдэнэцагаан, Сүхбаатар, Түмэнцогт, Мөнххаан зэрэг сумдын 2680 өрхийн иргэд гар утсанд нь мессежийг 7 хоногийн давтамжтай 2 сарын хугацаанд хүргэж ажиллаа. Сүхбаатар аймгийн аялал жуулчлалын газрын зургийг шинэчлэн 1000 хувь хэвлүүлсэн. Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор Агтана хүрээт арга хэмжээг АИТХ-тай хамтран зохион байгуулсан. Дарьганга сумын ганга нууран дээр 3-р сургуулийн ахлах ангийн сурагчдыг оролцуулан шувуу ажигласан аяллыг зохион байгуулсан. Сүхбаатар аймгийн байгалийн болон түүх соёлын дурсгалт газар, өв уламжлалын зураг авалт, аялал жуулчлалын видео танилцуулгын ажлыг УБ хот " Нано дизайн" ХХК -тай гэрээ байгуулж стандартын шаардлагад нийцсэн 15 минутын танилцуулгыг хийлгэсэн. Аймгийн хэмжээнд аргаль хонины тоо толгойд мониторинг хийж 5 сумын хэмжээнд 101 толгой аргаль хонь тоолж байршил болон сүргийн бүтцийн судалгааны тайлан гарсан. Байгаль хамгаалагч нарт цахим сургалт – 1, танхимын сургалт – 2 нийт 3 удаагийн сургалт зохион байгуулсан. Сургалтад нийт 26 хүн хамрагдсан.
		15.2.17	Ногоон байгууламжийн үйл ажиллагаа	Аймгийн төвийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Ногоон байгууламжийн ургалт 85%	66.6	66.6	"Сүхбаатар-Ойжуулалт" Сум дундын ойн анги, "Ойжуулалт-хайлаас" ХХК, " Шаргын модод цэцэрлэг" ХХК-иуд нийтийн ээзмшлийн 11 байршилд нийт 19734 ширхэг 7 төрлийн мод сөөгийг арчлан модны ургалтын 87%-д хүргэсэн. Усалгаа арчилгаг тогтмол хийж гүйцэтгэсэн.
		15.2.18	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	Батлагдсан 33 арга хэмжээг чанартай зохион байгуулах	88%	3,479.1	2,301.2	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны 12 сарын 4-ны өдрийн 10/6 дугаар тогтоолын 3-р хавсралтаар орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2020 онд хэрэгжүүлэх 33 төсөл арга хэмжээг батлсан. 2020 онд орон нутгийн хөрөнгөөр 1572.8 сая төгрөгийг 29 төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн.Үүнд малжуулах төсөл, өвөлжилтийн бэлтгэл хангах, гэрэгүүлэх төсөл, нийтийн номын сангийн цахим үйлчилгээ, Хүүхдийн төлөө төвийн сантехникийн засвар, хувийн мал эмнэлгүүдийг цахим системд нэвтрүүлэх, техник тоног төхөөрөмжийн шинэчлэл, шинэ суурьшлын бүс зэрэг төсөл арга хэмжээнүүдийг санхүүжүүлсэн. Мөн боловсрол эрүүл мэндийн дэмжих чиглэлээр Сүхбаатар сумын спорт залны засвар, сургуулийн ширээ сандал орон нутагт ажиллах боловсон хүчний сургалтын зардал эрүүл мэндийн ажилтануудад хамгаалах хувцас хэрэглэл зэргийг санхүүжүүлсэн байна.
		15.2.19	Аймгийн халамжийн сан	Нийгмийн халамжийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэсэн байх	100%	115.5	115.0	2020 онд орон нутгийн төсвөөс Амьжиргаат дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмжид 34,8 сая төгрөг, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 80.7 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны нийт 4 иргэнд 4.8 сая төгрөг, гэр оронгүй буюу цаашид гэр орон нь амьдрах боломжгүй болсон 21 өрхөд 25.2 сая төгрөг өөрийн гэр оронгүй нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай 4 иргэнд 4.8 сая төгрөг тус тус олгосон байна.
		15.2.20	Санхүүгийн хяналт, аудитын алба	67 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх , үйл ажиллагаат сайжруулах	100%	197.2	189.5	2020 онд тус алба нь67 байгууллагад хучин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө ер төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээ хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, байгууллагын ажилчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах үүднээс 18.3 сая төгрөгөөр хөрөнгө худалдан авч,тус алба нь 2830 хүн өдөр ажиллахаар төлөвлөн ажиллаж ажлын хүн өдрийн хүчин чадлын ашиглалт 100 хувьтай.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч. түүний хэрэгжүүлэх хөтөлбөр. хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар. танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт. бодлогын зорилтын хэрэгжилт. түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт. хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт. тасарсан бол шалтгаан/
		15.2.21	Соёлын үйлчилгээ	Соёлын байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах орчин үеийн стандартын шаардлага хангасан барилга байгууламжийг нэмэгдүүлж, иргэдэд соёлын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, соёлын байгууллагуудыг орчин үеийн хэрэгцээ шаардлагыг хангахад нийцэхүйц техник тоног төхөөрөмжөөр хангана.	69.50%	2,894.0	2,749.7	2 суманд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 300 хүний суудалтай Соёлын төв шинээр баригдаж, 2 суманд Соёлын төвийн их засвар хийгдсэн. Нутгийн угсаатны онцлогийг илэрхийлсэн Соёл, спортын эвент арга хэмжээнүүдийг зохион байгуулах ажлын хүрээнд "Агтана хүрээт" хүлэгч эрсийн наадам, олон улсын гэрэл зурагчдын фестивалийг 3 дахь удаагаа Дарьганга суманд зохион байгуулагдаж арга хэмжээний зардалд 10,0 сая төгрөг зарцуулсан. Мөн "Өвлийн мишээл" цасны баярын арга хэмжээг БТСГ, "Жаахан шарга" театр, BBS телевизтэй хамтран зохион байгуулж, ард иргэд, ААНБ-ын байгуллагын албан хаагчдыг өргөн хамруулж BBS телевизээр тусгай нэвтрүүлэг болгон олон нийтэд хүргэсэн. Мөн угсаатны соёл, урлагийг өвлөн уламжлах ажлын хүрээнд Зүүн Монгол Дорнын гоёл" дуу, хөгжим, бүжгийн чуулбаруг дурсжүүлэх ажлыг "Бидний цөөхөн монголчууд" төсөл, Үндэсний телевизтэй хамтран хийсэн. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны 97 дугаар зарлигийн дагуу "Соёлын цаг" нэгдсэн арга хэмжээг соёлын байгууллагууд хамтран зохион байгуулж, өөрсдийн үйл ажиллагааг сурталчлах, олон нийтэд соёлын үйлчилгээ хүргэх ажлыг хийсэн. Номын сан, Угсаатны зүйн музей, ХЖТ болон сумдын Соёлын төвүүд цахимаар олон ажил арга хэмжээнүүдийг иргэдийн дунд зохион байгуулсан. Соёлын байгууллагуудыг явуулын үйлчилгээг алслагдсан хөдөөгийн иргэдэд хүргэх зорилтын хүрээнд 2020 онд ХЖТ-д улсын төсвийн 65.0 сая төгрөгийн санхүүжилтээр 45 хүний суудалтай автобус, Нийтийн номын санд орон нутгийн санхүүжилтээр 19.0 сая төгрөгийн техник тоног төхөөрөмжийн шинэчлэл, Халзан сумын Соёлын төвд 50.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгдсэн. .
		15.2.22	Нийтийн биеийн тамир	Спортын клуб холбоод, тамирчид дасгалжуулагчдыг бүх талаар дэмжинэ.	100%	907.2	876.5	Усан спорт чийрэгжүүлэлтийн төвийн үйл ажиллагааг тогтмолжуулж, иргэд, ААНБ-уудыг төлбөрийн хөнгөлөлттэй нөхцөлөөр хамруулан усан спорт төвд фитнес, спининг хичээллэж сард тогтмол 50-60 үн хичээллэж байна. Аймгийн аварга шалгаруулах өсвөр үеийн шатрын тэмцээн зохион байгуулагдаж 160 тамирчин, Аймгийн аварга шалгаруулах өсвөр үеийн ширээний теннисний тэмцээнд 30 тамирчин, насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах ширээний теннисний тэмцээнд зохион байгуулагдаж 35 тамирчин оролцсон. Өсвөр үе, идэрчүүдийн улсын аварга шалгаруулах усанд сэлэлтийн тэмцээнийг орон нутагтаа зохион байгуулж, тус тэмцээнд 5 аймаг, Улаанбаатар хотын 20 клубийн 236 тамирчин оролцсон. 2020 онд Монгол улсын мастер-5, Спортын дэд мастер-5, нийт 10 тамирчин болзол хангаж, Азийн аварга шалгаруулах тэмцээнээс 2, УАШТ-ээс 21, УАШТ-ээс 5 баг эхний 3 байрын шагнал авсан амжилт үзүүлсэн. 2020 онд үндэсний спортыг хөгжүүлэх зорилтын хүрээнд сум бүрд спортын клуб холбоодыг байгуулан идэвхжүүлж ажилласан.
	15.3	**Улсын төсвөөс авах тусгай зориулалтын шилжүүлгээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ**				**36,313.5**	**34,570.0**	
		15.3.1	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх, төрийн бус өмчийн цэцэрлэгт нэмэлт бүлэг байгуулах	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх, төрийн бус өмчийн цэцэрлэгт нэмэлт бүлэг байгуулах	80%	10,095.0	9,507.8	2020-2021 оны хичээлийн жилд 5656 хүүхдийг 24 цэцэрлэгт хүлээн авч хамран сургалт 92,9% байна. Эрдэнэцагаан сумын Бичигт шалган нэвтрүүлэх боомтод 2-р цэцэрлэгийн салбар 50 хүүхэд хүлээн авах хучин чадалтай цэцэрлэгийг АНУ-нАзи Номхон далай дах цэргийн корпусын хүмүүнлэгийн тусламжаар санхүүжүүлэн, ТТК барилгын компани барьж ашиглалтад өгсөн. Аймгийн ЗДТГ-аас санаачлан Японы Элчин сайдын яамны "Өвсний үндэс-Хүний аюулгүй байдлыг хангах "хөтөлбөртэй хамтран Түмэнцогт сумын хүүхдийн цэцэрлэгийн иж бүрэн их засварыг хийж ашиглалтад оруулсан. Төсөөс санхүүжсэн хөрөнгийн хэмжээ 265,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн. Шинээр баригдаж байгаа 2 сургууль, 5 цэцэрлэгийг ашиглалтад оруулж, 3 сургууль, 2 цэцэрлэгт их засварын ажлыг хийж дуусган, Нийт 18 барилгын 13 -г ашиглалтад оруулж 72.2 % гүйцэтгэлтэй биелэгдсэн.
		15.3.2	Сургуулийн өмнөх боловсрол	Сургуулийн өмнөх боловсролд 5 настай хүүхдийг бүрэн хамруулах, хувилбарт сургалт, гэр бүлийн орчинд сургуулийн өмнөх боловсролд хамруулах үйл ажиллагааг дэмжих, бага насны хүүхэдтэйгээ ажиллах мэдлэг чадварыг эцэг, эхчүүдэд олгох ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж,	96%			2020-2021 оны хичээлийн жилд 1570 таван настай хүүхэд байгаагаас 1496 буюу 98,7 хувь нь СӨБ-д хамрагдаад байна. Хөдөөгийн малчдын болон цэцэрлэгт хамрагдах боломжгүй 5 настай хүүхдийг гэр бүлийнх нь орчинд сургуульд бэлтгэх хөтөлбөрийг хэрэгжүүлж 2019-2020 оны хичээлийн жилд 119 хүүхдийг хамруулсан. 2020-2021 оны хичээлийн жилд 5 настай 91 хүүхдэд хувилбарт сургалтаар сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ үзүүлж гэр бүлийн орчинд хөгжлийг дэмжих ном тогтоомын багц хүргэж ажиллаж байна. Хорио цэцэрлэгийн дэглэм тогтоож сургалтын үйл ажиллагааг зогсоосонтой холбогдуулж ирэх намар сургуульд элсэн орох 5 настай хүүхдүүдэд 340 ширхэг "Ном тогтоомын багц"-ыг теле хичээлээр үзэх боломжгүй хувилбарт бүлгийн 119 хүүхэд, цэцэрлэгийн үндсэн бүлгийн 314 хүүхдэд ээлжээр өгч гэр бүлийн орчинд хүүхэд хөгжүүлэх сургалтыг зохион байгуулахад эцэг эхэд дэмжлэг өгч ажилласан. Сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн Теле хичээлийн үзэлт 78,7 % байна. Багш багш нар хүүхэд, эцэг эх, асран хамгаалчдад цахимаар заавар зөвлөгөө өгч, цаасан хэлбэрээр 2484 дасгал даалгавар, 99 хичээл цахим хичээл бэлтгэн хүргэсэн. Мөнхааан, Сүхбаатар сумдын цэцэрлэг Теле хичээлээ үзэх боломжгүй зорилтот өрхийн хүүхдүүдэд хичээлийг DVD, болон мемори карт дээр суулган түүнийг унших нэмэлт төхөөрөмжөөр баяжуулан гэр бүлийн орчин хүүхэд хөгжүүлэх ном тогтоомын багцыг хүргэсэн.
		15.3.3	Ерөнхий боловсрол	Эрүүл аюулгүй , эрсдэлгүй орчин бүрдүүлж, тэгш, хүртээмжтэй, чанартай үр дүнд суурилсан боловсролын үйлчилгээг үзүүлэх боловсролын чанар, хүртээмж, өрсөлдөх чадварыг сайжруулах, насан туршийн боловсролын тогтолцоог бүрдүүлэх,	90%	20,244.8	19,255.5	2020-2021 оны хичээлийн жилд Ерөнхий боловсролын 16 сургуульд нийт 12866 сурагчдад анхаарч стандартын дагуу боловсролд 6929 сурагчдыг сурагчдаж байна. Нийт сурагчдын тоо өмнөх оноос 569 -өөр өссөн.Бага боловсролын хамран сургалт 97,9 хувьд хүрч ,өмнөх оноос 2.0 %-иар ахисан. 6 настны хамран сургалт 95,8 %- д хүрсэн. Нийт сургуулиудын 12.5% нь биеийн тамирын талбайтай. Сургуулиуд сурагчдын аюулгүй байдалд анхаарч стандартын дагуу биеийн тамирын болон тоглоомын талбайг тохижуулан, ногоон орчныг бий болгон ажиллаж байна. Сургуулийн хүүхдийг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор сургуулийн нийт 12866 эцэг эх асран хамгаалагч нартай гэрээ байгуулан гэрээний хэрэгжилтэд сургуулийн нийгмийн ажилтнууд байнга хяналт тавин ажиллалаа. Орчны аюулгүй байдлыг бүрэн хангахтай холбогдуулан 14 сургууль, 24 цэцэрлэг камержуулалтын тоог 213-аар, 9 сургууль, 14 цэцэрлэг гадна, дотор орчны гэрэлтүүлгийн тоог 93-р нэмэгдүүлж 5 сургууль, 7 цэцэрлэг өөрсдийн нөөц бололцоог ашиглан авто машины зогсоолыг шинэчлэн хийж, тэмдэг тэмдэглэгээг нэмэгдүүлсэн байна. 2020-2021 оны хичээлийн жилд Дүйцсэн хөтөлбөрөөр боловсрол нөхөн эзэмшсэн 219 суралцагчаас бага боловсролд 54, суурь боловсролд 165, үүнээс төгсөх ангийн 32 суралцагч байна. Хөгжлийн бэрхшээлтэй нийт 74 иргэн, түүнээс сургуулийн насны 38 хүүхдийг хамруулан сургаж байна. Улсын чанартай олимпиад уралдаан тэмцээнд өндөр амжилт гаргасан 18 багш , 3 сурагч, 9 анги хамт олныг журамд заасан болзлын дагуу 4070000 төгрөгийн шагнал олголоо. Хэрэгжилт 10%

№	Төсвийн ерөнхийлөн захирагч. түүний хэрэгжүүлэх хөтөлбөр. хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар. танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт. бодлогын зорилтын хэрэгжилт. түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт. хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт. тасарсан бол шалтгаан/
				Суралцагчийн авьяасыг нээн хөгжүүлэх секц, дугуйлан хичээллүүлэх тэдгээрийн тогтвортой байдлыг хангана.	100%			2019 - 2020 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 16 сургууль, 24 цэцэрлэгт хичээллэж буй хараа, орон зай, Хэл, өгүүлэхүйн, Хөдөлгөөн, тэнцвэр, Хэмнэл, сонсгол, Логик, харилцааны мэдрэмжид суурилсан авьяас сэтгэхүйг хөгжүүлэх 5 чиглэлийн 395 төрлийн секц дугуйлан клубт нийт 41 иргэн, 395 багш дугуйлан секц удирдан ажиллуулж эхэлсэн. Мөн хүүхдийн өөрөө удирдлагын байгуллагын 89 клуб, хүүхэд дугуйлан секц клубийг удирдан ажиллуулж байна. Тус хүүхдийн өөрөө удирдлагын байгуллагад 1528 хүүхэд хамрагдаж авьяас чадвараа хөгжүүлж байна. Аймгийн хэмжээнд сургуулиас гадуур иргэдийн хичээллүүлж буй Соробан сампин, спортын бужиг, спорт өрөлт, монгол бичиг, англи хэл, төгөлдөр хуур, морин хуур, шатар, гитар, дуу бүжгийн 12 төрлийн дугуйлан, секц, сургалтын төвд нийт 424 хүүхэд хамрагдан суралцаж байсан бөгөөд коронавирус (COVID 19)-ийн халдвараас шалтгаалж, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан сургалтын болон дугуйлан секцийн үйл ажиллагааг түр зогссон.
				Ерөнхий боловсролын сургуулийн удирдах ажилтныг хууль дүрмийн дагуу сонгон шалгаруулж, мэргэжлийн багшаар бүрэн хангах	100%			ЕБС-ийн нийт 1103 багш, ажилтан албан хаагч ажиллаж байгаагаас 633 бүюу 57.3 хувийг үндсэн багш эзэлж байна. Тухайн хичээлийн жилд анги, бүлэг сурагчийн тоо нэмэгдсэнтэй холбоотой бага ангийн 15, монгол хэл, уран зохиолын 6, гадаад хэл 4, математик 2, физик 1 биология 1 нийгмийн ухаан 2, биеийн тамир 3, дуу хөгжим 3, технологи 6 нийт 45 багш шинэлэг ажилд орсон байна. БСУГ-ын Мэдээллийн технологийн ажилтан, Математик- Физикийн мэргэжилтнүүд өөрсдийн хүсэлтээр ажлаасаа чөлөөлөгдсөн тул ажлын байрны захиалгыг төрийн албаны зөвлөлд хүргэсэн.Төрийн аудитын дүгнэлтийг үндэслэн Баруун-Урт мын 2, 3, 5, 6, 7, 9 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч нарын ажлын байрыг сольж ажиллуулж байна.
		15.3.3.1	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ	Алслагдсан нутгийн иргэдэд Явуулын амбулаторийн үйлчилгээ үзүүлж зорилтот бүлгийн хүн амыг ХДХВ/ДОХ, БЗДХ, сүрьеэг илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж эрүүлжүүлэх	65%	5,214.4	5,060.6	Түмэнцогт, Уулбаян, Эрдэнэцагаан, Асгат Түвшинширээ, Мөнххаан, Сүхбаатар, сумдад 6-8 төрлийн нарийн мэргэжлийн эмч нарын баг ажиллаж 16617 иргэдэд үзлэг хийн дээрх сумдын нөхөн үржихүйн насны 9038 хүнийг ХДХВ /ДОХ/ БЗДХ, Сүрьеэг илрүүлэх үзлэг шинжилгээнд хамруулсан нь зорилтот бүлгийн хүн амын 65.3 хувийг эзэлж байна. Санхүүжилт -28,5 сая төгрөг. Сүрьеэгийн эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгийг өөрийн орон нутагт зохион байгуулж үзлэг, шинжилгээ хийх зорилгоор орон нутгийн 50 сая, улсын төсвийн 99 сая төгрөгөөр зөөврийн дижитал рентген аппаратаар хангалаа. Мөн аймгийн Нэгдсэн эмнэлэгт Genexpert аппаратаар оношилгоо шинжилгээг цаг алдалгүй хийж илэрсэн өвчлөлийг эрүүлжүүлэх, эмчилгээнд хамруулан ажиллаж байна. Сүрьеэгийн өвчлөл 10000 хүн амд 6.4 бүюу өнгөрсөн оны мөн үеийнхээс 0.4-өөр буурсан үзүүлэлттэй байна.
		15.3.3.2		Хүн амын дунд зонхилон тохиолдож буй элэг, хөх, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг үзлэгийг өмнөх тоон үзүүлэлтээс 10-15 хувиар нэмэгдүүлэх	86%			Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/420 "Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг шинжилгээ" тушаалын дагуу томилогдсон анхан шатны эрүүл мэндийн 15 байгууллагад эрт илрүүлэг үзлэгийг хянах, үйл ажиллагааг эрчимжүүлэх багийг арга зүйгээр ханган ажиллаж ХБӨ-ийн эрт илрүүлэг үзлэг өмнөх оноос 10 хувиар өссөн үзүүлэлттэй байна . Эрт илрүүлэг үзлэг артерийн гипертензи-84,6% чихрийн шижин -82,2% хөхний үзлэг-91,8% , умайн хүзүүний эсийн шинжилгээ -85,6% -тай байна .Артерийн гипертензи өвчнөөр батлагдсан 212, чихрийн шижин -10, хөхний үзлэгээр өөрчлөлттэй- 151 умайн хүзүүний эсийн шинжилгээгээр өөрчлөлттэй -9 тус тус хяналтад авч эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулж байна. Хорт хавдрын шинэ тохиолдлын 61.7% нь эрэгтэй, 38,3% эмэгтэй , шинэ тохиолдлын 36,6 хувь нь I, II үе, 63,4 хувь нь III, IV үе шатандаа оношлогдсон байна.
		15.3.3.3		Алслагдсан сум багийн иргэдийн эрүүл мэндийн эрэлт, хэрэгцээг үндэслэн сум, өрхийн эрүүл мэндийн төвийн жигд тасралтгүй үйл ажиллагаг хангах, тусламж үйлчилгээ үзүүлэхэд нэн шаардлагатай тоног төхөөрөмж, эм эмнэлгийн хэрэгсэл, багаж, шатахуун тослох материал, сэлбэгийг улс, орон нутгийн хөгжлийн сангаас шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллана.	100%			Улсын төсвийн 430,7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар АНЭ-т суурин Рентген аппарат /256,3 сая/, Зөөврийн Рентген аппарат /99,9 сая/, Амьсгалын аппарат /34,9 сая/, Онгон суманд Унтуулгын аппарат /39,6 сая/, аймгийн ЗДТГ-50,0 сая, АНЭ-28,0 сая, ЭМГ-0,5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Зөөврийн Рентген аппараттай болсон. МУ-ын Засгийн газар, ХБНГУ-ын сэргээн босголт, зээлийн банкны "Байгалийн олон янз байдлыг хамгаалах уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох төсөл"-ийн 40,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Эрдэнэцагаан сумын ЭМТөв Түргэн тусламжийн иж бүрэн тоноглогдсон Фургон авто машин, сум орон нутгийн төсвийн 160,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд багаж тоног төхөөрөмжийн хангалт хийгдсэн байна.
		15.3.4	Газрын харилцаа, кадастр	Газар зохион байгуулалтын системд сумдын 2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг нэвтрүүлэх, газрын мониторингийн цахим системийг нэвтрүүлэх	100%	434.4	422.0	ГЗБГЗЗГ-ын даргын 2020 оны А/40, А/45, А/46 дугаар тушаалаар газар зохион байгуулалтын цахим системийг нэвтрүүлж, хэрэглэгчийн эрх олгон, газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем ажиллуулах журмыг батлсан.Үүний хүрээнд аймгийн хэмжээнд систем нэвтрэн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.13 сумыг уг системд бүрэн оруулсан.2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх үүднээс дуудлага худалдаагаар олгогдох 13 сумын 80 байршилд 50.2 га газарт эрх зүй харилцаа үүсэж дуудлага худалдаа болон ззэмших, өмчлөх эрх үүссэн. ГХГЗЗГ-ын 2015 оны А/105 тоот тушаалын дагуу бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг орон нутагт зохион байгуулах үүднээс Газрын албаны даргын А/34 дугаар тушаалаар комисс томилж удирдамж хөтөлбөр боловсруулан газрын даамлуудын болзолт уралдаан зарлаж ажлыг идэвхжүүлсэн. 2020 онд бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлын хүрээнд 253 цэгт судалгааны ажил хийж хугацаанд нь гүйцэтгэн ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн.
		15.3.5	Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ	Холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, Гэр бүл хүүхэд залуучуудад төрийн үйлчилгээг чанартай хүргэх, тэдний оролцоог нэмэгдүүлэх, хөгжих эрхийг хангах, хүндэлж ээлтэй үйлчилгээг бий болгох	91%	324.9	324.1	Тус газар нь Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд, хамгаллын тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Залуучуудын хөгжлийн тухай хууль болон бусад хууль эрхийн актыг мөрдлөг болгон Гэр бүл,хүүхэд, залуучуудад төрийн үйлчилгээг хуулийн хүрээнд шуурхай, чанартай үзүүлж, тэдний оролцох, хамгаалуулах, хөгжих эрхийг хангаж, хүндэлж ээлтэй орон нутгийг хөгжүүлэх зорилтын хүрээнд 2020 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг бодлогын баримт бичигт тусгагдсан зорилтын хүрээнд 3 зорилт, 11 арга хэмжээ, төрийн үйлчилгээний чанар хүртэхэжийг сайжруулах 3 зорилт, 3 арга хэмжээ, хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх 6 зорилт, 6 арга хэмжээ, хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх 7 зорилт, 20 арга хэмжээ , нийт 22 зорилт 40 арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж, төлөвлөгөөний гүйцэтгэл 91.3 хувьтай байна.
16	**СЭЛЭНГЭ**					**104,550.6**	**91,576.6**	
	16.1	**Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа**				**2,021.4**	**1,870.4**	
		16.1.1	Монгол Улсын хуулиудад болон журамд заасан ИТХ-ын чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлж, аймгийн хөгжлийн бодлого чиглэлийг тодорхойлсон тогтоол шийдвэрийн төслийг хэлэлцэх	5 доошгүй удаа хуралдаан хийгдсэн байна	Аймгийн ИТХ нь 2020 онд 6 удаа, ИТХ-ын тэргүүлэгчид 13 удаа хуралдсан байна.	1,790.8	1,663.5	Аймгийн ИТХ нь 2020 онд 6 удаа, ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдааныг эдийн засаг, нийгмийн 56 асуудал, төсөв санхүүгийн үйл ажиллагаа, гүйцэтгэл 11, Байгаль орчныг хамгаалах 9, Хүн амын эрүүл мэнд, боловсрол, соёл, биеийн тамир, нийгмийн дэг журмыг хангуулах чиглэлээр 25, Орон нутгийн өмч, хөрөнгөтэй холбоотой 10 гаруй асуудал хэлэлцсэн. Төлөвлөгөөний хэрэгжилт 79.1 хувийн гүйцэтгэлтэй байлаа.
		16.1.2	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуулийн дагуу сурталчлан таниулах ажлыг тогтмолжуулж, гэмт хэргийн тоог бууруулна.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуулийн дагуу сурталчлан таниулах ажлыг тогтмолжуулж, гэмт хэргийн тоог бууруулна.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуулийн хэрэгжилтийг хангуулан гэмт хэргийн тоо өмнөх оноос 218 хэргээр буюу 28.4 хувиар буурсан.	228.1	204.4	Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс өгсөн ажлын чиглэл, удирдамжийн дагуу аймгийн хэмжээнд хийж гүйцэтгэх 5 бүлэг 47 заалт бүхий төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллалаа. 2020 онд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нийт 80 удаагийн 158 минутын мэдээ мэдээлэл бэлтгэн 215 удаагийн давтамжтайгаар нэвтрүүлж олон нийтийн цахим сүлжээ болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээн ажиллалаа. Хүүхэд эмэгтэйчүүдийг гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Сүүдэр бүү тусга, Хайр өөтгөдөггүй, Яг одоо хүчирхийллийг цэглэх зэрэг нөлөөлийн арга хэмжээний хүрээнд 12 сум, 4 тосгоны цэцэрлэгийн ахлах бүлгийн 916 хүүхэд ЕБС-ийн 2640 сурагчдад танхимын сургалтыг зохион байгуулж, 11 удаагийн онлайн сургалтаар дамжуулан 1097 иргэд гэр бүлийн боловсрол олгох үйл ажиллагааг зохион байгуулж 68 иргэнд сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээг үзүүлсэн. Гэмт хэрэг гаралтын тоо өмнөх оныхоос 218 хэргээр буюу 28.4 хувиар буурсан. Төлөвлөгөөний хэрэгжилт 58.4 хувийн хэрэгжилттэй байлаа. Төлөвлөгөөнд тусгагдсан томоохон сургалт, зөвлөгөөн Ковид-19 цар тахалтай холбоотойгоор тарсан байна.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч. түүний хэрэгжүүлэх хөтөлбөр. хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар. танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт. бодлогын зорилтын хэрэгжилт. түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт. хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт. тасарсан бол шалтгаан/
		16.1.3	ЦАУЗБСК-ийн үйл ажиллагаа	Шийдвэрийг үндэслэн нөхөн олговрыг олгох	34 хүний 1683.0 сая төгрөгийн нөхөх олговрыг олголоо.	-		Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах аймгийн салбар комиссоос энэ онд "Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хууль", мөн хуулийн нэмэлт өөрчлөлтийг сурталчлах, хэрэгжүүлэх, хэлмэгдэгчдийн дурсгалыг хүндэтгэх өдрийг тэмдэглэх ажлыг орон нутагт бэлтгэлийг ханган зохион байгуулахад ажлаа чиглүүллээ. Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Сэлэнгэ аймгийн салбар комисст "Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хууль"-д нэмэлт өөрчлөлт орж хэрэгжиж эхэлснээс хойш 2020 онд 34 иргэнд 1.683.0 мянган төгрөгийн нөхөх олговрыг олгуулан ажиллалаа. Мөн онд нөхөх олговор олгох тухай шүүхийн шийдвэр нь гарч хүлээгдэж байгаа 23 иргэний 980.0 сая төгрөгийн нөхөх олговрыг олгуулахаар Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комисст баримт материалыг хүргүүлэн хүлээгдэж байна.
		16.1.4	Аймгийн ИТХ-ын хяналт шалгалтын ажил	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт явуулах	Аймгийн ИТХ-ын тогтоол шийдвэрийн хэрэгжилт, аймаг сумдын Засаг дарын 2016-2020 оны үйл ажиллагааны хэрэгжилтийн талаар газар дээр нь танилцахаар 5 суманд ажиллалаа.	2.5	2.5	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Сүхбаатар, Алтанбулаг, Зүүнбүрэн, Хүдэр, Ерөө суманд ажиллаж сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажилтай газар дээр нь танилцаж заавар зөвлөгөө өгч, зарим сумдад хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг гаргуулан ажиллалаа. Архидан согтуурахтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх, аймгийн Засаг дарын баталсан "Архидан согтуурахтай тэмцэх ажлын төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Стандартчилал хэмжил зүйн төв зэрэг байгуулагуудтай хамтран 2020 оны 03 дугаар сард Сүхбаатар, Зүүнбүрэн, Цагааннуур, Мандал, Сайхан сумдад тус бүр 2 удаа хамтарсан хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж үр дүнг тооцлоо.
	16.2	**Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага**				**32,818.2**	**25,480.9**	
		16.2.1	Аймгийн эдийн засгийн, нийгмийн чадавхыг бэхжүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд, шударга, шуурхай хүргэж ил тод байдалд шинэчлэл хийж, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн үнэлэмжийг дээшлүүлнэ	Төрийн үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамж дээшилнэ.	2020 онд эдийн Засаг нийгмийн хөгжлийн шалгуур үзүүлэлт тус бүр дээр анхаарал хандуулж, тусгай төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж, өөрөг үзүүлэлттэй болгож, зорилтот түвшинд хүргэхийг зорин ажилласан. 2020 онд эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлт 4.3 оноо буюу 86,7 хувь байна.	14,584.7	12,530.1	2020 оны жилийн эцсийн байдлаар Сэлэнгэ аймаг хамааралтай хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 98.5 хувьтай байна. Тайлант онд аймгийн Засаг даргаас 439 захирамж, 2 албан даалгавар, Засаг дарын Тамгын газрын дарын 268 тушаалыг гаргасан бөгөөд эдгээрээс зохион байгуулалтын шинжтэй 480 гаруй шийдвэрийг гарган хэрэгжилтийг зохион байгуулан ажиллалаа. Сэлэнгэ аймгийн Засаг дарын Тамгын газар, 17 сумдын Засаг дарын Тамгын газар, аймгийн Засаг дарын эрхлэх асуудлын хүрээний 24 газар, хэлтэс, агентлаг, албан тушаалтанд 2020 онд аймгийн хэмжээнд нийт 4798 иргэн хандаж санал, хүсэлт, өргөдөл, гомдол гаргаснаас 4483 иргэний өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариу өгсөн нь 93.4 хувийн үзүүлэлттэй байна. Иргэдээс төрийн байгуллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын тоо 2020 онд 4798 буюу өмнөх оноос 19 хувь буурсан үзүүлэлттэй байна. Ухаалаг утсанд зориулсан "Нээлттэй Сэлэнгэ" аппликэйшнд аймгийн Засаг дарын Тамгын газар, Засаг дарын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудаас үзүүлэх төрийн үйлчилгээний төрөл, бүрдүүлэх баримт бичиг, төлбөр хураамжийн талаарх мэдээллийг багтаасан "Танд үйлчилье" хэсгийг бий болгож, аймгийн цахим хуудсанд байршуулж буй мэдээ мэдээллүүд давхар байршин иргэдэд хүрч байна.
		16.2.2	Байгалийн гамшиг үр дагаврыг арилгах, халдварт өвчин түүний тархалтыг зогсооно. Иргэд олон нийтийн өргөдөл, хүсэлтийн дагуу тусламж дэмжлэг үзүүлнэ. Спорт, урлагийн амжилтыг урамшуулна.	Нөөц хөрөнгө журмын дагуу төлөвлөгдсөн зардалд зохистой зарцуулагдана	2020 онд аймгийн Засаг дарын 74 захирамжаар 374.8 сая төгрөгийн зардлыг нөөц хөрөнгөөс зарцуулсан байна.	1,434.3	1,005.6	Тайлант онд Ковид-19 /коронавируст халдвар/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, тархалтыг хумих зорилгоор 199.1 сая төгрөгийг зарцуулсан байна. Иргэдээс гаргасан өргөдлийн дагуу аймгийн Засаг даргаас 35 иргэн, аж ахуйн нэгжид нийт 26.1 сая төгрөгийн тусламж дэмжлэг, гал түймрийн болон үерийн аюулд өртсөн иргэдээс гаргасан хүсэлтийн дагуу 2 иргэнд гэр олгож, 6.0 сая төгрөг зарцуулсан. Нийгмийн хариуцлагынхаа хүрээнд 1 аж ахуйн нэгж 3 иргэнд гэр олгосон. Мөн аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж байгаа томоохон арга хэмжээний зардал, улс, тив, дэлхийн спорт урлагийн тэмцээнд оролцох тамирчид, соёлын ажилтан нарт шаардлагатай зардлуудыг олгож ажилласан.
		16.2.3	Байгаль орчны чиглэлийн гэмт хэргийг арилгах, ойн нөхөн сэргээлтийг чанартай гүйцэтгэж, хортон шавжтай тэмцэх ажлыг эрчимжүүлнэ. Иргэдийн байгаль орчинтой холбогдох мэдээллийг дэлгэрүүлнэ	Ойжуулалтын хэмжээ нэмэгдэнэ	Байгаль орчны чиглэлийн гэмт хэргийг бууруулж, ойн нөхөн сэргээлтийг чанартай гүйцэтгэж, хортон шавжтай тэмцэх ажлыг эрчимжүүллээ.	578.4	576.6	Аймгийн хэмжээнд 2020 оны байдлаар 166 ойн нөхөрлөл нийт 456,865 га талбай ойн санг гэрээгээр эзэмшин ойг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. 2020 оны байдлаар 120 ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөл ойн менежмент төлөвлөгөөтэй ба төлөвлөгөөнд тусгагдсан ойн аж ахуйн арга хэмжээг явуулж байна.
		16.2.4	Мал эмнэлгийн үйлчилгээний хөлсийг үйлчилгээний чанар, хүртээмж малын халдварт өвчний статистик бүртгэлд үндэслэн олгоно.	Мал эмнэлгийн үйлчилгээ сайжирна	45 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид 319.2 сая төгрөгийн санхүүжилтийг олголоо.	319.5	319.2	2020 онд аймгийн нийт малын тоо 1818.5 мянган толгой болж урьд оноос 136.0 мянган толгойгоор өссөн байна. Сэлэнгэ аймаг нь эрчимжсэн мал аж ахуйг газар тариалантай хослуулан эрхлэх стратегийн бүс нутаг болох асуудлыг холбогдох байгууллагуудад уламжилснаар Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 131 тоот тогтоолоор Сэлэнгэ аймгийн 44 багийг "Тариалангийн бүс нутаг" болгон зарлаж, малын тоонд биш ашиг шимд анхаараан эрчимжүүлэх бодлогыг барин ажиллаж байна. Мал эмнэлгийн 45 нэгж нь хуваарийн дагуу 6 төрлийн вакцин, тарилга, шинжилгээ, үйлчилгээг бүрэн хийж гүйцэтгэсэн.
		16.2.5	Замын сан	Зам засварын ажил болон шинээр зам барих ажлыг хийж гүйцэтгэнэ.	Сумдын зам засварын ажилд 762.2 сая төгрөгийг зарцуулсан.	794.4	762.2	Баянгол, Орхон, Сүхбаатар, Хүдэр, Мандал сумдын зам засварын ажлыг 108,7 сая төгрөгөөр, Сүхбаатар суманд хатуу хучилттай зам тавих ажлыг 213,2 сая төгрөгөөр, Ерөө, Жавхлант сумдын авто замын тэмдэг, тэмдэглэгээ тавих ажлыг 38,1 сая төгрөгөөр хийж замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулан ажиллалаа. Мандал сумын хайрган хучилттай зам засварын ажлыг 50,0 сая төгрөгөөр, Алтанбулаг сумын зам засвар, тэмдэг тэмдэглэгээ хийх ажлыг 18,3 сая төгрөгөөр, Баянгол суманд олон улсын авто замын доогуур бохир ус зайлуулах шугам байгуулах ажлыг 80,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалттай хийж 80-90 хувийн гүйцэтгэлтэй байна. Хушаат сумын зам засварын ажлыг 20,0 сая төгрөгөөр 50 хувийн гүйцэтгэлтэй, Мандал сумын Хэрх, Түнхэл тосгонд хатуу хучилттай зам тавих ажлыг 598,6 сая төгрөгөөр, Зүүнбүрэн суманд сайжруулсан хайрган зам тавих ажлыг 20,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалттай хийж ажлын гүйцэтгэл 50 хувьтай байна.
		16.2.6	Хот тохижилт, үйлчилгээний үйл ажиллагаа	Орчны бохирдлыг бууруулсан байна.	Сүхбаатар , Сайхан, Мандал сумдад ОНХС-аас 141.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон.	1,121.5	1,050.7	Хот тохижилтын газрыг өмчийн хэлбэрийг өөрчлөн ОНӨААТҮГ болгон ажиллуулж байгаа. ОНХС-аас хур хог хаягдал, орчны бохирдлыг цэвэрлэх, төвлөрсөн хогийн цэгийн устгалын арга хэмжээний зардлыг Сүхбаатар суманд 25.2, Мандал суманд 77.3, Сайхан суманд 38.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгож ажиллалаа.
		16.2.7	Сүхбаатар сумын гудамжны гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, гэрэлтүүлгийн асаах цагийн хуваарийг чанд мөрдүүлж, иргэд олон нийтийн ая тухтай, аюулгүй орчныг бүрдүүлнэ.	Гэрэлтүүлгийн тоо нэмэгдэнэ	Иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.	118.4	118.4	9 сумдын 2 тосгонд хөл бөмбөг, волейбол, сагсан бөмбөгийн болон хүүхдийн тоглоомын төрөлжсөн талбай байгуулан зарим талбайд гэрэлтүүлгийн ажлыг хийж ашиглалтад оруулаа. Ерөө, Баруунбүрэн, Хүдэр, Сайхан, Сант сумд, Ерөө сумын Бугант тосгоны замын гэрэлтүүлэг хийх ажлуудыг 240,6 сая төгрөгөөр хийж гүйцэтгэж байнгын ашиглалтад хүлээлгэн өглөө. Сүхбаатар сумын байрнуудын гэрэлтүүлгийн ажлыг 170,4 сая төгрөгөөр хийж гүйцэтгэж иргэдийг ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүллээ.
		16.2.8	Аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон ахмадуудын нийтийн тээврээр зорчиход хөнгөлөлт үзүүлнэ.	Нийтийн тээврийн зорчигч хөнгөлөлт эдэлнэ	Сүхбаатар суман дахь хөгжлийн бэрхшээлтэй болон ахмад настнуудын нийтийн тээврээр үнэ төлбөргүй зорчдог.	60.0	60.0	Сүхбаатар суман дахь хөгжлийн бэрхшээлтэй болон ахмад настнуудын нийтийн тээврээр үнэ төлбөргүй зорчдог. Сүхбаатар хөгжил тохижилт ОНӨААТҮГ-т түлш шатахуун, сэлбэг хэрэгсэл, тээврийн хөлсөнд 60.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүллээ.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч. түүний хэрэгжүүлэх хөтөлбөр. хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар. танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт. бодлогын зорилтын хэрэгжилт. түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт. хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт. тасарсан бол шалтгаан/
		16.2.9	Аймгийн орон нутгийн өмчийн газар	Орон нутгийн өмчит байгууллагуудад үйлчилгээ үзүүлнэ. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээг чанартай зохион байгуулна.	"Сэлэнгэ аймгийн төрийн болон орон нутгийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-уудыг батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	161.4	160.5	"Сэлэнгэ аймгийн төрийн болон орон нутгийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-уудыг батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3 дахь хэсэгт заасны дагуу Аймгийн ИТХ-ын Тэрүүлэгчдийн 5 удаагийн хурлаар орон нутгийн өмчит байгууллагуудын илүүдэлтэй ашиглалттүй хөрөнгийн асуудлыг хэлэлцүүлж 10 заалт бүхий 10 тогтоол гаргуулан орон нутгийн өмч хөрөнгийн ашиглалтыг сайжруулж ажилласан. Сүхбаатар сумын 6 дугаар багт байрлах Халуун усны барилга, газар эзэмших эрхийн 000323535 дугаар бүхий гэрчилгээтэй газрын хамт нээлттэй дуудлагын худалдаагаар худалдаж ер төлбөрийг барагдуулахыг зөвшөөрөх тухай тогтоолын төслийг холбогдох хууль журмын дагуу боловсруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн Хурлаар оруулахаар бэлтгэсэн.
		16.2.10	Ахмад настны амралт, чөлөөт цагийн клуб, эмчилгээ, сувилгааны төв, ахмадын байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.	Ахмадын хороодын үйл ажиллагаа сайжирна	Ахмад настнуудын амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн ажиллалаа.	146.1	142.1	Ахмадын 25 хороогоор дамжуулан 8837 ахмад настанд 4 төрлийн арга хэмжээг зохион байгуулсан. Ахмад настны нийгмийн хамгаалал, тэдэнд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Мандал, Сүхбаатар, Баянгол, сумын "Ахмад настны сувилал"-д 2016-2020 оны байдлаар 3282 ахмад настан хүлээн авч амрааж эмийн бус эмчилгээ сувилгааг үзүүлж, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан үйлчилсэн.
		16.2.11	Байгаль орчны газар	Хүрээлэн буй орчны зохистой удирдлага хангагдана.	Сумдын байгаль орчны байцаагч нартай хурдан шуурхай ажиллахыг нөхцөлийг бүрдүүлж, байгаль орчны эсрэг хийгдэх гэмт хэргийн гаралтыг бууруулан ажиллаж байна.	693.9	661.6	Байгаль орчны холбогдох хууль, журмын хэрэгжилтийг ханган ажиллаж, байгалийн тэнцвэрт байдлыг хадгалж, зохистой ашиглах, нөхөн сэргээх боломж бүрдүүлэх зорилгоор сумдын байгаль орчны байцаагч нартай хурдан шуурхай ажиллахыг нөхцөлийг бүрдүүлж, байгаль орчны эсрэг хийгдэх гэмт хэргийн гаралтыг бууруулан ажиллаж байна.
		16.2.12	Сум дундын ойн анги	Ойн санг зориулалтын дагуу ашиглаж, нөхөн сэргээж, хамгаалсан байна.	Ойн нөхөн сэргээлтийг төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэлээ.	324.2	294.0	Ерөө, Мандал, Цагааннуур, Баруунбүрэн, Сүхбаатар сумдын ойн ангиуд нь ойн санг хариуцан ойг нөхөн сэргээх, хамгаалах ашиглах үйл ажиллагаог зохицуулан ажиллаж байна.
		16.2.13	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу аймгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааг ил тодоор зохион байгуулна.	6.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдэнэ.	ОНХО-аар 1.5 тэрбум, ОНХС-аар 3.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэлийг санхүүжүүлж ажиллалаа.	12,119.2	7,516.6	Орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, замын сангийн хөрөнгө оруулалтаар дараах ажлыг хийж гүйцэтгэсэн: Сүхбаатар сумын Улаан загалмайн хорооны байрны засварын ажлыг 29,9 сая төгрөгөөр, Аймгийн засаг даргын Тамгын газрын үүдний засварын ажлыг 28,0 сая төгрөгөөр, багийн болон ерхийн эмнэлгийн байр барих ажлыг 370,1 сая төгрөгөөр, Мандал сумын Засаг даргын Тамгын газрын сантехник засвар, дотор заслын ажлыг 136,8 сая төгрөгөөр, Зүүнбүрэн сумын төрийн үйлчилгээний нэгдсэн төв байгуулах ажлыг 91,0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэж байнгын ашиглалтад хүлээлгэн өгч иргэдийг ая тухтай орчинд төрийн үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүллээ. Баруунбүрэн сумын сургуулийн их засварын ажлыг 67,8 сая төгрөгөөр, Орхонтуул, Түшиг, Сайхан сумын Номгон тосгоны эрүүл мэндийн төвүүдийн хүчитгэлийн ажлыг 103,4 сая төгрөгөөр, Сүхбаатар сумын 4 дүгээр цэцэрлэг, Мандал сумын Түнхэл тосгоны цэцэрлэгийн засварын ажлыг 97,0 сая төгрөгөөр, Мандал сумын хүүхэд залуучуудын соёл спортын цогцолбор төвийн барилгын ажлыг 198,0 сая төгрөгөөр гүйцэтгэлээ. Ерөө, Баруунбүрэн, Хүдэр, Сайхан, Сант сумд, Ерөө сумын Бугант тосгоны замын гэрэлтүүлэг хийх ажлуудыг 240,6 сая төгрөгөөр, спорт цогцолборын хана буулгаж, засварлах ажлыг 67,0 сая төгрөгөөр, Хушаат сумын соёлын төвийн засварыг 94,7 сая төгрөгөөр, Сүхбаатар сумын биет үсгэн хөшөө хийх ажлыг 35,3 сая төгрөгөөр, хүчирхийллийн эсрэг төвийн их засварын ажил 77,3 сая төгрөгөөр, прокурорын барилгын дээвэр, фасад засварын ажлыг 29,2 сая төгрөгөөр, Сүхбаатар сумын орон сууцуудын кодтой хаалга суурилуулах ажлыг 22,5 сая төгрөгөөр, тоглоомын талбай байгуулах ажлыг 43,5 сая төгрөгөөр хийж гүйцэж байнгын ашиглалтад хүлээлгэн өглөө. Түшиг суманд хүүхдийн тоглоомын талбай байгуулах ажлыг 36,0 сая төгрөгөөр, Сайхан сумын Номгон тосгонд цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлыг 128,5 сая төгрөгөөр, Сүхбаатар сумын цэнгэлдэх хүрээлэнгийн засварын ажил 39,9 сая төгрөгөөр, Шаамар сумын Дулаанхаан тосгоны наадмын талбай барих ажлыг 57,2 сая төгрөгөөр, Сүхбаатар сумын байрнуудын гэрэлтүүлгийн ажлыг 170,4 сая төгрөгөөр, Сүхбаатар сумын 8 дугаар багт дулааны шугам тавих ажлыг 30,0 сая төгрөгөөр, Сант сумын цэвэр усны магистрал шугамын засварын ажлыг 153,5 сая төгрөгөөр, Түшиг, Хүдэр сумдын шугам засварын ажлыг 36,7 сая төгрөгөөр, Нутгийн захиргааны 3 дугаар байрны сантехникийн засварыг 104,9 сая төгрөгөөр, Орхон сумын ерөнхий боловсролын сургуулийн цэвэр усны шугамын засварын ажлыг 7 сая төгрөгөөр тус тус хийж гүйцэж иргэдийг ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүллээ. Шаамар сумын партизаны талбайн тохижилтын ажлыг 19,0 сая төгрөгөөр, Шаамар сумын ундны усны худаг гаргах ажлыг 29,3 сая төгрөгөөр гүйцэтгэж байнгын ашиглалтад хүлээлгэн өглөө. Мандал сумын Хэрх тосгоны соёлын төвийн засварын ажлыг 154,0 сая төгрөгөөр хийж 80-90 хувийн гүйцэтгэлтэй байна
		16.2.14	Олон нийтийн оролцоотой үйл ажиллагааг дэмжиж, аймгийн зорилтот бүлгийн айл өрх, иргэдийн амьжиргааг дээшлүүлнэ.	Халамжийн үйлчилгээ зорилтот бүлэгт хүрнэ	"Олон нийтийн оролцоонд тушиглэсэн халамжийн үйлчилгээний ёдрийн үйлчилгээг гүйцэтгүүлж 271 ахмад настныг хамруулсан. Мөн орон гэрээгүй амьжиргааны эх үүсвэрээ алдсан 40 өрхөд дэмжлэг үзүүлсэн	162.2	115.8	ЭБУС ХХК, Бум хараа ХХК, Энэрэлт үйлс ХХК, Хараа Алтан-Од ХХК-уудтай хамтранажиллах гэрээ байгуулан Сэргээн засах үйлчилгээг Сүхбаатар, Мандал суманд зохион байгуулж нийт 271 ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэн хүүхдийг хамрууллаа. Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.1.9-д заасан "Нийгмийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай ерх иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухааны сургах" заалтын дагуу нийт 34 бүлэгт 43.5 сая төгрөгийн санхүүжилтийг олгоод байна. Нийгмийн халамжийн тухай хуулийн 18.1.8-д заасан "Гэр оронгүй иргэн түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах" заалтын хүрээнд нийт 87 иргэнийг Улсын бүртгэлийн хэлтэстэй хамран бичиг баримттай болгон 1.5 сая төгрөгийн санхүүжилтийг олголоо. Мөн гэнэтийн аюул, осол, урьдчилан төсөөлөх боломжгүй бусад шалтгаанаар гэр оронгүй, гэр орон нь цаашид амьдрах боломжгүй болсон болон амьжиргааны эх үүсвэрээ алдсан, хорих ангиас суллагдсан, 18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн нийт 40 иргэнд орон гэртэй болоход нь дэмжлэг үзүүлж 48.0 сая төгрөгийг олголоо
		16.2.15	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төсвийн ил тод байдлыг хангаж, төрийн байгууллагуудын дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулна.	Төсвийн ил тод байдал хангагдана.	Аймаг, сумын ТЕЗахирагч нар нь 2020 онд шилэн дансанд нийт 2683 мэдээлэл байршуулахаас 99%-тай мэдээлэл байршуулсан.	148.3	116.0	Аймаг, сумын төсвийн ерөнхийлөн захирагч 18, аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 10 байгууллага, аймаг, сумын ЗДТГ, ИТХ, сургууль, цэцэрлэг, хүн эмнэлэг, соёлын төв, спорт цогцолбор зэрэг төсвийн 169 байгууллага, орон нутгийн өмчит аж ахуй нэгж, үйлдвэрийн газар 14, ерхийн эмнэлэг 7, мал эмнэлэг 45, хүнсний талоноор үйлчилдэг 41 байгууллага, хувийн цэцэрлэг, сургууль 5, албан журмын даатгагчдын холбоо 1, ахмадын холбоо 1 нийт 311 аж ахуй нэгжүүд хамрагдаж шилэн дансны цахим хуудсанд албан ёсны нэр хаягтай мэдээлэгдсэн. Шилэн дансны цахим санд хийсэн шалгалтад 311 аж ахуй нэгж байгууллага хамрагдаж "Шилэн дансны тухай" хуулийн хэрэгжилт 2020 оны жилийн эцсийн байдлаар 92,1 хувьтай дүгнэгдсэн. Аймгийн албан ёсны цахим хуудасны "Шилэн данс" хэсэгт 2020 онд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө хэсэгт 67, орон нутгийн хөгжлийн сан 47, орон нутгийн хөрөнгө оруулалт 7, авто замын сан 3, аймгийн ЗДТГ гэсэн дэд хэсгүүдэд нийт 124 мэдээллийг тухай бүр шинэчлэн оруулсан. Мөн Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажлын гүйцэтгэлийн мэдээг https://pimis.publicinvestment.gov.mn/#/login цахим хуудсанд байршуулан ажиллаж байна.
		16.2.16	Мал амьтны халдварт өвчний тархаалтыг зогсоох, урьдчилан сэргийлэх арга хэмжээг	Малын халдварт өвчин буурна.	-		-	Мал эмнэлгийн нэгдсэн систем нэвтрүүлэх ажлын тендерийг 2 удаа зарласан боловч компаниудаас огт санал ирээгүй тул тайлант онд хэрэгжээгүй.
		16.2.17	Газар тариалангийн бүс нутгийн хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор үүлэнд зориудаар нөлөөлнө.	Хур тунадасны хэмжээ нэмэгдэнэ	Цаг агаарын төлөв байдалд тогтмол зөдлан шинжилгээ хийж, зориудаар нөлөөлөх нөхцөл бүрдсэн тохиолдол бүрийг зохистой ашиглан ажиллалаа.	30.0	30.0	Аймгийн нутаг дэвсгэр дээр цаг агаарын үзэгдэлд зориудаар нөлөөлж, хур тунадас нэмэгдүүлэх нөхцөл бүрдсэн үед цаг уурын пуужин харвах болон газрын генератор ашиглан утаа үүсгэн хур тунадас нэмэгдүүлж ажиллалаа. "Хур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги төлөвлөгөө" боловсруулан хэрэгжүүлэх, цаг агаарт зориудаар нөлөөлж, хур тунадас нэмэгдүүлэх, мөндөр зайлуулах арга, техникийг судалж, турших ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч. түүний хэрэгжүүлэх хөтөлбөр. хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар. танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт. бодлогын зорилтын хэрэгжилт. түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт. хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт. тасарсан бол шалтгаан/
		16.2.18	Зөөврийн ундны усны үнийн зөрүүний татаасыг ундны усны зөөвөрлөсөн хэмжээ, үйлчилгээний чанар, хэрэглэгчдийн үнэлгээнд үндэслэн олгоно.	Ундны усны хангамж сайжирна	Сэлэнгэ мөрний дагуу байрлах эх үүсвэрийн 5 гүний худагтай, хоногт 10400 м3 ус олборлох хүчин чадалтай.	21.7	21.7	2014 оны 63 тоот тогтоолоор үнэ тарифаа батлуулсан бөгөөд үүнээс хойш өөрчлөлт ороогүй. Сухбаатар сумын 309 үйлдвэр, ААНБ, орон сууцны 2398 айл өрх, гэр хороллын 2520 айл өрхөд ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.
	16.3	**Улсын төсвөөс авах тусгай зориулалтын шилжүүлгээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ**				**69,711.0**	**64,225.3**	
		16.3.1	Сургуулийн өмнөх боловсрол	СӨБ-д 7914 хүүхэд, СӨБ-ын хувилбарт сургалтад 502 хүүхэд хамрагдана	Аймгийн хэмжээнд нийт 39 төрийн болон хувийн хэвшлийн цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байна.	18,874.8	16,662.0	2020-2021 оны хичээлийн жилд 41 цэцэрлэгт 7246 хүүхэд хамрагдсан ба өмнөх оны мөн үеэс 1136 (13.6%) хүүхдээр буурсан байна. Цэцэрлэгийн нэг багшид дунджаар 24 хүүхэд ногдож байна. Цэцэрлэгт 694 багш ажилтан ажиллаж, мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтад 311, орон нутгийн сургалтад 1573, ажлын байран дээрх сургалтад 5000 багш, ажилтан хамрагдаж 5.7 сая төгрөгийг зарцуулсан байна. Гаднаа машины хурд сааруулагч 11 цэцэрлэг, явган хүний гарцтай 12 цэцэрлэг, хөдөлгөөн зохицуулсан тэмдэг тэмдэглэгээг 30 цэцэрлэг хийсэн байна. 2020 оны 01 дүгээр сард Цагааннуур сумын 2 дугаар цэцэрлэгийг шинээр ашиглалтад оруулан ажиллаж байна.
		16.3.2	Ерөнхий боловсрол	Хүүхдэд ая тухтай орчин бүрдүүлж /хоол, байр/ үйлчилнэ.	Аймгийн хэмжээнд нийт 35 төрийн болон хувийн өмчийн сургууль сургалтын чанар ур дүнг дээшлүүлж, сурч боловсрох орчныг сайжруулан, чанартай хоолоор үйлчилж, дотуур байрны үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.	34,766.5	32,043.3	2020-2021 оны хичээлийн жилд 35 сургуульд 21182 сурагчид суралцаж байгаа ба 1098 үндсэн багш ажиллаж байна. 2347 хүүхэд шинээр 1 дүгээр ангид элсэн орж, албан бус сургалтад нийт 332 сурагч суралцаж байна. Хичээлийн жилд 1249 хүүхэд дотуур байранд амьдарч байгаа нь өмнөх оны мөн үеэс 21 (1.7%)-ээр буурсан байна. Удийн цай хөтөлбөрт 986.4 сая төгрөгийн зардал зарцуулсан нь өмнөх оны мөн үеэс 90.4 (10.1%) сая төгрөгөөр өссөн бөгөөд сургууль, цэцэрлэгийн тогооч нарын сургалтад бүрэн хамрууллаа. 2020-2021 оны хичээлийн жилд дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас 9020 сурагч буюу 42.5% дугуйлан, сонгонд хамрагдсан ба шинээр 101 дугуйлан шинээр нээгдсэн бол 338 багш, 45 иргэн, мэргэшсэн байгуллага хамтран хичээлүүлсэн. Ерөнхий боловсролын сургуулийн номын сангаас номтой нөхөрлүүлэх 164 арга хэмжээ зохион байгуулж, 13158 сурагчийг хамруулсан байна. Аймгийн нийт сургуулийн сурагчдын 19896 буюу 93,2 хувь нь эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байна.
		16.3.3	Соёлын үйлчилгээ	Урлаг соёл, музей, номын сангаар үйлчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлнэ.	Аймгийн хэмжээнд сумын соёлын төв, Сэлэнгийн долгио болон Мөнгөн хараа чуулга, аймаг болон Мандал сумын номын сан, аймгийн Музей зэрэг нийт 25 соёлын байгууллагаар дамжуулан урлаг соёлын арга хэмжээг зохион байгуулж, иргэд олон нийтэд түгээн ажиллаж байна.	4,701.9	4,467.5	Өндөржүүлсэн бэлэн байдлын үед аймгийн Нэгдсэн музей уран зургийн сан хөмрөгөөс 60 ширхэг уран зургийн үзэсгэлэнг цахимаар гаргаж иргэдийн түүх соёл, танин мэдэхүйн мэдлэгийг дээшлүүллээ. Аймгийн хэмжээнд 32478 иргэд, соёлын биет бус өв тээгчдийг хамруулан шаардлагатай мэдээ, мэдээлэл, гарын авлагаар ханган ажиллалаа. Алслагдсан багийн иргэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон улирлын амралтаар амарч буй сурагчдад зөөврийн номын сангийн үйлчилгээг “Ном унших аян”, “Номын бөгц”, “Үүргэвчтэй уншлага” зэргээр зохион байгуулж, идэвхтэн уншигчдыг шалгаруулан урамшуулж, 469 удаагийн соёл, олон нийтийн ажил, арга хэмжээ зохион байгуулж 26838 уншигчдыг хамрууллаа. “Соёл урлаг-хүний хөгжилд” хөтөлбөрийг боловсруулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 141 тоот тогтоолоор батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна
		19.2.12	Орон нутгийн ахмад настанд үйлчлэх кабинет төв	Ахмадуудад зориулсан үйл ажиллагааг дэмжинэ.	100%	63.2	63.2	Ахмадуудад зориулсан үйл ажиллагааг дэмжиж ажилласан.
		19.2.13	Байгаль орчны газар	Байгаль орчны хамгаалан, нөхөн сэргээх, зохистой ашиглах, байгаль хамгаалалд иргэдийн оролцоо хяналтыг нэмэгдүүлэх	100%	457.4	457.3	Тогтвортой хөгжлийн боловсрол үндэсний хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хотод зохион байгуулсан сургагч багш бэлтгэх сургалтад нийт 19 багш хамрагдсан бөгөөд Тогтвортой хөгжлийн боловсрол теслийн багтай хамтран аймгийн зарим сургуулийн сурагч, багш, удирдлага, ажилчин, эцэг эх зэрэг нийт 120 хүнд тогтвортой хөгжлийн төлөөх загвар сургуулийн зарчим үзэл баримтлал талаар мэдлэг ойлголт өглөө. Мөн 10 ширхэг багц гарын авлагыг 140 хүнд тараасан бөгөөд Тогтвортой хөгжлийн боловсролын гарын авлага болон зөвлөмжтэй болсон нь цаашид сургалтын үйл ажиллагааг явуулах нөхцөл боломж бүрдэж байна.
		19.2.14	Сум дундын ойн анги	Үндэсний мод тарих өдрийг 5, 10 дугаар саруудад зохион байгуулах, Мод үржүүлгийн талбайд тарьц суулгацын нөөцийг бий болгоно	100%	53.1	53.1	Ойн тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн "Мод тарих үндэсний өдөр зарлах тухай" 2010 оны 63 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор 2020 оны бүх нийтээр мод тарих өдрийг 5 сарын 09, 10 сарын 10-нд тэмдэглэн өнөөрүүллээ. Хавар, намрын бүх нийтээр мод тарих өдрөөр аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 189 аж ахуйн нэгж, байгуллагын 5867 иргэн 61677 ширхэг мод, бут сөөг тарьсан. Уг үйл ажиллагаанд багш сурагчид идэвх санаачилгатай оролцлоо. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, ажилтан, ажиллагсад, хүүхдүүдэд амьдралын хэв маяг, зөв хандлагыг төлөвшүүлэх, сурагчдын танхимын сургалтаар зэзмшсэн мэдлэг, чадвараг амьдралд хэрэгжүүлж, зөв амьдрах арга ухааны сургах, санаачилгыг дэмжих, ая тухтай, цэвэр цэмцгэр, эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор "Хоггүй орчин–Ногоон ирээдүй" аяныг амжилттай өрнүүллээ. Мөнххайрхан сумын ерөнхий боловсролын сургууль болон Жаргалант сумын 2 дугаар сургуулиуд эко сургуулийн сүлжээнд хамрагдаж Тогтвортой хөгжлийн боловсрол төсөлд хамрагдаад байна.
		19.2.15	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулах, хэрэгжилтийг хангуулах	81%	1,132.0	915.9	Энэ оны аймгийн төсөвт батлагдсан орон нутгийн хөрөнгө оруулалтын 30 төсөл, арга хэмжээнд төлөвлөсөн 1132.0 сая төгрөгөс 915,9 сая төгрөгийн гүйцэтгэл гарч 81.0 хувийн хэрэгжилттэй байна.
		19.2.16	Аймгийн халамжийн сан	Хамрагдах иргэдийг үнэн зөв тодорхойлж, тусламжид хамрагдсан иргэдэд зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулна.	100%	435.6	386.5	Орон нутгийн төсвөт хуваарилагдсан хүнс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ болон нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн 154,9 сая төгрөгийг сарын хуваарийн дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт сар бүр санхүүжилтийг олгон зориулалтын дагуу зарцуулахад хяналт тавин хэрэгжүүллээ.
		19.2.17	Санхүүгийн хяналт, аудитын алба	Санхүүгийн зөрчил бууруулах, төсвийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, хариуцлага сайжирна.	100%	145.3	145.3	Санхүүгийн хяналт шалгалтаар нийтдээ 44 байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, улсын ахлах байцаагчийн 212 актаар орон нутгийн төсвийн орлогод 146,7 сая төгрөг, тухайн байгуулламжын төсөвт орох, нөхөн олгох, сум хөгжүүлэх сангийн төсөвт оруулахаар 134.1 сая төгрөгийн, нийт 280.9 сая төгрөгийн акт тогтоож, улсын байцаагчийн 4 албан шаардлагаар 143.8 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар шийдвэр гарган биелэлтийг хангуулсан байна.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч. түүний хэрэгжүүлэх хөтөлбөр. хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар. танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт. бодлогын зорилтын хэрэгжилт. түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт. хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт. тасарсан бол шалтгаан/
		19.2.18	Соёлын үйлчилгээ	Чанартай уран бүтээл туурвиж, иргэдэд соёл урлагийн үйлчилгээг өндөр түвшинд хүртээмжтэй хүргэх	100%	1,381.2	1,373.2	Олон үндэстэн ястны өв соёл хөтөлбөрийн хүрээнд Олон улсын хөөмийн наадам, Алтан хэлхээ уран нугаралтын тэмцээн, Өв соёлоороо гоёцгооё урлаадаан зөрэг томоохон арга хэмжээнүүдээс гадна соёлын биет болон биет бус өвийг хадгалан хамгаалж, түгээн дэлгэрүүлж, өвлүүлэн хөгжүүлэхэд чиглэгдсэн олон талт арга хэмжээнүүдийг төлөвлөн бэлтгэл ажлыг хангаж байсан хэдий ч цар тахлын улмаас арга хэмжээ цуцлагдлаа. Хөтөлбөрийн хүрээнд Аймгийн музей нь 9 сумын 578 дэсийн 975 ширхэг үзмэрт Сангийн сайдын 2013 оны 140 тоот тушаалын дагуу шинэчилсэн үнэ тогтоов. Мөн Зөрэг сумын Баатархайрханы нуруу Бурхдын гол орчимд түүх, соёлын үл хөдлөх дурсгалын хайгуул судалгаа хийж, 7 дурсгалт газрын 10 ширхэг дурсгалыг бүртгэн баримтжуулсан байна. Ховд аймгийн Мянгад сумын Орон нутаг судлах кабинетын үзмэрийг баяжуулах зорилгоор шувуу, амьтны 10 ширхэг чихмэл хийж, эдгээр чихмэлүүдийг байрлуулан дэглэв. Үүнд: янгирын чихмэл 1ш, зэгсний гахайн тоорой 1ш, бор галуу, тураг гогой, нугас, цахлай тус бүр 1ширхэг, ногруу 1ш, алаг даага 2ш хийв. Мөн Мянгад сумын Орон нутаг судлах кабинетын 35 дэсийн 35 ширхэг үзмэрүүдийн гэрэл зургийг авч бүртгэл мэдээллийн санд бүртгэлээ.
		19.2.19	Нийтийн биеийн тамир	Иргэдийн нийтийн биеийн тамираар хичээллэх орчин нөхцөлийг сайжруулж, тамирчдын амжилтыг өсгөх. Дотоод, гадаад аялал жуулчлалыг хөгжүүлэх	100%	**497.6**	**497.6**	Спортын аварга хөтөлбөрийн хүрээнд 2020 оны хагас жил хүртэл чөлөөт бөхийн өсөвөрийн баруун бүсийн аварга шалгаруулах, гар бөмбөгийн Идэрчүүдийн Баруун бүсийн аварга шалгаруулах, Ширээний теннис, Чөлөөт бөхийн өсөвөрийн улсын аварга шалгаруулах тэмцээнүүдийг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байсан Орон нутгийн спортын клуб, холбоодыг дэмжин хамтран ажиллаж байна. Энэ жил хөтөлбөрт орон нутгийн хөгжлийн сангаас 130 саа төрөг батлагдсан. 2020 онд спортын аварга хөтөлбөр 130 саа төрөгийн санхүүжилт батлагдсан. Дэлхий дахинд Covid-2019 цар тахлаас шалтгаалан спортын бүх үйл ажиллагааг хаасан. 2020 оны 9, 10 дугаар саруудад хорио цуцлагдаж Засаг даргын дэргэдэх шигшээ багийн спортын секц дугуйлан 9 төрлөөр өдөрт 2 ээлжээр хичээллэн, 620 хүүхэд хамрууллаа. 9, 10 дугаар саруудад Улсын аварга шалгаруулах тэмцээнд спортын 8 төрлөөр оролцож Хөлбөмбөг алт, волейбол хүрэл, үндэсний бөх бага насанд алт, таеквондо 2 алт, 6 хүрэл, самбо бөх хүрэл, жудо бөх 1 алт, 1 мөнгө, 6 хүрэл, ширээний теннис хүрэл, Бүсийн аварга шалгаруулах тэмцээнээс сагсан бөмбөг багаараа алт, ширээний теннис багаараа түрүүлж алт хүртсэн амжилт үзүүлээд байна.
		19.2.20	Үндсэн тэнцлийн ашгаас Улсын төсөвт төвлөрүүлэх орлого					
	19.3	**Улсын төсвөөс авах тусгай зориулалтын шилжүүлгээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ**				**50,903.6**	**47,907.6**	
		19.3.1	Сургуулийн өмнөх боловсрол	цэцэрлэгийн тоо-47, хүүхдийн тоо-7052, хамран сургалтын хувь-83.5	цэцэрлэгийн тоо-43, хүүхдийн тоо-6797, хамран сургалтын хувь-80,0	13,439.6	12,766.8	Аймгийн хэмжээнд 2020 оны хичээлийн жилд төрийн өмчийн 33, хувийн өмчийн 10 нийт 43 байгууллагад 6797 хүүхэд 243 бүлэгт суралцаж байна. Үүнээс үндсэн өдрийн 221 бүлэгт 6030 хүүхэд, хувилбарт сургалтын 22 бүлэгт 767 хүүхэд хамрагдаж сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 80 хувьд хүрч байна. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 5 настай 1921 хүүхэд хамрагдаж байгаа нь нийт 5 настай хүүхдийн 90 хувь байна.
		19.3.2	Ерөнхий боловсрол	Сургуулийн тоо 27, хүүхдийн тоо-19401, хамран сургалтын хувь-95,8, бага-95.1, суурь- 95.1, дотуур байрны хүүхдийн тоо-2027, үдийн цай хөтөлбөрт- 10572, элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноо-499	Сургуулийн тоо 27, хүүхдийн тоо-20206, хамран сургалтын хувь-96.5, бага-96.2, суурь- 95.6, дотуур байрны хүүхдийн тоо-1745, үдийн цай хөтөлбөрт- 9485, элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноо-509,2	30,314.7	29,264.0	Ерөнхий боловсролын 27 сургуульд 2020-2021 оны хичээлийн жилд 20206 хүүхэд суралцаж байна. Бага боловсролын хамран сургалтын бохир жин 96.5%, болж өмнөх оноос 0.8%-иар өссөн. Бага боловсролын цэвэр жин 96.2% болж өмнөх оноос 0.6%-иар өссөн, суурь боловсролын хамран сургалт 95.6% болж өмнөх оноос 0.6 хувиар өссөн дүнтэй байна. 1 дүгээр ангид 2123 хүүхэд суралцахаас энэ хичээлийн жилд 2131 хүүхэд суралцаж байгаагаас 6 настай 1951 хүүхэд суралцаж байгаа нь элсэн суралцах 6 настай хүүхдийн 92% байна
		19.3.3	Соёлын үйлчилгээ					
		19.3.4	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ	Нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээг тогтвортой, тасралтгүй үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх	14 сумын, 6 өрхийн эрүүл мэндийн төв, 85431 хүн амд анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлж, амбулаторийн үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувийг 35-д, 0-1 хүртэлх насны хүүхдийн дархлаажуулалтын хамралтын хувийг 95 хүргэж, хүн амын эрүүл мэндийн боловсрол олгож, тусламж үйлчилгээ үзүүлнэ.	6,133.0	6,120.3	Эрүүл мэндийн сайдын А/420 дугаар "Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт хамруулах тухай" тушаалын дагуу хавдрын эрт илрүүлэг болон урьдчилан сэргийлэх үзлэгийг БОЭТ, Булган нэгдсэн эмнэлэг, Мөст сум дундын эмнэлгүүд зохион байгуулж хавдрын үзлэгт 4347 хүн хамрагдлаа. 2020 оны байдлаар артерийн даралт ихдэлт, чихрийн шижингийн эрт илрүүлэг шинжилгээний хамралт 54.8 хувийн хамралттай байгаа нь енгерсөн оны мөн үеэс 2.7 хувиар нэмэгдсэн байна.Сум өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр 2020-2021 онд улсын төсвөөс 5 томоохон хөрөнгө оруулалтын арга хэмжээнд нийт 7.4 тэрбум төгрөг төсөвлөсний 3.4 тэрбум төгрөгийн ажил 2020 онд хийгдэж, орон нутгаас эрүүл мэндийн салбарт 14 ажил төлөвлөж нийт 367.6 сая төгрөгийн төсвийг төсөв төлөвлөгөөнд тусган санхүүжүүлж хэрэгжилтийг хангуулан ажиллав. Тус онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Алтай сумын Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөлийн гүйцэтгэгчээр "Бивазоне" ХХК, Дөргөн сумын Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгын гүйцэтгэгчээр "Толхын ойл" ХХК шалгарч гэрээ хийгдэж ажил 20-40 хувийн гүйцэтгэлтэй байна. Ховд сумын Эрүүл мэндийн төвийн барилгын засварын ажлыг "Хос арьс" ХХК гүйцэтгэж, БОЭТ-ийн засварт орон нутгаас 200.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэв.
		19.3.5	Газрын харилцаа, кадастр	Орон нутгийн газрын бодлогыг тодорхойлон, хэрэгжүүлэх, зөрчлийг арилгуулах,	100%	503.8	499.3	2020 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан Иргэн, аж ахуйн нэгж байгууллагад үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ээмшүүлэх газрын дуудлага худалдааг ил тод нээлттэй, шударга байх зарчимд тулгуурлан Газрын биржийн цахим систем www.mle.mn сайтаар цахим хэлбэрээр зохион байгуулж, Жаргалант, Ховд, Булган, Үенч, Дөргөн сумдад нийт 1,79 га газрыг худалдан ээмшүүлж, 56,2 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн.
		19.3.6	Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ	Шалгуур үзүүлэлтэд заасан үзүүлэлтүүдийн хүрэх түвшинд хүрч ажиллах	100%	512.5	454.9	"Хайраар дүүрэн танхим" төслийн үндсэн зорилго нь: гэр бүл бол амьдралын хамгийн чухал үнэт зүйл гэсэн мэдрэмжийг бий болгож, хосуудын гэр бүлийн боловсролыг нэмэгдүүлснээр жендерт суурилсан хүчирхийлэл, ялангуяа хамтрагчийн зүгээс үйлдэгдэж буй хүчирхийллийг бууруулахад хувь нэмрээ оруулах юм. Энэхүү танхимыг ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсээс танхимын тохижилт, тоног төхөөрөмжийг нийлүүлж, дотоод засал засварын ажлыг хийж үйл ажиллагаа явуулж эхлэзд байна.
		19.3.7	Нийтийн биеийн тамир					
20	**ХӨВСГӨЛ**					**122,735.7**	**113,601.3**	
	20.1	**Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа**				**1,947.9**	**1,863.3**	
		20.1.1	Нутгийн өөрөө удирдах ёсыг бэхжүүлж, түүний хэрэгжилтийг хангаж, тэргүүлэгчдийн хуралдааныг товлон зарлах, хэлэлцэх асуудлыг оруулж, хэлэлцүүлж гарсан шийдвэрийг байгууллагуудад танилцуулах, Засгийн газраас болон аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх үйл явцын талаар болон түүний биелэлтийн талаарх тайлан мэдээллийг ИТХ-ын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх	Хэлэлцэж шийдвэрлэсэн асуудлын хэрэгжилт сайжрах, хуралдааны тоо	1.0	1,817.6	1,760.6	Аймгийн болон 23 сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаан 2020 онд нийт 4 удаа хуралдсан. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 16 удаа хуралдаж нийт 114 асуудал хэлэлцэн 117 тогтоол баталж, хяналтад авч ажиллалаа. Эдгээр хуралдаанаар "Багшийн хөгжил" хөтөлбөр, "Эх хэл бичиг" аймгийн дэд хөтөлбөрийн нэмэлт өөрчлөлт, "Иргэдийн оролцоонд тулгуурласан өв хамгаалал" хөтөлбөр, "Хоршоог хөгжүүлэх" аймгийн дэд хөтөлбөр, "Соёл урлагийн салбарыг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө 2020-2025", Эрүүл хүнс-Эрүүл монгол хүн" аймгийн дэд хөтөлбөр зэрэг дунд болон богино, урт хугацаанд хэрэгжиж буй хөтөлбөрүүдийг баталж хэрэгжилтийн тайланг сонсож үнэлэлт дүгнэлт өгч Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын бодлогын чиг үүргийг биелүүлэх зэрэг олон асуудлыг хэлэлцэн зохих шийдвэрүүдийг гарган ажилласан байна.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч. түүний хэрэгжүүлэх хөтөлбөр. хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар. танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт. бодлогын зорилтын хэрэгжилт. түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт. хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт. тасарсан бол шалтгаан/
		20.1.2	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаат сайжруулах, гэмт хэргийн гаралтыг бууруулах.	Гэмт хэргийн гаралт буурсан байна.	79%	130.2	102.7	Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдөр хуралдаж 2020 оны ажлын төлөвлөгөөгөө баталсан. Салбар зөвлөлөөс 2020 оны "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх байгууллагын үйл ажиллагааг бэжүүлэхэд дэмжих жил" болгон зарлаж 11 бүлэг 77 ажил зохион байгуулахаар төлөвлөсөн. Тус төлөвлөгөө 85 хувийн хэрэгжилттэй биелсэн. Хөвсгөл аймгийн хэмжээнд 2020 онд 535 гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд урьд онтой харьцуулахад 209-өөр буюу 28 хувиар буурсан байна. Үйлдэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь ангилбал: Хүний амьд явахын эсрэг гэмт хэрэг 52.4 хувиар, Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 5.7 хувиар, хүний бэлгийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг /хүчиндэх гэмт хэрэг 16-аар буюу 55.2 хувиар, 16 насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох гэмт хэрэг 11-эр буюу 84.6 хувиар/ нийт 64.3 хувиар, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг /хувийн өмчийг хулгайлах 92-оор буюу 58.6 хувиар, дээрэмдэх гэмт хэрэг 6-аар буюу 4.9 хувиар, залилах гэмт хэрэг 25-аар буюу 49 хувиар, хөрөнгө завших гэмт хэрэг 9-өөр буюу 60 хувиар, алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд зүйл ашиглах гэмт хэрэг 7-оор буюу 70 хувиар, мал хулгайлах гэмт хэрэг гэмт хэрэг 74-өөр буюу 26.7 хувиар/ нийт 164-өөр буюу 42.8 хувиар, авлигын эсрэг гэмт хэрэг 10-аар буюу 90.9 хувиар, авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэрэг 10-аар буюу 26.3 хувиар тус тус буурсан байна. Харин Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг /Хууль бусаар ан агнах гэмт хэрэг 9-өөр буюу 45 хувиар, хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг 8-аар буюу 21.6 хувиар/ нийт 57-оор буюу 42.5 хувиар, Гэр бүлийн хүчирхийлэл 2.5 дахин өссөн байна.
	20.2	**Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ**				**33,138.3**	**29,170.8**	
		20.2.1	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага					
		20.2.1.1	Засгийн газрын болон аймгийн Засаг дарга, ИТХ-аас гаргасан бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, сум, хэлтэс агентлагийн үйл ажиллагаат уялдуулах, аймаг, сумдын ЗДТГ-ын ажилтнуудад нутгийн удирдлагын чиглэлээр мэргэжлийн зөвлөгөө өгч сургалт семинарыг зохион байгуулж, мэдээллээр хангах	Төлөвлөсөн ажил бүрэн хэрэгжсэн байх, ажлын ур дүн сайжрах. Биелэлт гаргах тогтоол шийдвэрийн тоо, хэрэгжилтийн байдалд ахиц гарсан байх	9605.3%	12,057.1	11,581.2	"Хүүхэд хамгаалал, өрхийн хөгжлийг дэмжих" жил болгон зарлаж иргэд, иргэний нийгмийн байгууллагууд, хувийн хэвшил, олон улсын төсөл хөтөлбөрийн болон төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Аймгийн Засаг дарга төрийн албан хаагчдыг ЗҮТГЭЖ, ИТГЭЖ, СЭТГЭЖ (ЗИС) ажилахыг уриалж, төрийн байгууллагын удирдлагуудтай үр дүнгийн гэрээ байгуулан хэрэгжилт үр дүнг тооцон ажиллалаа. Мөн Засгийн газрын болон аймаг орон нутгийн удирдах байгууллагаас гарсан, гарч байгаа бодлого шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллалаа. Аймаг сумдын болон агентлаг байгууллагуудын удирдах ажилтны цугларалтыг улиралд 1 удаа зохион байгуулахын зэрэгцээ бусад сургалт зөвлөгөөн, бүсчилсэн сургалтуудыг удаа дараа явуулж мэдээллээр хангахын зэрэгцээ цаг үеийн олон ажлуудыг шийдвэрлэн ажиллаж байна. 2020 онд холбогдох хууль журам, сайдтай байгуулсан гэрээ, улсын ЭЗНХҮЧ, аймгийн Засаг даргын 2016-2020 оны "Хөгжлийн хөтөч" үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл зэрэг хяналтад авч хэрэгжүүлэх 90 гаруй эрх зүйн баримт бичиг, тогтоол шийдвэрийн 430-аад заалт байгаа бөгөөд тус бүрд биелэлт, үнэлгээ дүгнэлтийг гарган ажиллалаа.
		20.2.1.2	Хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол шийдвэр, Засгийн газар, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, Хөтөлбөр, төслийн мэдээлэл, үйл ажиллагааны үр дүнгийн мэдээллийг графикт хугацаанд гаргаж холбогдох газарт хүргүүлж мэдээлж байх					
		20.2.2	Мэргэжлийн хяналт /СХАА/. Төсөвт байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаа, шилэн дансны хуулийн хэрэгжилтэд байнгын хяналт тавих, үйл ажиллагааг сайжруулах	Хяналт хийх байгууллага, дансны тоо, хяналтаар гарсан үр дүнгийн хувь	10000%	204.5	202.9	Санхүүгийн хяналт шалгалтаар 2019 онд 121,5 сая төгрөг, 2020 онд 1755.2 сая төгрөгийн акт тогтоогдсон. 2019 онд актын барагдуулалт 18%-тай байсан бол 2020 онд тайлант хугацааны сүүлийн улиралд тогтоогдсон цагдаагийн бэлэн бус торгуулийн нөхөн төлбөр болон бусад хугацаа болоогүй акт 1646.6 мянган төгрөгийн барагдаагүй үлдэгдэлтэй гарсан боловч 2019 онд 13.5 мянган төгрөг, 2020 онд 42.1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт оруулсан дүн, тухайн байгууллагад барагдуулсан дүн багтаж байгаа болно. Түүнчлэн авто тээврийн үзлэг, оношилгооны ажлын явцад акт тогтоохүйгээр авто-тээврийн бэлэн бус торгуулийн 428.3 мянган төгрөгийг Мөрөн сумын ОНО-д оруулж ажилласан. 2020 онд орон нутгийн орлогод төвлөрүүлж болох орлогын эх үүсвэрийг олж илрүүлэхэд холбогдох байгууллагуудын үйл ажиллагаат чиглүүлж, зөвлөмж өгөх, шаардлагатай бусад арга хэмжээг хэрэгжүүлэхэд анхаарч ажилласнаар тодорхой үр дүнд хүрсэн.
		20.2.3	Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх БХНСАХ-ний зардлаар хэрэгжүүлэх ажил үйлчилгээг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, батлагдсан ажлын даалгавар, техникийн нөхцөл, зураг төсвийн дагуу батлагдсан төсөвт багтаан хугацаанд нь хэрэгжүүлэх.	Төлөвлөсөн ажил бүрэн хэрэгжсэн байх	69.3%	860.3	596.6	Аймгийн Засаг даргын 2020.02.20-ны А/103 захирамж, аймгийн онцгой комиссын 02 албан даалгаврын дагуу ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар сумдад ажиллах удирдамж боловсруулан Онцгой байдлын газрын албан хаагчидтай 21 сумаар явж ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлын бэлэн байдал, багаж хэрэгсэлтэй танилцан зөвлөмж өгч, 60 ойн мэргэжлийн байгуллага, 21 сумын байгуллагатай ажилласан. 2020 онд ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгааны ажлыг сайн хийсний үр дүнд энэ жил ой, хээрийн түймэр өмнөх жилээс 76,6 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Ойн цэвэрлэгээ хөтөлбөрийг хэрэгжүүлэх, "Илч түлш" аян зохион байгуулах, ойн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээнд 6 аж ахуй нэгж шалгарч гэрээ байгуулж түлшний мод татах ажил хийгдэж нийлүүлэлтэд тогтмол хяналт тавьж байна. Гэрээний дагуу нэгдүгээр элжийн таталтаар 1368.8 м3 мод бэлтгэн нийлүүлэхээс 6 аж ахуй нэгж 985.9 м3 түлшний модыг Мөрөн сумын "Шинэс" захын хашаанд буулган хураах ажлын хэсэгт хэмжилт хийн хүлээлгэн өгсөн. Загас үржүүлэх, цөөрөм байгуулах ажлыг эхлүүлэх тендерт Байгаль хамгаалах монголын тул сан ТББ шалгарч ХӨАОНӨГ-202012101 гэрээ байгуулан Бүрэнтогтох сумын Дэлгэрмөрөн голын цутгал гол Баян голд зөвэг загасны 150.000 жарамгай үржүүлэн тавьсныг төслийн менежерийн баг хүлээн авч гэрээний санхүүжилт болох 20,000,000 төгрөгийн санхүүжилтийг олгосон.
		20.2.4	Санхүүгийн зах зээлийн зохицуулалт /жолоочийн хариуцлагын даатгал Жолоочийн хариуцлагын даатгалын үйл ажиллагаат чанаржуулах, улам өргөн хүрээг хамруулах, татвар бүрэн төлөгдсөн байх	Тээврийн хэрэгслээс авах татвар хураамжийн биелэлт, дүн	1.0	8.4	8.4	Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын дүнгээс Жолоочийн хариуцлагын тухай хуулийн заалтын дагуу 10 хувь болох 8,4 сая төгрөгийг жолоочийн хариуцлагын даатгалын санд төлөрүүлэхээр баталж, уг төсвийг зохих хууль журмын дагуу шилжүүлэн ажиллаж байна. Уг зардлаар хийж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажил бүрэн дүүрэн, чанар хүртээмжтэй хийгдсэн байна.
		20.2.5	Төрийн өмчийг эрхийг хэрэгжүүлэх /ОНӨГазар/ Худалдан авах үйл ажиллагаат болон холбогдох сургалтуудыг зохион байгуулах. Орон нутгийн өмчийн байгууллагын менежментийг сайжруулж, ашигтай ажиллуулах замаар орлогыг төвлөрүүлэх. Орон нутгийн өмчит этгэдийн санхүү эдийн засаг үйлдвэрлэлийн үйл ажилласанд хяналт тавьж тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийх.	Худалдан авах үйл ажиллагаа зохион байгуулсан тоо, орон нутгийн өмчит газруудын үйл ажиллагаа сайжрах	97.0%	206.4	200.2	А-3 сертификатын сургалтыг зохион байгуулж нийт 175 хүнд сургалт өгсөн ба 2020 онд давхардсан тоогоор 422 тендерт 380 аж ахуйн нэгж оролцож тендер ирүүлсэн бол байгууллагын захиалгаар 92 худалдан авах ажиллагаат гардан зохион байгуулсан. Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллага -189, төсөвт үйлдвэрийн газар-5, орон нутгийн өмчит аж ахуйн нэгж-13, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар-6, орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж 2, нийт 215 орон нутгийн өмчит хуулийн этгэдийн эзэмшилд байх орон нутгийн өмчийн бүртгэл, хяналт, удирдлагыг хэрэгжүүлж, 2019 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж ашиглалтад орсон барилга байгууламжуудыг ТӨБЗГ-ын 2020 оны 63, 64, 111 дүгээр тогтоолоор орон нутагт бүртгэх зөвшөөрөл ирүүлсний дагуу орон нутгийн өмчит байгуулагуудад эзэмшүүлж, бүртгэх асуудлыг аймгийн ИТХТ-ийн хуралд танилцуулж, 2020 оны 56 дугаар тогтоолоор баталлаа. Тус тогтоолоор 32.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 29 барилга байгууламжийг холбогдох байгууллагуудад бүртгүүлэх ажлыг зохион байгууллаа.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч. түүний хэрэгжүүлэх хөтөлбөр. хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар. танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт. бодлогын зорилтын хэрэгжилт. түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт. хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт. тасарсан бол шалтгаан/
		20.2.6	Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт ОНХС-ийн болон ОН-ын хөрөнгө оруулалтын зардлыг хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой орон нутагт зайлшгүй шаардлагатай хөрөнгө оруулалтын ажил, төсөл арга хэмжээнд зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, төлөвлөн батлсан ажил үйлчилгээнүүдийг хугацаанд нь бүрэн, чанартай хийж гүйцэтгэх	Баталсан хөрөнгө оруулалтын ажлууд хугацаандаа бүрэн хийгдсэн байх	82%	10,098.0	8,290.2	Аймаг сумдын ОНХС-ийн санхүүжилт болон Орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын зардлууд үүнд багтаж байна. Мөн шат шатны ЗД нарын мөрийн хөтөлбөр болон үндсэн чиглэлд тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх зардлууд үүнд багтаж байна. Дэд хөтөлбөрүүд амжилттай хэрэгжиж ажлын байр бий болох, эрүүл таатай орчинд амьдрах, сурч боловсрох орчин нөхцөл сайжирч, амжилт бүтээлээ зүй зохистой үнэлүүлэх зэргээр ард иргэдийн амьдралд тодорхой ахиц дэвшил гарсан байна.
		20.2.7	Мал аж ахуйг хөгжүүлэх Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх үйлчилгээнд хамруулахаар тооцсон мал бүрэн хамрагдсан байх, аймгийн хэмжээгээр малын гоц халдварт болон бусад өвчлөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх.	Тарилга туулга хийх малын тоо	87%	937.0	813.7	Мал эмнэлгийн ерөнхий газрын шийдвэрийн дагуу малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг Рашаант сумын засаг даргын 2020 оны 5 дугаар сарын 11-ны өдрийн А/47 тоот захирамжаар 2020 оны 05 дугаар сарын 12-25-ны өдрүүдэд 229142 толгой малыг дархлаажуултад хамруулан 99.4 хувийн гүйцэтгэлтэй хийгдсэд байна.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 7 нэрийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 816,7 мянган толгой мал хамруулахаар төлөвлөснөөс дархлаажуулалтын арга хэмжээнд 810,6 мянган толгой мал хамрагдаж гүйцэтгэл 99,2 хувьтай хийгдэд байна. Бруцеллёз өвчний дархлаажуулалтад 1392,0 мянган төл мал хамрагдаж гүйцэтгэл 99,3 хувьтай хийгдэж 213,9 сая төгрөгийн санхүүжилт хүссэн материалыг МЭЕГ-т хүргүүлэд байна.
		20.2.8	Авто зам Төв доторх замын тэмдэг тэмдэглэгээг сайжруулах, гэмтэлтэй замыг засварлах, шинээр нэмж барих, хөдөөгийн зарим зам даваат засах, ажил үйлчилгээг чанартай хийх	Засвар хийгдсэн зам талбайн хэмжээ	87.5%	887.6	776.7	Замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх зам даваана замын засвар, гэрлэн дохио суурилуулах, хяналтын камер суурилуулах, замын тэмдэг тэмдэглэгээ сайжруулах зэрэг олон ажил, арга хэмжээ батлагдсан бөгөөд ажлуудыг тодорхой түвшинд хийж гүйцэтгэгдсэн.
		20.2.9	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага Байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх боломжийг бүрдүүлэх, байгальд ээлтэй тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар хүрээлэн байгаа орчны тогтвортой байдлыг хадгалж, ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх байгаль орчны чиглэлийн орон нутгийн байгууллагуудын салбар дундын зохицуулалтыг уялдуулах	Байгаль орчны чиглэлээрх бүхий үйл ажиллагаанд ахиц гарсан байх	100%	919.8	917.4	Байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, байгалийн баялгийг зөв зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, өсгөн үржүүлэхэд мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, түүнд хяналт тавих эрх, үүрэг бүхий сумдын Засаг дарга, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч мөн Ойн алба, ойн анги, байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төсөл хөтөлбөр, төрийн бус байгууллага, ойн мэргэжлийн байгууллагууд, ард иргэдийн оролцоотойгоор манай байгууллага нь байгаль орчны тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд хамтран ажиллалаа. Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар нь 2020 онд 76 орон тоотой, 1.5 тэрбум төгрөгийн төсөвтэй үйл ажиллагаа явууллаа.
		20.2.10	**Нийгмийн халамж**					
		20.2.10.	Халамжийн бусад хөнгөлөлт, үйлчилгээ	Тэтгэмж цаг хугацаандаа очсон байдал, үйлчилгээ үзүүлсэн иргэний тоо	92.4%	963.6	890.2	Аймгийн халамжийн сангийн 2020 оны батлагдсан төсөв 963.6 сая төгрөг, үүнээс амьжиргаат дэмжих мөнгөн тэтгэмжийн гүйцэтгэл 118.4 сая төгрөг буюу 99 хүнд, бусад тэтгэмж, хөнгөлөлт 745.8 сая төгрөг буюу 397 хүнд, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамж 25.9 сая төгрөг буюу 623 хүнд үзүүлсэн байна.
		20.2.10. 2	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ					
		20.2.10. 3	Амьжиргаат дэмжих нөхцөлт мөнгөн тусламж					
		20.2.11	Ахмад настны хөгжил хамгаалал					
		20.2.11. 1	Байгууллагын “Дотоод журам” ХАХНХамгааллын сайдын 2013 оны 11-р сарын 06-ны өдрийн 247/А/163-р тушаалаар баталсан “Төрөлжсөн асрамжийн үйлчилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлын норматив журам, стандартыг мөрдлөг болгон үйлчлүүлэгч нарт байнгын асрамжийн үйлчилгээг үзүүлэх	Ахмадын асрамж үйлчилгээний төвийн асруулагчдад үзүүлэх үйлчилгээ бүрэн хүрсэн байх.	100%	333.4	333.3	Байгууллагын “Дотоод журам” ХАХНХамгааллын сайдын 2013 оны 11-р сарын 06-ны өдрийн 247/А/163-р тушаалаар баталсан “Төрөлжсөн асрамжийн үйлчилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлын норматив журам, стандартыг мөрдлөг болгон үйлчлүүлэгч нарт байнгын асрамжийн үйлчилгээг чанартай хүргэж байна. Мөн хувь хүнд чиглэсэн асаргаа, сувилгаа, нөхөн сэргээх, бумба, бариа засал, шарлага, иллэг массаж зэрэг үйлчилгээг шаардлагатай асруулагч нарт үзүүлсэн. Асруулагчдад шаардлагатай эм тариа, багаж хэрэгслээр ханган ажилласнаар асруулагчдын өвчлөл тодорхой хэмжээгээр багассан үр дүнтэй байна. Асруулагчдад норм нормативын дагуу өвөл, хавар, зун, намрын болон хувь хүний онцлог, насны онцлогт тохирсон чанартай хувцас хэрэглэлийг одоогийн байдлаар 3 удаа олгосноор ахуйн хэрэглээний хэрэгцээ хангагдсан. Мөн сар бүр ариун цэвэр ахуйн хэрэглэлээр хангаснаар асруулагчдын ариун цэвэр амьдрах орчин нь цэвэр цэмцгэр орчинд амьдарч байна.
		20.2.11. 2	Асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэний хоногт хэрэглэх хоолны норм, илчлэгийн хэмжээ, зардлын дундаж норматив"-ыг хэрэгжүүлэн үйлчлүүлэгч нарт халуун хоол ундаар үйлчилнэ	Хоол хүнсний үйлчилгээ бүрэн хүрсэн байх	100%	102.0	102.0	ХАХНХамгааллын сайдын 2013 оны 11-р сарын 06-ны өдрийн 247/А/163-р тушаалаар баталсан “Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэний хоногт хэрэглэх хоолны норм, илчлэгийн хэмжээ , зардлын дундаж норматив"-ыг хэрэгжүүлэн үйлчлүүлэгч нарт эрүүл ахуйн шаардлага хангасан халуун хоол ундаар үйлчилсээр байна. Мөн дархлаа дэмжих хоол унд түлхүү оруулсан. Манай байгууллагаар 2020 онд 36-40 хүн үйлчлүүлсэн. Эдгээр үйлчлүүлэгчдийн эрүүл ахуй, хоол хүнс, эмнэлгийн үйлчилгээг байнгын чанартай хүргэсээр байна.
		20.2.11. 3	/Ахмадын хороо/ Аймгийн ахмадын хорооны үйл ажиллагаа тогтвортой явагдаж, ахмадын хорооны болон төрийн үйл ажиллагааны уялдаа холбоо сайжирсан байна.	Төлөвлөгөөт ажил гэрээний дагуу бүрэн хэрэгжсэн байна.	100%	63.8	63.8	Ахмадын байгууллагын ажлыг тогтмол тасралтгүй явуулах зорилгоор аймагт 30 ХБИ, ахмад настны үйлчилгээний төвийг ажиллуулж, менежерийг нь ажилласан сар бүрд 100 мянган төгрөгөөр нийгмийн халамжийн сангаас олгодог юм. Аймгийн ИТХ-аас жил бүр аймгийн шат шатны ахмадын байгууллагуудыг санхүүжүүлэхээр 62,2 сая төгрөг батлан хэрэгжүүлж байна. Аймгийн ахмадын хороо жилийн эцэст санхүүгийн тайлангаа гаргаж жилийн эхэнд тэргүүлэгчдийн хуралдаанаараа төсвийн хуваарилалтаа батлан хэрэгжүүлдэг. Ахмад настны тухай хуульд заасан өдрийн үйлчилгээ үзүүлэх ажлын сонгон шалгаруулалтад аймгийн Ахмадын хороо шалгарч 4 сумын 200 ахмад настанд тусгайлсан үйлчилгээ үзүүллээ.
		20.2.12	**Ангилагдаагүй бусад**					
		20.2.12. 1	Орон нутгийн нөөц хөрөнгийг журамд заасан хүрээнд шаардлагатай зардлуудад хуваарилан зарцуулах	Санхүүжилтийг төлөвлөгөөт хуваарийн дагуу бүрэн олгох, журмын дагуу зарцуулах	99.8%	423.2	422.4	Онцгой байдал, ган зуд, үер усны аюул осол, хүн малын гоц халдварт өвчний улмаар гарсан хохирол барагдуулахад зарцуулж байна. Нөөц хөрөнгө зарцуулах журамд заасан 30% буюу түүнээс дээш хувийг 2.1.1, 2.1.2 дахь заалтын дагуу зарцуулах ба зарцуулахгүй үлдэгдлийг тооцон ажиллаж байна.
		20.2.12. 2	Хууль тогтоомжийн дагуу аймгийн Засаг даргын хүлээлгэсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулах.	Тухайн төсөөр хэрэгжүүлэх ажил үйлчилгээг чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэх	99.1%	909.1	900.7	Үүнд аймгийн баяр наадмын зардал, сайн малчин тариаланчдын шагнал, алдар гавьяа амжилтын бүухиа арга хэмжээний зардал, хэрэглэгчийн үнэлгээ хийх зардал зэрэг Засаг даргын хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, цаг үеийн шинжтэй бусад шаардлагатай арга хэмжээг санхүүжүүлэх зардлууд багтаж байгаа бөгөөд зориулалтын дагуу зарцуулж байна.
		20.2.13	Ус түгээгч аж ахуй нэгжийн үйл ажиллагааг дэмжиж төсвөөс татаас өгөх.	Усны үнийг тогтвортой байлгах	100.0%	318.8	318.8	Ус түгээгч аж ахуй нэгжийн үйл ажиллагааг дэмжиж ОНХСангийн суурь зардлаас 308,8 сая төг, Орон нутгийн орлогоос 10,0 сая төг нийт 318,8 сая төгрөгийн татаасыг олгосон.
		20.2.14	Ойжуулалт	Аймгийн ойн нөөц баялгийг тогтоох, хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх ажлыг зохион байгуулах	98.1%	159.6	156.5	Цагаан-Үүр, Жаргалант, Мөрөн, Улаан-Уул сумдад үйл ажиллагаа явуулж байгаа ой ангиудад олгож байгаа санхүүгийн дэмжлэгийн дүн, төсөв хамаарч байгаа бөгөөд батлагдсан хуваарийн дагуу бүх санхүүжилтийг олгож байна. 4-н ой ангийн тухайд аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлын шийдвэрээр аймгийн бүх сумдын хуваан хариуцдаг бөгөөд хариуцсан сумддаа ой хэрийн түймрээс урьдчилан сэргийлэх, байгаль орчныг нөхөн сэргээх зэрэгт холбогдох сургалт сурталчилгаа явуулахын зэрэгцээ мод бэлтгэл, ойжуулалт, ойн хортонтой тэмцэх мэргэжлийн байгууллагуудын мэргэжил арга зүйгээр ханган хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллаж байна. Ойн ангиуд нь нийт төсвийн 46-55%-ийг нь өөрийн орлогоор бүрдүүлж байгаа бөгөөд татаасаар авч байгаа санхүүгийн дэмжлэгийг ажиллагсдын цалинд зарцуулж байна.
		20.2.15	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих СХС-ийн зээлийн эргэн төлөлтийг сайжруулах, зээл олголтыг нэмэгдүүлэх. Батлагдсан төсөв 2,870.6 сая төгрөг	Зээлийн эргэн төлөлт болон зээл олголтыг өмнөх оноос 5%-иар нэмэгдүүлэх	57.8%	2,568.6	1,486.0	Зээлийн эргэн төлөлт хангалтгүй байгаас шалтгаалж зээл олголт бага хийгдсэн.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч. түүний хэрэгжүүлэх хөтөлбөр. хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар. танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт. бодлогын зорилтын хэрэгжилт. түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт. хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт. тасарсан бол шалтгаан/
		20.2.16	Хот тохижуулалт Хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, арчлах хамгаалах, хог хаягдлын болон зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулах, золбин нохойн устгалыг хийх.	Нэмэгдүүлсэн бут сөөгийн тоо, ачсан хог хаягдлыг болон цэвэрлэсэн зам талбай хэмжээ, устгасан золбин нохойн тоо	99.3%	983.9	976.5	Мөрөн сумын 14 багийн айл өрх болон аж ахуйн нэгж байгууллагуудын 37374 мянган тонн 12322 рейс хог хаягдлын ачилтыг хийж түрж булах үйл ажиллагаат хэрэгжүүлсэн. Сумын ногоон байгууламжийн тариалалт, арчлалт хамгаалалт, нийтийн эзэмшлийн хөрөнгийн бүрэн бүтэн байдал, засвар үйлчилгээг тасралтгүй хийж гүйцэтгэсэн. Жилийн турш 983 нохойг устган, ариутгаж булах ажлыг хэрэгжүүлэв. Нийтийн тээвэрт 5 автобус ажилласан. Зарцуулсан төсөв 976,5 сая төгрөг
		20.2.17	Гудамжны гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх, асалтын чанар байдлыг сайжруулах	Гэрэлтүүлгийн тоо	100.0%	133.4	133.4	Мөрөн сумын нийтийн эзэмшлийн гудамж, талбайн 4600 гаруй гэрэлтүүлгийн төлбөр тооцоог тооцож шилжүүлэх, урсгал засвар үйлчилгээг тасралтгүй зохион байгуулах, улирлын байдлаар цаг хугацаанд асааж гэмт хэрэг гарч болзошгүй байдлаас урьдчилан сэргийлж ирэгдийн ая тухтай байдлыг хангах ажлыг хэрэгжүүлсэн. 2020 оны байдлаар нийт гэрэлтүүлгийн 88 хувь нь хэвийн асалттай ажиллалаа. Зарцуулсан төсөв 133.4 сая төгрөг
	20.3	**Улсын төсвөөс авах тусгай зориулалтын шилжүүлгээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ**				**87,649.5**	**82,567.2**	
		20.3.1	**Сургуулийн өмнөх боловсрол**					
		20.3.1.1	Цэцэрлэгийн өдрийн үйлчилгээ	СӨБ-н бага насны хүүхдийн хөгжлийн стандарт хэрэгжиж, сургалт хүмүүжлийн таатай орчин бүрдэнэ.	91.7%	20,326.0	18,630.7	Өдрийн цэцэрлэгийн үйлчилгээнд 9544 хүүхэд хамрагдаж байгаа бөгөөд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг төрийн 42, төрийн бус өмчийн 8 цэцэрлэгээр дамжуулан хүргэсэн. Ингэснэр сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт Хөвсгөл аймаг 80,6 % болсон. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр БШУ-ны сайдын 2020 оны 86 дугаар тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд цэцэрлэг бүр орхигдсон агуулгыг хүүхэд хүргэх чиглэлээр цахим болон цаасан сууриар дасгал даалгаврыг боловсруулан хүүхэд бүрд хүргэж гүйцэтгэлийн хяналтыг хийж ажиллалаа. Цэцэрлэг бүр сургалтын хөтөлбөрийн хэрэгжүүлэхэд шаардлагатай хэрэглэгдэхүүнийг бэлтгэж хэвлэл мэдээллийн хэрэгслээр суртачлан ажилласан болно. Хөвсгөл аймгийн цэцэрлэгүүдийн 75% нь хүүхдэд зөлтэй цэцэрлэгийн шалгуурыг хангасан. Сургуулийн өмнөх бага насны хүүхдийн хөгжлийн стандарт гараагүй бөгөөд сургуулийн өмнөх боловсролын орчны стандарт MNS 6558:2015 хэрэгжүүлэн ажиллаж байна. Хөвсгөл аймгийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагын орчны стандартын хэрэгжилт, цэцэрлэгийн байрны шинэчлэл 83,3 хувьтай байгаа бөгөөд 2021 онд 90%-д хүргэх зорилт тавьсан. Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмнэлтээс 423,0 сая төгрөгөөр Аймгийн ИТХ-н шийдвэрийн дагуу зөөлөн эдлэлийг иж бүрэн шинэчилсэн.
		20.3.1.2	Хувилбарт сургалтын үйлчилгээ.	Нүүдлийн, Ээлжийн, явуулын сургалтын хэлбэрээр СӨБ-д хамрагдаагүй хүүхдийг хамруулж хамран сургалтын нэмэгдүүлнэ.				Ковид-19 өвчлөлийн хөл хорионы улмаас хувилбарт сургалтаар нүүдлийн цэцэрлэг ажиллаагүй болно. Нүүдлийн цэцэрлэгт төсөвлөсөн санхүүгийн эх үүсвэрийг 2020 оны 9-р сард аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолоор тодотгол хийж хүүхдийн цэцэрлэгийн цэвэрлэгээ үйлчилгээ, ариутгал хийх, эм эмнэлгийн хэрэгслийн хангамжийн зардалд шилжүүлсэн болно.
		20.3.1.3	Нийгмийн баталгаат хангах	СӨБ-н ажиллагсад хамрагдана				Төсвийн гүйцэтгэл 629,8 сая төгрөг буюу 100,0%, Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийг 77 хүнд, Тэтгэвэрт гарахад олгодог нэг удаагийн тэтгэмжийг 20 хүнд тус тус олгож сургуулийн өмнөх боловсролын байгууллагад ажиллаж буй багш, ажилтнуудын нийгмийн баталгаат хангахад анхааран ажилласан.
		20.3.1.4	Хувийн хэвшлийн татаас	Мөрөн суманд 5, Жаргалант суманд 1 нийт 6 хувийн цэцэрлэг				Хувийн цэцэрлэгүүдэд санхүүжилтийг бүрэн олгож байна, аймгийн хэмжээнд төсвийн татаас авч байгаа 8 хувийн цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байгаа ба Төсвийн гүйцэтгэл 398,1 сая төгрөг буюу 100,0%, хамрагдаж байгаа 524 хүүхдэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээг хүргэсэн.
		20.3.2	Соёл урлаг Орон нутгийн иргэдэд урлаг соёлын үйлчилгээг хүргэх	Хүн амд хүрэх урлаг соёлын үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдэнэ.	97.6%	4,037.7	3,942.0	Соёл урлагийн байгууллагуд ихэнх хугацаанд цахим хэлбэрээр үйл ажиллагаагаа зохион байгуулсан. Аймгийн Хөгжимт драмын театр, Орон нутгийг судлах музей, Нийтийн номын сангаас хүүхдэд зориулсан орон нутгийн онцлог бүхий "Хугашхан" контентыг бий болгож хамтран ажиллалаа. Сумдын соёлын төвүүд алслагдсан багийн иргэд, ахмад настанд чиглэсэн үйл ажиллагааг өргөн хүрээнд зохион байгуулж ажилласан байна. Аймгийн БСУГ-ын санаачлан Хөвсгөл аймгийн түүх соёлын дурсгалт зүйлсийг эмхэтгэн "Хөвсгөлийн 99 гайхамшиг" номыг бүтээлээ.
		20.3.3	**Ерөнхий боловсролын үйлчилгээ**					
		20.3.3.1	Бага, суурь, бүрэн дунд боловсрол олгох үйлчилгээ	"Оюунлаг Хөвсгөл", Боловсролын шинэчлэл цөм хөтөлбөриг хэрэгжүүлж хүүхэд бүрийн хөгжилд ахиц гарсан байна.	93.8%	51,389.1	48,222.6	Суралцагчдын тоо 27890. Бага боловсролын хамран сургалт 99%, суурь боловсролын хамран сургалт 100%. 2020 онд БСУГ-с санаачлан "Багшийн хөгжил" хөгжлийн хөтөлбөрийг батлуулан хэрэгжүүлж эхлэхэд байна. 2020 онд дэлхий нийтийг хамарсан цар тахал гарсан тул 75 өдрийг цахим хэлбэрээр сургалт явагдсан. Цахим сургалтын явуулахдаа орон нутагтаа сурагчдын мэдлэгийг бататгах зорилгоор ЕБС, СӨББ-тай хамтран цахим хичээл, арга зүйн материалыг боловсруулан 14 төрлөөр цахим хичээл 151, арга зүйн материал 83, жишиг даалгавар 9 буюу СӨБ-40, бага боловсрол-48, суурь, ахлах боловсрол-155 цахим хичээл, арга зүйн материал, дасгал даалгаврыг веб сайт болон багш нарын фейсбүүк группээр дамжуулан сурагчдад хүргүүллээ. ЭЕШ, нэгдүгээр ангийн сурагчдын бүртгэлийг цахим хэлбэрээр зохион байгуулсан. 2020 оны ЭЕШ-ыг 1357сурагч оролцож 13 сурагч 800 оноо авсан нь улсад хамгийн өндөр амжилт үзүүлсэн аймаг болсон. Сургалтын орчныг сайжруулах зорилгоор 2020 онд 8 сургуульд гадаад хэлний кабинет, 5 сургуульд тестийн машин, 7 сургуульд цахим номын сан, 8 сургуульд мэдээлэлзүйн кабинет, 4 сургуульд технологийн кабинет, 8 сургуульд биеийн тамирын хичээлийн хэрэгсэл, 7 сургуульд бага ангийн кабинетын тохижилтыг шийдвэрлэж орчин үеийн стандартын шаардлага хангасан сургалтын техник хэрэгсэл,тоног төхөөрөмжтэй болсон.
		20.3.3.2	Үдийн цайгаар үйлчлэх	Хүнсний эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүнээр үйлчилнэ.				Хамрагдсан хүүхэд оны эхний төлөвлөлтөөр 14323 байсан бөгөөд Ковид-19 өвчний улмаас хөл хорио тогтоож 2020 онд 15 долоо хоног буюу 75 өдрийг цахимаар хичээллэсэн тул эдгээр хоногт ногдох үдийн цай хөтөлбөрийн зардал хэмнэгдэж 2020 оны 4 ба 11-р сард БШУЯамны ерөнхий дансанд 1096,8 мянган төгрөг, 2020 оны 12-р сарын 31-ны үлдэгдлээр 2414,7 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн.
		20.3.3.3	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	"Хүүхдэд эзлтэй сургууль" хөтөлбөр хэрэгжиж, сурагчид, багш ажиллагсдын суралцах, ажиллах таатай орчныг бүрдүүлнэ.				Тусгай зориулалтын шилжүүлгээр байгууллагуудын хэвийн үйл ажиллагаг хангах албан тушаалтнуудын цалин, НДШ-д зарцуулсан бөгөөд үлдэх 5696,7 сая төгрөгийг сургуулиудын халаалт, гэрэл, цэвэр бохир ус, урсгал засварын зардалд зориулан орон нутгийг төсөвөс санхүүжүүлсэн. Үүний үр дүнд ерөнхий боловсролын сургуулиудад ашиглалтын зардалтай холбоотой өр төлбөр үүсээгүй.
		20.3.3.4	Нийгмийн баталгаат хангах /ЕБС/	Хуулийн дагуу тэтгэмжүүдийг олгогдоно.				Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж, ээлжийн амралтаар нутаг явах унааны зардал олгоход нийт 259 хүнд 1032,8 мянган төгрөг, Тэтгэвэрт гарахад олгодог нэг удаагийн тэтгэмжийг 63 хүнд 1147,6 мянган төгрөг. Нийт 2180,4 мянган төгрөгийг тэтгэмжийн зардалд олгосон. Гүйцэтгэл 100%.
		20.3.3.5	Хувийн хэвшлийн татаас	Далай ван сургууль 167 хүүхэд хамруулан ЕБС-н үйлчилгээг үзүүлнэ.				Төсвийн гүйцэтгэл 79,3 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Суралцагчдын тоо 96.
		20.3.4	**Насан туршийн болон албан бус боловсрол**					
		20.3.4.1	Насан туршийн боловсрол буюу дүйцсэн хөтөлбөрөөр боловсрол олгох үйлчилгээ	Сургууль завсардсан болон сургуулийн гадна байгаа хүүхэд, насанд хүрэгчдэд боловсрол олгож , завсардалтын тоо 20%-р буурна.	97.4%	467.2	454.9	Төсвийн гүйцэтгэл 546,7 сая төгрөг. Сургууль завсардсан хүүхэд залуучуудад боловсрол нөхөн эзэмшүүлэх дүйцсэн хөтөлбөрийн сургалтад 362 хүнийг хамруулсан. Энэ нь сургууль завсардсан хүүхэд, залуучуудын 89% боловсрол нөхөн олгох сургалтад хамрагдсан. Огт сургуульд хамрагдаагүй, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 38 хүүхэд ерөнхий боловсролын сургуульд элсэх байснаас 26 хүүхдийг элсүүлсэн. Хөвсгөл аймгийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сургуульд хамруулах чиглэлээр хийж буй ажлууд нь улсын хэмжээнд туршлага болж байгаат БСШУСЯам, ХНХЯамнаас хамтарсан баг ирж туршлага судалсан. 2020 онд хэвтрийн хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 142 хүүхэд сургуулийн гадна байна. Эдгээр хүүхдүүдэд тохирсон уян хатан, гэрээр үйлчлэх боловсролын үйлчилгээ хэрэгцээтэй байна. Цаашид эдгээр хүүхдүүдэд "Айлчлах" боловсролын үйлчилгээг үзүүлэх зорилгоор төсөл хөтөлбөр боловсруулан Олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрт хандан ажиллаж байна.
		20.3.4.2	Дотуур байрны үйлчилгээ	"Хүүхдэд эзлтэй дотуур байр" хөтөлбөриг хэрэгжүүлэн сурагчдын сурлагын амжилтад ахиц гарч, тав тухтай амьдрах орчныг бүрдүүлнэ.				Төсвийн зарлагын гүйцэтгэл 4594,0 сая төгрөг буюу 100% зарцуулсан. 3696 хүүхэд дотуур байрны үйлчилгээ авсан. Дотуур байрын орчин нөхцөлийг сайжруулах зорилтын хүрээнд шинээр Түнэл, Цагаан-Үүр, Зүрх багт 300 хүүхдийн шинэ дотуур байрыг барьж ашиглалтад оруулаа. Хөл хорионы улмаас хичээллээгүй хугацаанд дотуур байрны хоолны хэмнэгдсэн зардлыг Аймгийн ИТХ-р хэлэлцүүлэн тодотгол оруулж 23 сум, 3 багийн бүх дотуур байрны зөөлөн эдлэлийг 400,0 сая төгрөгөөр иж бүрэн шинэчлэлээ. Дотуур байрны хүүхдийг гэрийн нөхцөлд суралцах боломжоор хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор иж бүрэн судалгаа хийж, эцэг эхчүүдэд зөвлөмж, сургалт хийн "Хүүхэд-итгэлийн харц" аяныг зохион байгуулсан. Хүнс тэжээлийн хомсдолд орсон сургууль, цэцэрлэгийн 2602 хүүхдэд 130,9 сая төгрөгийн хүнсний тусламж үзүүлсэн.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч. түүний хэрэгжүүлэх хөтөлбөр. хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар. танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт. бодлогын зорилтын хэрэгжилт. түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт. хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт. тасарсан бол шалтгаан/
		20.3.5	Биеийн тамир спортын арга хэмжээг улам өргөжүүлэх, шат шатны уралдаан тэмцээнд оролцогчдын тоо болон амжилтыг нэмэгдүүлэх	Шат шатны тэмцээнд оролцогчдын тоо болон амжилтыг нэмэгдүүлэх	98.2%	502.7	493.6	2020 оны жилийн эцсийн байдлаар 14 спортын төрлөөр 56 тамирчид амжилт үзүүлсэн байна. Үүнээс дэлхийн аварга болон дэлхийн цом олон улсын тэмцээнээс 5 алт, 6 мөнгө, 1 хүрэл медаль хүртсэн байна. Улсын чанартай тэмцээн уралдаанаас 7 алт, 12 мөнгө, 14 хүрэл медаль хүртсэн бол спортын цол зэрэг хүртсэн 9 тамирчин байгаа бол улсын рекорд амжилт үзүүлсэн 2 тамирчид байна. 2020 онд дэлхий нийтэд ковид-19 цар тахал тархсаны улмаас УОК, Засгийн газар, АОК, аймгийн Засаг даргын шийдвэрээр бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотойгоор аймгийн болон сумын чанартай тэмцээн уралдаан цуцлагдсан ба цахим хичээл сургалт, гарын авлага эзвлөмжүүдээр тандалт хийх 42 арга хэмжээнд 17968 хүн хамрагдсан болно.
		20.3.6	**Эмнэлгийн тусламж үйлчилгээ**					
		20.3.6.1	Сумын эрүүл мэндийн төвийн анхан шатны тусламж үйлчилгээ.	Нийт үзлэгийн 70%-д урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулсан байх, Эхний 3 сарын жирэмсний хяналтыг 90%-д, 6 бүюу түүнээс дээш удаа жирэмсний хяналтын үзлэгт хамрагдалт 100%-д хүргэх, Эх, хүүхдийн эндэгдлийг өмнөх оныхоос бууруулах, Халдварт өвчнийг бууруулах, ЭМДэмжигч айл, ерх, ААНБ-ыг нэмэгдүүлэх, Эрүүл зан үйлийг төлөвшүүлэх	99.6%	9,828.7	9,789.8	Аймгийн Эрүүл мэндийн газраас сумдын Засаг дарга, Эрүүл мэндийн төвийн дарга нартай хамтын ажиллагааны гэрээ байгуулан хагас, бүтэн жилээр дүгнэн цаашид анхаарах асуудлуудад зөвлөмж, чиглэл өгч хамтран ажиллалаа. 2020 онд сумдын гэрээний биелэлт 90.2%, ерхийн эрүүл мэндийн төв 92.3%-тай үнэлэгдлээ. Аймгийн хэмжээнд 2020 оны урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь 35.2%, эрт илрүүлгийн үзлэгийн дундаж хувь 71.2%, жирэмсний эрт үеийн хяналт 88% байна. 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн тохиолдлын тоо 47 бүртгэгдсэн нь 2019 оноос 17 тохиолдлоор буурч, 1000 амьд төрөлтөд 17.2 ногдож байна.
		20.3.6.2	Ерхийн эрүүл мэндийн төвийн анхан шатны болон НЭМ-ийн тусламж үйлчилгээ.					Ерхийн эрүүл мэндийн төвүүдийн гэрээг шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэж гаргахад Гурван гал ӨЭМТ бүрэн хангалттай 94%, Далайн- элбэрэлт ӨЭМТ 91.8 бүрэн хангалттай, Дэлгэрмөрөн ӨЭМТ бүрэн хангалттай 91.8, Энх-Үйлс ӨЭМТЗ бүрэн хангалттай 90.9, Энэрэл ӨЭМТ бүрэн хангалттай 93.7 % тус тус дүгнэгдсэн байна. Гэрээг дүгнэж дүгнэлт хийж Эрүүл мэндийн яам, Аймгийн Засаг дарга, Мөрөн сумын Засаг дарга түүний тамгын газар, Ерхийн эрүүл мэндийн төвүүдэд, албан бичгээр хүргүүлэн ажилласан. 2020 оны байдлаар 5 ерхийн эрүүл мэндийн төвийн Артерийн гипертензийн эрт илрүүлгийн үзлэгийн дундаж 87.3%, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.6 хувиар, Чихрийн шижингийн эрт илрүүлгийн үзлэгийн дундаж 85.8%, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6 хувиар, умай хүзүүний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгийн дундаж 61,7%, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2,1 хувиар тус тус буурсан. Хөхний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгийн дундаж 82,4% өмнөх оны түвшинд байна. Эрүүл мэндийн байгууллагууд нийт 644 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 7765 хүн хамрагдсан. Ганцаарчилсан зөвлөгөөнд 79386 хүнийг хамруулсан байна. Мэдлэг дадал бий болгох, эрсдэлийг бууруулах 5 сургалтыг Эрүүл мэндийн газраас 2017-оноос хойш анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудаар дамжуулан зохион байгуулж байна. Нэгтгэн дүгнэхэд 5 сургалтын хамрагдалтын дундаж хувь- 51,0%, мэдлэгийн ахиц 20%-тай байна. Үндэсний хөтөлбөрүүдийг 83.6% -тай амжилттай хэрэгжүүлсэн өмнөх оноос 1.97%-иар өссөн үр дүнтэй байна. Батлагдсан хуваарийн дагуу санхүүжилтийг олгон ажиллаж байна. 1103,3 сая төгрөг буюу 100,0%-ийн санхүүжилтийг олгосон байна.
		20.3.7	Газрын харилцаа, кадастр	Иргэд өмчлүүлсэн газрын хэмжээ нэмэгдэх, барилга байгууламжийн үгсралтын ажилд хяналт хийх ажлыг чанарт ахиц гарах	94.1%	638.9	601.3	Сумдын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу иргэнд өмчлүүлэх газрын нийт хэмжээ, байршил, зориулалтыг аймгийн хэмжээнд нэгтгэн аймгийн ИТХ-аар батлуулан ажилласан. Гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 1.44 га газар ээмшүүлэхээр төлөвлөснөөс 1.14 га газар, адэлбэр газартай амины орон сууцны зориулалтаар 1.8 га газар ээмшүүлэхээр төлөвлөснөөс 0.56 га газар, төрийн байгууллагад ээмшүүлэх, ашиглуулах зориулалтаар 0.16 га газар төлөвлөснөөс 0.16 га газар, үйлдвэрлэлийн зориулалтаар дуудлага худалдаагаар 1.18 га газар ээмшүүлэхээр төлөвлөснөөс 0.92 га газар, хууль бусаар газар ээмшилтийн талаар авах арга хэмжээнд 0.13 га газар төлөвлөснөөс 0.13 га газар, аймгийн ИТХ-ын 2020 оны төсвийн тодотголоор төрийн байгууллагад ээмшүүлэх газар 0.4 га төлөвлөснөөс 0.14 га газрыг ээмшүүлсэн.
		20.3.8	Хүүхэд хамгаалал, гэр бүл залуучуудын хөгжлийн асуудлыг тодорхойлох, шаардлагатай ажил үйлчилгээг зохион байгуулах.	Эрсдэлийн түвшин өндөртэй нас насны хүмүүсийн тоог цөөрүүлэх, секц дугуйланд хамрагдах хүүхдийн тоог нэмэгдүүлэх	94.1%	459.2	432.2	Үйл ажиллагааны чиглэлээр 10 төрлийн үйлчилгээг үзүүлснээр 2020 онд эрсдэлийн түвшин өндөртэйд тооцогдож байсан 2705 хүүхэд, 2620 гэр бүлийн асуудлыг шийдвэрлэж ажилласан байна. Шатар, даам, саробан сампин болон урлагийн чиглэлээрх сургалтуудыг зохион байгуулж байгаа бөгөөд 341 хүүхэд хамрагдаж байна. Төсвийн гүйцэтгэл 432,2 сая төгрөг буюу 93,8%-ийн гүйцэтгэлтэй байна.
21	**ХЭНТИЙ**					**87,251.0**	**77,181.6**	
	21.1	**Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа**				**2,029.4**	**1,972.0**	
		21.1.1	Аймгийн ИТХ-ын үйл ажиллагаа	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017-2020 оны үйл ажиллагааны үндсэн зорилт бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг бүрэн тооцож ажиллах	100%	2,029.4	1,972.0	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 16 дугаар хуралдаанд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017-2020 оны үйл ажиллагааны үндсэн зорилтын хэрэгжилт, баталсан хөтөлбөр төлөвлөгөөний биелэлтээ тайлагнаж, Төлөөлөгчдийн 96.2 хувийн саналаар "Хангалттай сайн үнэлгээ өгөгдсөн.
				Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн орон нутаг, сонгогдсон тойрог, иргэдтэйгээ эргэх холбоотой ажиллах, бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжийг хангах	100%			
				Улсын Их Хурлын баталсан хууль, тогтоомж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих Аймгийн Засаг даргын "8 Б" зорилт бүхий үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, дэд хөтөлбөрүүдийн заалт бүрийг хангуулах	100%			
				"Ногоон хөгжилд суурилсан тогтвортой хөгжлийн хэтийн зорилт-2026" хөтөлбөр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах, хяналт тавьж, дэмжлэг үзүүлж ажиллах	100%			
		21.1.2	ГХУСАЗЗ-ийн үйл ажиллагаа	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, тэргүүлэгчдэд олгогдсон бүрэн эрхийн хүрээнд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаг зохион байгуулах,	100%			Гэмт хэргийн гаралт, зөрчил өнгөрсөн оны мөн үеийнхээс 32-41 хувь түвшингээр буурсан үзүүлэлт гарсан.
				Сумдад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр арга зүйн зөвлөгөө, санхүүгийн дэмжлэг үзүүлж ажиллах	100%			
				Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажилладаг байгууллагуудтай хамтарч ажиллах, бодлого, үйл ажиллагааны дэмжлэг үзүүлэх	100%			
		21.1.3	ЦАУЗБСК-ийн үйл ажиллагаа	Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг	100%			Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, 107 иргэнд 40-80 сая төгрөгийн нөхөн олговор авах боломж бүрдсэн.
				Цагаатгах, нөхөн олговор олгохтой холбогдсон журмын хэрэгжилтийг хангаж, хуулийн шаардлага хангасан бүртгэл бүхий хүмүүст арга зүйн дэмжлэг үзүүлж, нөхөн олговрын материал баримт бичгийг шуурхай бүрдүүлэх, зарлуулах, шийдвэр гаргуулах, олгуулах талаар холбогдох байгууллагатай хамтарч ажиллах	100%			

№	Төсвийн ерөнхийлөн захирагч. түүний хэрэгжүүлэх хөтөлбөр. хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар. танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт. бодлогын зорилтын хэрэгжилт. түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт. хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт. тасарсан бол шалтгаан/
			Хэлмэгдэгсдийн ар гэрт анхаарал тавих, төрийн үйлчилгээнд зуучлах, хөшөө дурсгалыг сэргээх, засах, санал, өргөдлийг хүлээн авч шийдвэрлүүлэх	100%				
		21.1.4	Аймгийн ИТХ-ын хяналт шалгалтын ажил					
	21.2	**Орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ**				**29,958.1**	**24,166.0**	
		21.2.1	Иргэдэд үзүүлэх засаг захиргааны болон төрийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын бодлого шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллана.	100%	14,959.2	9,520.7	Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын бодлого шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.
		21.2.2	Орон нутгийн засаг захиргааны стратегийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаа	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллана.	100%	2,289.4	2,119.4	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг "Хангалттай сайн" гэж дүгнүүлсэн.
		21.2.3	Орон нутгийн засаг захиргааны бодлогын хэрэгжилтийг ханган үйл ажиллагаа	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллана.	100%			Аймгийн эдийн засаг нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг "Хангалттай сайн" гэж дүгнүүлсэн.
		21.2.4	Орон нутгийн засаг захиргааны хяналт шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаа	АИТХ-аар батлагдсан дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллана.	100%			Хэнтий аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 12 дэд хөтөлбөрийг 2017 онд аймгийн ИТХ-аар батлуулж, жил бүр төлөвлөгөө гарган ажиллаж байна.
		21.2.5	Урьдчилан төлөвлөх, нарийвчлан тооцож төсөвт тусгах боломжгүй, Засаг даргад хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой цаг үеийн арга хэмжээ	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллана.	100%			Төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан.
		21.2.6	Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ	Байгалийн сэргэн ургалтад туслах, ойн хөнөөлт шавжийн тэмцлийн ажил	100%	956.5	952.8	БОАЖЯ-ны тусгай зөвшөөрлөөр Гоц халдварт шулхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тандалт судалгааг 8 сумын нутаг дэвсгэр 16 цагаан зээрэс авсан. Шинжилгээгээр гоц халдварт өвчин илрэгүй. Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлүүдийн холбоо ТББ-тай хамтран Батширээт, Биндэр сумын нутаг дэвсгэрт амьдардаг ховор амьтдад биотехникийн арга хэмжээ авсан.
		21.2.7	Орон нутгийн мал эмнэлгийн үйлчилгээ	Малчинд ойрхон мал эмнэлэг	100%	142.8	142.8	Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 18 сумын 1742200 тун вакциныг хуваарилан олгож дархлаажууллаа.
		21.2.8	Замын сан	Төсөл арга хэмжээг бүрэн санхүүжүүлж ажиллана.	100%	435.8	420.9	2020 онд 420.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 7 төсөл арга хэмжээг баталсан.
		21.2.9	Жолоочийн даатгалын сангийн үйл ажиллагаа					
		21.2.10	Нийтлэг үйлчилгээний алба					
		21.2.11	**Хот тохижуулах газар**			**921.2**	**921.2**	
		21.2.11.1	Хот тохижилт, үйлчилгээний үйл ажиллагаа	Чингис хотын VI-н багт нохой устгалыг үе шаттай явуулах. Замын боржуриг шохойдох, гэрлийн шонг будах мөн цэцэрлэгт хүрээлэнгүүдийг будаж, тэмдэг тэмдэглэгээг сэргээн засах.	100%	921.2	921.2	Хэрлэн сумын бүх багуудыг хамарсан нохой устгалын ажлыг зохион байгуулж 98 % иар хийж гүйцэтгэлээ.
		21.2.11.2	Гудамжны гэрэлтүүлэг, цэвэрлэгээ	Хэрлэн сумын гудамж талбайн 810 гэрэлтүүлгийг асааж эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх. Чингис хотын төвийн 32 км засмал болон явган хүний зам, цэцэрлэгт хүрээлэнг 14 үйлчлэгчдэд хуваарилан тогтмол цэвэрлэх.	100%			Чингис хотыг цэвэр цэмцгэр байлгах байгууллагын үйл ажиллагааны зорилгыг хэрэгжүүлэхийн төлөө нийтийн эзэмшлийн зам талбайг тогтмол хуваарийн дагуу цэвэрлэгээ, засвар, үйлчилгээний тасралтгүй байдлыг ханган ажиллаж байна.
		21.2.11.3	Ногоон байгууламжийн үйл ажиллагаа	Хэрлэн сумын ногоон байгууламжийг усалгаа арчилгаа тогтмол хийх.	100%			Ногоон байгууламжийн усалгаа, арчилгаа тайралтыг цаг хугацаанд нь гүйцэтгэж байна.
		21.2.11.4	Хог хаягдлын тээвэрлэлт, устгах, дарах үйлчилгээ	Хэрлэн сумын 5160 өрх айл мөн бүх аж ахуй нэгж байгууллагын хог хаягдлыг ачих, тээвэрлэх, булшлах үйл ажиллагаа явуулах.	100%			Төвийн багуудын айл өрх болон албан газар аж ахуйн нэгжийн хог хаягдлыг өдөр бүр тасралтгүй ачиж дарж булах устгах ажлыг хийж байна.
		21.2.12	Аймгийн орон нутгийн өмчийн газар	Худалдан авах ажиллагааны талаар: Төсөл, тендер шалгаруулалтыг цахим худалдан авалтад шилжүүлж, орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжиж ажиллах	100%	136.3	127.8	2020 онд хэрэгжсэн улсын болон орон нутгийн төсвийн, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний хүрээнд бий болсон 17.3 тэрбум төгрөгийн үнэ бүхий эд хөрөнгүүдийн эзэмшигч, ашиглагч байгууллагуудыг тодруулан тухайн байгууллагын балансад бүртгүүлэх ажлыг зохион байгуулав. Мөн хандив тусламж болон байгууллага өөрийн нэмэлт санхүүжилтээр худалдан авсан нийт 5.2 тэрбум төгрөгийн үнэ бүхий эд хөрөнгүүдийг байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэх зөвшөөрөл олгов.
				Өмчийн харилцааны талаар: Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт тавьж өмч эзэмшлийн гэрээний дүгнэх ажлыг тогтмолжуулж өмч эзэмшлийн гэрээний үр дүнг байгууллагын дарга эрхлэгч нарын жилийн ажлыг дүгнэх нэг үзүүлэлт болгож хэвших, үл хөдлөх хөрөнгө болон үндсэн хөрөнгөнд хамаарах хөдлөх хөрөнгийг олж авах саналыг хэрэгцээ шаардлагад нь үндэслэн ОНӨГазрын зөвшөөрлөөр тухайн оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж батлуулж ажиллах				Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой байгууллагуудын өмч эзэмшүүлэх гэрээний биелэлтийг дүгнэх ажлыг газрын даргаар батлуулсан удирдамжийн дагуу 2020 оны 11-р сараас эхлүүлэн 2020 оны 12-р сарын 24-нд гүйцэтгэж дуусан болно. Өмч эзэмшүүлэх гэрээний биелэлтийг дүгнэх ажилд нийт 202 орон нутгийн өмчит байгууллагуудыг 100 хувь хамруулж ажилласан бөгөөд гэрээ дүгнэсэн дундаж үнэлгээ 88.2 хувь байгаа нь өмнөх оны үзүүлэлтээс 1.1 хувиар нэмэгдсэн байна.
		21.2.13	Орон нутгийн ахмад настанд үйлчлэх кабинет	Аймгийн Ахмадын хороонд дэмжлэг үзүүлнэ.	100%	65.8	64.9	Аймгийн Ахмадын хороонд дэмжлэг үзүүлж ажилласан.
				Ойжуулалт, байгалийн сэргэн ургалтад туслах, ойн хөнөөлт шавжийн тэмцлийн ажил	100%			1060 га-д
				Түймрээс хамгаалах харлуулсан шороон зурвас татах	100%			100 км
				Ногоон байгууламж нэмэгдүүлэх, байгалийн ургамлын нөөцийн суурь судалгааг гарах	100%			5 га
				ЕБСургуулийн багш, сурагчдын дунд "Тогтвортой хөгжлийн боловсролын олимпиад"-ыг зохион байгуулна.	100%			1 удаа
				Жилд хүлээн авах гадаад, дотоодын жуулчдын тоог нэмэгдүүлэх	100%			43500
				Гадаргын усны тооллого зохион байгуулах	100%			Хэрлэн голын сав газарт хамаарах 11 сум, Умард говийн гүвээт халхын дундад талын сав газарт хамаарах -3 сумын нутаг дэвсгэрт гадаргын болон гүний усны тоо бүртгэлийн ажлыг сав газрын захиргаадтай хамтран зохион байгуулж, мэдээллийн санд бүртгэсэн.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч. түүний хэрэгжүүлэх хөтөлбөр. хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар. танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт. бодлогын зорилтын хэрэгжилт. түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт. хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт. тасарсан бол шалтгаан/
		21.2.14	Байгаль орчин аялал жуулчлалын газар	Онон голыг онцгой хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлэх	100%	563.5	561.4	Онон голын онцгой хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдүүлэх, иргэдэд мэдээлэл хүргэх зорилгоор Батширээт, Биндэр, Баян-Адрага сумдын нутаг дэвсгэрт 40ш тэмдэгжүүлэлтийг Цахиурт Өндөр ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн.
				ын менежментийг сайжруулах төлөвлөгөө бол	0%			Хийгдэгүй
				Ядарсан, гэмтсэн, дүрвэсэн амьтдыг тэжээн тэнхрүүлэх хорогдос байр,хашаа барих	100%			Ядарсан гэмтсэн, дүрвэсэн амьтдыг тэжээн тэнхрүүлэх зорилгоор шургаагаар 98 м2 хорогдос байрыг Мөрөн сумын нутаг дэвсгэр Өндерхаан ууланд байгуулсан. Уг ажлыг "Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлүүдийн холбоо" ТББ хийж гүйцэтгэсэн.
				Мониторинг ажиглалт судалгааг хийх хөдөлгөөнт камераар ажиглалт хийх	100%			Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, зөрлөг амьтадын тандалт судалгаа хийх зорилгоор Хөдөлгөөн мэдрэгч автомат камер 10 ширхэгийг дагалдах хэрэгслийн хамт Монгол шилажит ХХК-тай гэрээ байгуулан худалдан авч ашиглаж байна.
				Зөрлөг амьтанд гоц халдварт өвчний тандан судалгааг явуулж, нэн ховор, ховор амьтны байршил нутагт биотехникийн арга хэмжээ авах,тэжээлийн цэгийг бий болгож, мониторинг судалгааг явуулах	100%			БОАЖЯ-ны тусгай зөвшөөрлөөр Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тандалт судалгаг 8 сумын нутаг дэвсгэр 16 цагаан зээрэс авсан. Шинжилгээгээр гоц халдварт өвчин илрэгүй. Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлүүдийн холбоо ТББ-тай хамтран Батширээт, Биндэр сумын нутаг дэвсгэрт амьдардаг ховор амьтдад биотехникийн арга хэмжээ авсан.
				Хэнтий аймгийн Хэрлэн голын агнуурын ач холбогдолтой загасны нарийвчилсан агнуур зохион байгуулалт, менежментийн төлөвлөгөөг боловсруулах	100%			Хэрлэн голын агнуурын ач холбогдолтой 9 сумын нутаг дэвсгэрт Загасны нарийвчилсан агнуур зохион байгуулалтыг мэргэжлийн байгууллага болох Эко үйлчилгээ ТББ-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж, БОАЖЯ-нд хүргүүлж батлуулсан.
		21.2.15	Сумдын ойн анги	Ойжуулалт -60 га ,Ойн хөнөөлт шавж устгах ажил-1000 га ,Тарьц, суулгац үржүүлэх-100 ширхэг Ногоон байгууламж нэмэгдүүлэх ажил-5 га , Бүх нийтээр мод тарих ажлыг зохион байгуулах ажил-2 удаа ,Ойн нөхөрлөлүүдийн ойн менежмент төлөвлөгөөнд хяналт тавих, "Нөхөрлөл хөгжил" 2019 наадмыг зохион байгуулах -1 удаа	100%	208.7	192.4	Ойжуулалт -60 га ,Ойн хөнөөлт шавж устгах ажил-1000 га ,Тарьц, суулгац үржүүлэх-100 ширхэг Ногоон байгууламж нэмэгдүүлэх ажил-5 га , Бүх нийтээр мод тарих ажлыг зохион байгуулах ажил-2 удаа ,Ойн нөхөрлөлүүдийн ойн менежмент төлөвлөгөөнд хяналт тавих, "Нөхөрлөл хөгжил" 2019 наадмыг зохион байгуулах -1 удаа
		21.2.16	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	Төсөл арга хэмжээг бүрэн санхүүжүүлж ажиллана.	100%	898.5	859.6	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд 898.5 сая төгрөгийн 38 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлан ажилласан.
		21.2.17	Аймгийн халамжийн сан	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ болон амьжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тусламжийн үйлчилгээг зориллот бүлэгт чанартай хүргэж төсвийн зарцуулалтын ур ашгийг дээшлүүлэн ажиллана	100%	134.7	126.7	2020 онд Орон нутгийн төсвөөс Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний бүлгийн төсөлд 65 иргэнийг хамруулан 41.2 сая төгрөг , сэргээн засах үйлчилгээнд 25 иргэнийг хамруулж 2.7 сая төгрөг мөн Амьжиргаг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмжид 69 өрхийг хамруулан 82.8 сая төгрөг тус тус олгож төсвийг зориулалтын дагуу зарцуулсан.
		21.2.18	Санхүүгийн хяналт, аудитын алба	Байгууллагын дотоод хяналтын нэгжийн ажлыг тогтмолжуулж, эрсдэлийг тодорхойлж түүнийг бууруулах, гаргахгүй байхад анхаран ажиллана	100%	132.4	131.5	2020 онд нийт 77 объектод хяналт шалгалт, дотоод аудит хийснээс 53 газарт төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдэж бүгд 100% "БАГА" эрсдэлтэй үнэлэгдсэн.
				Төсөвт байгууллагуудад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, эрсдэлийг бууруулан санхүүгийн үйл ажиллагааг сайжруулна	100%			Жил бүр төсөвт байгууллагуудын эрсдэл бууруулах зорилготой 70 гаран объектод санхүүгийн хяналт шалгалт хийж, холбогдох хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар байнга зөвлөн тусалж ажиллаж байна.
		21.2.11	Орон нутгийн хөгжлийн сан	Төсөл арга хэмжээг бүрэн санхүүжүүлж ажиллана.	100%	8,113.3	8,023.9	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд 6723.9 сая төгрөгийн 194 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлан ажилласан.
21.3	**Улсын төсвөөс авах тусгай зориулалтын шилжүүлгээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ**					**55,263.5**	**51,043.6**	
		21.3.1	Сургуулийн өмнөх боловсрол	Сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж 2-5 настай хүүхдийг бүрэн цэцэрлэгт хамруулах	100%	14,398.8	12,644.5	Ковид-19 цар тахлын улмаас БШУ-ны сайдын тушаал гарч анги дүүргэлтийг багасгах чиглэл өгсний дагуу хүүхдийн хамрагдалт багассан. Энэ онд нийт хүүхдийн 82,2%-ийг хамруулсан.
		21.3.2	Ерөнхий боловсрол	Ерөнхий боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж , хамран сургалтыг өмнөх оныхоос 1,7 хувиар нэмэгдүүлнэ. Дотуур байрны хамрагдалтыг өмнөх оныхоос 2,8 хувиар нэмэгдүүлнэ.	100%	28,219.4	26,386.2	Статистик тоо мэдээгээр 17483 хүүхэд байгаагийн 15889 хүүхэд буюу 90,8 хувь нь Хэнтий аймагт ЕБС-д хамрагдаж байна. Бусад хүүхдүүдийн хувьд суурь боловсрол эзэмшин сургуулиас гарсан, дараагийн шатны буюу МСҮТ, Политехникийн коллежид орсон, өөр аймаг сум руу шилжсэн шалтгаантай байна. Дотуур байранд суух хүсэлт гаргасан 1592 хүүхдийн 1470 буюу 92,3%-ийг хамруулсан.
			Соёлын үйлчилгээ	Зүүн монголын уламжлалт соёлын өвийг хадгалан хөгжүүлж, зорилтот зах зээлд суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээ, уран бүтээлийг хүргэдэг бүс нутгийн тулгуур чуулга болно	100%	1,157.1	908.8	Нөөцийн удирдлагыг оновчтой зөв ашиглаж, чанартай уран бүтээл туурвихын тулд Монголын Морин Хуур Чуулгын ерөнхий удирдаач Улсын Филармонийн уран сайхны удирдагч Д.Түвшинсайханаар удирдуулан хөгжмийн тогломт зохион байгуулах болсонч тогломт цуцлагдсан , үзвэр үйлчилгээний чанар дээр анхааран үзэгчдэдээ тав тухыг үзүүлэх зорилгоор теле тоглолтуудыг онлайнаар тоглож үзэгчдийн хүртээл болгоод байна.
			Сумдын соёлын төвүүд	Үзэгчдийн эрэлт хэрэгцээг хангасан соёл олон нийтийн шинэлэг үйлчилгээг тасралтгүй явуулахад анхаарч, соёлын төвийн үзэгчдийн тоог нэмэгдүүлэх	100%	2,372.4	2,183.9	Соёлын төвүүдийн үйлчилгээний чанар хүртээмж сайжирсан.
			Музей	Музейн сан хөмрөгийг баяжуулж, улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд бүртгэн баримтжуулах	100%	184.6	183.9	Музейн сан хөмрөгийг Засгийн азрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын санхүүжилтээр 20.480.000 төгрөгийн үнэ бүхий 11 дэсийн 11 ширхэг үзмэр, эд өлгийн зүйлс, бэлэг хандиваар 6 дэсийн 6 ширхэг үзмэр, эд өлгийн зүйлсээр баяжуулж улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд бүртгэлээ. Үүнд: Хардэл жанжин бэйс өвгөн ноён М.Пүрэвжавын өөрийн гараар зурсан "Хошуу наадам" зураг, Ар халхын 7 баяны нэг олноо "Ланс баян" хэмээн алдаршсан М.Цогбадрахын эхнэрийн эдлэж байсан монгол гутал,гар тээрэм, Урианхай дээл, хөгжмийн зэмсгүүд, тамганы хайрцаг, танк зураг
				Түүх, соёлын үл хөдлөх 6730 дурсгалын 50-иас доошгүй хувийг сумдын ЗДТГ-тай хамтран Иргэдийн оролцоотойгоор соёлын үл хөдлөх дурсгалын 10% нь харуултай хамгаалалттай болсон байх	100%			Улсын бүртгэл мэдээллийн сангийн түүх, соёлын үл хөдлөх дурсгалын нэгдсэн бүртгэлд Хэнтий аймгийн 992 дурсгалт газрын 6885 дурсгал бүртгэлтэй байдаг. Үүнээс 2016-2020 оны байдлаар нийт дурсгалын 64,5 хувийг гэрээт харуултай болгож ажиллалаа.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч. түүний хэрэгжүүлэх хөтөлбөр. хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар. танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт. бодлогын зорилтын хэрэгжилт. түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт. хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт. тасарсан бол шалтгаан/
		21.3.3	Номын сан	Ном уншлагыг дэмжих олон талт арга хэмжээг зохион байгуулж, номын сангаар үйлчлүүлэх уншигчдын тоог нэмэгдүүлэх, номын фондыг цахим каталогт оруулах	100%	135.3	135.0	1.Хандив тусламж, батлагдсан төсөв болон нөхөн бүрдүүлэлтээр нийтдээ 539 нэр төрлийн 575 ширхэг 5925.6 мян.төг-ийн сан хөмрөгийн баяжилт хийж үүнээс батлагдсан төсвийн 3.2 хувиар буюу 3905.3 мян.төг-өөр 149 нэр төрлийн 171 ширхэг, хандив тусламжаар 390 нэр төрлийн 404 ширхэг номоор сан хөмрөгөө баяжуулсан. Эдгээрийг мэдлэгийн анги салбараар нь ангилбал байгалийн шинжлэх ухаан 2, техник 7, хөдөө аж ахуй 30, анагаах ухаан 32, түүх 55, улс төр 5, эдийн засаг 20, соёл, шинжлэх ухаан боловсрол 45, хэл шинжлэл 3, аман зохиол утга зохиол 14, уран зохиол 254, урлаг 19, шашин 2, гүн ухаан 25, сэтгэл судлал 2, лавлах хэвлэл 59 тус тус байна. Үүнийг нэгбүрчилсэн бүртгэлд бүртгэж 4 танхимд хуваариллаа. Үүнд нийтийн уншлагын танхимд 92, гэрээр ном олгох танхимд 301, хүүхдийн танхимд 41, сан хөмрөгт 182 ширхгийг тус бүрээр хуваарилав. Жилийн эцсийн байдлаар батлагдсан төсвөөс хэмнэлт хийж ном хэвлэлийн зардалд шилжүүлснээр 1780.0 мян.төг-ийн ном хэвлэл худалдан авч нийт 130701.8 мян.төг-ийн 52016 ширхэг номын үндсэн сан хөмрөгтэй. 2. Аймгийн Засаг даргын дэмжлэгтэйгээр номын сангийн электрон каталог нь 2019 оны 09 сарын 02-ны өдрөөс эхлэн khentii.LiB4U.Net гэсэн хаягаар интернэт орчинд байршиж өнөөдрийн байдлаар 20813 нэр төрлийн 50264 ширхэг ном цахимд бүртгэлжүүлэн, варкод нааж электрон хэлбэрт орууллаа. Нийт номын 96.6 хувийг цахимд байршууллаа. Үүнээс номын санч тус бүрээр харуулахад: Нийтийн уншлага болон Хүүхдийн уншлагын танхимууд сан хөмрөгтөө буй номоо 100 хувь цахимжуулж Сан хөмрөгийн танхим 85.3, Гэрээр ном олгох танхим 98.6 хувийн тус тусын биелэлттэй байна.
				Хүүхэд залуусын номтой нөхөрлөх иргэд олон нийтийн ном унших боловсролыг дээшлүүлэх зорилгоор “Ном уншицгаа” хөдөлгөөнийг өрнүүлэх	100%			Сар бүрийн сүүлчийн долоо хоногийн Бямба гариг бүрийг гэр бүлийн өдөрт зориулан “Гэр бүлийн уншлага” үйлчилгээ явуулж СӨБ-ын болон ЕБС-ийн бага ангийн сурагчдын эцэг эхийн хамт урилгат уншлага зохион байгуулж уншсанаа ярилцах, ном уншиж өгөх, зохиолын баатруудаараа бүтээлч ажил зохион байгуулах, цаасан хайчилбар хамтдаа бүтээж танин мэдэхүйн хөгжөөнт тэмцээн зохион байгуулж ирсэн. Үлгэрийн цаг урилгат уншлага зохион байгуулж Хэрлэн сумын ЕБС-ийн бага ангийн 362 хүүхдүүдийг хамруулан 543 гаруй номоор үйлчиллээ. Нийтийн уншлагын танхимаар үйлчлүүлэгчдийн дунд “Соёлтой уншигч аян”, “Ном уншихын ач тус” сэдэвт номд дурлах, сэтгэлгээг хөгжүүлэх, багаар ажиллах ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор ЕБС-ийн ахлах ангийн давхардсан тоогоор 60 гаруй сурагчдыг хамруулан номыг хэрхэн гамтай цэвэр нямбай унших, уншсанаа тэмдэглэх, ярилцах зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Онцгой байдлын газрын нийт албан хаагчдад ажлын байран дээр нь номын өдөрлөг зохион байгуулж хуучин монгол бичгээрээ унших, бичих уралдаан, АХА хөгжөөнт тэмцээн, зөөврийн номын сангийн үйлчилгээ, уншигчийн карт үнэ төлбөргүй нээх, сэдэвчилсэн номын үзэсгэлэн үзүүлэх зэрэг арга хэмжээг хамтран зохион байгууллаа
				“Үндэсний бичиг соёлын өдөр”-ийн хүрээнд “Бичиг үсгийн баяр” монгол бичгийн “Уран бичлэг”-ийн уралдаан зохион байгуулах	100%			Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 105 дугаар зарлигаар жил бүрийн 5 дугаар сарын эхний ням гаригийг Монголын "Үндэсний бичиг соёлын өдөр" болгож, үндэсний хэл бичиг, түүнтэй холбогдолтой ёс заншил, уламжлал, өвийг судлах, сурталчлах, үндэсний бичгээ чадмаг ээмших, ур хүүхдэдээ зааж өвлүүлэх талаар өргөн олонд хүртээлтэй ажил өрнүүлэн ард нийтээр тэмдэглэн ирсэн. Үндэсний бичиг үсгийн баярыг тохиолдуулан бүх насны хүмүүсийг үндэсний бичгээрээ зөв сайхан цэвэр бичихэд уриалах, алдаршуулах зорилгоор С.Дулам “Хүмүүн бичиг”, Б.Рөнчин “Монгол хэл” шулгийг монгол бичгээр бичсэн бүтээлийг цахимаар сурталчлан Үндэсний бичиг үсгийн баярыг тохиолдуулан номын үзэсгэлэнгийн тавиурыг шинэхэн хийж, монгол бичгийн номын үзэсгэлэнг 24 номоор, бичиг соёлын түүхийн холбогдолтой 13 номоор үзэсгэлэн гаргаж, мөн 8 номоор санамж өгөх ном зүйн бүртгэл хийж онлайн орчинд байршуулж сурталчилсан бөгөөд нийт 3200 орчим хүмүүсийн хандалт авсан. Үндэсний бичиг үсгийн баяртай холбогдуулан сан хөмрөгт байгаа бичиг үсэг, биет болон биет бус өв соёл, угсаатны зүй, монголын түүх соёлын дурсгалт зүйл зэрэг 8 номыг тодорхойлох товч ном зүйг танилцууллаа.
		21.3.4	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ	Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн хүний нөөцийн хангалтыг сайжруулах, эхийн эндэгдэлгүй ажиллах, нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг улс, аймгийн дундаж түвшинд хүргэх, жирэмсний эрт үеийн хяналтыг сайжруулж 85,0 хувьд хүргэх, зорилтот насны хүн амын дунд халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийг зохион байгуулж ажиллах	100%	7,196.4	7,034.0	Сум өрхийн эрүүл мэндийн төвүүдийн хүний нөөцийн хангалтыг 98 хувьд хүргэж, багийн 60,0 хувь нь эмчээр хангагдсан байна. 2019 онд эхийн эндэгдэлгүй ажилласан, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 14.5 промиль улс аймгийн дундаж түвшинээс бууран үзүүлэлттэй байна. Эрт үеийн жирэмсний хяналт 89.7% болж өмнөх оны мөн үеэс өссөн. Бие эрүүл Хэнтийчүүд, Элэг бүтэн Хэнтийчүүд хөтөлбөрийг зорилтот насны хүн амын дунд хэрэгжүүлж ажилласан.
				Халдварт өвчний гаралтыг бууруулж улсын дундаж түвшинд хүргэх. Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр: Хүн амын эрүүл мэндийг дэмжих, эрүүл бус зан үйлийг өөрчлөх, эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлэн ажиллах, товлолт дархлаажуулалтын хувийг нэмэгдүүлнэ.				
		21.3.5	Газрын харилцаа, кадастр	төлөвлөгөөг хэрэгжүүлэх, аймгийн эдийн засаг нийгмийн зорилтыг хот байгуулалт, төлөвлөлтийн бодлоготой уялдуулан хотын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах газрын кадастр эрхлэх, мэдээллийн сан байгуулж иргэдэд мэдээллээр үйлчлэх	100%	594.3	586.8	Хүн амын дунд халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг сэдэвчилсэн төлөвлөгөөний дагуу сар бүр зохион байгуулан ажиллаж байна. .Товлолт дархлаажуулалтыг 98,9 хувьд хүргэн ажилласан.
		21.3.6	Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ	Хууль эрчсэн болон хохирогч хүүхэд хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үзүүлсэн үйлчилгээний үр дүн, шийдвэрлэлтийн хувь	100%	376.6	354.3	Монгол Улсын Хаягжуулалтын тухай хууль, Засгийн газрын 2013 оны 280 дугаар тогтоолоор батлагдсан “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам”, MNS 5283:2014 стандартын дагуу хаягийн тэмдгийг суурилуулах ажлыг хийж гүйцэтгэлээ. “Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сан”-ийн программ хангамжийг нэвтрүүлж барилга байгуулламжийн суурь мэдээллийг бүрэн оруулаад байна.
		21.3.7	Нийтийн биеийн тамир	Хүүхдийн спортын их наадмыг орон нутагт зохион байгуулах, шигшээ тэмцээнд оролцох	100	628.6	626.2	Бүх төрөлд амжилттай оролцсон.
				Нийтийн биеийн тамир, спортыг орон нутагт хөгжүүлэх “Эрүүл мэнд-Хөдөлгөөн-Хөгжил” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх	100			Хөтөлбөрийн хэрэгжилт 70%-тай байна.
				Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг дэмжих	100			ӨШБагийн үйл ажиллагаа хэвийн явагдах таатай орчныг бүрдүүлэн ажиллаж байна
				Хан Хэнтий нутгаас Олон улс, Тив, дэлхий, олимпын наадмын спортын тэмцээн уралдаанд оролцож амжилт гаргасан гаргасан тамирчид, багш, дасгалжуулагчдыг урамшуулах	80			Медаль хүртсэн тамирчдыг хамруулсан.
				Спортын эрдэм шинжилгээ, мэдээллийн технологийн сан байгуулах	100			Сан бүрдүүлэлтийг 70%-д хүргэсэн.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч. түүний хэрэгжүүлэх хөтөлбөр. хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар. танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт. бодлогын зорилтын хэрэгжилт. түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт. хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт. тасарсан бол шалтгаан/
				Шигшээ багийн дасгалжуулагч,тамирчдын мэдээллийг программд шивж санг бүрдүүлэх.	70			Шигшээ багийн дасгалжуулагч,тамирчдын мэдээллийг программд шивж санг бүрдүүлэн ажилласан.
				Дасгалжуулагч, тамирчдыг мэдлэг, мэргэжил, ур чадварыг сайжруулах, туршлага солилцох гадаад, дотоодын хамтарсан бэлтгэл, сургалт семинарт хамруулах, орон нутагт зохион байгуулах;	90			4-5 удаа оролцуулж, улирал бүр сургалт зохион байгуулсан
22	**УЛААНБААТАР**					**1,709,254.6**	**1,357,177.3**	
		Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагаа				**38,324.7**	**33,962.0**	
		22.1.1	Аймгийн ИТХ-ын үйл ажиллагаа	ИТХ–ын чиг үүргийг цаг хугацаанд бүрэн хэрэгжүүлэх.	НИТХ–ын ээлжит хуралдаан, Тэргүүлэгчдийн хуралдааныг товлосон хугацаанд багтааж хуралдаж, хэлэлцэх асуудлыг бүрэн шийдвэрлэсэн.	27,674.9	23,514.0	Монгол Улсын хууль тогтоомж, Төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэхтэй уялдуулан нутаг дэвсгэрийн хөгжлийн бодлого, төлөвлөлт, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулан хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийт 10 баримт бичиг, дэд хөтөлбөр, төсөл, журмыг хэлэлцэн батлаж, хэрэгжилтийг хангуулан ажилласан. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон Нийслэлийн ИТХ-ын Хуралдааны дэгийн дагуу 2020 онд ээлжит хуралдаан 6 удаа, ээлжит бус хуралдаан 4 удаа, нийт 10 удаа цахимаар тус тус зохион байгуулж, нийт 31 асуудал хэлэлцэж 24 тогтоол гарсан. Ковид-19 халдварын тохиолдол Монгол улсад батлагдаж, Монгол Улсын Засгийн газраас гаргасан шийдвэр, ДЭМБ-аас гаргасан зөвлөмжийн дагуу цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үүднээс Нийслэлийн ИТХ цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалж 3,4,6,8 дугаар саруудад хуралдаан зохион байгуулаагүй болно.
	22.1	22.1.2	ГХУСАЗЗ-ийн үйл ажиллагаа	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хуульд заагдсан арга хэмжээг хуулийн дагуу бүрэн хэрэгжүүлэх.	үүл болон бусад гэмт хэргээс урьдчила	10,649.8	10,448.0	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас нийслэлийн хэмжээнд 2020 онд ажиллах олон нийтийн цагдаагийн орон тоог 200 байхаар баталсан бөгөөд энэ онд цалин, урамшуулалд 1,086,443,963 төгрөгийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас шийдвэрлүүлэн олгосон. Олон нийтийн цагдаагийн дутуу орон тоонд 2 удаа сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, 67 иргэн 2 удаа цахим сургалтыг зохион байгуулж, ур дүнг тооцон шалгалтад тэнцсэн 26 иргэнийг газрын даргын 2020 оны Б/221 дүгээр тушаалаар харьяа дүүрэг дэх цагдаагийн хэлтсүүдэд томилон ажиллуулж эхэлсэн. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 46 дугаар тогтоолоор "Олон нийтийн цагдаагийн тоог 1700-аар нэмэгдүүлэн ажиллуулахаар болсонтой холбогдуулан 960 олон нийтийн цагдаагийн чиг үүрэгтэй хэсгийн ахлагч нарыг сургалтад хамруулж, бичиглэл бичий хантааз, малгай, үнэмлэх, нэрийн бичиглэл, ялгах тэмдэг хийлгэх 76.5 сая төгрөгийг, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2020 оны 94 дүгээр захирамжаар Covid-той холбогдуулан олон нийтийн цагдаа нарт халдвар хамгааллын хувцас хэрэгсэлд 96.100.000 төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэн тус тус үйл ажилагаандаа зарцуулсан. Нийслэлд нийт 220 олон нийтийн цагдааг ажиллуулж байна. - Нийслэлийн Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, жуулчдын аюулгүй байдлыг хангах, тэдэнд мэдээлэл сэрэмжлүүлэг, зөвлөгөө хүргэх ажилд оюутан залуусын оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 200 олон нитийн цагдаагийн хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэглэл бүюу дүрэмт хувцас, хамгаалах нэг бүрийн хэрэгсэлд нийслэлийн төсвөөс 1.6 тэрбум төгрөгийг төсөвлөж нийт 200 ширхэг олон нийтийн цагдаагийн хөдөлмөр хамгааллын хувцсыг худалдан авч, хамгаллын хувцас хэрэгслээр бүрэн хангаж ажилласан. Нийслэл хотод 2020 онд 14.633 гэмт хэрэг үйлдэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 5628 нэгжээр буюу 27.8 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна.
		22.1.3	ЦАУЗБСК-ийн үйл ажиллагаа			-	-	
		22.1.4	Аймгийн ИТХ-ын хяналт шалгалтын ажил			-	-	
		Орон нутгийн төсөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ				**1,163,197.6**	**845,654.3**	
		22.2.1	Иргэдэд үзүүлэх засаг захиргааны болон төрийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа			-	-	
		22.2.2	Орон нутгийн засаг захиргааны стратегийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагаа			-	-	
		22.2.3	Орон нутгийн засаг захиргааны бодлогын хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа	Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хуулийн хүрээнд ажиллана.	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээнд шинэ менежмент нэвтрүүлэх, мэдээллийн технологийн ухаалаг шийдлүүдийг ашиглах, төрийн албан хаагчийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, хариуцлагыг дээшлүүлэх замаар төрийн үйлчилгээг иргэдэд ШУУРХАЙ, ТЭГШ, НЭЭЛТТЭЙ хүргэн ажиллаа. Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төв болон нутгийн захиргааны байгууллагуудад мөрдөгдөж байгаа эрх зүйн зохицуулалтыг шинэчлэн, шаардлагатай дүрэм журмыг баталж мөрдүүлэн ажилласан. Нийслэл үйлчилгээний нэгдсэн төвөөс үзүүлж байгаа төрийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулсан.	185,071.8	168,667.6	2020 онд батлагдсан нийт зарлагын төлөвлөгөөний биелэлт 79.8-тай гарсан. Энэ нь Монгол улсын засгийн газрын 2020 оны "Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах арга хэмжээний тухай" 114 дүгээр тогтоол, "Коронвируст халдварын цар тахлын үед төсвийн зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай" 168 дугаар тогтоол, "Төсвийн ерөнхийлөн захирагч нарт зохицуулалтын эрх олгох тухай" 187 дугаар тогтоолуудын дагуу төсвийн байгууллагуудын зардлыг эрэмбэлэн санхүүжүүлэх, зарим зардлын санхүүжилтийг түр зогсоосонтой холбогдон гарсан хэмнэлт болно. Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвөөс үзүүлж байгаа төрийн үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах ажлын хүрээнд: -НҮНТ-өөс иргэн, хуулийн этгээдэд 273 нэр төрлийн төлбөртэй үйлчилгээг үзүүлж байгаа бөгөөд банкны ачааллыг бууруулж, иргэдийн цагийг хэмнэн, нэг цонхноос цогц үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэх зорилгоор төлбөр хураамжтай үйлчилгээг цахим хэлбэрээр төлөх боломжийг бий болголоо. Төрийн үйлчилгээний төлбөрийг уламжлалт хэлбэрээр /банкнаас цаасан суурьтай/, пос төхөөрөмж, "Гэрэгэ" Киоск төхөөрөмж, QPay /банкны аппликэйшн/, И-баримт /татварын гар утасны аппликэйшн/ зэрэг төрийн үйлчилгээний төлбөрийг иргэн өөрийн боломжит хувилбарыг сонгон төлөх боломжтой юм. Төрийн мэдээлэл солилцооны ХУР нэгдсэн систем, танилт нэвтрэлтийн ДАН нэгдсэн системтэй холбож, төрийн үйлчилгээг үзүүлэхэд иргэний үнэмлэх шаардахгүйгээр иргэний бүртгэлийн мэдээллийг тоон гарын үсгээр баталгаажуулан ХУР системээс татан ашиглах боломжийг бүрдүүлж, ЗГ-ын тохируулагч агентлаг ХХМТГ-аас төрийн байгууллагуудын мэдээллийн сервисүүдийг ХУР системтэй холбон, иргэний мэдээллийг лавлах сангаас татан нийт 240 нэр төрлийн төрийн үйлчилгээг түргэн, шуурхай үзүүлж эхлээд байна. Үндэсний Дата төвтэй хамтран албан хаагчдад тоон гарын үсгийн гэрчилгээ олгож, ННЗ-ны 13 байгууллагын 167 албан хаагчид тоон гарын үсгийн и-токен төхөөрөмж олгосон. Үүнээс НҮНТ-өөс 6 салбарын 21 үйлчилгээний оператор ажилтан тоон гарын үсгийн и-токен ашиглан 15 байгууллагын 156 нэр төрлийн төрийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд үзүүлж байна. - Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагааны журмыг операторын тогтолцоонд нийцүүлж шинэчлэн батлах ажлын хүрээнд: Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 84 дүгээр тушаалаар батлагдсан "Үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагааны журам"-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлэн ажиллаж байна. Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 84 дүгээр тушаалаар батлагдсан "Үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагааны журам"-ын хүрээнд нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагааны түр журмыг оператор тогтолцоонд нийцүүлэн шинэчлэн боловсруулав. Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвөөс иргэн хуулийн этгээдэд үзүүлж байгаа төрийн болон нийслэлийн нутгийн захиргааны 38 байгууллагын 392 нэр төрлийн төрийн үйлчилгээнээс 15 байгууллагын 156 үйлчилгээг www.operator.e-mongolia.mn системээр цахим болон оператор хэлбэрээр үзүүлж байна. - Иргэн хуулийн этгээдийн төрийн үйлчилгээ авах эрэлт, хэрэгцээнд тулгуурлан үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, бүх шатны төрийн байгууллагатай хамтарч ажиллах ажлын хүрээнд:Төрийн захиргааны төв болон нийслэлийн нутгийн
		22.2.4	Орон нутгийн засаг захиргааны хяналт шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаа			-	-	
		22.2.5	Урьдчилан төлөвлөх, нарийвчлан тооцож төсөвт тусгах боломжгүй, Засаг даргад хуулиар олгогдсон бүрэн эрхэз хэрэгжүүлэхтэй холбоотой цаг үеийн арга хэмжээ	агдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулг	НИТХ–ын 2015 оны "Нийслэл, дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгийн төлөвлөлт, зориулалт, зарцуулалт, гүйцэтгэлийг тооцох" 134 дүгээр тогтоолын хүрээнд Нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгийг төлөвлөн зарцуулсан.	17,851.9	14,143.2	Нийслэлийн Засаг даргын нөөц хөрөнгөөс батлагдсан төлөвлөгөөний дагуу бүх нийтийг хамарсан гамшиг ослын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд төсөвлөгдсөн зардлаас шинэ төрлийн коронавирус /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, өвчлөлийг бууруулах, таслан зогсоох үйл ажиллагааны зардалд тухай бүрд нь халдварүйтгэл ариутгал, хамгаалах хувцас хэрэглэл авахад нийт 8.7 тэрбум төгрөгийн зардал гаргасан. Нэг удаагийн тусламж дэмжлэг үзүүлэх, гал түймэр, байгалийн гамшигт үзэгдэл, үер усны аюулаас шалтгаалан орон гэргүй болсон иргэдэд орон байрны тусламж дэмжлэг үзүүлэхэд зориулж 4.3 тэрбум төгрөгийн зардал гарсан. Нийслэл хотыг хөгжүүлэхэд идэвх санаачилгатай ажиллаж, үйл ажиллагаагаараа үр дүнтэй ажилласан иргэд, байгууллагыг шагнаж урамшуулахад 1.2 тэрбум төгрөгийн зардлыг зарцуулж болзошгүй эрсдэлд 3.7 тэрбум төгрөгийн нөөцийг хуваарилж зарцуулалгүй үлдсэн.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч. түүний хэрэгжүүлэх хөтөлбөр. хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар. танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт. бодлогын зорилтын хэрэгжилт. түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт. хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт. тасарсан бол шалтгаан/
		22.2.6	Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ	Агаарын бохирдлыг бууруулах газар, Байгаль орчны газар, Үндэсний цэцэрлэгт хүрээлэн, Минж нутагшуулах төслийн үйл ажиллагаа хамаарна.	Нийслэлийн хэмжээнд ногоон хөгжлийн үзүүлэлтийг тодорхойлон гаргаж, хот тохижилт, ногоон байгууламжийг сайжруулахад анхааран ажилласан.	39,361.8	23,028.3	Уур амьсгалын өөрчлөлтийн тухай НҮБ-ын суурь конвенцын Парисын хэлэлцээр 2020 оноос нэгдсэн байдлаар хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан гишүүн орон бүр үндэсний зорилтоо ахиулан тодорхойлох шаардлагын дагуу Монгол Улс 2019 онд үндэсний зорилтоо шинэчилж, нийслэл хотын оролцоог дахин тодоттох, экосистемд тушиглэсэн дасан зохицох шийдлүүдийг тодорхойлох зорилгоор "Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах дэд хөтөлбөр боловсруулахад холбогдох судалгаа хийлгэх шаардлагатай болсон. Иймд "Хөгжлийн газарзүйн судалгааны хүрээлэн" ТББ-тай НБОГ-2020/06 дугаар зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан судалгааны ажлыг хийлгэж, акт, протокол үйлдэж хүлээн авсан. Судалгааны үр дүнгээс харахад үндэсний тодорхойлсон хувь нэмэр дэх Улаанбаатар хотын оролцоо 2030 он гэхэд 6.0% буюу 4428,83 мян.тн CO2, ойн талбайн жилийн шингээх чадвар нь тухай жилийн ургалтаас хамаарч 198.7 мян.тн CO2 байна. 2019 онд ахуйн болон үйлдвэрлэлийн галлагаанаас гарч байгаа үнсийг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, тээвэрлэх, дахин ашиглах, хэрэглээнд нэвтрүүлэх талаар санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдаж, Дулааны IV цахилгаан станцын үнсэн сангийн өнөөгийн нөхцөл байдал, нөхөн сэргээлт хийхээр сонгосон талбайтай танилцаж дэгдэмхий үнсийг эвдэрсэн газрын нөхөн сэргээлтэд дүүргэгч материал болгон ашиглах боломжит газруудын судалгаат хийж, Хан-Уул дүүргийн 10 дугаар хороо, Морин даваанд байрлах 117.000 м3 эзлэхүүнтэй эвдэгдсэн газрыг сонгосон. Улмаар IV Дулааны цахилгаан станцаас нөхөн сэргээлтийн талбай хүртэлх үнс тээвэрлэлтийн маршрутыг тодорхойлж, хоорондын зайг хоёр талдаа 30 км байхаар тогтоож, тээвэрлэлтийг түгээмэл тархацтай ашигт малтмал олборлогч ААН-үүдийн 2020 оны дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зардлаар шийдэхээр тусгаж 17,5 сая төгрөгийг батлуулсан. Тус ажлын хүрээнд 2020 онд Налайх дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт бичил уурхайн улмаас ухагдаж эвдэгдэн эзэнгүй орхигдсон 1 га талбай дахь ам цоонгуудад "Амгалан" дулааны цахилгаан станцаас гарсан 180 м3 үнсийг дүүргэгч материал болгон загвар нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэсэн. "Ногоон хэрэм" хөтөлбөрийн хүрээнд Налайх дүүргийн 7-р хорооны нутаг дэвсгэр Шинэ Налайх цэцэрлэгт хүрээлэнд 10 га талбайд ногоон зурвас байгуулах ажлын тендер зарлаж, гүйцэтгэгчээр "Аглаг ой" ХХК-ийг шалгаруулж НБОГ-2020/03 дугаартай гэрээ байгуулж ажлыг хугацаанд нь гүйцэтгүүлэн 5100 ширхэг навчит мод тариулж, Газрын даргын 2020 оны А/71 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 2020.11.03-ны өдөр ажлын гүйцэтгэлийг дүгнэж, актаар хүлээн авсан. Нийслэлийн ногоон бүсэд тархсан ойн хөнөөлт шавж, өвчний судалгааны ажлыг ойн мэргэжлийн байгууллагын тусгай зөвшөөрөлтэй "Байгаль орчин, тогтвортой хөгжлийн санаачилга" ТББ-тай БО-2020/37 гэрээ байгуулж, гүйцэтгүүлэн, актаар хүлээн авсан. Хаврын судалгааны тайлангаар хөнөөлт шавжийн илэрч гараагүй ба намрын судалгааны ажлын үр дүнгээр Баянзүрх дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт 3.000 га талбайд якобсоны төөлүүрч эрвээхэйн голомт илэрсэн тул тэмцлийн ажлыг зайлшгүй гүйцэтгүүлэх шаардлагатай гэсэн дүгнэлт гаргасан боловч цаг хугацааны хувьд тэмцлийн ажлыг 2021 онд явуулахаар шийдвэрлэсэн. Хөрсний бохирдлыг бууруулахад мөрдөж буй эрх зүйн орчныг судалж, хөрс хамгаалах, хөрсний
		22.2.7	Орон нутгийн мал эмнэлгийн үйлчилгээ					
		22.2.8	Замын сан	Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор баталсан "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг" – ийн хүрээнд ажиллана	э. Нийслэлийн гол гудамж, замын уулзв	15,713.5	6,494.8	Авто замын сүлжээний техник ашиглалтыг сайжруулах чиглэлээр дараах ажлуудыг хэрэгжүүлж байна. Үүнд: -13.3 км өргөтгөл шинэчлэлт, -3 байршилд борооны ус зайлуулах шугам, худгийн засвар, -Хотын гол болон туслах гудамж зам, төвийн дүүргүүдийн орон сууцны хороолол доторх авто замын нөхөөс 65000 м2, -Заадас 110000 у/м, -Тэмдэглэгээ 98,039.1 м2, -95 ш чигийн урьдчилсан заалт, -175 цэгт тэргэнцэртэй иргэдэд зориулсан налуу зам гаргах, -368 м2 чулуун зам засварлах, -Үзэгдэх орчин хязгаарлагдмал газруудад 50 ш толь байршуулах, -9600 км авто зам, замын байгууламжийн үзлэг шалгалт, -Гэр хорооллын 157000 м2 замыг хусаж, тэгшлэх, нягтруулах, -Босоо тэмдэг 4111 ш, -4742 у/м туузан хаалт, хайс байршуулах, -1000 м2 хурд сааруулагч, тэмдэглэгээний хамт, 4000 м2 гуурний өндөр далангийн хажуу налуугийн бэхэлгээ хийх, -Гүүрэн гарцад 14 ш оврын хаалт байрлуулах, -Явган хүний гүүрэн болон нүхэн 6 гарцад 178 у/м засварын ажил, -3 гүүрний 54 у/м засвар, шинэчлэлт, -Төмөр зам доогуурх автомашины 3 нүхэн гарцын арчлалт, -Замын хөдөлгөөн зохицуулах гэрэл дохионы засвар, арчлалт хийх, шилэн кабель татах, -Багануур, Багахангай, Налайх дүүргийн авто замын засвар, -18 байршилд автомашин, таксины зориулалтын зогсоол хийх ажил тус тус хийгдэхээр төлөвлөж улс, нийслэлийн замын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс 30,570.6 сая төгрөг батлагдсан. Нийт 59 төсөл арга хэмжээ хэрэгжихээс 55 төсөл арга хэмжээний гүйцэтгэгч шалгарч, 30,415.9 сая төгрөгийн гэрээ байгуулж, 90 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж байна. Үлдсэн 4 төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолтыг боловсруулан худалдан авах ажиллагааны эрх шилжсэн байгууллагуудад хүргүүлсэн. Сонгон шалгаруулалт УБЗАА, НХААГ-т хийгдэж байна. Нийт 59 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр улс, нийслэлийн замын сан, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс 30,415.9 сая төгрөг батлагдсан. 55 төсөл арга хэмжээний гүйцэтгэгч шалгарч, 30,415.9 сая төгрөгийн гэрээ байгуулагдан, 90 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж
		22.2.9	Жолоочийн даатгалын сангийн үйл ажиллагаа					
		22.2.10	Нийтлэг үйлчилгээний алба					
		22.2.11	**Хот тохижуулах газар**					
		22.2.11.1	Хот тохижилт, үйлчилгээний үйл ажиллагаа			43,378.8	40,692.5	Тохижилт бүтээн байгуулалтын ажлын хүрээнд Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн гадна зам талбайн тохижилтын ажил, Хан-Уул дүүргийн 18 дугаар хороо, Их Жанжин Д.Сүхбаатарын хөшөөг шилжүүлэн байршуулж, сэргээн засварлах, хөшөө орчмыг тохижуулах, 200 дугаар байрны зүүн талд цэцэрлэгт хүрээлэн, спортын талбай байгуулах тохижилтын нэмэлт ажил , Маршалын гүүрний баруун талд Туул голын урд эрэгт амралтын талбай байгуулах ажил, Зооноз судлалын үндэсний төвийн гадна зам талбайн тохижилтын нэмэлт ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Нэг хот- Нэг стандарт зорилтот жил болгон зарласантай холбогдуулан өнгө, үзэмж, аюулгүй байдлын шаардлага хангахгүй, холбогдох норм дүрэм стандартад нийцэхгүй, эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авааагүй, журмаар хориглосон байршилд байрлуулсан, авто замын хөдөлгөөн, явган зорчигчийн хөдөлгөөнд саад учруулсан, гадна зар сурталчилгааны байгууламжийг буулгах цэгцлэх ажлын хүрээнд 261 ширхэг мэдээллийн байгууламжийг буулгасан. Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд нийслэлийн авто замын сангийн хөрөнгөөр 2020 онд санхүүжих 7 дүүргийн 129 гудамж, замд 41704м2 авто замын нөхөөсний ажил, 6 дүүргийн гэр хорооллын гудамжны 68400м2 шороон замыг түрж тэгшлэх ажлыг 2020 оны 09 дугээр сарын 19-нөөс 10 дугаар сарын 15 хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.
		22.2.11.2	Гудамжны гэрэлтүүлэг, цэвэрлэгээ		Нийслэлийн төвийн 6 дүүргийн 4,164,1	13,216.8	13,026.6	Цахилгаан эрчим хүчний төлбөр: Улаанбаатар хотод нийтийн эзэмшлийн гудамж зам талбай, гэр хорооллол, орон сууцны хорооллын 65 000 орчим гэрэлтүүлэг ашиглагдаж байна. Эдгээр зам талбайн гэрэлтүүлгээс гадна хотын өнгө үзэмжийг сайжруулах ажлын хүрээнд том оврын 10 000 орчим нарс модыг гэрэлтүүлэхэд шаардлагатай цахилгаан эрчим хүчний зардал өвөл, зуны асах цагаас хамааран сар бүр хангах түгээх байгууллагууд бичилт хийлгэн, бусад эрх бүхий байгууллагуудаар баталгаажуулан санхүүжилтийг гүйцэтгэлээр олгосон. Гэрэлтүүлгийн урсгал засвар: Төвийн 6 дүүргийн төв замын 30 000 гаруй гэрэлтүүлгийн өдөр дутамын ашиглалт засвар үйлчилгээ, урсгал болон их засвар, шинэчлэлийн ажлыг мэргэжлийн 6 байгууллага хариуцан ажиллаж байна. Төв замын гэрэлтүүлэг хариуцсан байгууллагуудын өдөр бүрийн засвар үйлчилгээний материалын зардал, тээвэр хүн хүч, машин механизмын ашиглалтын зардалд хяналт тавин сар бүр гүйцэтгэлээр санхүүжилтийг олгон ажилласан.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч. түүний хэрэгжүүлэх хөтөлбөр. хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар. танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт. бодлогын зорилтын хэрэгжилт. түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт. хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт. тасарсан бол шалтгаан/
		22.2.11.3	Ногоон байгууламжийн үйл ажиллагаа	НИТХ–ын 2013 оны 13 дугаар тогтоолоор баталсан "Хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөр" болон бусад хот тохижуулах үйл ажиллагааны хөтөлбөр арга, хэмжээний хүрээнд үйл ажиллагаа явуулна	Нийслэлийн төвийн 6 дүүргийн 4 104.4 мянган м кв талбайд тохижилт, цэвэрлэгээг гүйцэтгэж, 900.0 мянган м2 талбайд цэцэрлэгжүүлэлтийн ажил гүйцэтгэнэ. Хотын 9 дүүргийн 95 гудамж, талбайд мод, зүлэг цэцгийг арчлах, тарих ажлыг гүйцэтгэсэн.	15,556.0	15,302.6	Улаанбаатар хотын агаар, орчны бохирдлыг бууруулах, авто зам дагуу хамгаалалтын зурваст ногоон зурвас байгуулах ажлын хүрээнд нийт 32.4 км урт хамгаалалтын ногоон байгууламж байгуулсан. Үүнд: • Ард аюушийн өргөн чөлөөнд 2,2 км, • Дүнжингаравын зам дагуу 6,5км, • Чингисийн хүрээ 3,3км, • 22 товчооны авто замд 7км, • Амарсанаагийн гудамжинд 0.8км, • Наадамчдын зам дагуу 6.0км, • Чингэлтэйн гудамж, Ногоон нуурын гудамж-3,5км, • Эрхүүгийн гудамж 0.9км, • Бээжингийн гудамж 0.9км, • Тасганы зам дагуу 0.6км, • 10 хорооллын туслах зам дагуу 0,7км Нийтийн эзэмшлийн гудамж талбайд модлог ургамлын хослол зохиомжийг 23 байршилд, Ойн теглийг 14 байршилд, 1200ш савтай модыг нийтийн эзэмшлийн 86 байршилд байршуулж, 31000ш гөлөн чимэглэлийн мод сөөг тарьж, 22 байршилд 1442 ш шилмүүст модыг шинэзр тарьж ногоон массын хэмжээг нэмэгдүүлсэн. - "Улаанбаатар хотын ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн мастер төлөвлөгөө"-г хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийтийн эзэмшлийн гудамж талбайд шинэзр 11,8 га талбайг зүлэгжүүлж, 3241ш шилмүүст мод 250000ш гөлөлын навчит мод сөөг тарьж, арчилгаг мэргэжлийн байгууллагуудаар гүйцэтгүүлж байна. Нийтийн эзэмшлийн шинэзр 40.4га, арчилгааны 122.4га, хязгаарлагдмал хэрэглээний 1.2га, тусгай хэрэглээний 16га нийт 180,0га газарт ногоон байгууламжийг шинэзр нэмэгдүүлж, нягтралын хэмжээг нэмэгдүүлснээр Нийслэлийн нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээ 5,1м2-т хүрээд байна. - Улаанбаатар хотын 2030 оны ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан "Ногоон байгууламж цэцэрлэгжүүлэлтийн мастер төлөвлөгөө "-г НИТХ-н 2019.01.28-ны өдрийн 21/05 дугаар тогтоолоор батлуулснаар дунд хугацааны бодлогын баримт бичигтэй болсон. Нэг хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээ нь 2016 онд 1.7м2, 2017 онд 2.4м2, 2018 онд 3.2м2, 2019 онд 4.1м2, 2020 онд 5,1м2-т хүрч өссөн үзүүлэлттэй байна.
		22.2.11.4	Хог хаягдлын тээвэрлэлт, устгах, дарах үйлчилгээ			41,417.5	40,208.9	Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн цэвэрлэгээ, үйлчилгээ хийгдэх хотын гол гудамж, зам талбай, алслагдсан зам, замын байгууламжийн 7,823,708м2 талбайг сард 2-6 удаагийн давтамжтай цэвэрлэгээ үйлчилгээ хийлгэж, төвлөрсөн хогийн цэгт 2020 онд нийт 1.2 сая тонн хог хаягдал дарж булагдсан. Эзэнгүй нохой, муур устгалын ажилд 2020 онд 9 дүүргийн хэмжээнд 100 000 нохой, муурыг устгах төлөвлөгөө батлагдсан бөгөөд 2020 онд нийт 98.226 эзэнгүй нохой, муур устгаж ажилласан байна.
		22.2.12	Аймгийн орон нутгийн өмчийн газар	Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газар нийслэлийн өмчийн бүртгэл, хяналт, үйл ажиллагаат хариуцан ажиллана.	Нийслэлийн өмчит 23 аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын ашигт үйл ажиллагаат нэмэгдүүлэх, нийслэлийн өмч байршиж буй 710 байгууллага, өмчит үйлдвэрийн газрын өмчийн ашиглалт хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна. Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын удирдлагын багийг чадваржуулан, контрактаар хүлээсэн үүрэг, бизнес төлөвлөгөөний биелэлттэй уялдуулан хариуцлагыг тухай бүр тооцдог тогтолцоог бий болгож, үйл ажиллагаат оновчтой зохион байгуулан эдийн засгийн үр дүнг дээшлүүлэн ажиллаж байна.	6,082.1	2,421.7	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудыг хүнсний бүтээгдэхүүнээр ханган ажилладаг "Асгат", "Багачууд хүнс", "Өсвөр үе хүнс", "Хүнс хангамж" гэсэн 4 ОНӨААТҮГ-ын дүрмийг судлан үзэж, дүрмийн 4.2.3-т заасан "мал аж ахуй, хүнсний ногоо тариалалт, ахуйн бараа бичиг хэргийн хангалт, худалдаа эрхлэх, сургалт зохион байгуулах, мах ногоо ангилах, савлах жижиг үйлдвэр ажиллуулах, нийтийн хоолны тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ зэрэг туслах аж ахуй эрхэлж болно" гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах чиглэл өгөн ажиллаж байна. Дээрх 4 үйлдвэрийн газрыг зах зээлийн зарчимд шилжүүлэх, дүрэмд заасан туслах аж ахуйн үйл ажиллагаат бүрэн хэрэгжүүлэхэд бүтэц орон тоог нэмэгдүүлэх шаардлагатай болсныг үндэслэн Нийслэлийн Засаг даргын 2020 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн А/1093 дугаар захирамжаар бүтэц орон тоог шинэчлэн батлуулаад байна. Нийслэлийн орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын нээлттэй зах зээлд ерөлдөх замаар орлогын хэмжээг нэмэгдүүлэх, хөрөнгийн ашиглалт, үр өгөөжийг нэмэгдүүлэх зорилгоор "Бэлчээрийн менежмент төслийн нэгж" ОНӨТҮГ-ын Австри улсын дэвшилтэт технологи, тоног төхөөрөмжийн нөөц бололцоонд тулгуурлан Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт "Асгат" ОНӨААТҮГ-т газар тариалан, фермийн аж ахуйг эрхлэхэд шаардлагатай газрын асуудлыг 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулсан. Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/497 дугаар захирамжаар Нийслэлийн өмчит аж ахуйн тооцоотой 16 үйлдвэрийн газрын 2020 оны эдийн засаг, санхүүгийн үр ашигт дээшлүүлэх зорилтот түвшинг хянан нийт орлогыг 257,3 тэрбум буюу 2019 оны гүйцэтгэлээс 25,9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн батлуулсан. Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын захирлуудад 2020 оны зорилтын дагуу "Контракт"-аар хүлээсэн үүргээ биелүүлж орлогоо нэмэгдүүлэн, зардлыг хэмнэн зарцуулалтын үр ашигт дээшлүүлэн, менежментийг сайжруулан ажиллахыг үүрэг болгосон. Нийслэлийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар ашигтай ажилласан 7 үйлдвэрийн газраас нийт 332.0 сая төгрөгийн ногдол ашгийг нийслэлийн төсөвт төвлөрүүлсэн. - Үйлдвэрийн газрыг зах зээлийн зарчимд шилжүүлэх, дүрэмд заасан туслах аж ахуйн үйл ажиллагаат бүрэн хэрэгжүүлэхэд бүтэц орон тоог нэмэгдүүлэх шаардлагатай болсныг үндэслэн Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1093 дугаар захирамжаар бүтэц орон тоог шинэчлэн баталсан. - Нийслэлийн өмчит аж ахуйн тооцоотой 16 үйлдвэрийн газрын 2020 оны эдийн засаг, санхүүгийн зорилтот түвшинг хянан батлуулахдаа өмнөх оны гүйцэтгэлээс орлого, үр ашгийг 25,9 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, удирдлагын зардлыг бууруулан батлуулсан.
		22.2.13	Орон нутгийн ахмад настанд үйлчлэх кабинет төв					
	22.2	22.2.14	Байгаль орчны газар					
		22.2.15	Сум дундын ойн анги					
		22.2.16	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт			360,912.1	277,606.8	Нийслэлд 2020 онд нийслэлийн төсвийн хөрөнгөөр 176.4 тэрбум төгрөгийн 138 төсөл, арга хэмжээ, Нийслэлийн 2020 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 17.9 тэрбум төгрөгийн 245 төсөл, арга хэмжээ, Монгол Улсын 2020 оны төсвийн хөрөнгө оруулалтаар 110.9 тэрбум төгрөгийн 222 төсөл, арга хэмжээ, нийт 305.2 тэрбум төгрөгийн 605 төсөл, арга хэмжээний хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг зохион байгуулах тухай Нийслэлийн Засаг даргын 291 захирамжийн төсөл боловсруулан батлуулж, холбогдох байгууллагуудад хүргүүлэн хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллалаа.
		22.2.17	Аймгийн халамжийн сан	Монгол Улсын холбогдох халамжийн тухай хуулиудын хүрээнд ажиллана.	жих тэтгэмж, олон нийтийн оролцоонд т	2,847.1	1,568.9	"Нийгмийн халамжийн тухай" хуулийн хүрээнд нийслэлийн хэмжээнд 2020 онд нийгмийн халамжийн санд нийслэлийн төсвөөс Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, онцгой тохиолдлын болон амьжиргаат дэмжих мөнгөн тэтгэмжид нийт 2.8 тэрбум төгрөгийн санхүүжилт баталгдсан. Үүнээс 2020 онд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 983.7 сая төгрөг, онцгой тохиолдлын болон амьжиргаат дэмжих мөнгөн тэтгэмжид 785.8 сая төгрөгийн нийт 1,769.5 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Оны эхний болон эцсийн арилжааны банкны үлдэгдлээс санхүүжилт олгосон.
		22.2.18	Санхүүгийн хяналт, аудитын алба	Нутгийн захиргааны байгууллагуудын дотоод хяналтыг сайжруулан, төсөв санхүүгийн хяналтыг сайжруулж, төсвийн үрэлгэн байдал, үр ашиггүй зардлыг бууруулж хэмнэлтийн горимоор ажиллана.	ггүй зардлыг бууруулж хэмнэлтийн гор	1,321.4	1,170.7	Нийслэлийн дотоод аудитын газрын "Аудит, хяналт шалгалтын 2020 оны төлөвлөгөө"-ний дагуу Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Улаанбаатар чуулга, Хүнс хөдөө аж ахуйн газар, Агаарын бохирдлыг бууруулах газар, Нийтийн тээврийн үйлчилгээний газар зэрэг 7 төсөвт байгууллага, 11 аж ахуйн тооцоот байгууллага нийт 18 байгууллагын 2019 оны үйл ажиллагаанд дотоод аудитыг хэрэгжүүлсэн ажилласан байна. Тайлант онд гүйцэтгэсэн дотоод аудитаар нийт 135 асуудлын 11.7 тэрбум төгрөгийн алдаа зөрчлийг илрүүлж, 11.7 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 3.2 тэрбум төгрөгийн алдаа зөрчлийг арилгах 7 албан шаардлага өгч, 8.5 тэрбум төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх 125 зөвлөмж өгч ажилласан байна. Дүүргүүдийн дотоод аудитын алба нь 2020 онд тухайн дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дүүргийн эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэх, төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагуудын эрсдэлийн удирдлага, засаглал, дотоод хяналт үйл явцыг үнэлэх, зөвлөмж өгөх, үйл ажиллагаат нь сайжруулахад дэмжлэг үзүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч. түүний хэрэгжүүлэх хөтөлбөр. хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар. танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт. бодлогын зорилтын хэрэгжилт. түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт. хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт. тасарсан бол шалтгаан/
		22.2.19	Үндсэн тэнцлийн ашгаас Улсын төсөвт төвлөрүүлэх орлого			275,188.2	108,100.0	Нийслэлийн төсөөс 2020 онд улсын төсөвт төвлөрүүлэх шилжүүлгийн хэмжээ 275.2 тэрбум төгрөгөөр батлагдсанаас гүйцэтгэлээр жилийн эцэст 108.1 тэрбум төгрөг төвлөрүүлсэн. Хотын шуудан төсвийн 2020 оны төсвийн орлогын төлөвлөгөө Монгол Улсын засгийн газрын 2020 оны 114 дүгээр "Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах арга хэмжээний тухай" тогтоолын 1.9-д "Монгол Улсын иргэний 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд олсон цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдох хувь хүний орлогын албан татварыг чөлөөлөх" заалт болон Ковид цар тахлын улмаас бүх шатны байгууллагуудын хэвийн үйл ажиллагаа доголдсоны улмаас тасарсан нь дээрх шилжүүлгийн хэмжээг тасалдуулахад нөлөөлсөн байна.
		22.2.20	Нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлэх	НИТХ – ын 2015 оны "Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх журам" – ыг баталсан 6/22, "Оюутан сурагч, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийтийн тээврийн хэрэгслээр цахим төлбөрийн картаар зорчих" 6/21 дүгээр тогтоолын хүрээнд ажиллана.	ийн үйлчилгээний чанар, стандартыг дэ	120,752.3	118,862.7	Тус газраас холбогдох судалгаа тооцоллыг хийж Нийтийн тээврийн салбарыг 2040 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө урьдчилсан байдлаар боловсруулан мастер төлөвлөгөөний суурь судалгаг хийсэн. Нийслэлийн Засаг даргын 2020 оны "Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай" А/463 дугаар захирамжаар нийтийн тээврийн, сургуулийн автобусны парк шинэчлэлтийн төсөл арга хэмжээг зохион байгуулах эрхийг "Улаанбаатар хотын хөгжлийн корпорац" ХК –д шилжүүлсэн. Тус газраас "Улаанбаатар хөгжлийн корпорац" ХК-иас худалдан авалт хийгдэх сургуулийн автобус болон нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллах тээврийн хэрэгслүүдийн техникийн үзүүлэлтийг гарган 2020 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 2/644 тоот албан бичгээр хүргүүлж хамтран ажилласан.Нийслэлийн Засаг даргын Тамгын газар Сургуулийн автобус худалдан авах НЗДТГ-20/А-463-2 дугаартай гэрээг Моннис Моторс ХХК-тай байгуулж, Нийслэлийн төсвийн 23.05 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 75 сургуулийн автобусаар парк шинэчлэлт хийх бэлтгэл ажлыг хангасан. Гэрээний дагуу эхний ээлжинд 2020 оны 10 дугаар сард 5 сургуулийн автобусаар парк шинэчлэлт хийгдсэн. Мөн Нийслэлийн Засаг даргын Тамгын газар Цахилгаан автобус худалдан авах НЗДТГ-2020А/463 дугаартай гэрээг Моннис Моторс ХХК-тай байгуулж, Улсын төсвийн 21.4 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 32 ширхэг цахилгаан автобусаар парк шинэчлэлт хийх бэлтгэл ажил хангагдсан боловч Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдаж, 2020 онд санхүүжих дүн нь буурсан төсөл, арга хэмжээний жагсаалтын 2 дугаар хавсралтаар Нийтийн тээврийн парк шинэчлэлтэд тусгагдсан 22.0 тэрбум төгрөгөөс 19.308.5 сая төгрөг нь хасагдаж, 2.691.5 сая төгрөг санхүүжихээр болсон. 2020 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/1185 дугаар Захирамжаар Улсын төсвийн хөрөнгөөр 2020 онд санхүүжүүлэх Зам, тээврийн хөгжлийн сайдын багцаас Нийслэлийн Засаг даргад эрх шилжүүлэн хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний жагсаалтад орох өөрчлөлтийг 1 дүгээр хавсралтаар баталж санхүүжилтийг хассан. Иймээс 2020 онд багтаан 32 цахилгаан автобусаар парк шинэчлэлт хийх ажил 2021 он хүртэл хойшлогдсон. Засгийн газрын 2020 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн хурлаар "Цахилгаан автобусны парк шинэчлэлт" төслийг санхүүжүүлэх 20.9 тэрбум төгрөгийг зээллэг хэлбэрээр бүрдүүлэх шийдвэр гарсан. Төслийн хүрээнд "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ БНХАУ-ын Хөгжлийн банкны санхүүгийн урт хугацаат зээлийн эх үүсвэрээр нийт 10 давхар цахилгаан автобус, 36 цахилгаан автобусаар парк шинэчлэлт хийхээр бэлтгэл ажлыг хангаж байна. 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар хувийн хэвшлийн 15 аж ахуйн нэгж дотоодын нөөц бололцоогоор 126 их багтаамж, 5 дундын багтаамжийн автобусаар нөхөн хангалт хийсэн. Тус газрын бүртгэлийн санд үндсэн чиглэлийн 1263 тээврийн хэрэгсэл бүртгэлтэйгээс 59 буюу 4,6% нь цахилгаан, 95 буюу 7,5 % нь CNG, 1109 буюу 88,0%-ийг дизель хөдөлгүүртэй тээврийн хэрэгсэл тус тус эзэлж байна.
		22.2.21	Үерийн хамгаалалтыг зохион байгуулах	Нийслэлийн хот тохижуулах зардлаас үерийн далан сувгийн цэвэрлэгээ, хамгаалалтын зардлыг холбогдох хууль, журмын дагуу хянан санхүүжүүлнэ.	лан сувгийг цэвэрлэж, 4436.0 м3 лаг ша	3,592.4	3,481.4	Улаанбаатар хотын хэмжээнд ашиглагдаж буй нийт 148 км урт үерийн хамгаалалтын барилга байгууламж, далан сувгийн үерийн хамгаалалтын барилга байгууламжийн өдөр тутмын болон гэнэтийн үер усны гамшгийн үед байнгын бэлэн байдлыг хангуулах зорилгоор жилийн 4 улиралд тогтмол хуваарийн дагуу цэвэрлэгээ, засвар арчлалтын ажил хийгдсэн. Халиа мөсөн дошны ажлын хүрээнд дараах 7 байршилд ажиллаа. • ЧД-ийн 10,11,12 хороо Д1000-ын 1, • ЧД-ийн 10,11,12 хороо Д1000-ын 3 • СБД-ийн 14-р хороо Чингэлтэйн далан • БЗД-ийн 2-р хороо Петровис-8 ШТС-ын арын далан • БЗД-ийн 5,13,14-р хороо Зүүн уулын суваг • СХД-ийн 27-р хороо Толгойтын суваг • ЧД-ийн 9-р хороо БУС Баянбүрдийн ус гаргуурууд тус тус ажиллаж нийт 16200 м3 мөсийг суваг татах, суваг сэргээх, ооолох, тээвэрлэх ажлыг гүйцэтгэн , СХД-ийн 27-р хороо Толгойтын сувагт 12 рейсээр 70тонн шороог далан өндөрлөн халиа дошин үүсэхээс сэргийлж аюулгүй байдлыг ханган ажиллав. - Улаанбаатар хотын хэмжээнд 2020 оны жилийн эцсийн байдлаар 53 байршлын 153,2 км үерийн хамгаалалтын барилга байгууламжийн ашиглалт, засвар, цэвэрлэгээний ажлыг хариуцан гүйцэтгэж байна. Үүнээс 2020 оны байдлаар 20 байршилд 21481м3 лаг хагшаасыг цэвэрлэж үерийн ус чөлөөтэй нэвтрэх нөхцөлийг бүрдүүлэн ажиллаа. - Үерийн хамгаалалтын барилга байгууламжийн засвар, нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд 5 байршилд 1926 м2 талбайн засвар нөхөн сэргээлтийн ажил гүйцэтгэж, үзлэгийн 3ш худаг шинээр суурилуулан ажиллаа.. - Ашиглалт, хамгаалалтын ажлын хүрээнд Хамгаалалтын хайс хашлага суурилуулах ажлын хүрээнд нийт 10 байршилд 2519 м урт хамгаалалтын хайс хашлага суурилуулан ажиллаа. - Үерийн хамгаалалтын барилга байгууламжийн хамгаалалтын зурваст суурьшиж буй айл өрөх, иргэн байгууллагын зөвшөөрөлгүй үйл ажиллагаат зогсох зөрчлийг арилгах ажил мэргэжлийн байгууллагуудтай хамтран байнгын үзлэг шалгалт хийж, 2020 оны жилийн эцсийн байдлаар 42 зөрчлийг арилган ажиллаа.
		22.2.22	Орон сууц нийтийн аж ахуйн үйлчилгээ үзүүлэх	Улаанбаатар хотын нийтийн орон сууцны цахилгаан шатны засвар, үйлчилгээ, хяналтыг "Улаанбаатар Лифт" НӨҮГ хариуцан гүйцэтгэж байна	удын нэгдсэн судалгааг гарган цахилгаа	246.0	245.1	2020 оны нийслэлийн төсөвт хөрөнгө батлагдаагүй боловч УБЗАА-аас Улсын төсвийн хөрөнгө оруулалтад санал тусгуулж, хөрөнгийг шийдвэрлүүлснээр НЗД-ын 2020 оны "Эрх шилжүүлэх тухай" А/475 дугаар захирамжаар Улсын төсвийн 1,120.0 тэрбум төгрөгийн хөрөнгөөр БГД, БЗД, СХД, СБД, ЧД-ийн нийтийн эзэмшлийн орон сууцны 13ш, Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр БГД-ийн 5, 10, 13 дугаар хорооны орон сууцны 3ш цахилгаан шат засварлах ажлын худалдан авах ажиллагаг зохион байгуулж, гүйцэтгэгчийн сонгон шалгаруулж гэрээг байгуулсан, захиалагчийн хяналтыг Улаанбаатар лифт хэрэгжүүлж байна. 2018 онд Беларусь улсын Аж үйлдвэрийн сайд Вовк Виталий Михайловичийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч хүлээн авч уулзан, Белорусь улсын Засгийн газрын 50 сая еврогийн хөнгөлөлттэй зээлийн хүрээнд Улаанбаатар хотын хот нийтийн аж ахуйд оруулах хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ, барилга байгууламжийн талаар санал боловсруулах ажлын хэсгийг 2 талын төлөөлөл оролцуулан, Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга Т.Гантөмөрөөр ахлуулан байгуулсан байна. Ажлын хэсэг Улаанбаатар хотын нийтийн зориулалттай орон сууцны хуучирч муудсан 135ш цахилгаан шат шинэчлэх төслийг боловсруулж, Бүгд Найрамдах Беларусь Улсын ЗГ-ын 50,0сая еврогийн экспортын хөнгөлөлттэй зээлд хамруулахаар Сангийн яаманд 2020 оны 03-р сард хүргүүлсэн. МУЗГ-ын 2020 оны 4 дүгээр сарын 15-ны 131 дүгээр тогтоолоор дээрх хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжүүлэх 5 арга хэмжээний жагсаалтад тус нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шатыг шинэчлэх төслийг багтаан баталсан байна. СЯ-наас Бүгд Найрамдах Беларусь улсын Могилевлифт Маш ХХК-тай гэрээ байгуулах ажлыг хариуцан, шийдвэрлүүлэх чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж байна. Беларусь улсын Могилевлифт Маш ХХК-д 135ш цахилгаан шатны хонгилын хэмжээг гаргаж өгөхөөр нарийвчилсан судалгаг гаргахаар ажиллаж байна.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч. түүний хэрэгжүүлэх хөтөлбөр. хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар. танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт. бодлогын зорилтын хэрэгжилт. түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт. хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт. тасарсан бол шалтгаан/
		22.2.23	Хөдөө аж ахуй бэлчээрийн менежмент	"Нийслэл орчмын бэлчээрийн менежментийг сайжруулах, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр" – ийг Нийслэлийн Үйлдвэр, хөдөө аж ахуйн газар хэрэгжүүлэн ажиллана	Органик хүнс үйлдвэрлэлийг хөгжүүлэх төслийг дэмжин, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадлыг нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах, Хүн амын хүнсний эрүүл, аюулгүй бүтээгдэхүүний хангамжийг тогтворжуулна.	842.4	794.7	Баяжуулсан хүнсний тухай хуулийг дагалдан гарах хүнс баяжуулах үйл ажиллагаанд тавих хяналтын журам, "Баяжуулсан хүнсний болон баяжуулагч бэлдмэлийн шинжилгээний аргын стандарт"-ын төслийн хэлэлцүүлэгт оролцож холбогдох саналыг өгсөн. Баяжуулсан хүнсний тухай хууль түүнийг дагалдан гарсан хүнсний үйлдвэрүүдэд мөрдөгдөх нийтлэг журам стандартуудыг сурталчлан таниулах зорилгоор 2020.09.16-ны өдөр албан журмаар хүнс баяжуулах аж ахуйн нэгжүүдийг хамруулсан уулзалтыг зохион байгуулсан. Улзалтад гурилын 14 үйлдвэр, давс үйлдвэрлэгчдийн холбоо болон давсны үйлдвэрлэгчдээс 8, төрийн байгуллагын 10 нийт 30 гаруй төлөөлөгчдийг хамруулсан. Улзалтын үеэр ХАБҮЛЛ болон ШУТИС-ээс хамтран боловсруулж байгаа баяжуулсан хүнс, баяжуулагч бэлдмэл дэх аминдэм, эрдсийн агуулгыг тодорхойлох лабораторийн шинжилгээний аргын стандартуудын төслийн танилцуулга, НЭМҮТ-ээс Хүнсний зориулалтын иоджуулсан давс MNS 5046:2019, Буудайн гурилыг баяжуулагч бэлдмэл MNS 6811:2019, Буудайн баяжуулсан гурилын стандарт MNS 6812:2019, МХЕГ-аас "Албан журмаар хүнс баяжуулах үйл ажиллагаанд тавих хяналтын журам, Тэс трейд ХХК-аас албан журмаар баяжуулах хүнсний жагсаалтад заасан баяжуулагч бэлдмэлийн танилцуулгаар тус тус илтгэл тавьж нийт 120 гаруй аж ахуй нэгж байгууллагын төлөөлийг оролцуулсан. Хяналт шалгалтаар нийслэлийн хүн амын өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүнүүдэд эрүүл аюулгүй байдал сав, баглаа бооднлын MNS 6648:2016 стандартыг даган мөрдүүлж байгаа эсэхэд хяналт шалгалтыг тогтмол хийж илэрсэн зөрчлийн газар дээр нь арилгуулж, зөвлөмж өгч ажиллаж байна. 2020 онд Нийслэлийн 9 дүүргийн 418 цэгээр 52 аж ахуйн нэгжийн бэлтгэсэн 12696.8 тонн махыг 12%-35% хувийн хямд үнээр худалдсан. Үхрийн махыг 7700 тг, хонь 6700 тг, ямааны махыг 6200 төгрөгийн ханштайгаар борлуулсан. Коронавирус халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх нийслэлийн хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх үнийг тогтвортой хадгалах, зохиомол хомсдолоос сэргийлэх зорилгоор 7 дүүрэгт нөөцийн мах бэлтгэн нийлүүлэгч 17 аж ахуйн нэгж давхардсан тоогоор 68 байршилд буюу өдөрт 18-23 байршилд 497.8 тн мах худалдан борлуулсан.
		22.2.24	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, ядуурлыг бууруулах	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн үйл ажиллагаа хамаарна.	эрхлэгчдийн худалдааны төв байгуула	5,442.5	2,142.3	Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрлэл эрхлэгчдийг төсөл боловсруулах мэргэжил арга зүйгээр ханган ХХААЯ-ны ЖДҮ-ийг хөгжүүлэх сангийн зээлийн хүсэлтэд 21 үйлдвэрийн материалыг цахим хэлбэрээр хүргүүлж 9 аж ахуй нэгж байгууллагад хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгосон. Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төвөөс салбарын болон бүсад хууль эрх зүй, хөрөнгө оруулалтын мэдээ мэдээлэл мэргэжлийн зөвлөгөөг 753 иргэн, аж ахуйн нэгжид өгч, үйл ажиллагаат нь дэмжин ажилласан. -Сангийн хөрөнгийг зарцуулахтай холбоотой Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6 дахь заалтыг үндэслэн сангийн хөрөнгийг зарцуулах боломжгүй болж, цаашид судалж байна. "Улаанбаатарт үйлдвэрлэх" үзэсгэлэн худалдаг 7 удаа зохион байгуулж давхардсан тоогоор нийт 2316 иргэн, аж ахуйн нэгжийг оролцуулан бараа бүтээгдэхүүний борлуулалтыг тодорхой хэмжээнд нэмэгдүүлж, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч 13 аж ахуй нэгжийг бизнесийн хөнгөлөлттэй зээлд хамруулан үйл ажиллагаат дэмжин ажиллалаа.
		22.2.25	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих ядуурлыг бууруулах	Нийслэлийн Хөдөлмөрийн газар хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ядуурлыг бууруулах ажлыг хариуцан гүйцэтгэнэ.	"Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв"-ийн үйл ажиллагаат тогтмолжүүлж иргэдэд нэг цэгээс үйлчилгээг үзүүлж байна.	5,723.8	393.4	Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар, дүүргүүдийн ХХҮХ-т 21225 ажлын байрны захиалга авч, ажил хайгч 21953 иргэн бүртгүүлснээс 14310 иргэнийг тохирох ажилд зуучилж, зуучилсан иргэдийн 63 хувь нь буюу 9032 иргэнийг ажилд оруулсан байна. 2020 онд Шинээр бий болсон 6632 ажлын байрыг дүүргүүдийн ХХҮХ-ийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн шинэ ажлын байр хариуцсан мэргэжилтнүүд холбогдох дүүргүүдийн ажил олгогч нараас шинээр бий болсон ажлын байрны мэдээллийг авч, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэв. Үүнээс Багануур дүүрэгт 279, Багахангай дүүрэгт 28, Баянгол дүүрэгт 509, Баянзүрх дүүрэгт 1169, Налайх дүүрэгт 162, Сонгинохайрхан дүүрэгт 1724, Сүхбаатар дүүрэгт 1550, Хан-Уул дүүрэгт 570, Чингэлтэй дүүрэгт 641 ажлын байр тус тус шинээр бий болсон. - НИТХ-ын 2014 оны 17/16 дугаар тогтоолоор батлагдсан Бичил бизнесийг дэмжих, ядуурлыг бууруулах нийслэлийн хөтөлбөрийн хүрээнд 2014-2016 онд 150 хорооны 123 хадгаламж, зээлийн хоршоогоор дамжуулан иргэдийн 3479 төсөл нийт 14,3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдсон. Бичил бизнесийг дэмжих Нийслэлийн сангийн Зөвлөлийн 2017 оны 05 дугаар тогтоолын дагуу хөтөлбөрийн хүрээнд олгогдсон хөрөнгийг 24-36 сарын хугацаанд үе шаттай буцаан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулан ажилласнаар тайлант хугацаанд нийслэлийн төсөвт 6,3 тэрбум төгрөг буюу нийт санхүүжилтийн 44 хувийг эргэн төвлөрүүлээд байна. Хадгаламж, зээлийн хоршоодын зээлийг эргэн төвлөрүүлэх ажлыг эрчимжүүлэн, өмгөөллийн "Файт партнерс" хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлтэй хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулан хамтран ажиллаж, нийт 3,726,170,752 төгрөгийг нэхэмжлэн нэр бүхий 32 хадгаламж, зээлийн хоршоог иргэний хэргийн анхан шатны шүүхэд шилжүүлсэн. 2020 оны эцсийн байдлаар 833,2 сая төгрөгийг эргэн төвлөрүүлснээр, бичил бизнесийг дэмжих нийслэлийн санд нийт 6,307,013,008 төгрөг төвлөрч, 8,000,786,992 төгрөгийн үлдэгдэлтэй байна. Бичил бизнесийг дэмжих Нийслэлийн санд нийт 6,307,013,008 сая төгрөг төвлөрсөн.
		22.2.26	Хот төлөвлөлт, барилгажилт	Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор баталсан "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг" – ийн хүрээнд ажиллана.	Улаанбаатар хотыг 2040 он хүртэлх ерөнхий төлөвлөгөө боловсруулах бэлтгэл ажлыг эхлүүлнэ. Мөн Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичгийн дагуу хотын дагуул, хаяа хот, тосгодыг нутаг дэвсгэрийн бүсчлэлийн чиглэлээр хөгжүүлэх Тэрэлж, Гачуурт, Хонхор тосгоны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахаар ажиллаж байна. гэр хорооллын дэд бүтцийн хөгжлийн дунд хугацааны бодлогын бичиг баримтыг шинэ үзэл баримтлалын дагуу батлуулж, гэр хорооллын суурьшлын бүсийг бие даасан, ухаалаг дэд бүтэц бүхий хэсэгчилсэн байдлаар төлөвлөж, иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлэн ажиллаж байна. мөн шинэ үзэл баримтлалын дагуу 4 дүүрэгт жишиг дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэн ажиллаж байна.	8,679.2	7,302.1	"Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал /концепц/"-ыг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 35 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж дэмжигдсэн. Монгол улсын Засгийн газраас өгсөн үүрэг даалгаврын дагуу Барилга, хот байгуулалтын Сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч хамтран "Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах ажлын даалгавар"-ыг баталж, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн "Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээг "Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ-тай байгуулан ажиллаж, эхлэлийн тайлан гарсан. Одоогоор Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний ажлын даалгавар"-ыг батлуулж боловсруулах ажил хийгдэж байна.
	22.3	**Улсын төсвөөс авах тусгай зориулалтын шилжүүлгээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ**				**507,732.3**	**477,561.0**	
		22.3.1	Сургуулийн өмнөх боловсрол	Нийслэлийн Боловсролын салбарын батлагдсан төсвийг хөтөлбөр, арга хэмжээний дагуу хуваарилан дүүргүүдэд, дүүргүүд төсвийн шууд захирагч нарт хуваарилах.	Сургуулийн өмнөх боловсролын тусгай шилжүүлгийн дунг 205.9 тэрбум төгрөгөөр баталсныг нийслэл 9 дүүрэгт, дүүргүүд сургуулийн өмнөх боловсролын байгуллагууд болон төрийн бус өмчийн цэцэрлэгүүдэд тус тус хуваарилан ажилласан.	180,654.0	174,862.0	2019-2020 оны хичээлийн жилд нийслэлийн төрийн өмчийн 152 сургуулийн 7952 бүлэгт 261 754 хүүхэд, төрийн бус өмчийн 122 сургуулийн 1682 бүлэгт 39658 хүүхэд, 8 насан туршийн боловсролын төвд 781 хүүхэд нийт 286 байгууллагад 303 502 санхүүжих дундаж хүүхэд суралцахаар тооцож нийт 241.2 тэрбум төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлгийн төсөв батлагдсанаас 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар 234.4 тэрбум төгрөг буюу 6.8 тэрбум төгрөгөөр буурч батлагдсан. Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны нийт төсвийн 71 хувь нь буюу 171.3 тэрбум төгрөг багш, ажилтны үндсэн цалин, нэмэгдэл, урамшууллын зардал байна.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч. түүний хэрэгжүүлэх хөтөлбөр. хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар. танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт. бодлогын зорилтын хэрэгжилт. түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт. хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт. тасарсан бол шалтгаан/
		22.3.2	Ерөнхий боловсрол	Нийслэлийн Боловсролын салбарын батлагдсан төсвийг хөтөлбөр, арга хэмжээний дагуу хуваарилан дүүргүүдэд, дүүргүүд төсвийн шууд захирагч нарт хуваарилах.	Ерөнхий боловсролын сургуулийн тусгай зориулалтын шилжүүлгийн дүнг 241.3 тэрбум төгрөгөөр баталсныг нийслэл 9 дүүрэгт, дүүргүүд ерөнхий боловсролын сургуулиуд болон төрийн бус өмчийн сургуулиудад тус тус хуваарилан ажилласан.	279,704.4	262,870.6	2020 оны төсвийн жилд төрийн өмчийн 289 цэцэрлэгийн 2625 бүлэгт 98051 хүүхэд, төрийн бус өмчийн 430 цэцэрлэгийн 1395 бүлэгт 29859 хүүхэд, нийт 719 цэцэрлэгийн 4020 бүлэгт, 127910 санхүүжих дундаж хүүхэд сургуулийн өмнөх боловсролд хамрагдахаар тооцож, 205.9 тэрбум төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлгийн төсөв батлагдсанаас 2020 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар 195.5 тэрбум төгрөг буюу 10.4 тэрбум төгрөг буурч батлагдсан.
		22.3.3	Соёлын үйлчилгээ					
		22.3.4	Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ	Нийслэлийн Өрхийн эрүүл мэндийн салбарын батлагдсан төсвийг хөтөлбөр, арга хэмжээний дагуу хуваарилан дүүргүүдэд, дүүргүүд төсвийн шууд захирагч нарт хуваарилах.	Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тусгай зориулалтын шилжүүлгийн дүнг 40.6 тэрбум төгрөгөөр баталсныг нийслэл 9 дүүрэгт, дүүргүүд Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд тус тус хуваарилан ажилласан.	40,931.0	40,693.6	Нийслэлийн хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэх 141 Өрхийн эрүүл мэндийн төвөөр дамжуулан үзүүлж байна. Нийт өрхийн эмнэлгийн 84 буюу 64 орчим хувь нь магадлан итгэмжлэгдсэн байгаагаас 75 ӨЭМТ нь эрүүл мэндийн даатгалын 4 төрлийн тусламж үйлчилгээгээр санхүүжилт аван ажиллаж байна. ӨЭМТ-ийн 98.5 хувь нь зориулалтын байраар, 70 хувь нь автомашинаар хангагдаж тоног төхөөрөмжийн хангалт 80 хувь байна.
		22.3.5	Газрын харилцаа, кадастр	Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны батлагдсан төсвийг хөтөлбөр, арга хэмжээний дагуу хуваарилан төсвийн шууд захирагчид олгох.	Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны 2020 оны тусгай зориулалтын шилжүүлгийн дүн 3,535.7 сая төгрөгөөр батлагдсаныг хөтөлбөр, арга хэмжээний дагуу бүрэн санхүүжүүлэн ажилласан.	3,663.8	3,634.5	2020 онд Нийслэлийн газар зохион байгуулалтын алба нь Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд газрын тухай багц хууль, газрын харилцааны чиглэлээр батлагдан гарсан хууль, тогтоомжууд болон Газар зохион байгуулалт, Геодези, Зураг зүйн газар, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн засаг даргаас баталсан тогтоол, захирамж, шийдвэр, хөтөлбөр төлөвлөгөөг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээг иргэн аж ахуйн нэгж байгууллагад шуурхай хүргэх үндсэн үйл ажиллагааны зэрэгцээ "Нэг хот-нэг стандарт" Нийслэлийн газар зохион байгуулалтын албанаас "Байгууллагын соёл, үйлчилгээний чанар"-ыг сайжруулах зорилтот жил болгон зарласантай холбогдуулан дээрх хүрээнд үйл ажиллагааг чиглүүлэн ажилласан байна.
		22.3.6	Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээ	Нийслэлийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын батлагдсан төсвийг хөтөлбөр, арга хэмжээний дагуу хуваарилан төсвийн шууд захирагчид олгох.	Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын газрын 2020 оны тусгай зориулалтын шилжүүлгийн дүн 2,761.5 сая төгрөгөөр батлагдсаныг хөтөлбөр, арга хэмжээний дагуу бүрэн санхүүжүүлэн ажилласан.	2,779.1	2,764.8	Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжил, хамгааллын хууль тогтоомж, Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, чиг үүрэг бүхий төрийн захиргааны орон нутгийн байгууллага юм. Манай байгууллага нь Гэрлэх ёслолын ордон, Хүүхдийн урлаг бүтээх төв, Монголын хүүхдийн ордон, Хүүхэд, залуучуудын сургалт хөмүүжлийн тусгай цогцолборуудын бодлого төлөвлөлт, төлөвлөгөө, төсөл хөтөлбөрүүдийг бодлогын, нэгдмэл удирдлагаар хангаж, Нийслэлийн 9-н дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс, Гэр бүлд зөвлөгөө өгөх төв, олон нийтийн оролцоонд түшиглэсэн хүүхэд хөгжил, хамгааллын төвүүд, хүүхдийн зуслан, халамж асрамжийн төвүүдийг мэргэжил, арга зүй, удирдлагаар хангаж, хяналт тавин ажиллаж байна. "Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль" 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсээр нийслэлийн 9 дүүрэгт Залуучуудын хөгжлийг дэмжих төвүүд байгуулагдан ажиллаж залуучуудад сэтгэлзүй, гэр бүл төлөвлөлтийн зөвлөгөө өгөх, эрүүл мэндийн үйлчилгээ болон хууль эрх зүйн үйлчилгээнд холбон зуучлах, хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг цогц үйл ажиллагаа явуулах боломжтой болсны дагуу Залуучуудын хөгжлийн жишиг төвийг Налайх дүүрэгт байгуулсан ба тус төв нь холбон зуучлах, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, сайн дурын ажлыг бүртгэж, баталгаажуулах, лавлагаа, гаргах, хөгжлийг дэмжих, номын сангийн үйлчилгээ гэсэн 5 чиглэл, 16 төрлийн үйлчилгээг үзүүлж, залуучуудын чөлөөт цагаа өнгөрүүлэх нөхцөл боломжоор ханган ажиллаж байна.
		22.3.7	Нийтийн биеийн тамир					

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2020 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН ХӨТӨЛБӨР, ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭХ ҮР ДҮНГИЙН ТАЛААРХ ЧАНАРЫН БОЛОН ТОО ХЭМЖЭЭНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
1	2	3		4	5	6	7	8
1	**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА**					**6,714.1**	**6,586.9**	
	1.1	**Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагаа**				**6,547.0**	**6,422.4**	
		1.1.1	Төрийн байгуулал, улс орны удирдлагын асуудлаар Улсын Их Хурал, Засгийн газар, шүүх эрх мэдлийн байгууллагуудтай хамтарч ажиллана.	төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх	төлөвлөсөн хугацаанд 100 хийгдсэн	3,015.3	2,946.7	1. Чуулганы нэгдсэн хуралдаанд 3 удаа оролцон үг хэлж, төрийн бодлогын зарим асуудлаар УИХ-д 4 удаа санал оруулж, УИХ-ын баталсан 4 шийдвэрт хориг тавьж, хууль, шийдвэрийн 2 төсөл санаачлан өргөн барьж, 5 удаа албан тушаалтныг томилох асуудлаар зөвшилцөв. 2. Монгол Улсын Ерөнхийлөгч Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах тухай Ерөнхий сайдаас тавьсан саналын талаар зөвшилцөх бүрэн эрхийн хүрээнд Ерөнхий сайдад дөрвөн зүйл бүхий зөвшилцөх санал хүргүүлэв. Монгол Улсын Ерөнхийлөгч "Засгийн газарт чиглэл өгөх тухай" хоёр удаагийн зарлиг гаргав. 3. Монгол Улсын Үндэсэн хууль, холбогдох хуульд заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгч зарлиг гарган 17 шүүгчийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлж, 25 шүүгчийг шилжүүлэн томилов. 4. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгч зарлиг гарган 7 шүүгч, 1 Ерөнхий шүүгчийн бүрэн эрхийг сэргээж, 1 шүүгчийг албан тушаалаас нь огцруулсан. 5. Бүрэн эрхийн хугацаа дуусгавар болж, тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Лүндэндоржийг чөлөөлж, Э.Батбаярыг даргаар томилсон. Мөн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон ШЕЗ-ийн гишүүн Д.Эрдэнэчулууныг ШЕЗ-ийн гишүүний албан тушаалаас чөлөөлж, Л.Атарцэцэг, Д.Цогтсайхан нарыг ШЕЗ-ийн гишүүнээр томилсон. 6. Шүүхийн захиргааны тухай хуульд заасны дагуу бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон Шүүхийн ёс зүйн хорооны гишүүдийг чөлөөлж, Д.Ариунтуяа, Б.Энхтунгалаг, Л.Галбаатар, Т.Менх-Эрдэнэ,
		1.1.2	Үндэсний аюулгүй байдлыг хангах, улсыг батлан хамгаалах чиглэлд хэрэгжиж байгаа хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход санаачилга гарган ажиллана.	төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх		245.4	245.4	Монгол Улсын Ерөнхийлөгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүн Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болох Оршин тогтнохуйн аюулгүй байдал, Нийгэм-төрийн байгууллын аюулгүй байдал, Иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал, Эдийн засгийн аюулгүй байдал, Шинжлэх ухаан, технологийн аюулгүй байдал, Мэдээллийн аюулгүй байдал, Монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, Хүн ам, удмын сангийн аюулгүй байдал, Экологийн аюулгүй байдал, Хүнсний аюулгүй байдлын чиглэлээр улс үндэсний аюулгүй байдал болон төрийн гадаад, дотоодын бодлогын нэгдмэл байдлыг хангах үүднээс Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг 7 удаа хуралдуулж, 10 асуудал хэлэлцэн шийдвэрлэж 11 зөвлөмж, 9 тэмдэглэл гарган, Монгол Улсын Их хурал, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллага, холбогдох төрийн байгууллага, албан тушаалтнуудад зөвлөмж, үүрэг даалгавар, чиглэл хүргүүлэн хэрэгжилтийг хангуулав.
		1.1.3	Гадаад харилцааны Монгол Улсыг бүрэн төлөөлж, гадаад бодлого, олон улсын хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулна.	төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх		682.7	626.3	Монгол Улсын Ерөнхийлөгч АНУ, ОХУ, БНЭУ, Норвегийн Хаант Улс, БНХАУ-д албан ёсны айлчлал хийж, Дорнын эдийн засгийн IV дүгээр чуулга уулзалт, Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалт зэрэг уулзалтуудад оролцсон. Монгол Улсын Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улсаас Бүгд Найрамдах Куба Улс, Бүгд Найрамдах Польш Улс, Тайландын Хаант Улс, Шведийн Хаант Улс, Монгол Улсаас НҮБ-ийн дэргэд суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд нарыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Куба Улс, Бүгд Найрамдах Чили Улс, Бүгд Найрамдах Бразил Улс, Бүгд Найрамдах Перу Улс, Бүгд Найрамдах Уругвай Улс, Бүгд Найрамдах Польш Улс, Бүгд Найрамдах Латви Улс, Бүгд Найрамдах Литва Улс, Украйн Улс, Норвегийн Хаант Улс, Бүгд Найрамдах Эстони Улс, Бүгд Найрамдах Финлянд Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд нарыг түс түс тохоон томилов. Монгол Улсын Ерөнхийлөгч гадаад улсаас Монгол Улсад суугаа элчин сайд, суурин төлөөлөгч, Монгол Улсад айлчилсан болон ажилласан гадаад улсын 17 төлөөлөгчдийг хүлээн авч уулзав. Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд заасан Монгол Улсад суух гадаад улсын бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүний итгэмжлэх, эгүүлэн татах 12 жуух бичгийг хүлээн авсан.
		1.1.4	Хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж ажиллана.	төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх		2,603.6	2,604.0	Монгол Улсын Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн тухай хууль, "Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр", Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дүрмийг тус тус үндэслэн "Монгол Улсын Ерөнхийлөгчийн Бодлого үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг боловсруулан баталж түүнийг хэрэгжүүлэхэд чиглэсэн Тамгын газрын үйл ажиллагааны төлөвлөгөөг Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллага, Монгол Улсын Ерөнхийлөгчийн бодлого үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, Тамгын газрын үйл ажиллагааг тогтвортой, тасалдалгүй хэрэгжүүлэхэд чиглэсэн ажил, үйлчилгээ гэсэн гурвын үндэсэн хэсэгт хуваан төлөвлөгөөний төслийг жил бүрээр боловсруулан батлуулж, биелэлтийг хангаж ажиллаж байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар 2017-2019 оны хугацаанд "Бодлого үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 88 заалтын биелэлтийг хангахад чиглэсэн нийт 249 арга хэмжээ, ажил үйлчилгээг зохион байгуулж хэрэгжүүлэн ажилласнаас 2020 онд Бодлого, Үйл ажиллагааны 81 заалтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн 202 үйл ажиллагаа төлөвлөснөөс 171 арга хэмжээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллав.
	1.2	**Монгол Улсын Ерөнхийлөгч, хууль тогтоох байгууллага болон гүйцэтгэх засаглалын судалгаа, шинжилгээ**				**167.1**	**164.5**	
		1.2.1	Монгол хэлний тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаа эрхлэх	Судалгааны тайлан гаргах		167.1	164.5	Монгол хэлний хуулийг хэрэгжүүлэх, Монгол Улсын 21 аймаг, 9 дүүрэг, 333 сумын салбар зөвлөлийг мэргэжил арга зүйгээр хангах, салбар аман аялгуут хөгжүүлж, судалгаа хийх, цахим хэл шинжлэлийг хөгжүүлэх, хэлний бодлогыг ямар түвшинд байгаа талаар судалгаа хийх, энэ хүрээнд дархад аман аялгууны судалгаа хийж ном гаргав. Цахим 2 хуудас хийж, алдаа шалгах программыг хамтран бүтээв.
2	**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА**					**47,256.2**	**44,444.5**	
	2.1	**Хууль тогтоох, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих**				**47,256.2**	**44,444.5**	

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
		2.1.1	Хууль, тогтоолын төсөл хэлэлцэж батлах	100-аас доошгүй ажлын өдөр хуралдаж хууль, тогтоолын төсөл хэлэлцэж батлах	100% хэрэгжсэн	36,309.7	34,435.9	Тайлант хугацаанд Улсын Их Хурлын нэгдсэн болон Байнгын, дэд, түр хороодын хуралдааныг хэвийн явуулах хууль, тогтоолын төслийг хэлэлцэн батлах ажлын хүрээнд Улсын Их Хурлын чуулганы 61 удаагийн нэгдсэн хуралдаан, Байнгын хороодын 210, дэд хороодын 10, түр хороодын 6 удаагийн хуралдааныг явуулж 241 хууль, 106 тогтоолын төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэн, Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, анхдагч хууль 34, олон улсын гэрээ, хэлэлцээр соёрхон батлах тухай 24 хууль, хуулийн шинэчилсэн найруулга 8, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 167, хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль 8, Улсын Их Хурлын 106 тогтоолыг тус тус батлуулсан байна.
		2.1.2	Хууль, тогтоолын биелэлтийг хянан шалгах, холбогдох тайлан, мэдээллийг хэлэлцэх, сонсох	10-аас доошгүй удаа хяналт шалгалт хийх, 6-аас доошгүй удаа тайлан хэлэлцэх, 12-оос доошгүй удаа мэдээлэл сонсох	бүрэн хэрэгжсэн	3,343.9	3,080.2	Тайлант хугацаанд 2017-2019 онд байгуулагдсан 6 ажлын хэсэг үйл ажиллагаагаа үргэлжлүүлж, 12 ажлын хэсэг шинээр байгуулагдсан. Нийт 18 ажлын хэсгээс Улсын Их Хурлын даргын захирамжаар 9, Байнгын хорооны тогтоолоор 8, Дэд хорооны тогтоолоор 1 ажлын хэсэг байгуулагдан ажилласан байна. Тайлант хугацаанд хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцах, хянан шалгах үүрэг бүхий 10 ажлын хэсэг удирдамжид заасан чиг үүргээ хэрэгжүүлэн санал, дүгнэлт, шийдвэрийн төсөл боловсруулж, холбогдох байгнын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газар болон холбогдох байгууллагуудад Улсын Их Хурлын 2 тогтоол, Байнгын хорооны 3 тогтоолоор үүрэг чиглэл өгч ажилласан байна. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөхцөл байдал, түүнтэй холбогдуулан хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх нийт 4 удаагийн мэдээллийг байнгын болон түр хорооны хуралдаанаар сонсох ажиллагаг хэрэгжүүлсэн. Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг 6 байгууллагууд 2019 оны үйл ажиллагааны тайландаа "Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх аргачлал" ын дагуу системчилсэн үнэлгээ хийсэн эсэхэд хяналт тавьж,санал, дүгнэлтээ холбогдох Байнгын хороодод хүргүүлж, Байнгын хорооны хуралдаанаар дээрх үйл ажиллагааны тайланг хэлэлцээд үүрэг, чиглэл өгсөн шийдвэрийн биелэлтэд хяналт тавин ажиллалаа.
		2.1.3	Улсын Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагааг чиглүүлэн удирдаж, Улсын Их Хурлын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах	Хуульд заасны дагуу хангагдсан байх	бүрэн хэрэгжсэн	7,602.5	6,928.5	Монгол Улсын Их Хурлын Тамгын газар түүхэн замналынхаа гурван арванд хуримтлуулсан туршлага, чадамж, алсын хараа, үнэт зүйлсдээ тулгуурлан Улсын Их Хурлын хууль тогтоох, хянан шалгах бүрэн эрх, төлөөллийн чиг үүргээ хэрэгжүүлэх үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын зөвлөмж, туслалцаа үзүүлэх хуулиар хүлээсэн үүргээ амжилттай хэрэгжүүлэн ажилласан байна. 2020 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт хэрэгжиж эхэлсэн, парламентын нэгэн бүрэн эрхийн хугацаа өндөрлөж, шинэ парламент бүрэлдэн, үйл ажиллагаа явуулж эхэлсэн түүхэн онцлогтой жил болов. КОВИД-19-ын цар тахлын эрсдэл нүүрлэж, улс орон даяар хөл хорио, хязгаарлалтын дэглэм тогтоосон онцгой нөхцөлд төрийн эрх барих, хууль тогтоох дээд байгууллагын үйл ажиллагааны байдал, тасралтгүй ажиллагаа хангах онцгой зорилт тулгарч урьд өмнө огт тохиолдож байгаагүй шинэ сорилтыг амжилттай даван туулж, цахим хуралдааны шинэ дэгээр, техник, зохион байгуулалтын оновчтой шийдлийг нэвтрүүлж, хууль тогтоох үйл ажиллагаг цахим орчинд зохион байгуулснаар дэлхийн парламентын түүхэнд анхдагчдын нэг болон хуулиар хүлээсэн үүргээ амжилттай хэрэгжүүлэн ажилласан.
3	МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА					2,899.2	2,657.7	
	3.1	Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих				2,899.2	2,657.7	
		3.1.1	Өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг шийдвэрлэх	Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байх	Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байх	2,899.2	2,657.7	Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 2020 онд 191 өргөдөл, мэдээлэл, гомдол, хүсэлт хүлээн авснаас, урд оны үлдэгдэл 48, нийт 239 өргөдөл, мэдээлэл, хүсэлт, гомдлыг хянан шалгаад байна. Үндсэн хуулийн цэц 2020 онд Бага суудлын хуралдаан 27, Дунд суудлын хуралдаан 14, Их суудлын хуралдаан 1 -г бүхэл нийт 42 удаа Цэцийн хуралдаан хийсэн байна. Хуулийн хугацаандаа шийдвэрлэгдсэн байдал 100 хувь байна.
		3.1.2	Бага суудлын хуралдаанаар гомдол шийдвэрлэх	Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байх	Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байх			
		3.1.3	Дунд, их суудлын хуралдаанаар маргаан хянан шийдвэрлэх	Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байх	Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байх			
4	УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ					4,728.9	3,505.1	
	4.1	Хяналтын шатны шүүн таслах ажиллагаа				4,728.9	3,505.1	
		4.1.1	Хяналтын журмаар хуулийн хугацаанд хянан шидвэрлэх эрүүгийн хэргийн тоо	850	685	1,376.6	961.1	Улсын Дээд шүүх нь хяналтын шатны шүүн таслах ажиллагаа хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийг гаргахдаа өмнөх жилүүдийн шийдсэн хэргийн тооны дундаж үзүүлэлтийг харгалзан үзэж гаргадаг. 2020 онд хяналтын шатны журмаар шийдвэрлэсэн нийт хэргийн тоо өмнөх оныхоос 4.4 хувиар, тухайн жилийн зорилтот түвшингээс 14.5 хувиар тус тус буурсан байна. Хяналтын шатны журмаар шийдвэрлэгдэх эрүүгийн хэргийн тоо зорилтот түвшингээс 165 хэргээр бүюу 19.4 хувиар, иргэний хэргийн тоо 396 хэргээр бүюу 26.4 хувиар тус тус буурсан бол захиргааны хэргийн тоо 139 хэргээр бүюу
		4.1.2	Хяналтын журмаар хуулийн хугацаанд хянан шийдвэрлэх иргэний хэргийн тоо	1500	1104	2,429.2	1,549.2	
		4.1.3	Хяналтын журмаар хуулийн хугацаанд хянан шидвэрлэх захиргааны хэргийн тоо	570	709	923.1	994.7	
5	ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА					56,310.3	54,748.0	
	5.1	Шүүхийн бие даасан хараат бус байдлыг хангах				56,310.3	54,748.0	
		5.1.1	Хэрэг, маргааныг хуулийн хугацаанд шийдвэрлэх /хувиар/	93	97	56,310.3	54,748.0	Монгол Улсын шүүх 2020 онд 54 тэрбум 748 сая төгрөгийн төсөвтэйгөөр хэрэг, маргааныг анхан болон давж заалдах, хяналтын шатны журмаар хянан шийдвэрлэв. Монгол Улсын шүүхийн 2020 оны шүүн таслах ажиллагааны статистик нэгдсэн дүн мэдээнд анхан шатны шүүх хэрэг, маргааны 96.7 хувийг, давж заалдах шатны шүүх хэрэг, маргааны 99.9 хувийг хуулийн хугацаанд хянан шийдвэрлэсэн байна.
6	ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА					1,577.5	1,503.0	
	6.1	Хүний эрхийн хэрэгжилтийг хангах				1,577.5	1,503.0	
		6.1.1	Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл	1	1	1,577.5	1,503.0	Хүний эрхийн комисс нь Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 7 дугаар зүйлийн 7.11 дэх хэсэгт заасны дагуу бүрэн эрхийнхээ хүрээнд Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар илтгэл боловсруулж, жил бүрийн эхний улиралд багтаан Улсын Их Хуралд хүргүүлдэг. Комиссын Тамгын газрын ажлтнууд Комиссын дарга, гишүүдийн өгсөн чиглэл, удирдлагад дор "Монгол Улсын Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19 дахь илтгэл"-ийг боловсруулж, 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдөр УИХ-ын дарга Г.Занданшатарт өргөн барьж, Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайдад мөн хүргүүлсэн. ХЭҮК-ын тухай хуулийн 9 болон 17 дугаар зүйлд заасны дагуу Улсын Их Хурлаар хэлэлцүүлж, шийдвэр гаргуулахаар 23 саналыг тусгасан болно.
		6.1.2	Хяналт шалгалт хийх, судалгаа явуулах, дүн шинжилгээний тайлан боловсруулах, санал гаргах	Хяналт шалгалт 20, судалгаа 6, дүн шинжилгээ, санал гаргах 30	Хяналт шалгалт 226, судалгаа 6, дүн шинжилгээ, санал гаргах 189			Хүний эрхийн Үндэсний Комисс 2020 онд хяналт шалгалтын хүрээнд гомдлын дагуу 26, мэдээллийн дагуу 100, санамж бичгийн хүрээнд 57 нийт 266 хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж ажилласан байна. Комисс нь 2020 оны 12 сарын байдлаар байдлаар 14 хууль тогтоомжийн төсөл, бодлогын баримт бичиг, журмын төсөлд хүний эрхийн зарчим, хэм хэмжээний дагуу дүн шинжилгээ хийж, саналын томьёоллыг нэгтгэн боловсруулж, нийт 189 саналыг гарган хууль санаачлагчид хүргүүлжээ.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
		6.1.3	Хүний эрх, эрх чөлөө зөрчигдсөн асуудлаарх гомдол шийдвэрлэх	Гомдол шалгаж шийдвэрлэх-600, хуульзүйн зөвлөгөө-3000	Гомдол шалгаж шийдвэрлэх-790, хуульзүйн зөвлөгөө-1674			Хүлээн авсан гомдол, мэдээлэл 790, үүнээс 234 нь орон нутгаас, ирүүлжээ. Гомдол, мэдээллийг ирүүлсэн хэлбэрээр ангилбал бичгээр 628, цахимаар 86, утсаар 23, мэйлээр 32, цахим хуудсаар 21 гомдол, мэдээлэл хүлээн авсан байна. Тайлант хугацаанд нийт 1,674 иргэнд 32,342 минутын хууль зүйн зөвлөгөө өгч ажилласнаас 575 иргэнд утсаар, 1,099 иргэн биечлэн хууль зүйн зөвлөгөө өгсөн. Үүнээс орон нутаг дахь ажилтнууд 261 иргэнд утсаар, 579 иргэнд биечлэн нийт 17,121 минутын хууль зүйн зөвлөгөө өгсөн байна.
		6.1.4	Хүний зөрчигдсөн эрхийг сэргээлгэх талаар шүүхэд нэхэмжлэл гаргах, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүсэлт тавих, шаардлага хүргүүлэх, хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх нөхцөл бий болсон шалтгаан нөхцөлийг арилгуулахаар зөвлөмж хүргүүлэх	Төлөөлөн нэхэмжлэл 2, шаардлага 20, зөвлөмж 25	Төлөөлөн нэхэмжлэл 2, шаардлага 32, зөвлөмж 30			Комиссоос иргэн Ж.Н болон Д.О нарын төлөөлөн 2 нэхэмжлэл гаргасан бөгөөд шүүх хурал хойшлогдсон байна. Тайлант хугацаанд Комиссын гишүүний 30 зөвлөмж, 32 шаардлагыг аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлж ажилласан бөгөөд шаардлага, зөвлөмжийг хариуцан боловсруулсан ажилтнууд хэрэгжилтэд нь тогтмол хяналт тавьж ажиллаж байна.
		6.1.5	Хүний эрхийн боловсрол олгох сургалт, сурталчилгаа зохион байгуулах	400 цагийн сургалт, 6000 хүн	731 цагийн сургалт, 15789 хүн			2020 онд Комисс 731 цагийн сургалтыг 15,789 хүнд зохион байгуулсан байна. Үүнээс Комиссын төвийн ажилтнууд нийт 484 цагийн сургалт хийж, 9,741 хүн хамруулсан бол орон нутаг дахь ажилтнууд нийт 247 цагийн сургалтыг 6,045 хүн хамруулсан байна.
7	**УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР**					**43,678.1**	**41,610.4**	
	7.1	**Прокурорын хяналт**				**43,678.1**	**41,610.4**	
		7.1.1	Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих /хувиар/	100	100	43,678.1	41,610.4	Монгол Улсын хэмжээнд Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах, Эрүүгийн хэргийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавих, гэмт хэргийн талаарх гомдол, мэдээлэлд хяналт тавих, прокурорын байгуулагын нэгжүүдийн хэрэг бүртгэх, мөрдөх байцаах ажиллагаанд хяналт тавих ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангах, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцсон.
		7.1.2	Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих /хяналтын тоо/	7100	7198			Ял эдлүүлэх ажиллагаанд тавих хяналтын чиглэлээр шалгалт, судалгааны чанар үр нөлөөг сайжруулах, төв, орон нутгийн прокурорын газрын ял эдлүүлэх ажиллагаанд тавих хяналтын ажлыг газар дээр нь шалгаж заавар, зөвлөгөө өгөх, хуулиар тогтоосон нөхцөл, журмын дагуу ял эдлүүлэх, ял завшуулахгүй байх, ялтны эрхийг нь хангах, тэднийг нийгэмшүүлэх, хорихоос өөр төрлийн ялын бодит биелэлтийг сайжруулах, зорчих эрхийг хязгаарлах, нийтэд тустай ажил хийлгэх, ялын биелэлтийг хангуулах талаар удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авах, албадах байруудын ахуй нөхцөлийг дээшлүүлэхэд хяналтын ажлаа чиглүүлж, нээлттэй болон хаалттайгаар хорих ангиудын үйл ажиллагааг зохион байгуулах, хянах үйл ажиллагаанд хэрэгжүүлсэн.
		7.1.3	Зөрчлийн хэрэг бүртгэлтэд хяналт тавих /зөрчлийн тоо/	1350000	2344186			Монгол Улсын хэмжээнд Прокурорын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавих, прокурорын байгууллагын нэгжүүдийг мэргэжлийн удирдлагаар хангах, зөрчил шалган шийдвэрлэх 27 эрх бүхий байгууллагын 11,000 гаруй албан тушаалтны зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавьж зөрчлийн нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, эрх хязгаарлах зэрэг бусад албадлагын арга хэмжээнд зөвшөөрөл өгөх үйл ажиллагаа авч хэрэгжүүлсэн.
		7.1.4	Мөрдөн шалгах нууц ажиллагаа, гүйцэтгэх ажилд хяналт тавих	Төлөвлөгөөт хугацаанд хийгдсэн байх	төлөвлөгөөнд хүрч ажилласан			Мөрдөн шалгах нууц ажиллагаа, гүйцэтгэх ажилд хяналт тавих үйл ажиллагааг төлөвлөгөөндөө хүрч ажилласан.
8	**МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА**					**4,688.5**	**4,606.6**	
	8.1	**Үндэсний аюулгүй байдлыг сахин хамгаалах**				**4,688.5**	**4,606.6**	
		8.1.1	Бодлогын зөвлөгөө /тоогоор/	80	80	3,904.3	3,897.0	Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхол, оршин тогтнохын, дотоодын, эдийн засгийн, хүрээлэн байгаа орчны, мэдээллийн, хүний аюулыгүй байдлыг хангах, хүний эрх, эрх чөлөөг бэхжүүлэх төрийн нэгдмэл бодлогыг боловсруулах, аюулгүй байдлыг хангах, хууль тогтоомж, Зөвлөлөөс гарсан шийдвэрийн хэрэгжилтийг үялдуулан зохицуулах, бодлогын зөвлөгөөгөөр хангах, хяналт тавих, үндэсний аюулгүй байдлын тэргүүн гишүүдийн хуулиар хүлээсэн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд Монгол улсын үндэсний ашиг сонирхол, оршин тогтнох тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, эдийн засаг, экологийн тэнцвэртэй хөгжлийг хангах, бодлого үйл ажиллагаагаар дэмжлэг үзүүлэх, төрийн болон орон нутгийн төр захиргааны байгууллагуудад Монгол улсын хууль тогтоомж, зөвлөлийн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлэхэд нь бодлогын зөвлөгөөгөөр хангах, бодлого боловсруулах, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй байгууллагуудын салбар хоорондын үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөлт, зохицуулалтыг мэргэжлийн удирдлагаар хангаж ажилласан. 2020 онд ҮАБЗ-ийн хуралдаанаар 18 зөвлөмж , 13 тэмдэглэл -ийг гарган хэрэгжүүлэн ажиллаж байна.
		8.1.2	Эрдэм шинжилгээ, судалгаа /тоогоор/	90	90	784.3	709.6	ССХ 2020 онд 4 сектор, 22 судлаачийн бүрэлдэхүүнтэй ажиллаж төлөвлөгөөт болон цаг үеийн, даалгаварт судалгаа гүйцэтгэлээ. Шуурхай мэдээ, танилцуулах мэдээнээс эхлэн санал, зөвлөмж, бодлогын судалгааны цогц тайлан хүртэлх төрөл бүрийн цар хүрээний 115 мэдээлэл, материал бэлтгэж ҮАБЗ болон холбогдох байгууллагад хүргүүлж, зарим хэсгийг хүрээлэнгийн дотоод хэрэгцээнд, цаашдын судалгааны бааз болохоор хадгалж байна. Хүрээлэнгээс гаргасан эрдэм шинжилгээ, судалгааны бүтээгдэхүүн, ажлын гүйцэтгэлийг тоогоор илэрхийлбэл дараах үзүүлэлттэй байна. Илтгэх хуудас 3, Шуурхай мэдээ 3, Танилцуулах мэдээ 55, Танилцуулах тойм мэдээ 19, Бодлогын судалгааны тайлан 15, Мэргэжлийн сэтгүүл 1, Гадаадын байгууллагатай хамтарсан семинар 2, Нууцаар хүргүүлсэн санал, зөвлөмж, лавлагаа мэдээлэл, эрдэм шинжилгээний илтгэл 5, Эрдэм шинжилгээний өгүүлэл 8, Англи хэлнээс ном орчуулах 1 ширхгийг тус тус гаргаад байна.
9	**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР**					**21,700.1**	**20,312.8**	
	9.1	**Төрийн аудитын үйлчилгээ**				**21,700.1**	**20,312.8**	
		9.1.1	Санхүүгийн тайлангийн аудит	6504	6542	21,700.1	20,312.8	Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг төрийн аудитын байгууллага 5,241, хараат бус аудитын компани 1,301 нийт 6,542 байгууллагыг хамруулан зохион байгуулан ажилласан.
		9.1.2	Гүйцэтгэлийн аудит	58	160			Нэгдсэн удирдамжаар 82, УИХ, аймгийн ИТХ-ын хүсэлтээр 25, өөрсдийн санаачилгаар 50, өргөдөл, гомдлын дагуу 3 нийт 160 гүйцэтгэлийн аудитыг гүйцэтгэсэн.
		9.1.3	Нийцлийн аудит	39	156			Нэгдсэн удирдамжаар 97, УИХ, аймгийн ИТХ-ын хүсэлтээр 20, өөрсдийн санаачилгаар 39, өргөдөл, гомдлын дагуу 0 нийт 156 нийцлийн аудитыг гүйцэтгэсэн.
10	**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА**					**27,058.2**	**24,554.5**	

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт		2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	10.1	**Авлигатай тэмцэх**			**27,058.2**	**24,554.5**	
	10.1.1	Мэдүүлгийн бүрдүүлэлтэд хянагдсан хөрөнгө орлогын мэдүүлгийн тоо	3250	3250	6,000.0	6,000.0	Авлигын эсрэг хууль, НАНБХАСЗАСЗУСТХ-ийн үйлчлэлд хамаарах албан тушаалтнуудын 2019 оны ХАСХОМ-ийг шинэчлэн бүртгэх ажлыг улсын хэмжээнд удирдан зохион байгуулав. Төрийн захиргааны болон нутгийн захиргааны нийт 110 байгууллагаас ХАСХОМ-ийн талаарх тайлан, мэдээг хүлээн авч, ХАСХОМ-ийг 41685 албан тушаалтан мэдүүлсэн. Сонгуулийн тухай хууль шинэчлэгдэн батлагдсантай буюу 92.6 хувь нь цахим системд ХОМ-ээ гаргаж баталгаажуулсан. Мөн Төрийн болон нутгийн захиргааны нийт 36832 албан тушаалтны 2019 оны ХОМ-ийн хураангуйг http://www.xacxom.iaac.mn цахим хуудсанд нээлттэй байршуулсан. 2019 онд мэдүүлсэн мэдүүлгийн хамгийн өндөр орлоготой болон орлого нь өмнөх онуудаас хэт өссөн болон давтамжтайгаар өсөж байгаа албан тушаалтнуудын мэдүүлгийг Татварын ерөнхий газартай хамтран хянаж, нийт 31.952.1 сая төгрөгийн зөрчил илэрч, 801.6 сая төгрөгийн нөхөн ногдуулалтын акт тавигдсан байна. Монгол банкны нэр бүхий 5 албан тушаалтны ХАСХОМ-ийг хянаж, Монгол банкны ерөнхийлөгчид шаардлага хүргүүлснээр Монголбанкны ажлын байрны тодорхойлолтод "банк бус санхүүгийн байгууллага үүсгэн байгуулагч, хувь эзэмшигч биш байх" хориглолтыг тусгуулахаар болов. 2017-2019 онд хууль бусаар нийтийн албанаас халагдаж, шүүхийн шийдвэрээр ажлын байранд эгүүлэн томилогдсон нийт 796 албан хаагчийг буцаан томилж, 4094.0 сая төгрөгийн нөхөн олговор олгох шийдвэр гарсан байна.
	10.1.2	Авлигатай тэмцэх талаарх сургалтад хамрагдах хүний тоо /мянган хүн/	16	17.728	5,000.0	3,883.4	Тайлант хугацаанд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэдний мэдлэг мэдээллийг нэмэгдүүлэх, чадавхжуулах чиглэлээр 13820 хүнийг сургалтад хамруулж, 2190 хүнд цахим сургалт хийв. Монгол Улсын Их Хурлын 2020 оны сонгуультай холбогдуулан 29 тойргийн хорооны дарга болон нарийн бичгийн дарга нийт 160 гаруй албан тушаалтныг хамруулан сургалт зохион байгуулж, нэр дэвшигчдэд зориулсан гарын авлагыг боловсруулан хэвлүүлж түгээв. Тайлант хугацаанд 16 гарын авлага, эмхэтгэл, 2 тойм танилцуулгыг бэлтгэн хэвлүүлж, олон нийтэд түгээх ажлыг зохион байгуулав. 2020 онд анх удаа online болон LIVE сургалтуудыг амжилттай зохион байгуулав. 2020 оны 10 дугаар сард "Авлига ба эрэн сурвалжлах сэтгүүлчид" сэдэвт бүтэн өдрийн сургалтыг зохион байгуулав. 2019 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш төрийн албанд томилогдсон албан хаагчдын судалгаг авч нэгтгэн, гаргасан хуваарийн дагуу сургалтыг зохион байгууллаа. Сэтгүүлч, байгууллагын маркетинг, сошиал медиа хөгжүүлэгчдэд зориулсан сургалтыг 2020 оны 9 дүгээр сард 2 удаа зохион байгуулав. Нийслэлийн дүүргийн хороодын хэсгийн ахлагч, нийгмийн ажилтан, зохион байгуулагч нарт авлига, ашиг сонирхлын зөрчлийн эсрэг хууль тогтоомжийн зохицуулалтын талаар тодорхой мэдлэг олгох, чадавхжуулах сургалтыг 143 хорооны нийт 1631 албан хаагчийг цахим сургалтад хамруулаа.
	10.1.3	Авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх судалгаа дүн шинжилгээ.Үүнээс:	17	17	3,000.0	2,929.5	"Шударга байдлын үнэлгээ"-ий 2019 оны судалгаанд 62 байгууллага (яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар)-ыг хамруулсан. Төрийн байгууллагууд 74.1 оноо авсан нь 2018 оныхоос 5.4 пунктээр өссөн байна. Шударга байдлын үнэлгээний 2019 оны үр дүнг олон нийтэд мэдээлэх ажлын хүрээнд байгууллагын цахим хуудас болон хэвлэл мэдээллийн цахим хуудсанд байршуулж, телевизийн нэвтрүүлэг сайтад тус тус ярилцлага өгч, үр дүнг олон нийтэд танилцуулав. "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн авлигын талаарх ойлголт төсөөлөл"-ийг тодруулах судалгаат зохион байгуулан, үр дүнг олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулав. "Төрийн байгууллага дахь авлигын эрсдэлийн үнэлгээ" хийх ажлыг зарим байгууллагуудад зохион байгуулав. "Хүүхдийн шударга байдал" 2020 оны судалгаанд 5469 сурагч, 601 эцэг, эхээс асуулга авч, тайланг боловсруулж байна. 2018, 2019 онд авлигын эрсдэлийн үнэлгээнд хамрагдсан төрийн 39 байгууллагатай холбогдуулан иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлын тоон мэдээлэлд, улс орнуудын хөрөнгө, орлогын мэдүүлгийн системийн судалгаа, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэгжлэг хийх талаарх олон улсын эрх зүйн зохицуулалтын талаар судалгаг хийсэн. Авлигын гэмт хэргийн шалтгаан, нөхцөлийг тогтоох аргачилсан зөвлөмж (гарын авлага)-ийг бэлтгэн үйл ажиллаганд ашиглах нөхцөлийг бүрдүүлэв. Авлигатай тэмцэх газарт бүртгэгдсэн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл, гэмт хэргийн тайлан, мэдээг сар тутамд гаргаж, дүн шинжилгээ хийж ажиллаж байгаагийн зэрэгцээ Үндэсний Статистикийн хороонд мэдээ, тайланг тогтоосон хугацаанд хүргүүлж ажилласан. Байгууллагын албан хэрэг хөтлөлт, гомдол мэдээллийн болон гэмт хэргийн мэдээллийн цахим сан /е-оффис систем/-г 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс үйл ажиллаганд нэвтрүүлсэн.
	10.1.3.1	Авлигатай тэмцэх газарт хүлээн авсан өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээллийн шинжилгээ	12	12			
	10.1.3.2	Хүүхдийн шударга байдлын түвшин тогтоох судалгаа	1	1			
	10.1.3.3	Шударга байдлын үнэлгээ	1	1			
	10.1.3.4	Шударга ёс эмхэтгэл	1	1			
	10.1.3.5	Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа	2	2			
	10.1.4	Иргэд, байгууллага, албан тушаалтнаас хүлээн авсан гомдол, хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэх /хувиар/	98.9	98.9	7,058.2	6,876.9	2020 онд 1020 гомдол, мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шалган шийдвэрлэж, 281 гомдол, мэдээллийг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу харьяалах байгууллагад нь шилжүүлсэн. Хянан шийдвэрлэсэн гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл өмнөх оны мөн үеэс 126 нэгжээр буюу 14.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Мөрдөн шалгах ажиллагаа явуулсан 1020 гомдол, мэдээллээс 462 гомдол, мэдээлэл буюу 45.3 хувьд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг нээж, 487 гомдол, мэдээлэл буюу 47.7 хувьд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах, 27 гомдол, мэдээлэл буюу 2.6 хувийг харьяаллын дагуу шилжүүлэх саналтай тус тус прокурорт шилжүүлсэн дүнтэй байна. Албан тушаалтны авлига, ашиг сонирхлын зөрчлийг шалгуулахаар тайлант хугацаанд 616-г хянан шийдвэрлэсэн. Хянан шалгасан гомдол, мэдээллээс 73 албан тушаалтанд холбогдох зөрчлийг тогтоож, үүнээс 25 албан тушаалтанд хариуцлага тооцуулж, давхардсан тоогоор 64 байгууллага, албан тушаалтанд зөвлөмж, чиглэлийг хүргүүлсэн. Хуульд заасан үндэслэлээр буцаасан 31, гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй үндэслэлээр Мөрдөн шалгах хэлтэст шилжүүлсэн 116, бусад байгууллагад харьяаллын дагуу шилжүүлсэн 128, гомдлоо буцаасан 5, зөрчил илрээгүй 263 байна.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
		10.1.5	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх багц ажил, хэрэгжүүлэх арга хэмжээ	17	17	5,000.0	3,984.5	"Монгол Улсын авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал"-ын талаарх мэдээлэл, "Монгол Улсын авлигатай тэмцэх бодлогын хэрэгжилт, тойм танилцуулга" (2019.05.02-2020.05.02) жилийн үйл ажиллагааны мэдээлэл, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 1 дэх үе шатны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн мэдээллийг боловсруулж, эмхэтгэн УИХ-ын Тамгын газар болон холбогдох төрийн байгууллагуудад, мөн Транспэрэнси Интернэшнл олон улсын байгууллагаас зарласан 2019 оны авлигын төсөөллийн индексийн дүнгээр Монгол Улсын үзүүлэлтийн нөхцөл байдал болон холбогдох мэдээллийн эх сурвалж, индекс буурсан шалтгааны талаар УИХ-ын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлд тус тус хүргүүлж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллав. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн нэгдүгээр үе шатанд хэрэгжүүлбэл зохих 205 арга хэмжээнээс 192 арга хэмжээ зохих хэмжээнд хэрэгжиж, гүйцэтгэл 58,8 хувьтай буюу өмнөх оноос 23.3 хувиар өссөн дүнтэй үнэлэгдсэн. АТҮХ-т тусгагдсан зорилтын бүюу "Иргэний мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хуулийн хэрэгжилтийг хангах, мэдээллийн эрхзүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах" чиглэлийн хүрээнд Монголын сэтгүүлчдийн нэгдсэн эвсэл, Сэтгүүлчид, Хэвлэл мэдээллийн байгууллага, Төрийн бус байгууллагын төлөөлөл, ХЗДХЯ-тай хамтран "Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль"-ийн шинэчилсэн найруулгын төсөлд санал авах салбарын анхны хэлэлцүүлгийг зохион байгуулаа. Олон нийтэд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах зорилгоор сэтгүүлч, байгууллагын маркетинг, сошиал медиа хөгжүүлэгч мэргэжилтнүүдийг хамруулан 2 удаагийн сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулав. Төрийн албаны зөвлөл болон Төрийн албаны салбар зөвлөлтэй хамтран хяналт тавих, Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэлийн системтэй ХАСУМ-ийн цахим системийг уялдуулж, хяналтын механизмыг сайжруулах чиглэлээр ТАЗ-ийн удирдлагуудтай хамтран ажилласан.
		10.1.6	Авлигын эсрэг мэдээлэл, сурталчилгааны тоо	6	6	1,000.0	880.2	Авлигын нийгмийн хор аюулыг иргэд, олон нийтэд ухуулан таниулах ажлыг нийгмийн салбар, бүлэг тус бүрээр ангилан авч үзэж, тухайн салбар, бүлгийн онцлогт тохирсон агуулга, хэлбэрээр зохион байгуулсан. Ухуулга сурталчилгаг видео контент, зурагт хуудас, брошюр нугалбар, подкаст, үзүүлэн таниулах, радио контент, номын сангийн үйлчилгээ, мэдээллийн самбар, видео цахим хичээл, орон нутгийн, нийтийн тээврийн, гудамжны самбар болон дэлгэцийн, цахилгаан шатны сурталчилгаа, нийтлэл, нэвтрүүлэг зэрэг хэд хэдэн төрөл жанраар бэлтгэн, түгээж ажиллав. "Шударга тоглоё" хүүхэлдэйн зохиомж, дунд сургуулийн сурагчдад зориулан "Шударга ёс" цувралын эхний анги болох "Хичээл дээр" төле зохиомжийг мэргэжлийн уран бүтээлчидтэй хамтран хийсэн. Иргэдийг соён гэгээрүүлэхэд чиглэсэн "Авлигатай тэмцэх газарт гомдол, мэдээлэл хэрхэн гаргах вэ?", "Иргэн та авлигын эсрэг юу хийж чадах вэ?" Авлигад бид юу алдаж байна вэ?", "Авлигын эсрэг хууль тогтоомжид заасан үндэслэлээр хариуцлага тооцогдсон этгээдийн талаарх мэдээлэл" сэдвээр нугалбар танилцуулга (брошюр)-ыг боловсруулан хэвлүүлж, иргэдэд сурталчлав. Цахим орчинд мэдээлэл түгээх хүрээнд авлигын эсрэг 51 контентыг бэлтгэн агуулга, төрөл хэлбэрээр ангилан олон нийтэд хүргэж байна. Улсын Төв номын сан, Улаанбаатар хотын төв номын сан, МУИС-ийн номын сан, 21 аймгийн нийтийн номын сан, 25 их, дээд сургуулийн номын санд авлигын эсрэг номын буланг албан ёсоор нээн ажиллуулж байгаа бөгөөд нийт 31 төрлийн 98 ширхэг ном, гарын авлага, эмхэтгэл, товхимлыг номын сан бүрд хүлээлгэн өгөв. Цар тахлын улмаас үүссэн нөхцөл байдалтай уялдан орон нутагт албан томилолтоор ажиллах боломжгүй болсон тул тухайн орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон нутгийн захиргааны төв байгууллагаар дамжуулан орон нутгийн иргэдэд мэдээлэл, сурталчилгаа хүргэх ажлыг зохион байгуулаа. 21 аймагт 35 телевизээр 15236 удаагийн давтамжтайгаар, 23 радиогоор 265 удаагийн давтамжтайгаар, тараах материалыг 20 мянган хувь олшруулан орон нутгийн иргэдэд хүргэсэн бөгөөд нийтдээ 500 мянга гаруй иргэнд хүрч ажилласан байна. Нийт 1659 удаагийн давтамжтайгаар авлигын эсрэг мэдээлэл, сурталчилгааг 175.214 өрхийн 876.070 хүнд хүргэсэн дүн мэдээтэй байна.
11	**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА**					**4,567.5**	**4,269.3**	
	11.1	**Санхүүгийн зах зээлийн зохицуулалт**				**4,567.5**	**4,269.3**	
		11.1.1	Зохицуулалтын хүрээний санхүүгийн салбарын хууль тогтоомжийг боловсронгуй болгох /шинээр боловсруулах журмын төсөл/	5	24			Үнэт цаасны газрын чиглэлээр: Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон бусад холбогдох хуулиудад тусгай шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж ажилласан. Хадгаламж зээлийн хоршооны газрын чиглэлээр: Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, уг төсөлд Төв ХЗХ, тогтворжилтын сан, хадгаламжийн даатгалын зохицуулалтыг тусгасан. Хуулийн төслийг дагаж гарах Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль болон Зөрчлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийг хүчингүй болгох хуулийн төслүүдийг боловсруулсан. Хяналт шалгалт зохицуулалтын газрын чиглэлээр: Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулж, Улсын Их Хурлаар батлуулсан. ҮХХЗҮЗЗГ-ын чиглэлээр: Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.3-т шинээр нэмэгдсэн зохицуулалтын салбарын үйл ажиллагаат зохицуулах журам, зааврыг боловсруулах ажлын хүрээнд 2 тогтоол, 7 журам батлуулсан. 2020 онд Санхүүгийн Зохицуулах Хорооноос 11 журам баталж, Захиргааны эрх зүйн нэгдсэн санд бүртгүүлсэн. Мөн 2 журмыг батлан Хууль, зүй дотоод хэргийн яаманд хянуулж, бүртгүүлэхээр хүргүүлсэн.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
		11.1.2	Шинээр буюу шинэчлэгдэн батлагдсан хууль тогтоомжуудад нийцүүлэн банкнаас бусад санхүүгийн салбарт мөрдөгдөх дүрэм, журамд өөрчлөлт оруулах	30	32	4,567.5	4,269.3	Үнэт цаасны газрын чиглэлээр: Хорооноос баталж хэм хэмжээ тогтоосон нийт 4 захиргааны хэм хэмжээний актыг шинээр болон шинэчлэн баталж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлсэн. Мөн Хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын шинэчилсэн төсөл болон "Компаний өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын төслийг шинээр боловсруулсан. Хадгаламж зээлийн хоршооны газрын чиглэлээр: -Захиргааны өрөнхий хуульд нийцүүлж хүчингүй болгох шаардлагатай Хорооны 2012 оны 136 дугаар тогтоолоор батлагдсан. "Хадгаламж, зээлийн хоршоодын үндэсний холбооноос үзүүлэх тогтворжилтын үйлчилгээний журам"-ыг хүчингүй болгосон. Хорооны 2018 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан "Хадгаламж, зээлийн хоршооны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт"-д Хорооны 2020.12.23-ны өдрийн 1022 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт нөөцийн сангийн зохистой харьцаанд нийт хөрөнгөөс тооцдог байх болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааны хангах хувь хэмжээг бууруулах, маягтуудыг шинэчлэх өөрчлөлтийг оруулсан. Хяналт шалгалт зохицуулалтын газрын чиглэлээр: -Хорооны 2020 оны 4 сарын 08-ны 183 дугаар тогтоолоор 2018 оны 339 дүгээр тогтоолоор батлагдсан "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам"- д нэмэлт өөрчлөлт оруулав. -Зөрчлийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг зөрчих" заалтад холбогдох саналыг өгч ажилласан. -Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас боловсруулж буй "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам"-ын төсөлд холбогдох саналыг хүргүүлсэн. Мөн Хорооноос нэмэлт өөрчлөлт оруулсан 7, шинэчлэн баталсан, нийт 20 захиргааны хэм хэмжээний акт байна.
		11.1.3	Үнэт цаас, даатгал, бичил санхүүгийн салбарт эрсдэлд суурилсан хяналт, шалгалт хийх /хамрагдах аж ахуйн нэгж байгууллагын тоо/	250	178			Хадгаламж зээлийн хоршооны газрын чиглэлээр: "ХЗХ-ны үйл ажиллагаанд газар дээрх шалгалт хийх, үнэлгээ өгөх заавар"-т оруулах шаардлагатай өөрчлөлтийн талаар судалж, зааврыг "ХЗХ-ны үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт, шалгалт хийх журам" болгохоор төслийг боловсруулж, Хорооны цахим хуудсанд байршуулж, санал авсан. АХБ-тай хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд "ХЗХ-ны эрсдэлийг үнэлэх аргачлал"-ын төслийг боловсруулж, хоршоодын эрсдэлийг зайнаас үнэлж, хийсэн эрсдэлийн үнэлгээ нь бодит байдалтай нийцэж байгаа эсэхийг 2019 онд 35 ХЗХ-нд газар дээрх шалгалт хийж туршсан. Газар дээрх хяналт шалгалтын хүрээнд: Тайлант хугацаанд нийт 55 мэдээлэх үүрэгтэй этгээдийн 25 үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага, 22 үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээд, 8 иргэн/ үйл ажиллагаанд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангуулж байгааг эрсдэлд суурилсан хэлбэрээр газар дээрх шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Зайны хяналт шалгалтын хүрээнд: Тайлан мэдээг хүлээн авах орчныг бүрдүүлэх ажлын хүрээнд тайлан нэгтгэлийн ФинА системд 13 төрлийн тайлан, мэдээний мастер файлыг боловсруулж, мета датаг ФинА системд оруулсан. Хороо Татварын өрөнхий газартай байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-ний хүрээнд тусгай зөвшөөрөлтэй иргэдийн худалдан борлуулсан бүтээгдэхүүний төлбөрийн баримтыг татварын QR баримтаар олгох нөхцөлийг бүрдүүлэхээр "Гааль, татвар, санхүүгийн мэдээллийн технологийн төв" УҮГ-тай хамтран ажиллаж байна. Хяналт шалгалт зохицуулалтын газрын чиглэлээр: Нийт 185 этгээдийн үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалтыг хийж гүйцэтгэснээс газрын хэмжээнд нийт 88 мэдээлэх үүрэгтэй этгээдэд эрсдэлд суурилсан төлөвлөгөөт болон болон зорилтот МУТС болон Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх чиглэлээр газар дээрх хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. 2020 онд нийт 3 удаа МУТС эрсдэлийн үнэлгээг мэдээлэх үүрэгтэй этгээдүүдээс авч бөглүүлэх ажлыг зайнаас буюу цахим хэлбэрээр хэрэгжүүлж, мэдээлэх үүрэгтэй этгээдийн тайланг хянаж эрсдэлийн профайлыг шинэчилж, газар дээрх хяналт шалгалтын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлж ажиллав.
		11.1.4	Эрдэм шинжилгээ, судалгаа /тоогоор/	8	27			СЗХ нь 2020 онд газар хэлтсүүдийн хүрээнд нийт 27 судалгааг хийж гүйцэтгэсэн байна. 1. Даатгалын зах зээлийг хөгжүүлсэн олон улсын туршлага 2. Орон сууцны санхүүжилтийн тогтолцоо: Олон улсын туршлага 3. Барьцаалан зээлдүүлэх газар буюу ломбардын үйл ажиллагаа 4. Санхүүгийн зах зээлийн хяналт, зохицуулалтын тогтолцоо 5. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын эрхэүйн зохицуулалт олон улсад 6. Хүртээмжийн индикаторын судалгаа 7. Үнэт цаасны компаниудад эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг нэвтрүүлэх нь 8. Ковид-19 цар тахлын нөлөөллийн эсрэг бодлогын хариу үйлдэл 9. Системийн эрсдэлийг эрт дохиологч аргачлалаар үнэлэх нь 10. Зээлийн эрсдэлийг бууруулахад зээлийн батлан даалтын сангийн тогтолцоог боловсронгуй болгох нь зэрэг.
		11.1.5	Хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулан, хэрэгжүүлж ажиллах	Төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх	Төлөвлөгдсөн хугацаанд хийгдсэн.			"Монгол Улсын санхүүгийн хүртээмжийг сайжруулах хөтөлбөр"-ийг 2020 оны 3 дугаар улирлын Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн зөөлжит хурлаар танилцуулан Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайд, Хадгаламжийн даатгалын корпорацын гүйцэтгэх захирлын 2021 оны А-62/63/31/А\26 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан.\

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
		11.1.6	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Монгол Улсын тогтолцооны үнэлгээг сайжруулах чиглэлээр цогц арга хэмжээ хэрэгжүүлэх	Төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх	Төлөвлөгдсөн хугацаанд хийгдсэн.			2020 онд Санхүүгийн Зохицуулах Хорооны ҮХХЗҮЭЗГ-ын чиглэлээр:Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэхтэй холбоотой иргэд, олон нийтийг соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, анхан шатны мэдээлэл өгөх гарын авлагыг тусгай зөвшөөрөл авсан 90 иргэнд хүргүүлсэн. Тайлант хугацаанд нийт 55 мэдээлэх үүрэгтэй этгээдэд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор газар дээрх хяналт, шалгалт хийсэн. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын дотоод хэрэгцээнд зориулж "Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөрийн загвар"-ыг боловсруулсан. Мөн 2020 оны эхний хагас жилийн байдлаар тусгай зөвшөөрөлтэй 80 ҮХЭХЗ байгууллага, 8 ҮМҮЧЭТХЭА хуулийн этгээд, жилийн эцсийн байдлаар 96 ҮХЭХЗ байгууллага, 30 ҮМҮЧЭТХЭА хуулийн этгээдийн МУТС-ийн эрсдэлийн үнэлгээг ОУВС-ийн аргачлалаар үнэлсэн. Иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд 10 удаагийн 536 оролцогчдод 25 цагийн сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан. Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын МУТС эрсдэлийн үнэлгээг 2020 оны эхний хагас жилийн байдлаар тусгай зөвшөөрөлтэй 80 ҮХЭХЗ байгууллага, 8 ҮМҮЧЭТХЭА хуулийн этгээд, жилийн эцсийн байдлаар 96 ҮХЭХЗ байгууллага, 30 ҮМҮЧЭТХЭА хуулийн этгээдийн МУТС-ийн эрсдэлийн үнэлгээг ОУВС-ийн аргачлалаар үнэлсэн. Хяналт шалгалт зохицуулалтын чиглэлээр: Олон улсад нийтээр мөрдөгддөг стандарт буюу Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас гаргасан аргачлал, Техникийн 40 Зөвлөмж, үр дүнтэй байдлын шууд хэрэгжилтийг 11 үзүүлэлтийг хэрэгжүүлэх, нэвтрүүлэх цогц ажлыг авч хэрэгжүүлсэн. ФАТФ-ын техникийн 40 зөвлөмжөөс Хороонд хамааралтай бөгөөд үнэлгээг ахиулах шаардлагатай зөвлөмжүүд буюу Зөвлөмж 14 /Мөнгө болон үнэт зүйлсийн шилжүүлэг/, Зөвлөмж 28 /СББМҮҮ-ийн хяналт шалгалт/-ийн үнэлгээг дээшлүүлэх, ФАТФ-ын стандартыг хэрэгжүүлэх чиглэлээр ажиллаж 2020 оны 8 дугаар сард хэвлэгдэн гарсан Гуравдугаар дахин үнэлгээний тайланд Зөвлөмж 14-ийг 2 шатаар ахиулж “бүрэн биелүүлсэн”, Зөвлөмж 28-ийн 1 шатаар ахиулж “дийлэнхийг нь биелүүлсэн” болгосныг зарласан.
		11.1.7	Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр	6	6			Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн 2019-2020 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгагдсан 64 арга хэмжээний гүйцэтгэлийг 97.7 хувьтай биелүүлсэн. УИХ-ын 32 дугаарын тогтоолын 2.5 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг эрчимжүүлэх төлөвлөгөөг СЗХ ны даргын 2020 оны 181 дүгээр тушаалаар батлан сар бүр биелэлтийг хянаж ажилласнаар 96 хувьтай биелүүлсэн.
12	ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА					3,492.9	2,940.2	
	12.1	Төрийн албаны ерөнхий удирдлага, зохицуулалт				3,492.9	2,940.2	
		12.1.1	Төрийн албаны төв байгууллагын чадавх дээшилсэн байна.	Хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх	Төрийн байгууллагуудад мэргэшүүлэх болон арга зүйн сургалтууд зохион байгуулах, зөвлөмж, зөвлөгөө өгөх ажлыг амжилттай хэрэгжүүлэв.			Бүрэн, үр дүнтэй хэрэгжсэн. Төрийн албаны зөвлөлөөс яам, агентлаг, аймаг, нийслэл, сум дүүргийн нийт 525 төрийн байгууллагад хийсэн арга зүйн сургалтуудад давхардсан тоогоор 2,108 албан хаагч хамрагдлаа. Монгол Улсын Их Хурал, Төрийн албаны зөвлөл, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр хамтран “Иттгэл даах төрийн албаны төлөө” уриатай төрийн байгууллагуудын Ёс зүйн зөвлөлийн нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулж, төрийн болон нийслэлийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын 525 албан хаагчийг танхимаар, 330 сум, 21 аймгийн төрийн байгууллагын 4,000 гаруй албан хаагчийг цахимаар оролцууллаа. Төрийн албаны тухай хууль тогтоомжийг нэг мөр ойлгож, зөв хэрэгжүүлэх асуудлаар Төрийн албаны зөвлөлөөс 1 албан даалгавар, 7 зөвлөмж боловсруулан гаргаж, нийт төрийн байгууллагуудад хүргүүлэв.
		12.1.2	Ерөнхий болон тусгай шалгалт зохион байгуулсан байна.	Ерөнхий шалгалт 2, тусгай шалгалт 50	Төрийн албаны ерөнхий шалгалтын бүртгэл, шалгалт, үнэлж, дүгнэх бүх процессыг цахимжуулж, улсын хэмжээнд төрийн жинхэнэ албаны 1581 сул орон тоо, мөн төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн 228 сонгон шалгаруулалтыг тус тус зохион байгуулсан.			Бүрэн, үр дүнтэй хэрэгжсэн. 1.Төрийн албаны ерөнхий шалгалтын программд нэмэлт хөгжүүлэлт хийж, Төрийн албаны ерөнхий шалгалтыг 2020 оны 11 дүгээр сард 6 өдрийн туршид улсын хэмжээнд цахимаар амжилттай зохион байгууллаа. Ерөнхий шалгалтад нийт 16218 иргэн бүртгүүлснээс 75.7 хувь буюу 12286 иргэн шалгалтад орж, тэдгээрийн 31.1 хувь буюу 3823 хүн тэнцэж төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэгдсэн болно. 2.Тусгай шалгалтын программыг 2020 онд шинээр хөгжүүлж нэвтрүүлсэн. Дэлхий нийтийг хамран тархаж байгаа Ковид-19 цар тахлын үед Улсын онцгой комиссын шийдвэр, ЗГХЭГ-ын саналыг үндэслэн төрийн албаны тусгай шалгалтуудыг гамшгаас хамгаалах өндержүүлсэн бэлэн байдлын үеийн дэглэмийг баримтлан зохион байгуулж ажиллалаа. 2020 онд төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын 450, гүйцэтгэх албан тушаалын 1581 сул орны тооны сонгон шалгаруулалтыг захиалгын дагуу зохион байгуулж, удирдах албан тушаалын 350 сул орон тоо буюу 77.8 хувь, гүйцэтгэх албан тушаалын 578 сул орон тоо буюу 36.5 хувийг хуулийн дагуу нөхлөө. Мөн төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн албан тушаалын 287 сул орон тоог мэдээлж, үүнээс 228 албан тушаалын сонгон шалгаруулалтыг зохион байгуулахад давхардсан тоогоор 313 иргэн хамрагдсан. Сонгон шалгаруулалтад 138 иргэн буюу 44.1 хувь нь тэнцэж, зарлагдсан орон тооны нөхөгдсөн хувь нь 60.5 хувь болж нэмэгдлээ.
		12.1.2.1	Сорил, бодлого, даалгавар, ярилцлагын асуултын санг Төрийн албаны тухай хуульд заасан агуулгын дагуу бүрдүүлсэн байна.	2000 сорил, 300 бодлого, 300 даалгавар, 300 асуултын сан	шалгалтын агуулгыг шинэчлэн нийт 4213 сорилыг боловсруулж, магадлан шалгав.			Бүрэн, үр дүнтэй хэрэгжсэн. Төрийн албаны шалгалтын дүн шинжилгээ хийх чадвар шалгах 452, мэдээллийн технологийн ур чадвар шалгах 200, Монгол Улсын түүх, соёл, нийгэм эдийн засгийн шалгалтын 700, даалгавар, монгол хэлний ярианы болон бичгийн чадвар шалгах 732, удирдан зохион байгуулах ур чадварын 70, хууль эрх зүйн мэдлэг шалгах 2059 сорилыг тус тус боловсруулах, магадлан шалгах ажлыг зохион байгуулж төрийн албаны шалгалтын агуулгын шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлэв.
		12.1.2.2	Шалгалтын комиссын бүрэлдэхүүнд орсон албан хаагчдад сургалт зохион байгуулсан байна.	Төрийн захиргааны төв /13 яам/ байгууллагад шалган зааварлах, хяналт үнэлгээ хийнэ.	Төрийн захиргааны төв байгууллагад шалган зааварлах, хяналт үнэлгээ хийв.			Бүрэн, үр дүнтэй хэрэгжсэн. Төрийн албаны ерөнхий шалгалтыг зохион байгуулах Төв комиссыг ТАЗ-ийн даргын тушаалаар байгуулсан бөгөөд энэхүү төв комисс аймаг, нийслэлийн 22 салбар комиссын гишүүдийг байнгын мэргэшил, арга зүйн болон зохион байгуулалтын удирдлагаар хангаж, 2 удаа цахим хурал, сургалтыг хийж ажилласнаар ерөнхий шалгалтыг 2020 оны 11 дүгээр сард амжилттай зохион байгуулсан. Яамд, агентлаг, аймаг, нийслэл дэх Төрийн албаны 49 салбар зөвлөл, шалгалтын комиссыг мэргэшил, арга зүйн удирдлага, шалгалтын программ хангамжаар хангаж төрийн албаны тусгай болон ерөнхий шалгалтыг амжилттай зохион байгуулж ажиллав.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
		12.1.3	Төрийн албаны тухай хуульд заасны дагуу бүх шатны төрийн байгууллагад хяналт шалгалт хийсэн байна.	78	100 гаруй байгууллага	3,492.9	2,940.2	Төрийн албаны зөвлөлөөс ямдын Төрийн захиргааны удирдлагын газрын дарга нараар ахлуулсан ажлын хэсгүүдээр нийслэлийн төрийн захиргааны 18 байгууллагад хийсэн хяналт шалгалт хийлгэж, нэгдсэн тайланг Төрийн албаны зөвлөлийн хурлаар хэлэлцэн дүгнэсэн. Төрийн албаны зөвлөлд иргэнээс ирүүлсэн гомдлын дагуу Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн Ажлын албаны бүтэц, зохион байгуулалт, 2019-2020 оны хүний нөөцийн томилгоо, албан хаагчдад цалин олгосон баримт, төрийн жинхэнэ албан хаагчийн хувийн хэргийн бүрдүүлэлтэд тус тус үзлэг шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, давтан гаргахгүй байх талаар 7 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн. Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын үйл ажиллагаанд төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж, 45 албан хаагчийн томилгоог зөвтгүүлэх арга хэмжээ авав. Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хийсэн хяналт шалгалтын тайланд тусгасан Цаг уур, орчны шинжилгээний газрын нийт 22 удирдах албан хаагчийн томилгоог төрийн албан хаагчийн хувийн хэрэгтэй тулган дахин нягтлан шалгасан. Төрийн албаны зөвлөлийн дарга, гишүүдээр ахлуулсан ажлын хэсгүүд НҮБ-Хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй төслийн санхүүгийн дэмжлэгээр 11 аймаг, зарим сумдад ажиллаж, төрийн албаны хууль тогтоомжийн хэрэгжилттэй танилцаж, арга зүйн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэв.
		12.1.3.1	Төрийн захиргааны албан тушаалын тодорхойлолт тухайн албан тушаалын чиг үүргийг хэрэгжүүлэхүйц байдлаар нэгдсэн журмаар Төрийн албаны зөвлөлийн хяналт доор батлагдаж, төрийн албан тушаалыг хаших адил тэгш боломжоор хангагдсан байна.	Албан тушаалын тодорхойлолт батлагдсан байна.	Албан тушаалын тодорхойлолт батлагдсан.			Бүрэн, үр дүнтэй хэрэгжсэн. Төрийн жинхэнэ албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг хянан баталгаажуулах ажлыг улсын хэмжээнд амжилттай зохион байгуулан хэрэгжүүлж, 2020 оны эцсийн байдлаар давхардсан тоогоор нийт төрийн захиргааны бүх албан хаагчид бүюу 21692 албан хаагчид хамаарах төрийн захиргааны албан тушаалын шинэ тодорхойлолтыг хянан баталгаажуулав. Мөн түүнчлэн боловсрол, соёл урлаг, шинжлэх ухаан, эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний байгуулллагын төсвийн шууд захирагчийн 3000 шахам албан тушаалын тодорхойлолтыг хянан үзэж, санал өгөв. Төрийн албаны тухай хуулийн 23.3-т заасан чиг үүргийн хүрээнд төрийн захиргааны төв байгуулллагын 754, Засгийн газрын агентлагийн 1355, УИХ-д ажлаа тайлагнадаг 414 байгуллага, нутгийн захиргааны 73, бусад төрийн байгуллагын 916, нийт 3512 албан тушаалын тодорхойлолтыг ТАЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлж, батлах зөвшөөрөл олгов.
		12.1.3.2	Төрийн албаны тухай хуульд заасны дагуу бүх шатны төрийн байгууллага, албан хаагчдад зориулсан арга зүйн гарын авлага бэлтгэсэн байна.	5000	7991			Бүрэн, үр дүнтэй хэрэгжсэн. Төрийн албаны тухай хууль тогтоомжийг сурталчлан таниулах, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн орчин үеийн төрийн албаны менежмент, шинэтгэлийн онолын номуудыг орчуулан төрийн албан хаагчдын шинэ ойлголт өгөх, төрийн албаны шинэтгэлийн үзэл санаа, бодлого, үйл ажиллагааны мөн чанарыг тайлбарлан таниулсан гарын авлага эзэргийг Төрийн албаны зөвлөлөөс эрхлэн гаргаж, нийтийн хүртээл болгов. Тухайлбал, "Нийтийн салбарын стратеги удирдлага", "21 дүгээр зууны менежер", "Ковид-19"-ийн дараах төрийн алба" зэрэг номыг орчуулан гаргасны зэрэгцээ "Төрийн албаны шинэтгэл", "Төрийн албаны хууль тогтоомжийн эмхэтгэл", "Төрийн албаны хууль тогтоомжийн гарын авлага", "COVID 19- төрийн байгуллагуудын үйл ажиллагааны хэвийн, тасралтгүй байдлыг хангах нь", "Ерөнхий шалгалтын сорил-2020" гарын авлага гаргаж, цаасан болон цахим хэлбэрээр нийтийн хүртээл болгосон.
		12.1.4	Иргэд, төрийн албан хаагчдад мэргэшил, арга зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх байртай болно.	Зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх байрыг бий болгосон байна.	төрийн албаны сонгон шалгаруулалт, сургалт, зөвлөгөөн, арга зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг орчин үеийн түвшинд зохион байгуулах техник, технологийн боломж, ажлын шинэ орчин нөхцөлийг иж бүрнээр бүрдүүлэв			Бүрэн, үр дүнтэй хэрэгжсэн.Төрийн албаны зөвлөлийн "Олон үйлдэлт сургалтын танхим"-ын шинэчлэлт, их засварын ажлыг түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр тендер зарлан зохион байгуулж амжилттай хэрэгжүүлэв. Олон үйлдэлт танхимд шалгалтын болон сургалт, хурлын үйл ажиллагаанд шаардлагатай компьютер, техник хэрэгсэл, ширээ сандлаар бүрэн хангав. Үүний үр дүнд Төрийн албаны зөвлөл нь төрийн албаны шалгалтын болон сургалт, хурал зөвлөгөөний үйл ажиллагааг орчин үеийн түвшинд зохион байгуулах техник, технологийн боломж, ажлын шинэ орчин, нөхцөлийг иж бүрнээр бүрдүүлэв.
		12.1.4.1	Төрд учруулсан хохирлын мэдээллийн нэгдсэн сантай болно.	Нэгдсэн санг бий болгосон байна.	Төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавих, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах ажиллагаанд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэсэн			Бүрэн, үр дүнтэй хэрэгжсэн. Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлд заасан төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг тогтоосон бол төрд учруулсан хохирлыг үг шийдвэрийг гаргасан бруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллалаа. Хууль бус шийдвэрийн улмаас төрд учруулсан хохирол 72.1 сая төгрөгийг холбогдох иргэдээр төлүүлэхээр зохих шатны шүүхүүдэд нэхэмжлэл гарган ажиллалаа. Мөн төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавих, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах ажиллагаанд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх зорилгоор Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, Үндэсний аудитын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Шүүхийн ерөнхий зөвлөл зэрэг байгуулллагуудын холбогдох албан тушаалтнуудтай хэлэлцүүлэг хийж, цаашдын хамтын ажиллагааны чиглэлээ тогтсон нь чухал ач холбогдолтой арга хэмжээ болсон. Эрх бүхий албан тушаалтнуудад хууль эрх зүйн мэдлэг олгох, хууль бус шийдвэр гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор "Төрд хохирол учруулсан албан тушаалтан хохирлоо төлне" гэсэн нэртэй шторк хийлгэж цахим орчинд байршуулсан бөгөөд маш их хандалттай байгаа болно.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
		12.1.4.2	Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилт, зөрчлийн талаарх дүгнэлт, цаашид авах арга хэмжээний санал гаргах судалгааны нэгдсэн арга зүйг боловсруулна.	Судалгааны нэгдсэн арга зүйг боловсруулсан байна.	Төрийн байгууллагуудын Ёс зүйн хорооны тайлан мэдээг нэгтгэж, төрийн албан хаагчдын ёс зүйн зөрчлийн нэгдсэн тоон судалгааг гаргадаг болов. Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтын стандарт хөтөлбөрийг боловсруулж гаргалаа. Мөн ёс зүйн гарын авлагыг шинээр бэлтгэж төрийн байгууллагуудын хүртээл болгов.			Бүрэн, үр дүнтэй хэрэгжсэн. Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг журам болон ёс зүйн сургалтын жишиг хөтөлбөр, гарын авлагыг шинээр санаачлан боловсруулж, сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэн тогтмолжуулав. Ёс зүйн болон сахилгын зөрчил гаргасан, авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн, нийтийн албанд томилогдох эрх хасагдсан иргэдийн мэдээллийн нэгдсэн санг шинээр үүсгэж төрийн албанд ажиллах нөхцөл боломжийг хаах арга хэмжээ авч ажилласан нь төрийн албаны ёс зүй, шударга ёсны соёлыг тогтооход томоохон түлхэц, дэмжлэг боллоо. Ёс зүйн зөвлөлүүдийн 2020 оны тайланг нэгтгэн үзвэл 1422 төрийн албан хаагч ёс зүйн зөрчил гаргасан байх бөгөөд үүнээс 809 нь төрийн тусгай, 353 нь төрийн захиргааны, 260 нь төрийн үйлчилгээний албан хаагчид байна. Ёс зүйн зөрчлийн тоо 2019 онтой харьцуулахад 4.8 хувиар буурчээ. Ёс зүйн зөрчлийг агуулгаар нь авч үзвэл, ажил үүргээ хангалтгүй биелүүлсэн болон ажлын хариуцлага алдсан зөрчил 196, албан үүргээ гүйцэтгэх явцдаа болон ажлын байранд архидан согтуурсан зөрчил 37, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй зөрчил 48, ажлын цаг ашиглалтын зөрчил 46, харилцаа, хандлагын зөрчил 163, хууль, дүрэм, журам зөрчсөн зөрчил 108, бусад буюу нууц задруулах, захирах захирагдах ёсыг зөрчих, албаны нэр барих, байгууллагын эд хөрөнгийг хувийн зорилгоор ашигласан зөрөг зөрчил 15 байна. Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, сахилга, хариуцлагыг сайжруулах, ажлын байрны дарамтгүй орчин бүрдүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Төрийн албаны ёс зүй, сахилга, хариуцлагыг сайжруулах тухай” зөвлөмж боловсруулж, Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 22 дугаар хуралдаанаар шийдвэрлүүлж, төрийн байгууллагуудад хүргүүлж, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсанд байршуулсан.
		12.1.4.3	Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэмд заасны дагуу судалгаа, шинжилгээний ажлыг зохион байгуулна.	Мэдээллийн нэгдсэн санг баяжуулсан байна.	Төрийн албатай холбоотой захиалгат судалгааны ажлын бүртгэлийн санг баяжуулав.			Бүрэн, үр дүнтэй хэрэгжсэн. Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрийн хөрөнгөөр гадаад орнуудад 2016 онооос хойш суралцсан болон сурч байгаа төрийн албан хаагчид, тэдгээрийн ажил эрхлэлтийн байдлын талаарх судалгааг анх удаа хийлээ. Гадаадын 30 орны Засгийн газар, олон улсын байгууллагын тэтгэлэгт хөтөлбөр болон байгууллага хоорондын санамж бичиг, буцалтгүй тусламжийн хүрээнд нийт 1195 төрийн албан хаагч тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан байна. Төрийн албаны чадавхыг бэхжүүлэх чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн судалгааг улсын хэмжээнд хийж, гадаад орнуудын Засгийн газар, олон улсын байгууллагын буцалтгүй тусламж, техникийн туслалцаа, хөнгөлөлттэй зээл, улсын төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтэр 40 байгууллагад давхардсан тоогоор 126 төсөл хэрэгжиж байна. Монгол Улсад хүчин төгөлдөр дагаж мөрдөж буй 472 хууль, /2020 оны 10 дугаар сарын 01-ний байдлаар/ Төрийн албаны тухай хууль /шинэчлэсэн найруулга/ хоорондз зөрчил, давхардал байгаа эсэхийг харьцуулах судалгааны томоохон ажлыг хэрэгжүүллээ. Төрийн албатай холбоотой захиалгат судалгааг (2003-2019 он) бүртгэлийн санг үүсгэв. Мөн Удирдлагын академиас 2020 онд хийж ирүүлсэн 14 судалгааны бүтээлүүдийг хүлээн авч бүртгэлийн санг баяжуулав. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлж байгаа “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн хүрээнд хүний нөөцийн аудит хийх чадавхыг бий болгох чиглэлээр Канадын Засгийн газраас хэрэгжүүлж буй Мерит төсөлтэй хамтран ажиллалаа. Хүний нөөцийн өнөөгийн байдал, тогтвор суурьшил, ажиллах хүчний нөөцийн бүрдүүлэлт, төлөвлөлтийн үе шат, сургалт хөгжил, төрийн албан хаагчийн нийгмийн баталгаа, сэтгэл ханамж, ур чадварын зөрүүг тодорхойлох, бодлогын баримт бичгийг судалгааны суурилан боловсруулах, хэрэгжүүлэхэд ашиглах зорилго бүхий суурь судалгааг хийж үр дүнгийн талаар Төрийн албаны зөвлөлтэй хамтарсан хэлэлцүүлэг хийж бусад нэгжүүдэд хэрэгжүүлэх боломжийг судлан шийдвэрлэхээр боллоо.
13	**ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА**					**14,629.9**	**13,621.4**	
	13.1	**Албан ёсны статистикийг хөгжүүлэх**				**6,923.2**	**6,715.7**	
		13.1.1	Албан ёсоор гаргах статистикийн мэдээ, тайлангийн нэр төрөл	290	396	6,214.1	6,009.0	Аймаг, дүүрэг, нийслэлийн статистикийн хэлтэс, газрууд ҮСХ-ноос баталсан мэдээний хамрах хүрээ, маягт, нөхөх зааврын дагуу хүн ам, нийгэм, эдийн засгийн үйл ажиллагааны албан ёсны статистикийн 53 төрлийн мэдээг долоо хоног, сар, улирал, хагас жилийн давтамжаар өрх, аж ахуйн нэгж, байгууллагаас авч, хугацаанд нь ҮСХ-нд ирүүлсэн байна. Менгө, зээл, санхүү, гааль, даатгал, татвар, байгаль орчин, соёл, урлаг, боловсрол, шинжлэх ухаан техник, технологи, хүн амын эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хүнсний аюулгүй байдал, шүүхийн статистикийн мэдээллийг холбогдох яам, төрийн захиргааны нийт 27 байгууллага ҮСХ-нд сар, улирал, жилийн давтамжтай мэдээлсэн байна. ҮСХ ноос 2019 онд зохион байгуулсан статистикийн улсын хэмжээний 2 тооллого, 6 түүвэр судалгаанд өрх, аж ахуйн нэгж, байгууллагыг бүрэн хамруулж, төлөөрүүлэн авсан мэдээллийг бусад мэдээллийн эх үүсвэртэй тулган шалгаж, боловсруулан статистикийн 1212.mn мэдээллийн санг мэдээллийн давтамж бүрээр жилийн турш тогтмол шинэчлэн баяжуулж байна. Мөн Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Олон улсын валютын санд 1-12 сарын нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийг тусгайлан бэлтгэж, тогтсон загвар хүснэгтийн дагуу гаргаж хүргүүлсэн. Мөн үндэсний тооцоо, бүтээмжийн үзүүлэлтүүдийн мэдээллийг бэлтгэж, Олон улсын валютын сан, Дэлхийн банк, НҮБ-ын Статистикийн хэлтэс, Азийн хөгжлийн банк, Азийн бүтээмжийн байгууллагад тус тус хүргүүлсэн. Олон улсын валютын сангийн веб сайт, үндэсний нэгдсэн мэдээллийн цахим санд оруулах мэдээллийг бэлтгэж, Статистикийн мэдээлэл, мета мэдээллийг солилцох стандартад хөрвүүлэн, хүргүүлсэн. Сар, улирал, жилийн мэдээний маягт, ӨНЭЗС-ны маягт, дэвтэр, жилийн эцсийн мал тооллого, малын түүвэр судалгааны маягт зэрэг 1840.0 мянгыг, Нийгэм, эдийн засгийн байдлын сарын танилцуулга, ҮСХ, газар, нэгжийн тайлан, Гаалийн мэдээ, гарын авлага, сурталтын материал, илтгэл, урилга, хөтөлбөр, бланк зэрэг 1078.0 мянгыг нийт 5.3 сая хэвлэлийн даралт хуудас материал хэвлэсэн байна.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
		13.1.2	Албан ёсны статистикийн мэдээ, тайлангийн тоо /мянгаар/	112.1	153.1	449.9	438.6	НҮБ-ын Статистикийн комиссоос их өгөгдлийг албан ёсны статистикт ашиглах шинжээчдийн бүлэг ажиллаж, их өгөгдлийг ашиглах аргазүй, аргачлал, хөтөлбөрийг туршин сайжруулсан. ҮСХ-ноос мэдээллийн технологийг ашиглан төрийн захирагааны байгууллагуудын мэдээллийн сангийн уялдаа холбоог сайжруулж, зөрүүг арилгах ажлуудыг зохион байгуулсны үр дүнд статистикийн мэдээлэл цуглуулах шат дамжлага цөөрч, давхардал арилж, боловсруулах хугацаа багасаж, бодит байдал эрс сайжирсан. "Статистикийн бизнес регистрийн цогц программ хангамж"-ийг хөгжүүлж, олон улсын стандарт бүхий статистик нэгжийн санг байгуулах зорилгоор "Статистикийн бизнес регистрийг байгуулах аргачлал"-ыг баталж,үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг нэгж, түүний бүлгийг бизнес регистрийн санд байгуулсан.
		13.1.3	Албан ёсны статистикийн мэдээ, тайлангийн тархаалт	47	48	247.9	256.8	Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлын 2019 оны 12 сар, 2020 оны 1-5 сарын танилцуулгад орсон 26 бүлгийн 1590 хүснэгтэн (давхардсан тоогоор) мэдээлэлд орсон 1749 үзүүлэлт, 2019 оны статистикийн эмхэтгэлд орох 24 бүлгийн 593 хүснэгтэн мэдээллийн 652 үзүүлэлтийг Статистикийн мэдээллийн нэгдсэн сан (www.1212.mn)–д байршуулсан мэдээлэлтэй тулган хянаж, гарсан зөрүүг арилгуулав. Сарын мэдээг www.1212.mn–д байршуулсан эсэхэд хяналт тавьж ажилласан. Албан ёсны статистикийн 2020 оны 6-11 сарын бюллетеньд орсон 22 бүлгийн 1590 хүснэгтэн (давхардсан тоогоор) мэдээлэлд орсон 1286 үзүүлэлтүүдийг Статистикийн мэдээллийн нэгдсэн сан (www.1212.mn)–д байршуулсан мэдээлэлтэй тулгаж, зөрүүтэй мэдээллийг тухай бүрд нь засуулав. : Статистикийн мэдээллийн нэгдсэн сан 1212.mn-д байршуулсан 593 хүснэгтэн мэдээллийн мета мэдээллийг хянасан.
		13.1.4	Шинээр болон шинэчлэн сайжруулсан аргачлал, ангилал, статистикийн мэдээллийн санд суурилж эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтээр хийх судалгааны тоо	20	45	11.3	11.3	Арга зүйн байнгын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөө боловсруулж, ҮСХ-ны дэд даргаар батлуулан, хурлыг 17 удаа (танхимаар 4, цахимаар 13 удаа) зохион байгуулж, холбогдох шийдвэрийг гаргуулан ажиллаа. Хурлаар олон улсад нийтлэг мөрдөгдөж буй нийгэм, эдийн засаг, байгаль орчны статистикийн арга зүйг судалж, үндэсний онцлогт тохируулсан арга зүйг боловсруулах ажлын хүрээнд 11 аргачлал, арга зүй, 1 ангилал, судалгаа, мэдээний 24 маягт, нөхөх заавар, 4 судалгааны үзэл баримтлал, 3 гарын авлага, 1 зөвлөмж, 1 тооцооны тухай асуудал хэлэлцсэн байна.
	13.2	**Улсын хэмжээний тооллого**						
		13.2.1	Статистикийн хуулийн дагуу хийсэн байвал зохих улсын хэмжээний тооллогын тоо	1				
	13	**Улсын хэмжээний судалгаа**				**7,706.7**	**6,905.7**	
		13.2.1	Статистикийн хуулийн дагуу хийсэн байвал зохих улсын хэмжээний судалгааны тоо	16	16	7,706.7	6,905.7	Хүн ам орон сууцны ээлжит 2020 оны тооллогыг Монгол Улсын нийт өрхийн 10 хувийг энгийн санамсаргүй түүврийн аргаар сонгож, 2020 оны 1-р сарын 9-ний өдрийн 9:00 цагаас 15-ны өдрийн 22:00 цагийн хооронд сонгогдсон айл, өрх бүрээр бэлтгэгдсэн тоологч очиж, үлдсэн өрх, хүн амын мэдээллийг засаг захиргааны анхан шатны нэгжид хөтлөгддөг "Хүн ам, өрхийн мэдээллийн сан" болон төрийн байгууллагуудын мэдээллийн сангуудыг уялдуулан тоолов. Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын үр дүнгээр Монгол Улсын хүн ам 3 296 866, өрхийн тоо 897 427 болсныг тоолж гаргалаа. Байшин, орон сууцны тооллогын үр дүнгээр газрын зураглаг суурилсан үр дүнгийн мэдээллийн салбар/dashboard/ 21 аймаг, 9 дүүрэг тус бүрээр боловсруулсан. Түүвэр судалгаа: ҮСХ-ноос тогтмол зохион байгуулан явуулдаг "Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа"-ны мэдээллийг сар бүр 21 аймаг, 9 дүүргийн жилдээ нийт 16488 өрхөөс цуглуулан авч, статистик үзүүлэлтүүдийг улирал, жилээр тооцон гаргаж нийтэд тархаасан. Хэрэглэгчийн төлөв байдлыг тодорхойлох судалгааны 2019 оны тайлан, Ардчилсан засаглал судалгааны 2019 оны тайлан, Ажиллах хүчний судалгааны жилийн тайлан, Цаг ашиглалтын 2019 оны судалгааны мэдээлэл зэрэг тайлан мэдээллийг тус тус бичиж, нийтийн хүртээл болгон ажиллалаа. Хүн ам, өрхийн мэдээллийн сан: Хүн ам, орон сууцны 2020 оны улсын ээлжит тооллогын хүрээнд хүн ам, өрхийн мэдээллийн санг төрийн байгууллагуудын 50 төрлийн сан (7 яам, 9 агентлаг, 28 төрийн захиргааны мэдээлэл)-тай уялдуулах ажил хийгдсэн. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй хамаарах ОУ болон үндэсний түвшин дэх бодлого, хууль эрх зүйн баримт бичгийн судалгаа хийв. Тогтвортой хөгжлийн хөдөлмөрийн статистикийн шалгуур үзүүлэлтийн 6-н үзүүлэлтүүдийн тоо утгыг 2019 оны дүнгээр ул, бүс, аймаг, дүүргийн түвшинд бүсад холбогдох задаргаа тоон мэдээлэл, Эрүүл мэндийн салбарын ТХЗ-ын 25 үзүүлэлтийг 2019 оны байдлаар улсын түвшинд, 17 үзүүлэлтийг аймаг, нийслэлээр тооцон ШСГ-т хүргүүлсэн. Хүн амын тооллого, төрөлт, нас баралтын бүртгэл, гар утасны хэрэглээ, өрхийн ундны усны эх үүсвэр, бие засах газар, цахилгаан, хоол ундаа болгодог түлштэй холбоотой тогтвортой хөгжлийн 6 үзүүлэлтийг тооцож, гаргасан.
14	**СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА**					**38,109.9**	**37,270.5**	
	14.1	**Бүх шатны сонгууль зохион байгуулах**				**38,109.9**	**37,270.5**	
		14.1.1	Сонгуулийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой боловсруулах журам, заавар, маягт	40	59.00	27,721.2	27,686.3	Сонгуулийн Ерөнхий Хороо 2020 онд нийт 20 удаагийн хуралдаан зохион байгуулж, УИХ болон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын ээлжит сонгуулийг зохион байгуулах ажиллагаанд мөрдөж ажиллах журам, заавар-13, маягт, загвар-46 баталж сонгуулийн байгууллага, нэр дэвшигч, нам, эвсэл, холбогдох бүсад байгууллагад мөрдүүлж ажиллалаа.
		14.1.2	Сонгуулийн хууль тогтоомжийг сурталчлах сургалт, семинарын тоо	44	121	1,816.6	1,686.5	Байнгын бус ажиллагаатай сонгуулийн байгууллагын ажилтанд гэрчилгээ олгох сургалт 21 аймаг, 9 дүүрэгт цахимаар, Аймаг, нийслэл, сум, дүүрэг, хэсгийн хорооны гишүүн, МТБ-ийн гишүүн, даамлын "Сонгуулийн зохион байгуулалт" сургалтыг 121 удаа зохион байгуулж, нийт 42013 хүнийг хамруулсан байна.
		14.1.3	Сонгогчдын боловсролыг дээшлүүлэх /өмнөх оны суурь үзүүлэлтээс өсөх хувь/	5	0.051	928.1	761.6	Сонгогчдын боловсролыг дээшлүүлэх, сонгогчийн ирцийг нэмэгдүүлэх зорилгоор хууль тогтоомж сурталчилсан, саналаа хэрхэн тэмдэглэх, саналаа яаж өгөхийг тайлбарласан "Сонгогч Танаа" сурталчилгааны нугалбар /өрхийн тоогоор/, сонгуульд идэвхтэй оролцохыг уриалсан зураглаг хуудас, санал хураалтад оролцохыг уриалсан телемаркетинг үйлчилгээ, радио телевизийн реклам, сонгуулийн хууль, тогтоомж, журам, зааврыг сурталчилсан, санал авах өдрийн тухай ярилцлага, мэдээ, мэдээллийг цахим орчинд, и-мэйл сурталчилгаа, сонин, хэвлэл, радио, телевиз, гудамжны мэдээллийн самбар, лэд дэлгэцээр өргөн хүрээгээр сурталчилгаа хийсэн.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
		14.1.4	Сонгуулийн хороодын үйл ажиллагаанд хийх хяналт, шалгалтын тоо	21	21	294.5	283.2	Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны сонгуулийн зардлын тайланд орон нутгийн аудитын байгууллагаар аудит хийлгэсэн. Мөн УИХ-ын сонгуулийн зардалд Үндэсний аудитын газраар гүйцэтгэлийн аудит хийлгэж дүгнэлт гаргуулсан.
		14.1.5	Сонгуульд оролцсон нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн зардлын тайланг хянах	20	0	-	-	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуульд сонгуульд оролцсон нам, эвсэл болон нэр дэвшигчийн сонгуулийн зардлын тайланд төрийн болон орон нутгийн аудитын байгууллага аудит хийхээр хуульд өөрчлөлт орсон.
		14.1.6	Сонгуулийн автоматжуулсан системийг бүрэн ашиглах, хэвийн үйл ажиллагаа, санал хураах тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах /төхөөрөмжийн тоо/	5000	5500	6,723.0	6,315.8	2750 ш батарей, 2750 ш санал тоолох төхөөрөмжийг шалгах, цэнэглэх ажлыг хуваарийн дагуу зохион байгуулж бэлэн байдлыг хангаж ажилласан. УИХ-ын сонгуульд 2070 хэсэг, ОНС-д 2148 хэсэгт бүх санал тоолох төхөөрөмжийг ашигласан байна.
		14.1.7	Программ хангамжийн аюулгүй ажиллагааг хангах	бүрэн хамгаалагдсан байх	бүрэн хамгаалагдсан	-	-	Бүрэн хамгаалагдсан
		14.1.8	Мэдээллийн бааз үүсгэх	21	22	626.5	537.2	Байнгын бус үйл ажиллагаатай сонгуулийн байгуллагын ажилтны мэдээллийн сан /20000 гаруй хүн/, УИХ-ын болон орон нутгийн сонгуулийн саналын хуудасны зурган файл болон хүлээж авсан сонгуулийн дүнг мэдээллийн сан үүсгэн, хадгалсан. УИХ-ын сонгуулийн дүнг аймаг, дүүрэг, тойргоор нь шууд дамжуулсан.
15	**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД**					**160,002.3**	**150,111.6**	
	15.1	**Ангилагдаагүй бусад хөтөлбөр**				**98,975.2**	**98,027.8**	
		15.1.1	Цөмийн энергийн салбарт баримтлах бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх /хувиар/	100	90	98,975.2	98,027.8	ЦЭК-ын 3 удаагийн хуралдааныг зохион байгуулж, 11 асуудал хэлэлцүүлж, 3 тогтоол гарсан. Мөн ЦЭК-ын дэргэдэх Эрдэмтдийн зөвлөлийн 2 удаагийн хуралдаанаар 4, Цацрагийн аюулгүйн зөвлөлийн хуралдаанаар 4 асуудлыг тус тус хэлэлцүүлсэн. - "Цацрагийн үүсгүүртэй холбоотой үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход санал авах, санал өгөх хамтарсан журам"-ыг МХЕГ-ын дарга, Тагнуулын ерөнхий газрын дарга, ЦЭК-ын Ажлын албаны даргын 2020 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/62-А/63-А/17 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан. - "Засгийн газрын 2020.12.23-ны өдрийн хуралдаанаар "Цацрагийн ослоос хамгаалах улсын төлөвлөгөө", "Цөмийн материалыг бүртгэх, хянах журам"-ыг хэлэлцүүлж, Засгийн газрын 2020 оны 228, 229 дүгээр тогтоолоор тус тус батлуулсан. - ЗГХЭГ-ын даргын 2020 оны 22 дугаар тушаалаар Монгол Улсын Үндэсний хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан. - ОУАЭА-ийн ТХА-ны хөтөлбөрийн хүрээнд үндэсний 5 төсөл хэрэгжүүлж, бүсийн 21 төсөлд 11, бүс хоорондын 7 төсөлд 3 байгууллагыг хамруулж, нийт 21 арга сургалт, хэмжээнд манай улсаас дотоодын 15 байгууллагын 49 албан хаагч оролцож мэдлэг, чадвараа дээшлүүлсэн. - АНДБХАХ-ийн 2020-2021 оны төслийн циклд дотоодын 10 байгууллага, нийт 19 төсөлд мэдээлэл, туршлага солилцох чиглэлээр оролцож, 14 сургалт, семинар, арга хэмжээ зохион байгуулагдаж, 10 байгууллагын 23 албан хаагч оролцож, мэдлэг, чадвараа дээшлүүлсэн. - АЦХАФ-ын 5 төслийн хурал цахим хэлбэрээр зохион байгуулагдаж, 8 байгууллагын 8 албан хаагч оролцож, мэдээлэл солилцсон. - Гэрээ, конвенцод нэгдэн орох, батлах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх тухай ЦЭК-ын Ажлын албаны 2020.03.19-ний өдрийн 1/156 тоот албан бичгийг ЗГХЭГ-т хүргүүлсэн. Тус конвенцыг 2020 оны УИХ-ын ээлжит сонгуулийн дараа хэлэлцүүлэхээр хойшлуулсан. - Цөмийн хохирлын нэмэлт нөхөн төлбөрийн тухай конвенц, Цөмийн хохирлын үүрэг хариуцлагын тухай Венын конвенцын нэмэлт протоколын орчуулгыг ГХЯ-аар хянуулахаар хүргүүлсэн. Конвенцын танилцуулга, үзэл баримтлалын төсөл боловсруулсан. - Цөмийн зэвсгийг үл дэлгэрүүлэх тухай Гэрээтэй холбогдуулан баталгаа хэрэглэх тухай Монгол Улс, ОУАЭА хооронд байгуулсан Хэлэлцээрт оруулсан Нэмэлт протоколын мэдүүлгүүдийг гэрээнд заасан хугацаанд ОУАЭА-т хүргүүлж, нэмэлт протоколоор хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангасан.
		15.1.2	Дозиметрийн тохируулга, баталгаажуулалт хийх /тоогоор/	180	243			46 аж ахуйн нэгж, байгууллагын 243 хэмжих хэрэгсэлд шалган баталгаажуулалт хийсэн.
	15.2	**Төрийн өмчийн бодлогыг хэрэгжүүлэх**				**1,254.7**	**1,027.1**	
		15.2.1	Төрийн өмчит хуулийн этгээдийн санхүү, эдийн засаг, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын тоо	32	29	1,254.7	1,027.1	2020 онд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 19 хуулийн этгээдийн үйлдвэрлэл, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийхээр төлөвлөсөн боловч Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын улмаас Монгол Улс бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотой үлдсэн 4 төрийн өмчит хуулийн этгээдэд 2020 онд баримтын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх боломжгүй давагдашгүй нөхцөл байдал үүссэн. 2020 онд нийт 10 төрийн өмчит төсөвт байгууллагад системийн хяналт шалгалт хийхээр төлөвлөж байсан ч Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын эрсдэлийн улмаас орон нутагт байрлах Дорнод, Өвөрхангай, Ховд аймагт байрлах Бүсийн оношилгоо эмчилгээний төв гэсэн 3 төрийн өмчит төсөвт байгууллагад системийн хяналт шалгалтын хэрэгжүүлэх боломжгүй болсон. 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 15 баримтын хяналт шалгалтын тайлан, 7 төрийн өмчит төсөвт байгууллагад системийн хяналт шалгалтын тайланг шийдвэрийн төслийн хамт газрын хуралдаанд танилцуулж, хуралдаанаас гарсан саналыг "Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай" шийдвэрийн төсөлд тусган албажуулж, холбогдох байгууллагад тайлангийн хамт албан бичгээр хүргүүлсэн. Төлөвлөгөөт бус 7 хяналт шалгалтыг тухай бүр хэрэгжүүлж, тайлан боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлж ажилласан.
		15.2.2	Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт /өмч эзэмшлийн гэрээний дүгнэлтийн хувь/	100	100			Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр хяналт тавьж ажилласан ба ковид 19 цар тахлын улмаас өмч эзэмшлийн гэрээг 979 төрийн өмчит хуулийн этгээдтэй онлайнаар дүгнэж, ТӨБЗГ-ын 2020 оны 11 дүгээр сарын 24-ны өдрийн хуралдаанд танилцуулж 597 тоот тогтоол шийдвэр гаргуулж ажилласан.
		15.2.3	Төрийн өмчийн байгууллагын менежментийг сайжруулах, ашигтай ажиллуулах замаар орлогыг төвлөрүүлэх	Орлогыг бүрэн төвлөрүүлсэн байх	99.4%			Ногдол ашиг 170,552.8 сая, түрээсийн орлого 2,472.1 сая, өмч хувьчлалын орлого 445.6 сая, нийт 173,470.5 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн. Улсын төсөвт төвлөрүүлбэл зохих ногдол ашигийг "Эрдэнэс Монгол" ХХК 2,037,813.2 мянган төгрөгөөр,"Улаанбаатар Төмөр зам" ХНН 1,137,200.0 мянган төгрөгөөр,"Хөдөө аж ахуйн бирж" ХХК 543,273.1 мянган төгрөгөөр,"Монгол Кувейтийн байгаль хамгаалах төв" ТӨҮГ 19,216.7 мянган төгрөгөөр тус тус дутуу төвлөрүүлээд байна. Төрийн аудитын байгууллагатай ногдол ашгийн төлөлтийг барагдуулах талаар хамтран ажиллаж байна.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
		15.2.4	Монгол Улсын Засгийн газрын тогтоолын дагуу Төрийн өмчийн эд хөрөнгийн үзлэг тооллогыг 2020 оны 4 дүгээр улиралд зохион явуулах	Тооллогыг төлөвлөсөн хугацаанд зохион явуулах	Монгол Улсын Засгийн газрын тогтоолын дагуу хойшлогдсон			Ковид 19-ын нөхцөл байдлын улмаас Төрийн өмчийн эд хөрөнгийн үзлэг, тооллого хойшлогдсон.
		15.2.5	Өмч хувьчлалын үйл ажиллагааг зохион байгуулж, орлогын төлөвлөгөөг батлагдсан хуваарийн дагуу төвлөрүүлэх	Орлогыг бүрэн төвлөрүүлсэн байх	Орлогыг бүрэн төвлөрүүлсэн.			Өмч хувьчлалын үйл ажиллагааг зохион байгуулж, орлогыг төвлөрүүлсэн.
	15.3	**Жендерийн эрх тэгш байдлыг хангах**				**421.5**	**421.5**	
		15.3.1	Яамд /салбар/-ын жендерийн нэгдсэн бодлого, аймаг, дүүргийн жендерийн дэд хөтөлбөрийн тоо	Яам-9, аймаг-21, нийслэл, дүүрэг-10	Яам-11, аймаг-21, нийслэл, дүүрэг -8	421.5	421.5	Нийт 13 яамнаас 11 яам дэд хөтөлбөрөө боловсруулсан. 21 аймаг бүрэн дэд хөтөлбөрөө боловсруулсан. Нийслэл, нийслэлийн 9 дүүргэс 2 дүүрэг дэд хөтөлбөрөө боловсруулах шатандаа явж байгаа
		15.3.2	Оролцоонд суурилсан жендерийн үнэлгээ хийсэн яам /салбар/, аймаг, дүүрэг	Яам-9, аймаг-21, нийслэл, дүүрэг-10	5 аймаг: Булган, Ховд, Өмнөговь, Дорнод, Баянхонгор			Булган, Ховд, Өмнөговь, Дорнод, Баян хонгор зэрэг аймгуудад оролцоонд суурилсан жендерийн үнэлгээ хийгдэжд байна. Жендерийн дэд хөтөлбөр тухайн салбарт 2 жилээс дээш хэрэгжсэний дараа оролцоонд суурилсан үнэлгээ хийгддэг тул удашралтай байна.
		15.3.3	Жендерийн үндэсний сургагч багшийн тоо	160	194			Жендерийн сургагч багшийг бэлтгэх анхан шатны модулийн сургалтыг 2020 онд цаг үеийн байдлаас шалтгаалан зохион байгуулаагүй бөгөөд дунд шатны буюу сургагч багшийг давтан сургах сургалтыг 78 сургагч багшийг хамруулан чадавхжуулсан.
		15.3.4	Жендерийн сургалтад хамрагдсан удирдах ажилтан, төрийн албан хаагч	удирдах ажилтан 45.0 хувь, төрийн албан хаагч 55.0 хувь	удирдах ажилтан 40 хувь, төрийн албан хаагч 65 хувь			Төрийн албаны удирдах албан тушаалтанд зориулсан цахим модулиар 2020 онд 1159 удирдах албан тушаалтныг хамруулав. Мөн Хорооноос 2020 онд цахим болон танхимын нийт 21 сургалтыг зохион байгуулж өссөн дүнгээр нийт төрийн албан хаагчдын 65 хувийг сургалтад хамруулаад байна.
		15.3.5	Аймаг, нийслэл, дүүргийн жендерийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд орон нутаг дахь төрийн бус байгууллагаас хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тоо	18	18			Аймгийн жендерийн дэд хөтөлбөрийн хэрэгжилтэд орон нутгийн дахь төрийн бус байгууллагаар хяналт шинжилгээ, үнэлгээг Азийн хөгжлийн банктай хамтран "Иргэний нийгмийн ОЖТБ хангах төсөл"-ийн хүрээнд хийсэн.
		15.3.6	Аймаг, нийслэл, дүүрэгт ажиллаж байгаа хохирогчийг хамгаалах нэгжийн тоо	25	нийт 32 хамгаалах байр			Монгол Улсад хохирогчийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа хамгаалах байр-16, нэг цэгийн үйлчилгээний төв-16, нийт 32 хамгаалах байр ажиллаж байна.
		15.3.7	Эрэгтэйчүүдэд тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн тасаг, кабинет	20	УБ хотод 12, орон нутагт 8 нийт 20			Эрэгтэйчүүдэд зориулсан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ тогтмол явуулж буй эмнэлэг Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн-6, хувийн хэвшлийн-6, хөдөө орон нутагт 8, нийт 20 эмнэлэг байна.
	15.4	**Биеийн тамир, спорт**				**59,350.9**	**50,635.2**	
		15.4.1	Нийтийн биеийн тамираар хичээллэгчийн тоо /нийт хүн амд эзлэх хувиар/	47	37.5	59,350.9	50,635.2	Биеийн тамирын 2020 оны статистик судалгааагаар улсын хэмжээнд биеийн тамир, спортын арга хэмжээг давхардсан тоогоор 1,132.0 удаа зохион байгуулж 193,666 хүн, Үнэгүй фитнес төрийн бус байгуллагатай хамтран ажиллах санамж бичгийн дагуу 6,7,8,9,10 сард цэцэрлэгт хүрээлэнд, 11,12 сард цахимаар иргэдийн дунд хөтөлбөрийн дагуу дасгал хөдөлгөөн, эрүүл зөв хооллолтын зөвлөмжүүдийг зохион байгуулж давхардсан тоогоор 1,045,470 иргэн хамрагдсан байна. Нийт улсын хэмжээнд 1,133.0 удаагийн арга хэмжээнд 1,239,136 иргэн хамрагдаж нийт хүн амын 37.5 хувь хамрагдсан байна. Ковид-19 цар тахалтай холбогдуулж төлөвлөсөн арга хэмжээнүүд зохион байгуулагдаагүй.
		15.4.2	Олон улсын болон тив, дэлхийн чанартай тэмцээнээс авах медалийн тоо	150	46			Үндэсний шигшээ багийн тамирчид "Токио 2020" олимп болон параолимпийн наадамд оролцох эрх авах болон эрхийн оноо олгох 104 тэмцээн, 16 гадаадын хамтарсан бэлтгэл сургуулилт, 42 дотоодын бэлтгэл цугларалт хийхээр төлөвлөгдсөнөөс 19 тэмцээн, 52 дотоодын бэлтгэлд оролцож 6 алт, 12 мөнгө, 28 хүрэл медаль, нийт 46 медаль авсан. /Азийн аварга шалгаруулах тэмцээнээс алт 3, мөнгө 5, хүрэл 8, Их дуулга тэмцээнээс алт 2, мөнгө 10, хүрэл 12, Дэлхийн цомоос мөнгө 1, олимпын эрх олгох болон эрхийн оноо цуглуулах олон улсын бусад тэмцээнээс алт 6, мөнгө 6, хүрэл 13/ Биелэлт нь 30 хувьтай байна. Ковид-19 цар тахлын улмаас төлөвлөсөн ихэнх уралдаан тэмцээнд оролцож чадаагүй ба 3-12-р сард оролцохоор төлөвлөсөн тэмцээнүүд бүгд цуцлагдсан.
16	**МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД**					**178,658.5**	**175,817.1**	
	16.1	**Гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаа**				**122,506.2**	**122,583.4**	
		16.1.1	Байгалийн болон хүний хүчин зүйл, техникийн гаралтай гамшгийн төрөл тус бүрээр эрсдэлийн үнэлгээ хийх /гамшгийн тохиолдлын буурах хувиар/	10	10	122,506.2	122,583.4	Нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул дүүрэг Засаг захиргаа нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийж тайланг боловсруулсан. Мөн гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээний үр дүнд суурилсан "Нийслэлийн гамшгийн атлас"-ыг боловсруулсан.Булган, Өвөрхангай, Төв аймаг 2020 оны 07, 08 дугаар сард, Дорнод, Сэлэнгэ, Хэнтий аймгууд Монголын Улаан загалмай нийгэмлэгийн санхүүжилтээр 2020 оны 09 дүгээр сарын 07-10-ны өдрүүдэд зохион байгуулж үнэлгээнээс гарсан үр дүн, тайлан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний зөвлөмжийг Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.НОБГ, Хойд бүсийн төвийн төв-Орхон аймгийн Онцгой байдлын газар хамрагдаж, 466 хүний бүрэлдэхүүнтэй гамшгийн менежментийн багийг байгуулан "Бэлэн бай" сургалтын багцаар анхны тусламжийн сургагч багшаар бэлтгэсэн. Эдгээр сургагч багш нараар дамжуулан 20,642 иргэнд гамшгийн эрсдэлийг бууруулах мэдлэг олгов.
		16.1.2	Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгаас хамгаалах хяналт шалгалт /хүн өдөр/	32780	32780			2020 онд аюулт үзэгдэл ослын тоо 4894, нас барсан хүний тоо 243, хорогдсон мал /мян.төг/ 80.9, учирсан шууд хохирол 31.3 тэрбум төгрөг, аварсан хүний тоо 2234, аварсан эд хөрөнгө 114,5 тэрбум төгрөг.
		16.1.3	Гамшгийн хор уршгийг арилгах аврах ажлын зориулалттай тусгай багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангамжийг сайжруулах /хувиар/	60	50			Нийт 201,6 сая төгрөгөөр Баянзүрх дүүрэг, Сонгинохайрхан дүүрэг, Дорнод, Сүхбаатар, Хэнтий, Дорноговь, Дундговь, Баянхонгор, Өвөрхангай, Ховд, Баян-Өлгий, Увс, Завхан, Сэлэнгэ, Хөвсгөл зэрэг 2 дүүрэг, 13 аймгийн 18 нэгжид 18 иж бүрдэл Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвийн тоног төхөөрөмж, 1,2 тэрбум төгрөгөөр 254 ширхэг амьсгалын бие даасан төхөөрөмж, 910 сая төгрөгөөр 35 ширхэг аврах ажиллагааны комби багаж, 720 сая төгрөгөөр 40 ширхэг амьсгалын бие даасан төхөөрөмж цэнэглэх шахуурга, 40 сая төгрөгөөр 7 нэр төрлийн 144 ширхэг аккумлятор, 90 сая төгрөгөөр 11.2 тн гал унтраах хөөс үүсгэгч бодис худалдан авч, Онцгой байдлын ерөнхий газар дээр бүрттэлтэй 64 ширхэг 6.5 сая төгрөгийн IP утасны аппаратыг төв, орон нутгийн Онцгой байдлын анги байгууллагад хуваарилсан.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
		16.1.4	Цацраг идэвхт, химийн хорт бодисын болон тэсэрч дэлбэрэх бодисын аюулаас хамгаалах, хүн, мал, амьтны гоц халдварт, халдварт өвчин, ой хээр, объектын гал түймэртэй тэмцэх /хувиар/	90	90			Ой, хээрийн гал түймэр Улаанбаатар хот, Архангай, Булган, Говьсүмбэр, Завхан, Дорнод, Сэлэнгэ, Сүхбаатар, Хэнтий, Хөвсгөл, Төв, Ховд, Баянхонгор, Өвөрхангай, Увс зэрэг 15 аймгийн 74 суманд нийт 142 удаагийн ой, хээрийн түймэр гарч, урьдчилсан байдлаар 9549.3 га ой, 235.762 га хээр, нийт 245.311 га талбай, 2 гэр, 4 айлын өвөлжөө, 2 автомашин түймэрт өртөж, экологийн хохирол 3 тэрбум, эд материал 41.1 сая нийт 3.2 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна. Түймрийн нөхцөл байдлыг 2019 онтой харьцуулахад түймрийн тоо 17.2 хувиар өсөж, түймрийн улмаас учирсан хохирол 86.5 хувиар буурсан байна. Монгол Улсын хэмжээнд 2020 онд нийт 4894 удаагийн аюулт үзэгдэл, осол тохиолдож, үүний улмаас 243 хүн амь насаа алдаж, 1003 хүн гэмтэж бэртэн /евчилж/, 80954 толгой мал, амьтан хорогдож, 31.3 тэрбум төгрөгийн шууд хохирол учирсан.
	16.2	**Мэргэжлийн хяналт**				**45,932.4**	**42,418.5**	
		16.2.1	Хяналт шалгалтын үр дүнгээр шалгалтад хамрагдсан объектод их, дунд эрсдэлтэй объектын эзлэх хувь	60	54.1	731.6	658.7	Мэргэжлийн хяналтын байгууллагаас 2020 онд нийт 7,659 шалгуулагч этгээдийн 9,613 объектод 14,151 шалгалт, 4,441 шалгуулагч этгээдийн 5,068 объектод 6,389 зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөсөн. Гүйцэтгэлээр 2020 онд төлөвлөгөөт шалгалтад хамрагдах объектын 9358 буюу /97%/, зөвлөн туслах үйлчилгээнд хамрагдах объектын 4957 /97%-ийг тус тус хамруулсан байна. 2020 онд төлөвлөсөн их дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектуудад хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж, нийт 277 хяналтын хуудсаар үнэлэхэд 13% нь их, 41.1% нь дунд, 45.8% нь бага эрсдэлтэй үнэлэгдсэн байна.
		16.2.2	Хууль сахин мөрдөлтийн төвшин /хувь/	75	63	42,237.3	38,866.7	Тайлант хугацаанд Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан объектуудад хийсэн хяналтын хуудасны үнэлгээгээр хууль сахин мөрдөлтийн түвшин 63%-тай байна. COVID-19 халдвар гарсантай холбоотойгоор вирусийн халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авах зарим арга хэмжээг баталсны дотор бүх төрлийн үзвэр үйлчилгээ, нийтийн хоол, боловсролын байгууллага, сургалтын төвийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоон, бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбоотой төлөвлөгөөт хяналт шалгалтуудыг зогсоож, эсхүл хойшилсон нь хяналт шалгалтын үр дүнд нөлөөлсөн.
		16.2.3	Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн /акт, нөхөн төлбөр /биелэлт /хувиар/	74	68.5	138.1	133.2	Системийн хэмжээнд хяналт шалгалтад хамрагдсан иргэн, аж ахуй нэгжийн 30.7%-д нь улсын байцаагчийн шийдвэрээр арга хэмжээ авсан байна. Нийт арга хэмжээний 43.8% -д нь буюу 7027 иргэн аж ахуй нэгжид улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага, 26%-д буюу 4172 иргэн аж ахуй нэгжид зөвлөмж, 18.1% -д торгууль, нөхөн төлбөрийн арга хэмжээ авсан байна. 2020 онд МХБ-аас хяналт шалгалтын хүрээнд 1354 дүгнэлт, 7020 албан шаардлага /52%-ийн биелэлттэй/, 4166 зөвлөмж /57.6%-ийн биелэлттэй/, 14 объектын үйл ажиллагааг бүр, 153 объектыг түр зогсооснoор 6051 объектын эрсдэлийн түвшнийг бууруулж, аюулгүй байдлыг хангуулж ажилласан байна. Хяналт шалгалтаар 261410 зөрчил илрүүлснийг арилгах зориллгоор 2.068.742.165 төгрөгийн торгуулийн арга хэмжээ /82.4%-ийн биелэлттэй/, 4.052.294.739 нөхөн төлбөрийн арга хэмжээ ногдуулж 54.4% биелэлттэй байна.
		16.2.4	Лабораторийн шинжилгээний итгэмжлэгдсэн үзүүлэлтийн өсөлт	1240	1354	2,825.3	2,759.9	Орон нутгийн Мэргэжлийн хяналтын 8 лаборатори Үндэсний итгэмжлэлийн төвөөр итгэмжлэлийн хугацааг тус 4 жилийн хугацаатайгаар сунгуулан ажилласан бөгөөд өмнөх итгэмжлэлийн хүрээг дараах байдлаар нэмэгдүүлэн ажилласан байна. Үүнд: Архангай аймгийн МХГ-ын лаборатори хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний 3 ангиллаар 10 үзүүлэлт, Хөвсгөл аймгийн МХГ-ын лаборатори 2 ангиллын 6, Дорноговь аймгийн МХГ-ын лаборатори 4 ангиллын 9, Дундговь аймгийн МХГ-ын лаборатори 4 ангиллын 7, Өмнөговь аймгийн МХГ-ын лаборатори 3 ангиллын 8, Өвөрхангай аймгийн МХГ-ын лаборатори 4 ангиллын 11, Багануур дүүрэг дэх МХХ-ийн лаборатори 4 ангиллын 7, Налайх дүүрэг дэх МХХ-ийн лаборатори 5 ангиллын 8 буюу давхардсан тоогоор нийт 66 үзүүлэлтээр, Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн хувьд Америкийн нэгдсэн улсын Олон улсын итгэмжлэлийн байгууллага болох "ANAB"-аар эмийн хяналтын 43, хими, хор судлалын 85, нян судлалын 12 үзүүлэлтээр буюу шинээр 35 үзүүлэлтээр тус тус итгэмжлэлийн хүрээг өргөжүүлэн ажилласан байна. Хяналтын итгэмжлэгдсэн сүлжээ лабораториудын итгэмжлэлийн хүрээний тодорхойлолт хими, хор судлал, нян судлал, хорио цээр, цацрагийн хяналтын нийт 32 ангиллаар өргөжиж, 1354 (давхардсан тоогоор)-д хүрсэн байна.
	16.3	**Зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих, хэрэглэгчийн эрхийг хамгаалах**				**1,010.0**	**1,010.4**	
		16.3.1	Төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус хяналт хийх тоо	40	3991	380.3	384.1	ШӨХТГ-аас хууль тогтоомжийн хүрээнд удирдамжтай 59 хяналт шалгалт хийж, зөрчлийн шинжтэй 85 хэргийг хүлээн авч шийдвэрлэсэн байна. Бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд 3932 төлөвлөгөөт бус хяналт шалгалтуудыг хийсэн. Энэ хүрээнд улсын байцаагчийн 127 албан шаардлага, мэдэгдэх хуудас, дүгнэлт 149-ийг хүргүүлсэн байна. Нийт 29 аж ахуйн нэгж, иргэнд 222.7 сая төгрөгийн торгууль ногдуулсан. 2020 онд 1.9 тэрбум төгрөгийн торгуулийн орлого улсын төсөвт төвлөрүүлсэн.
		16.3.2	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлт /хувиар/	100	100	570.5	576.1	Иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас 11183 өргөдөл гомдол, саналыг хүлээн авч хянан шийдвэрлэсэн. Албан бичгээр ирүүлсэн өргөдөл, гомдлын тоо 802, "Хэрэглэгчийн мэдээллийн төв"-д 10,381 иргэн хандсан байна. Үүнээс 115 утсаар 7027, дуут шуудангаар 1963, чатботоор 1219, ибаримт апликэйшнээр 192 гомдлыг тус тус хүлээн авсан байна. Мөн өргөдөл гомдлын шинжтэй 7667 санал, лавлагааны шинжтэй 861, зөвлөгөө, мэдээлэл авсан 1873 иргэнд зохих хариултыг өгч, зөвлөгөө, мэдээллээр ханган, ирүүлсэн гомдлыг шуурхай шийдвэрлэж ажиллав. Өргөдөл гомдлын шийдвэрлэлт 100%-тай байна. Тус төв нь 350 иргэний 103.1 сая төгрөгийн мөнгөн хохирлыг барагдуулж шийдвэрлэсэн.
		16.3.3	Зүй ёсны монопол болон давамгай байдалтай аж ахуй эрхлэгчийг тогтоох судалгаг хийж, хуралдаанаар шийдвэрлүүлэх	Тухай бүр	3	16.7	7.8	2020 оны байдлаар 3 салбарт зүй ёсны монопол болон давамгай байдалтай эсэхийг тогтоох судалгаг хийж, 1 аж ахуй эрхлэгчийг давамгай байдалтай, 2 аж ахуй эрхлэгчийг зүй ёсны монопол аж ахуй эрхлэгчээр тус тус тогтоож, ШӨХТГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн, шийдвэрлүүлж, аж ахуй эрхлэгч нарт тогтоолыг хүргүүлсэн.
		16.3.4	Нийгэм, эдийн засгийн хөгжилд нөлөө үзүүлдэг салбараас сонгон авч зах зээлийн өрсөлдөөний төлөв байдлын судалгаа хийж, өрсөлдөөний хэв шинж, хэлбэрийг тодорхойлох судалгаг хийх	2-оос доошгүй удаа	15	7.8	7.8	Салбарын бодлогын судалгааны ажил – 10 /54 аж ахуй нэгж хамрагдсан. Үнийн судалгаа 5 удаа хийгдсэн байна.
		16.3.5	Холбогдох хууль тогтоомжийг сурталчлах, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулах	15	76	34.7	34.7	2020 онд хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулсан сургалт, уулзалт, хэлэлцүүлэг 76 удаа, үүнд хамрагдсан байгууллага, иргэний тоо 1532 байна.
	16.4	**Стандарт, хэмжил зүй**				**8,286.8**	**8,463.1**	

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
		16.4.1	Шалгалт тохируулга /калибровка/-д хамруулах хэмжих хэрэгслийн тоо /мянган нэгж/	7.6	9.6	2,521.8	4,209.0	ААНБ-ууд үйл ажиллагааны цар хүрээгээ нэмэгдүүлж байгаа нь төлөвлөгөө давж биелэх шалтгаан болсон.
		16.4.2	Загварын туршилтад хамруулан улсын бүртгэлд бүртгэх хэмжих хэрэгслийн тоо	43	61	12.0	20.0	38 ААНБ-ын 61 төрлийн хэмжих хэрэгсэл баталгаажуулж ажилласан. Үүнд: - ОУ-ын Хууль эрхийн хэмжил зүйн байгууллага болон үйлдвэрлэгч улсын хэмжил зүйн байгуулагын загварын туршилт гүйцэтгэсэн гэрчилгээтэй хэмжих хэрэгсэлд ажлын хөсөг хөсөгчилсэн туршилт гүйцэтгэж дүгнэлтээ Хэмжил зүйн зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн. 2020 оны 6-р сарын 9-нд батлагдсан "Хэмжих хэрэгслийн загварыг турших, батлах журам"-ын дагуу загварын туршилтаа сунгахаар хүсэлт ирүүлсэн ААНБ-ын загварын туршилтын дүгнэлтийг хянан шийдвэрлэсэн.
		16.4.3	Эзэлжит баталгаажуулалтад заавал хамруулах хэмжих хэрэгслийн тоо /мянган нэгж/	200	226	1,477.9	2,466.7	УБ хотын хэмжээнд шинээр бариглаж буй барилга байгууламжтай холбоотойгоор хэмжих хэрэгслийн нийлүүлэлтийн тоо эрс өссөн.
		16.4.4	Чанарын удирдлагын тогтолцооны баталгаажуулалтад хамруулах байгууллага, аж ахуйн нэгжийн тоо	101	167	185.0	308.8	Олон улсын менежментийн тогтолцооны ISO 9001, ISO 14001, ISO 45001/OHSAS 18001, ISO 22000, HACCP стандартуудыг 2020 оны жилийн эцсийн байдлаар НИЙТ 167 аж ахуйн нэгж үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн нь ААНБ-ын менежментийн тогтолцооны талаарх мэдлэг дээшлэх өрсөлдөх чадвар нэмэгдэн, зах зээл дээрх эдийн засгийн үр өгөөж нэмэгдэх хандлагатай байна.
		16.4.5	Итгэмжлэлд хамруулах сорилтын лабораторийн тоо	51	92	63.7	19.2	
		16.4.6	Үндэсний стандартад олон улс, бүс нутгийн дэвшилтэт стандартын эзлэх хувь	34	40	150.0	250.3	2020 онд Техникийн хороод нийгэм, эдийн засгийн тэргүүлэх ач холбогдол бүхий олон улс бүс нутгийн дэвшилтэт стандарт 105-ийг боловсруулан батлуулсан. Ингэснээр олон улсын стандарттай ижилтгэсэн стандартын түвшин 35%, адилтгасан стандартыг оруулаад олон улсын түвшин 40% болсон.
	16.5	**Худалдан авах ажиллагааг хэрэгжүүлэх**				**923.1**	**1,341.6**	
		16.5.1	Худалдан авах ажиллагааг хуульд заасны дагуу хугацаанд нь зохион байгуулах	Тухай бүр хугацаанд нь зохион байгуулах	хугацаанд нь зохион байгуулсан	923.1	1,341.6	Төрийн худалдан авах ажиллагааны газраас тайлант хугацаанд нийт 274 удаагийн тендер шалгаруулалтыг зохион байгуулж, 342 тэрбум төгрөгийн 187 багц ажлын 151 гэрээг байгуулсан ба төсөвт 14,6 тэрбум төгрөгийн хэмнэлт гарсан байна. Тус тендер шалгаруулалтуудад давхардсан тоогоор 1748 тендерт оролцогч оролцсон байна. Мөн 5 төсөл, арга хэмжээ хүчингүй болсон.
		16.5.2	Иргэн, хуулийн этгээдэд цахим худалдан авах ажиллагааны талаар цахим болон танхимын сургалт явуулах	80	12 удаа цахим сургалт зохион байгуулж 523 оролцогч хамруулсан			Улсын онцгой комиссын шийдвэрийн дагуу тогтмол зохион байгуулагддаг танхимын сургалтыг зохион байгуулаагүй бөгөөд Багануур дүүргийн худалдан авах ажиллагааны албаны хүсэлтээр 20 аж ахуй нэгжийн төлөөлөлд цахим системийн сургалтыг 2020 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр хийсэн. Цахим сургалтыг 12 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 523 тендерт оролцогчийн төлөөллийг сургалтад хамруулсан.
		16.5.3	Захиалагч байгууллагад цахим худалдан авах ажиллагааны сургалт явуулах /тоогоор/	250	14 удаагийн цахим сургалт зохион байгуулж, 322 захиалагч байгууллагын төлөөлөл оролцсон			Улсын онцгой комиссын шийдвэрийн дагуу тогтмол зохион байгуулагддаг танхимын сургалтыг зохион байгуулаагүй ба цахим сургалтыг 14 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 322 захиалагч байгууллагын төлөөллийг сургалтад хамруулсан.
		16.5.4	Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сургалтын тоо	35	175			Тайлант хугацаанд Сангийн яамнаас "Худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох сургалт" зохион байгуулах эрх авсан сургалтын байгууллагууд 175 удаагийн сургалтыг зохион байгуулсан байна. Цахим шалгалтыг 4897 суралцагчаас авч, 2933 хүн тэнцсэн байна.Төрийн худалдан авах ажиллагааны газар нь нийт 7 удаагийн сургалт зохион байгуулж, үүнд 92 хүн хамрагдаж, шалгалт өгснөөс 71 хүн тэнцсэн байна. Нийт 372 удаа цахимаар шалгалт авсан, үүнд 4989 хамрагдаж шалгалт өгснөөс 3004 хүн тэнцсэн байна.
17	**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**					**433,011.9**	**410,339.9**	
	17.1	**Гүйцэтгэх засаглалын удирдлага, түүний ажлын алба**				**18,614.6**	**11,299.8**	
		17.1.1	Засгийн газрын бодлого, шийдвэрийг боловсруулах, хуралдааны бэлтгэх болон яам, агентлагийн үйл ажиллагаг уялдуулан зохицуулах, энэ чиглэлээр цаг үеэ олсон, шуурхай зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх	Хууль тогтоомжид нийцсэн байх	төлөвлөгөөнд хүрч ажилласан	18,614.6	11,299.8	Яамд, Засгийн газрын агентлагийн чиглэлээр Засгийн газрын хуралдааны хэлэлцүүлэхээр ирүүлсэн асуудлыг хуулэн авч, эрх зүйн үндэслэл, найруулга, ач холбогдлыг нь үнэлж, шалган ажилласан ба Засгийн газрын хуралдаанд 937 асуудал боловсруулж хэлэлцүүлэх, танилцуулахад бүх талын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэн ажилласан.
		17.1.2	Ерөнхий сайд, Засгийн газрын танхим, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг даргыг нутгийн удирдлагын чиглэлээр мэргэжлийн өндөр, цаг үеэ олсон зөвлөгөө, дэмжлэгээр шуурхай хангах, тэдгээрийн үйл ажиллагааны үр нөлөөтэй, хэвийн жигд ажиллагааны эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх	Мэдээлээр хангасан байх	төлөвлөгөөнд хүрч ажилласан			Хөтөлбөрийн хүрээнд хуулиар хүлээсэн үүрэг зориптыг хэрэгжүүлэх, "Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр", түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, үндсэн чиглэлд тусгагдсан зориптыг хэрэгжүүлэх болон Ерөнхий сайд, Засгийн газрын танхимын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх талаар бүх талын зөвлөгөө, дэмжлэг үзүүлэн ажилласан. Засгийн газрын 74 удаагийн хуралдааныг зохион байгуулж, Засгийн газрын тогтоол 470, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл 509, бодлогын баримт бичиг, хөтөлбөр 17, журам, дүрэм 21, төлөвлөгөө 2 гаргасан байна.
		17.1.3	Хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол шийдвэрийн мэдээллийг 3, 9 дүгээр сард, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг 3, 9 дүгээр сард, хөтөлбөр, төслийн мэдээллийг 5 дугаар сард, үйл ажиллагааны үр дүнгийн мэдээллийг улирал тутам хийсэн байх	Төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх	Мэдээллүүд хууль тогтоомжид заасны дагуу улирал тутамд бүрэн гарч хэрэгжсэн.			Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 2020 оны эхний хагас жилийн дүнг Засгийн газрын 2020 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанд, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн 2020 оны эхний хагас жилийн биелэлтийн хэрэгжилтийг Засгийн газрын 2020 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанд тус тус танилцуулсан. Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн 2019 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүн, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанд тус тус танилцуулсан. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээнд 2019 оны жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнгийн талаар мэдээллийг 2020 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулсан.
	17.2	**Төр, засгийн үйлчилгээ**				**7,493.2**	**7,056.0**	
		17.2.1	Төр, засгийн авто баазын үйлчилгээний стандартыг хангах	CS11–0120:2010 стандартыг ханган биелүүлсэн байх	20:2010 стандартыг ханган а	2,995.3	2,995.3	Төр, засгийн авто тээврийн үйлчилгээнд CS11-0120:2010 стандартыг ханган ажилласан.
		17.2.2	Төр, засгийн төв байгууллага болон хэрэглэгчийн хэвийн үйл ажиллагааг хангуулах	MNS-ISO 9001:2010 стандартыг ханган биелүүлсэн байх	001:2010 стандартыг ханган	4,497.9	4,060.7	Төр, засгийн төв байгууллагуудын нийтлэг үйлчилгээнд MNS-ISO стандартыг ханган ажилласан ба 2020 оны 8 дугаар сард MNS-ISO 9001:2016 стандартын биелэлтэд Стандарт, хэмжил зүйн газрын Магадлангийн аудит хийгдэж "Үл тохиролгүй" гэрчилгээ олгогдсон.
	17.3	**Эдийн засгийн хөгжлийн төлөвлөлт**				**381,999.7**	**367,946.5**	

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
		17.3.1	Монгол Улсын нийгэм, эдийн засаг, санхүүгийн төлөв байдлын талаар цаг үеэ олсон шуурхай лавлагаа, зөвлөмж боловсруулж, Ерөнхий сайдыг шаардлагатай мэдээлэл, судалгаагаар хангаж ажиллах	Тухай бүр	Тухай бүр мэдээллээр хангаж ажилласан.	381,999.7	367,946.5	2015 онд батлагдсан хуулийн зүйл, хэсэг, заалтыг шинэчилсэн хуулийн төслийн зүйл, хэсэг, заалттай харьцуулсан товьёг хөтөлсөн. Үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын бүтэц, шаардагдах боловсон хүчин, хөрөнгийн урьдчилсан тооцоог хийсэн. УИХ-ын тогтоолын төсөл, танилцуулга, үзэл баримтлалын төслийг бэлтгэж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Үндэсний хөгжлийн газраас хуулийн төслийн найруулгад өгөх саналыг нэгтгэн Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлсэн. Улсын Их Хурлаас Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг 2020 оны 5 дугаар сарын 07-ны өдөр батлагдан гарсан.
		17.3.2	Улсын хөрөнгө оруулалтын статистикийн нэгдсэн санг үүсгэж, эрхлэн хөтлөх /хувиар/	100	100			Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төслийн нэгдсэн мэдээллийн систем байгнын ажиллагаанд шилжсэн бөгөөд тухайн төслийг хариуцсан яам, агентлагууд болон Үндэсний хөгжлийн газар нь мэдээллийн шинэчлэлийг тогтмол хийж байна.
		17.3.3	Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах /богино болон дунд хугацааны/	3	2			Үндэсний хөгжлийн газар нь чиг үүргийн дагуу Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" болон Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг боловсруулахад дэмжлэг үзүүлэн ажилласан.
		17.3.4	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн цахим мэдээллийн нэгдсэн сан, аж үйлдвэрийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэж, эрхлэн хөтлөх /хувиар/	100	100			Үндэсний хөгжлийн газрын дарга болон 21 аймгийн Засаг дарга хоорондын 2020 онд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр хамтран ажиллах гэрээнд "Аж үйлдвэрийн нэгдсэн мэдээллийн сан"-г хөгжүүлэх гэсэн заалтыг оруулж, тус ажлын дагуу 21 аймаг орон нутагт байгаа жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг /www.industry4.nda.gov.mn/ цахим системд бүртгэх ажлыг зохион байгуулсан. 2020 оны байдлаар 3,600 гаруй үйлдвэрлэл эрхлэгчдийн 5,000 гаран бүтээгдэхүүн бүртгэгдсэн байна. Засгийн газрын 2018 оны 20 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн индекс шинэчлэн тооцох аргачлал"-ын дагуу Монгол Улсын 5 бүс, 21 аймаг, 330 сумын хөгжлийн индексийг 2019 оны мэдээллээр шинэчлэн тооцож 2020 оны 1 дүгээр улиралд багтаан www.ldi.nda.gov.mn цахим системд оруулж нийтэд зарласан. Аймаг, сумын бүрттэл мэдээллийн систем /www.sector.gov.mn/-ийн мэдээллийг улсын хэмжээнд шинэчлэх ажлыг зохион байгуулсан.
		17.3.5	Хөгжлийн томоохон төслүүдийн санал, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төслийг боловсруулж батлуулах, саналыг нэгтгэн судалгаг зохион байгуулах, дүн шинжилгээ хийх, хянах, батлуулах /хувиар/	100	100			Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн 100 төсөл, арга хэмжээний жагсаалт гаргах ажлыг гүйцэтгэв. Уг жагсаалтад яамд агентлагаас ирүүлсэн нийт 180 орчим төсөл арга хэмжээний саналуудад дүн шинжилгээ хийн холбогдох аргачлалын дагуу үнэлгээ, эрэмбэлэлтийг 2 удаа тус бүр 2 хувилбараар гаргасан.
	17.4	**Дотоод, гадаад шуурхай мэдээллийн үйл ажиллагаа**				**2,453.0**	**2,090.8**	
		17.4.1	Дотоод үйл явдлын мэдээллийг бэлтгэн гаргах /мянган ширхгээр/	240, 400	239,100	2,453.0	2,090.8	Монгол Улсын төр, засгийн удирдлага ба төв байгууллагууд, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, өргөн олон нийтийг улс орны дотоод амьдралын шуурхай мэдээллээр хангах зорилтын хүрээнд санхүү, хүний нөөц, техник тоног төхөөрөмжийн хангамжийн бодлогыг оновчтой тодорхойлж, хэрэгжилтийг зохион байгуулсан. Мэдээллийг шуурхай хэрэглэгчдэд хүргэх зорилгоор дотоод мэдээний редакцын сэтгүүлчдийг чадавхжуулах, нийгмийн сүлжээний мэргэшсэн ажилтнуудаар бэхжүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэв. Мэдээллийн шуурхай байдлыг хангаж, вэбсайтын өнгө төрх дизайн, хүчин чадал, хэрэглээний боломжийг нэмэгдүүлж ажилласан болно.
		17.4.2	Гадаад үйл явдлын мэдээллийг бэлтгэн гаргах /мянган ширхгээр/	209, 370	185,370			Дэлхий дахинд болж буй олон улсын чанартай үйл явдлын тухай мэдээ, мэдээллийг Москва, Бээжин зэрэг хотуудад суугаа өөрийн байгнын сурвалжлагчдын болон ТАСС, Риа-Новости, VOA, Синьхуа, Anadolu, KCNA, ВМА, Киодо, Ёнхап, ПТИ зэрэг хамтын ажиллагаатай гадаадын улсуудын мэдээллийн агентлагуудын мэдээлэл, ОАНА, НАНАП зэрэг бүс нутгийн байгууллагуудын сүлжээнээс сонгон авч, орчуулан бэлтгэн нийлүүлж байна. Мөн мэдээллийн баталгаат эх үүсвэрийг хангах үүднээс Ройтерс, Тасс зэрэг мэдээллийн агентлагуудтай албан ёсны гэрээ байгуулан баталгаат эх сурвалжаас мэдээллийг хүргэж ажилласан.
		17.4.3	Хэвлэмэл бүтээгдэхүүний орлогыг нэмэгдүүлэх /хувиар/	3	3			Сүүлийн жилүүдэд хэвлэмэл бүтээгдэхүүн хэрэглэгчдийн хандлага өөрчлөгдсөн, нөгөө талаар дэлхий дахинд тархсан цар тахал Коронавируст халдвар (КОВИД-19)-аас шалтгаалан мэдээллийн цахим хэлбэрийг түлхүү сонирхох болсон хэдий ч цахим суртачилгаа хийх замаар хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх, захиалгат ном сонин хэвлэх, халдварын эрсдэлд бага ертсен байгууллага аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах зэргээр хэвлэмэл бүтэгдэхүүний хэмжээг бууруулахгүй байх арга хэмжээг авч ажилласан.
		17.4.4	Хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх /хувиар/	5	4			"МОНЦАМЭ" агентлагийн цахим хуудаст дунджаар 2019 онд 119,000 хэрэглэгч хандаж байсан бол 2020 оны байдлаар хэрэглэгчдийн тоо 99,800-д хүрсэн байна.
	17.5	**Мэдээллийн нэгдсэн тогтолцооны дэд бүтэц хөтөлбөр**				**22,451.4**	**21,946.9**	
		17.5.1	Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн системүүдтэй нийтийн түлхүүрийн дэд бүтцийг холбох /төрийн албан хаагчийн тоо, мянгаар/	3	3.0	9,929.4	9,462.2	Төрийн байгууллагын цахим албан хэрэг хөтлөлтийн mGov системийг хөгжүүлж холболт хийсэн. Бүх системүүдийн хоорондх холбож мэдээлэл илгээх тоон гарын үсэг хэрэглэх боломжийг бий болгосон. Digidoc.gov.mn Нэгдсэн систем нь 2020 оноос бүрэн ажиллаж эхэлсэн бөгөөд 1,700 гаруй төрийн болон хувийн байгууллагуудыг холбоод байна. Мөн төрийн байгууллагын дотоод удирдлагын erp.e-mongolia.mn системийн хөгжүүлэлт хийгдэж байна. Нийслэлийн төр захиргааны байгууллагын төрийн албан хаагчдын 70 хувь нь албан хэрэг хөтлөлтийн системүүдтэй цахим гарын үсгээр холбогдоод байна.
		17.5.2	Монгол Улсын иргэн бүрд цахим гарын үсэг олгох /иргэний тоо мянгаар/	100	40.6			Дундын мэдээллийн санд бүрттэлтэй тоон гарын үсгийн тоо 40,601 байна.
		17.5.3	Төрөөс цахим хэлбэрээр шинээр хүргэх үйлчилгээний тоо	300	181			e-Mongolia төрийн нэгдсэн портал системд 181 үйлчилгээ нэгтгэгдсэн.
		17.5.4	ХУР системд холбогдох төрийн байгууллагын тоо	40	62	8,840.5	8,803.2	ХУР системд 2020.12.31-ний байдлаар нийт 62 төрийн байгууллага холбогдоод байна.
		17.5.5	ХУР системээр дамжуулан хүргэх цахим үйлчилгээний тоо	380	345			ХУР системээр дамжуулан хүргэх цахим үйлчилгээний тоо 2020.12.31-ний байдлаар нийт 345 үйлчилгээ болсон байна.
		17.5.6	ХУР системийг ашиглах байгууллагын тоо	200	128			ХУР Төрийн мэдээлэл солилцооны системээр дамжуулан 2020 онд төр болон хувийн хэвшлийн нийт 190 байгууллага холбогдоод байна.
		17.5.7	Хөдөө орон нутгийн алслагдсан сум, суурин газарт шилэн кабелийн сүлжээнд холбох сумын тоо	3	2 тосгон	3,681.5	3,681.5	Хэнтий аймгийн Мөрөн сум/Өлзийт тосгон, Сэлэнгэ аймгийн Сайхан сум/Номгон тосгон тус тус өндөр хурдны шилэн кабелийн сүлжээнд холбосон бөгөөд нийт 3,061 иргэдийг төрийн үйлчилгээг авах боломжийг олгосон.
		17.5.8	Алслагдсан бүс нутагт хөдөлгөөнт холбооны үйлчилгээ хүргэх багийн тоо	30	31 цэгт			12 аймгийн 30 сумын 31 багуудад хөдөлгөөнт холбооны сүлжээ оруулж шинээр 30 гэрээт ажлын байр бий болгосон.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
		17.5.9	Алслагдсан сум, суурин газарт утасгүй болон суурин өргөн зурвасын сүлжээ байгуулах, интернэтийн үйлчилгээ хүргэх сумын тоо	90	71 цэгт			18 аймгийн 71 сумын ЗДТГ, Эрүүл мэндийн төвд 8 Mbps хүртэлх хурдаар интернэтийг үйлчилгээ хүргэсэн.
		17.5.10	Хэт богино долгионоор радиогийн нэвтрүүлгийг орон нутагт хүргэх сумын тоо	20	46 сум			Хэт богино долгионоор радио нэвтрүүлгийн үйлчилгээг аймгийн төвүүд болон нийт 46 сумдад шууд хөтлөгчтэй эфир 07:30 минутад эхэлж, 22:00 цаг хүртэл үргэлжлэх хугацаатайгаар цацагдсан.
18	БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД					157,769.2	132,500.6	
	18.1	Ойжуулалт				3,614.7	3,490.0	
		18.1.1	Ойгоор бүрхэгдсэн газар нутгийн хэмжээ /хувь/	8.5	7.96	3,614.7	3,490.0	Увс аймгийн ой бүхий сумдын 236.6 мянган га, Ховд аймгийн 799.8 мянган га, Өвөрхангай аймгийн заган ой бүхий сумдын 125.5 мянган га талбай, нийт 1161.9 мянган га талбайд ой зохион байгуулалтын ажлыг гүйцэтгэсэн. Увс аймгийн өмнөговь, Завхан сум, Ховд аймгийн Мөнххайрхан, Ховд сумдын нутагт тархан ургаж буй ойн санг улсын ойн санд шинээр бүртгэж авсан.Монгол улсын ойн сангийн талбайн 84,9 хувийг навчит, шилмүүст ой, 15.1 хувийг заган ой эзлэх ба Монгол орны ойрхог чанар 2020 оны байдлаар 7.96 хувийг эзэлж байна.
		18.1.2	Ойжуулах, ойг нөхөн сэргээх /мянган га/	12	4.04			Ойжуулалт, ойг нөхөн сэргээх арга хэмжээг 4042,2 га талбайд зохион байгуулсан. Шилмүүст модоор ойжуулах ажлыг 3088,7 га, байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг 582 га, ойн зурвас байгуулах ажлыг 183,1 га, ногоон байгууламж 183,93 га, мод уржүүлгийн газар байгуулах ажлыг 4,5 га талбайд тус хийж гүйцэтгэсэн.
		18.1.3	Ойн хөнөөлт шавж, өвчний голомтыг хязгаарлах тэмцлийн ажил хийх /мянган га/	50	50			Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг улсын төсвийн хөрөнгөөр 65,856 га талбайд хийж гүйцэтгэсэн. Ойн хөнөөлт шавжтай гэрлэн урхи тавих аргаар тэмцэх ажлыг 19256 га талбайд зохион байгуулан бие гүйцсэн Өрөөсгөл хүр эрвээхэй 1.8 сая ширхгийг урхидаж цуглуулан устгасан. Гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүд гэрлэн урхи тавих аргаар тэмцэх ажлыг ямар нэгэн зөрчилгүй 100 хувийн гүйцэтгэлтэйгээр техникийн дундаж 89.9 хувийн үр дүнтэй зохион байгуулсан. Ойн хөнөөлт шавжтай микробиологийн аргаар үүргийн шүршигч багаж ашиглан тэмцэх ажлыг Өвөрхангай аймгийн Хархорин, Говь-Алтай аймгийн Халиун, Есөнбулаг, Увс аймгийн Баруунтуруун, Малчин, Хэнтий аймгийн Биндэр сумын нутагт 4,900 га талбайд ямарваа нэгэн зөрчил, гологдолгүй ажлын 100 хувийн гүйцэтгэлтэй, техникийн дундаж 86.8 хувийн үр дүнтэй зохион байгуулсан.
		18.1.4	Ойн төлөв байдлыг сайжруулан ойг доройтлоос хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор арчилгаа, цэвэрлэгээ хийх /мянган га/	30	30			Ойн төлөв байдлыг сайжруулах ойг доройтлоос хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор арчилгаа, цэвэрлэгээ хийх ажлыг улсын төсвийн хөрөнгөөр 195 га талбайд ойн арчилгааны арга хэмжээг хэрэгжүүлэх замаар ойн төлөв байдлыг сайжруулах, 450 га талбайд ойн цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэн ойг доройтлоос хамгаалж, эрүүлжүүлсэн. Ойд арчилгаа, цэвэрлэгээ хийх, ойд үйлдвэрлэлийн ашиглалтын огтлолт хийх эрх бүхий мэргэжлийн байгууллага, ойн санг гэрээгээр ээлэмшигч нөхөрлөл, иргэд өөрсдийн хөрөнгөөр ойн сан бүхий 14 аймаг, нийслэлийн хэмжээнд нийт 29.0 мянган га талбайд арчилгаа, цэвэрлэгээ хийсэн. 2020 онд улсын хэмжээнд нийт ойн төлөв байдлыг сайжруулах ойг доройтлоос хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор арчилгаа, цэвэрлэгээг 30.2 мянган га талбайд хийж гүйцэтгэсэн.
	18.2	Усны нөөц, нуур, гол мөрний менежмент				4,909.1	4,453.2	
		18.2.1	Урсац бүрэлдэх эхийг тусгай хамгаалалтад авсан гол мөрний эзлэх хувь	50	50	4,909.1	4,453.2	Монгол Улсын цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн хэмжээ 14.4 сая га талбайг эзэлж байгаагаас 2020 оны байдлаар 7.2 сая га буюу 49.9 хувийг улсын тусгай хамгаалалтад аваад байна.
	18.3	Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт				11,540.2	10,386.1	
		18.3.1	Тусгай хамгаалалтад авсан газар нутгийн эзлэх хувь	21	21	11,540.2	10,386.1	Монгол Улсын Их Хурлын 2020 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 46 дугаар тогтоолоор 9 газар нутгийг шинээр, Ноён уулын орчмын дурсгалт газар болон байгалийн нөөц газрыг 10483 га талбайгаар өргөтгөж, дархан цаазат газраар ангиллаар ахиулан тус тус улсын тусгай хамгаалалтад авсан байна. Дээрх газруудыг улсын тусгай хамгаалалтад авснаар Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тоо 120 болж улсын газар нутгийн 21% хүрсэн.
		18.3.2	Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх /мянган га/	1200	1200			Өмнөговь аймгийн Балгасын улаан нуурын цэнгэг усны орд зэрэг онцлог экосистем бүхий 1.9 сая га газар нутагт судалгаа хийж, тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх үндэслэл боловсруулах ажлын хүрээнд 14 аймгийн 41 сумын 25 газар нутгийн нийт 2.6 сая гаруй га талбайг хамруулан судалгааг гүйцэтгэсэн.
	18.4	Ус цаг уур, орчны шинжилгээ				33,355.5	33,154.9	
		18.4.1	Цаг агаарын төлөв байдал, ус цаг уурын үзэгдэлд зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны үр ашгийн түвшин /хувиар/	68	68	33,355.5	33,154.9	Цаг агаарт зориудаар нөлөөлж, хур тунадас нэмэгдүүлэх 46 экспедиц, 12 газрын генератор, 2 радарын явуулын станцын үйл ажиллагаанд хяналт тавьж, тус үйл ажиллагаанд 1,391 пуужин зарцуулсан.
		18.4.2	Аэрологийн өртөөдийн хөөргөлтийн тооны өсөлт /тоо/	2 дахин	2 дахин			Өндөр нарийвчлалтай радарын ажиглалтын мэдээг богино хугацааны цаг агаарын урьдчилсан мэдээ гаргах, ялангуяа хүн ам олноор суурьшсан хот, суурин газарт дулааны улирал дахь босоо хөгжлийн үүлнээс үүдэлтэй байгалийн гамшгаас хүний амь нас, эд хөрөнгийн аюулгүй байдлыг хамгаалж, эрсдэлийг бууруулах, иргэний агаарын тэврийн нислэгийн аюулгүй байдлыг хангах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Цаг уурын улсын сүлжээний 61 харуул нь автомат хэмжих хэрэгслээр цаг уурын хэмжил хийх боломж бүрдсэн.
	18.5	Хүрээлэн байгаа орчны удирдлага, судалгаа шинжилгээ				23,623.8	20,093.4	
		18.5.1	Ховор, нэн ховор болон ашиглалтад өртөмхий амьтан, ургамлын нөөцийг хамгаалах, амьдрах орчныг тэтгэх төсөл арга хэмжээ /зүйлийн тоо/	2	2	23,623.8	20,093.4	Монгол орны ургамал газар зүйн 4-өөс доошгүй тойргийн ашиглалтад өртөмтгий 200 зүйл ургамал, 10 зүйл амьтны тархац нөөцийг тогтоож, Олон улсын улаан дансны шалгуураар 600 зүйл амьтан, ургамлыг нарийвчлан үнэлж, ховордлын шалтгааныг тодорхойлох зорилтыг ханган ажиллаж байгаа бөгөөд 2021 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
		18.5.2	Ховор, нэн ховор болон ашиглалтад өртөмхий амьтан, ургамлын нөөц, тоо толгой, тархцын судалгаа хийх /зүйлийн тоо/	2	2			Хэнтий уулын тайгын тойрогт 31, Монгол дагуурын уулын ойт хээрийн тойрогт 35 зүйл ургамлыг шинээр бүртгэж, 201 зүйл ургамлын тархац, биологийн болон ашиглалтын нөөцийг тогтоосон. 2020-2024 онд 7 тойргийн ургамлын нөөцийн судалгааг үргэлжлүүлэн хийнэ.
	18.6	Агаарын бохирдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт				77,322.5	58,336.2	

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
		18.6.1	Бохирдуулах бодисын бууралт /суурь түвшин-2016 оны 12 дугаар сарын дундаж, хувь/	50	PM2.5 тоосонцор 19%-аар, PM10 тоосонцор 9%-аар тус тус багассан	77,322.5	58,336.2	2020 онд агаар, орчны бохирдлыг бууруулах ажлын хүрээнд гэр хорооллын айл өрхөд шөнийн цахилгааны үнийн урамшуулал олгож, Таван толгой түлш компанийн түлш үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлж ажилласан. Гэр хорооллын айл өрхийг цахилгаан халаагуураар халаах техникийн боломжийг бий болгоход 2.6 тэрбум төгрөгийг зарцуулж байна. Агаар дахь агаар бохирдуулах бодисын 2020 оны жилийн дундаж агууламжийг 2019 оны жилийн дундаж агууламжтай харьцуулахад PM2.5 тоосонцор 11 мкг/м3-ээр буюу 18%-аар, PM10 тоосонцор 34 мкг/м3-ээр буюу 27%-аар тус тус бага байсан бол, хүхэрлэг хий 18 мкг/м3-ээр буюу 62%-аар их, азотын давхар исэл өмнөх жилийн түвшинд байна.
		18.6.2	Ногоон төсөл санаачилгыг дэмжих /Ногоон зээлд хамрагдах өрхийн тоо/	2000	327			2020 оны байдлаар нийт 36 байгууллагад 604,4 сая төгрөг, 291 иргэнд 236,3 сая төгрөгийн хүүгийн зээлийн хүүний санхүүжилт олгосон байна. Нийт 327 иргэн аж ахуй нэгжүүд буюу 16.35%-д хамрагдсан байна.
	18.7	**Аялал жуулчлал**				**2,853.0**	**2,110.7**	
		18.7.1	Жилд хүлээн авах гадаадын жуулчны тоо /сая хүн/	1	57,825 хүн	2,853.0	2,110.7	Дэлхий дахинд "Ковид-19" цар тахлын тархалттай холбогдуулан Монгол Улс өндержүүлсэн бэлэн байдал зарлаж, гадаад жуулчдын урсгалыг бүрэн зогсооосон. Аялал жуулчлалын салбарт үйл
		18.7.2	Аялал жуулчлалын салбарын орлого /сая ам.доллар/	900	4.40			
	18.8	**Газрын доройтлыг бууруулах, цөлжилтөөс сэргийлэх**				**550.6**	**476.2**	
		18.8.1	Цөлжилтөд өртсөн газар нутгийн эзлэх хувь	75.8	35 га	550.6	476.2	Газрын доройтлыг бууруулж, цөлжилтийг сааруулж, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор яамны зүгээс Тогтвортой хөгжлийн зорилгыг хангахад чиглэсэн нотолгоо ба үр дүнд 2020 онд Монгол орны цөлжилтийн атласыг шинэчлэх, 21 аймгийн хэмжээнд хөрсний үржил шимийн судалгаат тус тус хийж гүйцэтгэлээ. Цөлжилт газрын доройтлыг бууруулах, элсний нүүлтийг сааруулах механик хаалтыг 25 га, хамгаалалтын ойн зурвасыг 5 га, говийн баянбүрдийг нөхөн сэргээх арга хэмжээг 5 га, нийт 35 га талбайд арга хэмжээг хэрэгжүүлээд байна. Мөн говь хэрийн бүсэд 5 булаг шандын эхийг хашиж хамгаалан, уст цэгийн тоог 1-ээр нэмэгдүүлсэн.
19	**ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД**					**92,885.6**	**73,133.4**	
	19.1	**Гадаад харилцааны бодлого, удирдлага**				**16,417.8**	**9,937.0**	
		19.1.1	Гадаад харилцааны бодлого, удирдлагын чиглэлээр сургалт, семинар зохион байгуулах /тоогоор/	2	1	15,198.8	9,653.9	Гадаад харилцааны бодлого, удирдлагын чиглэлээр сургалт, семинар зохион байгуулах ажлын хүрээнд "Гадаад бодлогын хэрэгжилтийг нэгдсэн зохицуулалтаар хангах" сэдэвт сургалтыг ГХЯ-нд зохион байгуулж, арга хэмжээнд ЕТГ, УИХТГ, ЗГХЭГ, яамдын дэд сайд, ТНБД нар, яамдын харьяа агентлагуудын удирдлага, гадаад харилцаа хариуцсан нэгжийн дарга, ажилтан нийт 100 орчим хүнийг сургалтад хамруулав.
		19.1.2	Засгийн газар хоорондын хамтарсан хэлэлцээр байгуулах /тоогоор/	20	11			Гадаад харилцааны яамнаас шууд болон Засгийн газар хоорондын хамтран зохион байгуулсан олон улс, бүс нутгийн хэмжээний хурал, зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулж ажиллав. ЗГХК-ийн хуралдааныг айлын талын саналаар хойшлуулсан.
		19.1.3	Зөвлөлдөх уулзалт, дугуй ширээний уулзалт /тоогоор/	19	13	244.10	0.45	Тайлангийн хугацаанд хөрш орнууд болон гуравдагч хөрш улсуудтай тогтоосон харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх, хамтын ажиллагааны эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх үндсэн зорилт тавьж, гадаад харилцааны яамд хоорондын зөвлөлдөх болон дугуй ширээний уулзалтуудыг цахимаар зохион байгуулж ажиллав. Коронавируст халдвар "КОВИД-19"-ын цар тахлын нөхцөл байдлын улмаас зарим зөвлөлдөх уулзалт хурлыг 2021 онд хэрэгжүүлэхээр хойшлуулсан болно.
		19.1.4	Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээг хэвлэн нийтлэх тоо	300	168			Коронавируст халдвар "КОВИД-19"-ын цар тахлын нөхцөл байдлын улмаас өндөр дээд хэмжээний харилцан айлчлалын тоо буурсантай холбогдуулан Засгийн газар хоорондын 18 гэрээ (168 хуудас бүхий) хэвлэн нийтэлсэн байна.
		19.1.5	Өндөр, дээд түвшний айлчлал зохион байгуулах	Хоёр талын харилцаа, хамтын ажиллагаа өргөжихийн хирээр айлчлал арга хэмжээний давтамжийг нэмэгдүүлнэ.	7	974.90	282.70	Монгол Улсын төр, засгийн тэргүүн, Гадаад харилцааны сайд, төрийн дээд, өндөр албан тушаалтнуудын гадаад улсад хийсэн, гадаад улсын төр, засгийн тэргүүн, дээд, өндөр түвшний төлөөлөгчдийн манай улсад хийсэн нийт 7 удаагийн айлчлалын бэлтгэлийг ханган хэрэгжүүлсэн.
	19.2	**Гадаад улс дахь дипломат үйл ажиллагаа**				**76,467.7**	**63,196.4**	
		19.2.1	Хилийн чанадад суугаа Дипломат төлөөлөгчийн газраас төлөөлөн суугаа буюу хавсран суугаа улс, олон улсын байгуулагатай гадаад харилцаа, хамтын ажиллагаат хөгжүүлэх арга хэмжээ авах	Төлөвлөсөн хугацаанд хийгдсэн байх		72,243.7	52,124.8	Хилийн чанадад байгаа ДТГ-аар дамжуулан гадаад харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэн ажиллаж байна.
		19.2.2	Гадаад улсад байгаа Монгол Улсын иргэдийн гаргасан хүсэлтийг шийдвэрлэх хувь	100	100			Гадаад улсад суугаа Монгол улсын иргэдийн гаргасан өргөдөл хүсэлтийг иргэдэд туслах сангаас 100 хувь шийдвэрлэсэн.
		19.2.3	Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн дагуу дипломат аргаар хамгаалах	Тусламж шаардлагатай тухай бүрд		224.0	216.3	Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг олон улсын эрх зүйн дагуу дипломат аргаар хамгаалах үйл ажиллагаат тусламж шаардлагатай тухай бүрд шуурхай үзүүлж ажилласан.
		19.2.4	Төсвийн орлогын төлөвлөгөөг батлагдсан хуваарийн дагуу төвлөрүүлэх	Орлогыг бүрэн төвлөрүүлсэн байх		4,000.0	10,855.3	Төсвийн орлогын төлөвлөгөөг батлагдсан хуваарийн дагуу бүрэн төвлөрүүлсэн.
20	**САНГИЙН САЙД**					**3,100,293.6**	**2,828,126.6**	
	20.1	**Санхүү, төсвийн нэгдсэн удирдлага**				**2,953,713.7**	**2,695,201.8**	
		20.1.1	Монгол Улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв болон Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тухай хуулийн төсөл боловсруулж, өргөн мэдүүлэх, хэлэлцүүлэх	Хуульд заасан хугацаа, төсвийн тусгай шаардлагад нийцсэн байх	Хуульд заасан хугацаа, төсвийн тусгай шаардлагад нийцүүлэн боловсруулж, өргөн мэдүүлсэн.	2,953,713.7	2,695,201.8	Монгол Улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Хүний хөгжил сангийн төсөв болон Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тухай хуулийн төслийг хуульд заасан хугацаанд боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.
	20.2	**Татвар хураалт, орлого бүрдүүлэлт**				**146,579.9**	**132,924.8**	
		20.2.1	Улс, орон нутгийн төсөвт орох татварын орлогын төлөвлөгөөний биелэлт /хувиар/	75	86.2			COVID-19-ийн цар тахлын хөл хорионы улмаас бизнесийн идэвхжил саарч Экспортын гол нэрийн эрдэс бүтээгдэхүүний экспортын хэмжээ зэс 3.7 мянган тонноор, нүүрс 0.3 сая тонноор, төмрийн хүдэр 1.6 мянган тонноор, цайр 56.5 мянган тонноор тус тус буурсан төсвийн орлогын гүйцэтгэлд шууд нөлөөлсөн.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
		20.2.2	Өмнөх онуудын тайлангаар ногдуулсан татварын өр барагдуулалт /хувиар/	75	60.61	49,818.90	46,474.70	Өр барагдуулалт өмнөх оны мөн үеэс буурсан шалтгаан нь дараах 4 хүчин зүйл нөлөөлсөн. Үүнд: 1. Дэлхий нийтийг хамарсан "COVID-19" цар тахлын улмаас Монгол улсын ЗГ-ын 30,62,64 дугаар тогтоол гарч Улсын хэмжээнд БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГТ ШИЛЖҮҮЛЭХ ажлыг шат дараалан авсантай холбоотойгоор боловсруулах үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа эрхлэгчийн борлуулалтын орлого-56.7%, Бөөний болон жижиглэнгийн худалдаа -62.8%, мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн -45.8%, уул уурхай, олборлолт94.8%-иар хувиар буурсан. 2 .Монгол Улсын Засгийн газраас 2020 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 161 дүгээр тогтоол, Татварын ерөнхий газрын Гамшгийн удирдлагын багийн хурлын шийдвэр, Сангийн яамнаас өгсөн чиглэлийн дагуу татварын алба бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжин ажиллаж, бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанаас өмнө татварын өр хураах зорилгоор битүүмжилсэн 5,153 татвар төлөгчийн арилжааны 12 банканд байршсан 257.9 тэрбум төгрөгийн 31,630 дансны битүүмжлэлийг цуцлах ажиллагаа хийгдсэн. 3. Мөн Хувь хүний орлогын албан татвараас чөлөөлөх тухай хууль"-ийн дагуу 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд төрийн албан хаагчийн, төрийн өмчийн их, дээд сургуулиас бусад төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдэд ажилладаг хувь хүний, мөн гадаад улс, олон улсын байгуллагын зээл, тусламжийн эх үүсвэрээр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын ажлыг хийж гүйцэтгэх тендерт шалгарч, тус ажлыг хийж гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд ажилладаг хувь хүний зөвхөн уг ажилтай холбоотой олсон орлогоос бусад цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг хувь хүний орлогын албан татвараас чөлөөлсөн нь татвар, төлөлт хамрагдалтад шууд нөлөөлсөн байна. 4. 2020 оны 01 дүгээр сарын 01-ээс мөрдөгдсөн шинэ Татварын ерөнхий хуульд заасан татвар хураах үйл ажиллагаг хэрэгжүүлэхэд зарим тохиолдолд албан хаагч нарт хууль эрх зүйн мэдлэг дутмаг мөн практик алдаа гаргах зэрэг нь нөлөөлсөн.
		20.2.3	Өмнөх онуудын хяналт шалгалтаар ногдуулсан өр барагдуулалт /хувиар/	62.5	29.24			
		20.2.4	Тайлант хугацааны татварын тайлангийн ногдол, өр барагдуулалт /хувиар/	90	80.35			
		20.2.5	Тайлант хугацааны хяналт шалгалтын ногдол, өр барагдуулалт /хувиар/	75	48.99			
		20.2.6	Татварын цахим тайлан авалт /хувиар/	89.5	79.63			1. ААНОАТ-ын тайланг 2019 онд 157,9 мянган тайлан ирүүлэхээс 107,5 мянган тайлан ирүүлж ирц 65.9 хувьтай байсан бол 2020 онд 197,9 мянган тайлан ирүүлэхээс 129,8 мянган тайлан ирүүлж тайлангийн ирц 67 хувьтай байна. 2. 2020 онд ТТ-11 тайлангаар 194110 тайлан ирүүлэхээс 132330 тайлан ирүүлж 68,2 хувьтай байна. 3. АМНАТ тайланг 2020 оны 04-р улиралд 1097 тайлан ирүүлэхээс 1070 тайлан ирүүлж тайлангийн ирц 97 хувьтай байна. 4. ОАТ-ын тайланг 2020 онд 61 тайлан ирүүлэхээс 60 тайлан ирүүлж 98 хувьтай байна.
		20.2.7	Татварын зөрчлийн бууралт /хувиар/	6.3	26.2			Оюутолгой ХХК-г хяналт шалгалтад хамруулснаар зөрчлийн дүн өссөн. 2019 онд 2,825,713.8 сая төгрөгийн, 2020 онд 10,764,971.0 сая төгрөгийн зөрчил илрүүлсэн. 2020 онд зөрчлийн дүн 26.2 хувиар өссөн.
		20.2.8	Алдагдалтай буюу "Х" тайлан тушаалтын бууралт /хувиар/	0.6-1.0	5.5			1. ААНОАТ-ын тайлангаар Х болон алдагдалтай тайлангийн үзүүлэлт буураагүй шалтгаан нь 2020 оноос эхлэн төрийн бус байгуллага, сургууль, цэцэрлэг,эрүүл мэндийн байгуллага, СӨХ, сан, шашны байгуллагыг ААНОАТ-ын төрлөөр бүртгэж тайлан ирүүлж эхэлсэн. Мөн халдварт цар тахал ковидтой холбоотой үйл ажиллагаа доголдсонтой холбоотой байна. 2. Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн хугацаа /30 жил/, анхны хөрөнгө оруулалт өндөр дүнгээр хийгдэг тул үйл ажиллагаа явуулж, олборлолт хийж байгаа ААН-ээс бусад нь "Х" тайлан ирүүлж байна.
		20.2.9	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөгчийн баазыг нэмэгдүүлэх /хувиар/	2.5	7.8			Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөгчийн баазыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2019 оны жилийн эцсийн байдлаар татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй байсан ААНОАТ-ын төрлөөр бүртгэлгүй төрийн бус байгуллага, цэцэрлэг,эрүүл мэндийн байгуллага, СӨХ, сан, шашны байгуллагын тоог нэмэгдүүлсэн тооноос хасаж тооцсон дүнгээр 2020 онд 16647 аж ахуйн нэгжийг нэмж бүртгэсэн.
		20.2.10	Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчийн баазыг нэмэгдүүлэх /хувиар/	8	1.6			1. 2019 оны жилийн эцэст 39537 татвар төлөгч НӨАТ суутган төлөгчөөр бүртгэлтэй байснаас 2020 онд 5737 татвар төлөгчийг шинээр бүртгэн, 5011 татвар төлөгчийг хассан үзүүлэлттэй ажилласан. Үүнд: Үйл ажиллагаа явуулдаггүй, татварын төлөлт хийгдэггүй, чанаргүй татвар төлөгчдийг бууруулах зорилгоор ТЕГ-ын ЭҮГ-аас ирүүлсэн жагсаалтын дагуу 2020 оны 06 дугаар сарын 17-ны 05/2022 тоот албан бичгээр татварын албадад чиглэл хүргүүлэн, 5011 суутган төлөгчийг хасаж, НӨАТ суутган төлөгчөөр бүртгэгдвэл зохих татвар төлөгчийн судалгааг улирал бүр хүргүүлэн, нийт 5737 татвар төлөгчийг НӨАТ суутган төлөгчөөр бүртгэсэн. 2. Цахим төлбөрийн баримтын систем дэх борлуулалтын орлогын хэмжээ 50 сая болон түүнээс дээш хүрсэн татвар төлөгч нарт цахим шуудан болон бүртгэлтэй гар утсаар бүртгүүлэх анхааруулгыг тогтмол хүргүүлсэн.
		20.2.11	Бусад төрлийн татвар төлөгчийн баазыг нэмэгдүүлэх /хувиар/	2.5	6.04			1. 2020 онд 102268 иргэнийг шинээр татвар төлөгчөөр бүртгэсэн. ХХОАТ-ын татварын тайланг цахимаар хүлээн авахтай холбоотой төрийн байгуллагатай мэдээлэл харилцан солилцох, суутгагчийн тайлагнасан мэдээлэл зэргийг үндэслэн тайлангийн хавсралтын мэдээллийг дүүргэх, иргэдийг тайлангаа хэрхэн гаргах тухай 5 төрлийн шторк, 4 төрлийн тайлан гаргах видео хичээлийг түгээн сурталчилснаар 258764 тайлан хүлээн авсан. 2. АМНАТ -ын бааз суурийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд дамжуулан борлуулагчийг татварт хамруулах зорилгоор ашигт малтмалын дотоодын борлуулалтад ашигт малтмалын төлбөрийн баримтыг ашиглах загварын төслийг боловсруулан 2021 оны 04 сарын 07-нд Сангийн яамны нягтлан бодох бүртгэлийн газарт албан бичиг хүргүүлсэн.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
		20.2.12	Эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналт шалгалтын үйл ажиллагааны хэрэгжилт /хувиар/	62	55	96,760.97	86,450.11	Эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналт шалгалтын үйл ажиллагааны хэрэгжилт /хувиар/ 62.0 Монгол Улсын УИХ-ын чуулганаар 2020 оны 08 дугаар сарын 28-нд батлагдсан “Монгол улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2021-2022 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулиар 2020 онд гаалийн байгууллага Улсын төсөвт 3024.6 тэрбум төгрөгийг төвлөрүүлэх бүюу 471.7 тэрбум төгрөгөөр бууруулан тодотгосон. Гаалийн байгууллага нь улсын төсөвт 2020 оны жилийн эцсийн байдлаар 3024.6 тэрбум төгрөгийн орлого улсын төсөвт оруулах төлөвлөгөөтэйгөөс урьдчилсан байдлаар 2891.8 тэрбум төгрөг оруулж, гүйцэтгэл нь 95.6 хувийн гүйцэтгэлтэй байна. Гаалийн байгууллага нь Сангийн яаманд ХБГ-ийг бодит тооцоолол дээр үндэслэн 2968.45 тэрбум төгрөгийг төвлөрүүлэх тухай Гаалийн ерөнхий газрын 2020 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн 01/2997 албан бичгээр хүргүүлсэн. Нийт импорт 5371.1 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 8.8 хувиар буурсан. Экспортын бууралт Улсын онцгой комиссын 2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 4 дүгээр хуралдаанаар Монгол, Хятадын хилийн авто замын боомтуудаар нүүрс тээвэрлэлтийг 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийг хүртэл хугацаанд зогсоож, холбогдох арга хэмжээг авах шийдвэр гарсан тул экспортоор гаргасан нүүрсний тоо хэмжээ 2020 онд 28.58 сая тонн экспортолсон нь өнгөрсөн оны мөн үеэс 22.4 хувиар буурсан. /COVID 19/ цар тахлын тархалтыг сааруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газрын шийдвэр, Улсын онцгой комиссын шийдвэрийг тус тус үндэслэн 2020 оны сүүлийн 2 сард нийт 80.0 тэрбум төгрөгийн орлого буурсан үзүүлэлттэй байна. 2020 оны гаалийн хяналтын төлөв улаан төлөвт 44.64%, улбар шар төлөвт 29.90%, ногоон төлөвт 25.46% сонгогдсон. Бараанд хийх шалгалтаас чөлөөлсөн хувь хэмжээ 55.36% байна. 2020 оны коронавируст цар тахлын улмаас гаалийн бүрдүүлэлт 21% буурсан үзүүлэлттэй байна.
		20.2.13	Худалдааг хөнгөвчилж, гаалийн бүрдүүлэлтэд зарцуулах хугацааг бууруулах /хувиар/	5	Үнэлэх боломжгүй			Худалдааг хөнгөвчилж, гаалийн бүрдүүлэлтэд зарцуулах хугацааг бууруулах /хувиар/ 5.0 Гаалийн бүрдүүлэлтийн цаг хугацааг бууруулах арга хэмжээ авах, гаалийн хяналт, бүрдүүлэлтийн цаг хугацааны хэмжилтийг боловсронгуй болгох судалгаг хийж, үр дүнг тооцох, ачилтын мэдээллийг урьдчилан авч эрсдэл тооцох, гаалийн хяналтыг оновчтой зохион байгуулж, өндөр эрсдэл бүхий ачилтыг онилох зорилгоор Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн А/90 дүгээр тушаалаар “Гаалийн бүрдүүлэлтэд зарцуулагдаж буй цаг хугацааны судалгааг зохион байгуулах” ажлын хэсэг байгуулагдан ажиллаж, Дэлхийн банк группийн Олон улсын санхүүгийн корпорацын дэмжлэгтэйгээр амжилттай хэрэгжүүлсэн. Гааль болон мэргэжлийн хяналтын байгууллагуудын гүйцэтгэлийг сайжруулахад чиглэсэн мэдээллийг цуглуулах, түүнд үндэслэн холбогдох санал, зөвлөмж гаргах, шуурхай ажиллагааны горимыг тодорхойлох, түүнийг сурталчлах, улмаар худалдааг хөнгөвчлөх үйл явцыг гүнзгийрүүлэх зорилготой. “Бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгаа” хийсний үр дүнд программын жинлэсэн дундаж аргачлалаар дараах хугацааг автозам, агаар, төмөр замаар тус тус тооцоолж гаргасан. Бүрдүүлэлтийн цаг хугацааны судалгааны явцад цугларсан мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд, бараг экспортлох, импортлоход хилийн боомт болон гүний терминалд хяналтын байгууллагуудаас хэрэгжүүлэх үйл ажиллагааны давхардал, бараг гаалийн хяналтын бүсэд оруулж, гаргахад хүний хүчин зүйлээс хамааралтай гараар хийгдэг ажиллагаанууд, төрөл бүрийн зөвшөөрөл, шаардлагууд зэрэгт ихээхэн цаг хугацаа зарцуулагдсан байна. Судалгааны тайланг үндэслэн, хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулсан, арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлсэн байна. “Гаалийн бүрдүүлэлтэд зарцуулах цаг хугацааны судалгааны 2019 оны тайлан”-д 2 багц зөвлөмж өгсөн байна. Гаалийн ерөнхий газраас боловсруулж байгаа “Гаалийн байгууллагын 2021-2024 оны стратеги төлөвлөгөө”-ний төсөлд дээрх зөвлөмжид тусгасан чиглэлүүдээр үйл ажиллагаагаа төлөвлөн ажиллаж байна. тогтоол, шийдвэрүүдийн дагуу ялангуяа автозамын хилийн боомтуудаар нэвтэрч байгаа тээврийн хэрэгслийн жолооч нарыг шинжилгээнд хамруулах, бараа, тээврийн хэрэгсэлд гадаргуугийн ариутгал хийх, цагдаагийн хамгаалалтад тээвэрлэлт гүйцэтгэх зэрэг арга хэмжээг хилийн боомтод авч хэрэгжүүлж байгаа тул гаалийн бүрдүүлэлтэд зарцуулах цаг хугацаа тодорхой хэмжээгээр өсөж байна.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
		20.2.14	Гаалийн хууль тогтоомжийн зөрчил илрүүлэлтийг нэмэгдүүлэх /хувиар/	5	Үнэлэх боломгүй			1. Гаалийн байгууллага нь 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 944 зөрчил илрүүлсэн. Дээрх зөрчилд 1 тэрбум 408.4 сая төгрөгийн торгууль ногдуулж, 1 тэрбум 989.3 сая төгрөгийн татварыг нөхөн төлүүлсэн байна. Зөрчлийн улмаас улсын орлого болж хураагдсан бараа эд зүйлийн үнэ 130.1 сая төгрөг /үүнээс үнийн дүнг гаргуулсан 18.78 сая төг/, зөрчлийн хэрэг бүртгэл болон эрүүгийн шинжтэй хэргийн улмаас түр хураагдсан 11.83 сая төгрөг, харьяаллын дагуу шилжүүлсэн барааны үнэ 56.1 сая төгрөг болсон байна. Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын тархалттай холбогдуулан улсын хилээр нэвтрэх зорчигчийн хөдөлгөөнийг хязгаарласан тул Гаалийн байгууллагын хэмжээнд илрүүлсэн зөрчлийн тоо өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад буурсан ерөнхий үзүүлэлттэй байна. 2. 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газар нь Гаалийн ерөнхий газрын даргын баталсан 66 удирдамжийн дагуу гаалийн харилцаанд оролцогч хуулийн этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн бичиг баримтад бүрдүүлэлтийн дараах шалгалтыг хийсэн. Мөн 2019 онд Удирдамж батлагдсан 7 аж ахуйн нэгжийн шалгалт он дамжин 2020 онд дуусан. 2020 онд шалгасан нийт 68 аж ахуйн нэгжийн шалгалтаас 47 аж ахуйн нэгжийн шалгалтын үр дүнд 4 971 323 589 төгрөгийн зөрчил илрүүлж, 879 943 860 төгрөгийн нөхөн татвар, 250 225 628 төгрөгийн торгууль буюу нийт 1 130 169 488 төгрөгийн нөхөн татвар, торгууль ногдуулсан. 2019 онд Удирдамж батлагдсан 7 аж ахуйн нэгжийн шалгалт он дамжин 2020 онд дуусан. 2010-2019 онуудад хийгдсэн шалгалтаар зөрчил илэрсэн аж ахуйн нэгжээс 641.8 сая төгрөгийг барагдуулан улсын төсөвт төвлөрүүлсэн, Гаалийн харилцааны оролцогч аж ахуйн нэгж, иргэн, байгууллага гаалийн байгууллагад нөхөн бүрдүүлэлт хийлгэх хүсэлт гаргасан байдлыг үндэслэн 78 аж ахуйн нэгж, иргэнд 470 гаалийн мэдүүлгээр 21.8 сая ам долларын статистик үнийн дүнтэй, 60 801.0 сая төгрөгийн суурь үнэлгээтэй бараанд гаалийн нөхөн бүрдүүлэлт хийсэн. 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар бүрдүүлэлтийн дараах шалгалтын газраас нийт 11 058.6 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн.
21	**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД**					**605,191.7**	**621,116.0**	
	21.1	**Эрх зүй, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын удирдлага зохицуулалт**				**14,221.3**	**26,312.2**	
		21.1.1	Боловсруулах баримт бичиг, хуулийн төслийн тоо	35	19	2,291.8	1,991.0	УИХ-д өргөн мэдүүлж батлуулсан хууль 11, үүнд шинэчилсэн найруулгыг батлуулсан хууль 2 (Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хууль, Архивын тухай хууль), нэмэлт өөрчлөлт оруулж батлуулсан хууль 9 (Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөллийг бууруулах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай), Боловсруулалтын шатанд байгаа хууль 8, үүнд УИХ-д өргөн мэдүүлсэн хууль 4 (Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Патентын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Зохиогчийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл), Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн хууль 4 (Захирагааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Менгөн зээлийн үйл ажиллагаат зохицуулах тухай хуулийн төсөл, Хууль зүйн туслалцааны тухай хуулийн шинэчилсэн найруулга, Архидан соргуурахтай тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга) байна.
		21.1.2	Хянах эрх зүйн актын тоо	1000	1627	1,965.4	1,712.3	Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2020 онд 340 эрх зүйн акт хянаж бүртгэсэн байна. Хууль тогтоомжийн санд буюу "Төрийн мэдээлэл" сэтгүүлд хийсэн нэмэлт, өөрчлөлт 1,287 эрх зүйн акт байна.
		21.1.3	Сэтгэл зүйн анхан шатны болон мэргэжлийн сургалтад хамрагдан архины хамаарлаас гарах иргэний тоо	2000	2107	2,889.5	2,889.2	Зөрчлийн тухай хуулийн 14.7.5 дахь заалтын дагуу албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулсан 745 иргэнийг ШШГЕГ-ын харьяа Баривчлах төвд, 643 иргэнийг Баривчлах байранд сургалтад хамруулсан. Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуулийн дагуу ШШГЕГ-ын харьяа Согтуурах, мансуурах донтой өвчтөнийг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газарт 719 хүнийг 3-6 сарын хугацаатай хүмүүжүүлж 7 хоногт 2 удаагийн давтамжаар нийт 96 удаагийн сургалтад хамруулсан байна.
		21.1.4	**Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлттэй тэмцэх хүрээнд :**					
		21.1.4.1	Тусламж үйлчилгээ, сэтгэл зүйн зөвлөгөөнд хамрагдах хүний тоо	150	129	220.9	217.1	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд 2020 оны байдлаар хэвтэн эмчлүүлсэн болон амбулаторийн үйлчилгээ авсан, мөн 1800-2000 дугаар тусгай дугаарын утсаар донтох эмгэгийн чиглэлээр129 иргэн үйлчлүүлсэн.
		21.1.4.2	Сургалт, семинарт оролцох хүний тоо	150	805			Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 209, замын цагдаагийн 296 алба хаагчид, ЕБС-ийн болон яаралтай тусламжийн 300 эмч нийт 805 хүн мэргэшүүлэх сургалт зохион байгуулсан
		21.1.4.3	Сурталчилгаа хүрэх хүний тоо /мянгаар/	110	180			Эрсдэл ихтэй Өмнөговь аймгийн Гашуун сухайт, Дорноговь аймгийн Замын Үүд, Сэлэнгэ аймгийн Алтанбулаг болон Орхон аймгийн Баян-Өндөр суманд олон нийт рүү чиглэсэн хор хөнөөлийг таниулах ёдерлөгийг зохион байгуулж 180 гаруй хүнд хүргэсэн.
		21.1.5	**Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд:**					

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
		21.1.5.1	Тусламж үйлчилгээ, сэтгэл зүйн зөвлөгөөнд хамрагдах хүний тоо	1000	61	90.5	85.0	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба, Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага, Хүйсийн тэгш эрхийн төв, Гадаад харилцааны яамнаас хамтран Гадаад улсад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон 18 эмэгтэйг эх оронд нь эргүүлэн авчрах, тусгаарлалтын зардал, дотоодод энэ төрлийн гэмт хэргийн хохирогч гадаад 3, Монгол 40 хохирогчид өмгөөллийн, эрүүл мэндийн, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулсан.
		21.1.5.2	Сургалт, семинарт оролцох хүний тоо	100	70			Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагаас “Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ хамтран хэрэгжүүлэх нь” семинар цагдаа, шүүх, прокурор, хил хамгаалах, гадаадын иргэн, харьяатын байгууллагын 30 алба хаагч, Хүйсийн тэгш эрхийн төв ТББ-аас “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг олж тогтоох, хамгаалах, туслалцаа үзүүлэх цахим сургалт” хилийн чанад дахь дипломат төлөөлөгчийн газрын консулын 40 ажилтан хамрагдсан.
		21.1.5.3	Сурталчилгаа хүрэх хүний тоо /мянгаар/	40	65			Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх агуулга бүхий соён гэгээрүүлэх арга хэмжээг Хүйсийн тэгш эрхийн төв ТББ-аас зохион байгуулсан мэдээлэл, видео материалыг цахимаар үзсэн 65 мянган үзэгч байна.
		21.1.6	**Малын хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:**			716.8	630.4	
		21.1.6.1	Сургалт, семинарт оролцох хүний тоо	400	194			Монголын нутгийн удирдлагын холбоо” ТББ-тай хамтран Архангай, Баянхонгор, Хөвсгөл, Өвөрхангай, Булган, Төв, Говь-алтай, Сэлэнгэ, Орхон аймгийн 194 сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нарт “Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд нутгийн захиргааны байгууллагын үүрэг, оролцоо, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэдийг татан оролцуулах нь” сэдвээр сургалт зохион байгуулаа.
		21.1.6.2	Сурталчилгаа хүрэх хүний тоо /мянгаар/	20	50			NTB - телевизээр Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, Малчдын бүлэг зохион байгуулах, Малчдад хууль эрх зүйн боловсрол олгох 4 удаагийн нэвтрүүлгийг давталттайгаар олон нийтэд хүргэсэн нь 50 мянга гаруй хүнд хүрсэн гэж үзэж байна.
		21.1.7	**Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:**					
		21.1.7.1	Сургалт, семинарт оролцох хүний тоо	700	5825			Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн этгээдэд шүүхээс ШШГЕГ-ын харьяа Баривчлах байранд Зан үйлд нөлөөлөх сургалтын танхим, сургалтын хөтөлбөр, гарын авлага сургалтад 5825 хүн хамрагдсан.
		21.1.7.2	Сурталчилгаа хүрэх хүний тоо /мянгаар/	40	2300			НҮБ-ын Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аяныг 2020 онд дэлхийн улс орнууд "Өрх гэр, ажлын байр, олон нийтийн газарт: Яг одоо жендерт суурилсан хүчирхийллийг цэглэе!" уриан доор зохион байгуулсан. Тус аяныг 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн Засгийн газрын хуралдааны үеэр Монгол Улсын Ерөнхий сайд нөхөж, Жендерийн үндэсний хороо, бүх яамд, агентлаг, 21 аймаг, нийслэл, 9 дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргаар ахлуулсан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийг оролцуулсан Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн “Яг одоо” аяныг улсын хэмжээнд цахимаар зохион байгуулснаар 2.3 сая хүний хандалттай байна.
		21.1.8	**Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:**					
		21.1.8.1	Сургалт, семинарт оролцох хүний тоо	500	134			Байгаль, зэрлэг амьтдыг хамгаалах нийгэмлэг (WCS)-ийн Монгол дахь төлөөлөгчийн газартай хамтран “Зэрлэг амьтад, тэдгээрийн эд эрхтэн, бүтээгдэхүүний хил дамнасан хууль бус худалдаат бууруулах боломж” сэдэвт цахим сургалтын удирдамж, хөтөлбөрийг боловсруулан, Ажлын албаны даргаар батлуулан, 2020 оны 10 дугаар сарын 19,20-ны өдрүүдэд, Олон улсын сургагч багш нар сургалтыг зохион байгуулж, цагдаа, хил, гаалийн **18** алба хаагч хамрагдлаа. Дэлхийн Байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газартай хамтран “Зэрлэг амьтны эд эрхтэн, бүтээгдэхүүний хил дамнасан хууль бус худалдаа, түүний илрүүлэлт, хяналт, хамтын ажиллагааг сайжруулах нь” сэдэвт хөдөлгөөнт сургалтын удирдамж, хөтөлбөрийг боловсруулан Говь-алтай аймгийн Бургастай, Ховд аймгийн Булган, Баян-өлгий аймгийн Цагааннуур, Увс аймгийн Боршоо, Завхан аймгийн Арц-суурийн хилийн боомтод үүрэг гүйцэтгэж байгаа хил, гааль, мэргэжлийн хяналтын алба хаагчдад 2020 оны 09 дүгээр сарын 29-ны өдрөөс 10 дугаар сарын 09-ны хооронд УЕПГ, ДХИС, ГЕГ, ХХЕГ-ын сургагч багш нарын хамт сургалтыг зохион байгуулж, 116 алба хаагчид хамрагдлаа

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
		21.1.8.2	Сурталчилгаа хүрэх хүний тоо /мянгаар/	50	5,603.9			Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэргийн хор уршгийг иргэд, олон нийтэд таниулах, тэдний эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх зорилгоор "Байгалиа хамгаалъя" нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан, 2020 оны 04 дүгээр сарын 15-наас 05 дугаар сарын 15-ны хооронд зохион байгуулав. Дэлхийн Байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газраас Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээлэл авах утасны жагсаалт, Амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний хууль бус худалдааны хохирогч болохоос урьдчилан сэргийлье, Байгалийн ургамал, тэдгээрийн үр, эрхтний хууль бус худалдааны хохирогч болохоос урьдчилан сэргийлье зэрэг 45,000 ширхэг сурталчилгааны тараах материалыг ЦЕГ, Экологийн цагдаагийн албатай хамтран бэлтгэж хэвлүүлэн, иргэд, олон нийтэд тараалаа. "Байгалиа хамгаалъя" нэгдсэн арга хэмжээний хүрээнд MYOHPT, Mongol HD, ETV, Eagle, TV9, TV8, TV5, C1 телевиз зэрэг нийт 20 телевизийн "Зочны цаг", "Өглөө" нэвтрүүлэг, "Тодруулга" буланд 10 удаагийн ярилцлага, 12 сурвалжилга мэдээ өгч, сайтад ярилцлага 7, мэдээ, нийтлэл 14, лайв 2, подкаст 2-ыг бэлтгэн давхардсан тоогоор 36 сайтад давхардсан тоогоор 104 удаагийн мэдээ, мэдээлэл нийтлэл өгч, ФМ радиогоор цагийн мэдээ 4340, шторк 2790, нэвтрүүлэг 60 удаа эфирт цацагдаж, 56,000 ширхэг санамж, сэрэмжлүүлэг, ухуулгын хуудас бэлтгэн тарааж, видео шторк 15, бүтээлч постер 47 постер бэлтгэн байршуулж, олны танил 24 хүнийг аянд нэгдүүлэн уриалга гаргуулан, нийгмийн цахим сүлжээнд байршуулснаар 5,603,909 хүнд хүрсэн.
		21.1.9	**Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр:**					
		21.1.9.1	Боловсруулах баримт бичиг, стандарт, хөтөлбөрийн тоо	2	1			Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр боловсруулахаар 1 судалгааны ажил хийгдсэн
		21.1.9.2	Сургалт, семинарт оролцох хүний тоо	100	100			Мэдээллийн аюулгүй эсрэг гэмт хэрэг мөрдөх арга зүй сургалтад цагдаагийн энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүргийн 100 алба хаагчид болон прокуроруудыг хамруулсан.
		21.1.9.3	Сурталчилгаа хүрэх хүний тоо /мянгаар/	80	120			Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба үзүүлж байна "Сэргийлэгч" нэвтрүүлгийн дугаараар цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх агуулгатайгаар бэлтгэн олон нийтэд хүргэсэн 120 мянган хүний хандалттай.
	21.2	**Цагдаа**				**233,145.9**	**240,440.4**	
		21.2.1	Хэргийг хэрэг бүртгэлт явуулж эхэлснээс хойш хуулийн хугацаанд шийдвэрлэх хувь	80	93.2	233,145.9	240,440.4	Цагдаагийн байгууллагад 2020 онд нийт 43,339 хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулснаас 25,788 хэргийг шийдвэрлэсэн. Үүнээс 24,958 хэрэг буюу 93.2 хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэж, прокурорын байгууллагад хүргүүлжээ.
		21.2.2	Эрэн сурвалжлагдаж байгаа хүн, эд зүйлийн илрүүлэлт /хувиар/	50	76.6			Нийт 27,732 эрэн сурвалжлалтыг зарласнаас 21,254 олж тогтоон эрэн сурвалжлалтыг зогсоож, илрүүлэлтийг зогсоож, илрүүлэлт 76.6 хувьтай байгаа нь урьд оны мөн үеэс 9.18 хувиар өссөн байна
		21.2.3	Хэрэг илрүүлэлт /хувиар/	50	51.9			Засгийн газрын 2018 оны "Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үзүүлэлтүүд" 55 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтын дагуу Цагдаагийн байгууллагын хэмжээнд гэмт хэргийн илрүүлэлтийн талаар судалгаа хийж, одоогийн Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн 2017 оны 07 дугаар сараас хойших хэргийн илрүүлэлтийн тоо баримт, судалгаанд үндэслэн статистикийн энгийн аргачлалаар бодож үзэхэд жил бүр хэргийн илрүүлэлт 0.4-8.9 хувиар өссөн байна. Улсын хэмжээнд 51.9 хувь, нийслэлд 48.3 хувь, орон нутагт 59.2 хувь байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс улсын хэмжээнд 7.0, нийслэлд 9.4, орон нутагт 2.3 нэгжээр тус тус өссөн байна. 2020 онд хэрэг бүртгэлтийн 17,666 хэрэг нээн шалгасан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 11,750 хэрэг буюу 3.9 хувиар, үүнээс 9161 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 4,049 буюу 30.7 хувиар тус тус буурчээ.
		21.2.4	Гэмт хэрэг, захиргааны зөрчил, гал түймэр, гамшиг, осол, эмнэлгийн яаралтай тусламжийн талаар хангасан бодит мэдээллийн хувь	90	100			2020 онд гэмт хэрэг, зөрчлийн 541,910, галт түймэр, гамшиг ослын 4,409, эмнэлгийн 277,393 нийт 82,3712 дуудлага, мэдээллийг хүлээн авч, холбогдох нэгж, байгууллагад 100 хувь дамжуулж, яаралтай тусламж үзүүлжээ.
		21.2.5	Гэрч, хохирогчийн хамгаалалт /хүний тоо/	70	101			Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийн дагуу 101 гэрч, хохирогч хамгаалсан.
		21.2.6	Шүүхийн байрын хамгаалалт /хувиар/	100	90			Хууль зүй, дотоод хэргийн сайд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2016 оны А/40, 113 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Шүүх, шүүгчийн аюулгүй байдлын хангах журам"-д заасны дагуу шүүхийн байны хамгаалалтыг 90 хувьд, шүүх хурлын танхимын хамгаалалтыг 90 хувьд, шүүгчийн хамгаалалтыг 85 хувьд хүргэн ажиллалаа. Албадан иргүүлэх шүүгчийн захирамжтай иргэдийн 85 хувийг
		21.2.7	Шүүх хурлын танхимын хамгаалалт /хувиар/	100	90			
		21.2.8	Шүүгчийн хамгаалалт /хувиар/	100	85			
		21.2.9	Шүүгчийн захирамжаар албадан авчрах /хувиар/	85	85			
	21.3	**Хил хамгаалалт**				**156,491.2**	**156,490.1**	
		21.3.1	Хилийн зөрчлийн илрүүлэлт, шийдвэрлэлт /хувиар/	90.2	95.8			Монгол Улсын хилд 34 удаагийн хилийн дэглэмийн, 138 удаагийн хил орчмын дэглэмийн зөрчил гарсныг илрүүлж, илрүүлэлт 94.6, шийдвэрлэлт 97.0 хувьтай байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хилийн дэглэмийн зөрчил 63.6, бэлчээрээр мал хил давсан хилийн дэглэмийн зөрчил 62.0, бэлчээрээр мал хилд тулсан хил орчмын дэглэмийн зөрчил 16.2 хувиар буурч, хил орчмын дэглэмийн зөрчил 2.2 хувиар өссөн.
		21.3.2	Буйр нуурын усан хилийн хамгаалалтыг хөнгөн хөлөг, тусгай зориулалтын техник, хэрэгслээр хангаж, хил хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлэх /хувиар/	91	100			"Буйр нуурын усан хилийн хамгаалалтын дэд хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Хилийн 0306 дугаар ангийн 0219 дугаар салбар /Буйр/, 0321 дугаар салбар /Булан дэрс/-уудын усан хилийн инженерийн байгууламж хөвөгч усан зогсоолд хамгаалалтын олс хийж ашигласнаар хил хамгаалалтын нягтрал нэмэгдсэн.
		21.3.3	Ховд аймгийн Булган сумын нутагт хилийн застав шинээр байгуулж хилийн 0130 дугаар ангийн хил хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлэх /хувиар/	94.2	100			Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 100 дугаар тогтоол, ЗХЖШ-ын даргын 2020 оны н/27 дугаар тушаалыг үндэслэн ХХЕГ-ын даргын 2020 оны мн/14 дүгээр тушаалаар хилийн 0130 дугаар ангийн "Баянмод"-ны заставыг 2020 оны 04 дүгээр сарын 27-ны өдрөөс улсын хил хамгаалалтад шилжүүлснээр хил хамгаалалтын нягтрал нэмэгдсэн.
		21.3.4	Монгол Улсын хуурай газрын хилийн хэсгийг /7351.6 км/ инженерийн байгууламжаар техөөрөмжлөх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх /хувиар/	12.4	11.3			Хилийн 0108, 0129, 0131, 0146, 0184, 0198, 0306, 0132, 0275, 0287, 0243, 0245, 0311, 0277 дугаар ангиудын хилийн хэсэгт нийт 200.1 км торон саад, 5 ш хянах цамхаг, 784.5 км мөр хянах зурвас, 510.4 км туймрээс хамгаалах зурвас сэргээн засварлаж, шинээр 35.9 км нүхэн саад, 12.3 км хамгаалалтын хашаа, 3 ш хянах цамхаг байгуулж нийт ажлын гүйцэтгэлт 91 хувьтай хэрэгжсэн.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
		21.3.5	Хилийн манааг албаны нохойтой үүрэг гүйцэтгүүлэх зорилгоор хилийн ангиудыг албаны нохойгоор хангах, нохойн байр сургалтын хотхоныг шинэчлэн төхөөрөмжлөх /хувиар/	8	8	156,491.2	156,490.1	Хилийн 0285, 0245, 0311, 0277, 0257, 0286, 0243, 0287, 0275 дугаар ангидад тус бүр 1, хилийн 0151 дүгээр ангид 10, нийт 19 эрлийн нохойгоор хангасан. Хилийн 0151 дүгээр ангийн нохой сургалтын төвийн үржлийн нохойн байрыг шинэчлэн төхөөрөмжилсөн.
		21.3.6	Улсын хилээр нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгслийн бүртгэл мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлж, хүний биеийн давхцахгүй өгөгдөхүүн, биометрт тулгуурласан технологийг нэвтрүүлж, хяналт шалгалтын хугацааг багасгах /хувиар/	15	5			Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон урсгал санхүүжилт олгогдоогүй. "Хилийн аюулгүй байдлын онол, түүний үндэс" шинжлэх ухаан, технологийн төслийг боловсруулж, БСШУСЯ-наар батлуулж, "Шинжлэх ухаан технологи"-ийн сангийн санхүүжилтээр хилийн шалган нэвтрүүлэх албанд хүний биеийн давхцалгүй өгөгдөлд суурилсан технологийг нэвтрүүлэх судалгаа, туршилтын ажлыг Буянт-Ухаа боомтод эхлүүлсэн.
		21.3.7	Зорчигчийн хил нэвтрэх эрхийн баримт бичгийн хуурмаглалыг илрүүлэх, гүнзгийрүүлсэн шалгалтыг олон улсын стандартын шаардлагад нийцсэн лабораториор хангах /боомтоор/	4	0			Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон төсвийн урсгал санхүүжилтэд төсөв батлагдаагүй тул хэрэгжээгүй. 2021 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын саналд тусгасан.
		21.3.8	Хилийн боомтуудыг өндөр хөгжилтэй орнуудын стандартад нийцсэн дохиолол, хяналт, хамгаалалтын нэгдсэн системээр төхөөрөмжлөх /боомтоор/	7	1			2020 оны улсын төсвийн хөрөнгө оруулалт болон урсгал төсөвт зардал батлагдаагүй. Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь төлөөлөгчийн газрын 82.2 сая төгрөгийн санхүүжилтээр хилийн Булган боомтыг "Дохиолол, хяналт, хамгаалалтын нэгдсэн систем" төхөөрөмжилсэн
		21.3.9	Хилийн боомтын аюулгүй байдлыг хангах тусгай томилгоот бүлгийг уналга, зэвсэглэл, ажиллагааны хувцас, тусгай хэрэгслээр хангах /боомтоор/	6	6			УТХО-аар худалдан авсан "Ланд Крүйзер-70" серийн загвартай автомашинуудыг Шалган нэвтрүүлэх болон боомт бүхий уулзалтын заставуудыг бүрэн хангасан. БНХАУ-ын Цагаачлалын удирдах газраас 8 төрлийн 628 ширхэг тусгай зориулалтын хамгаалалтын хувцас, хэрэгслийг тусламжаар хүлээн авч хангасан.
		21.3.10	Хилийн заставуудын барилга, байгууламжийг сайжруулах /хувиар/	25	10			Хилийн 0165 дугаар ангийн 1 дүгээр застав /арал толгой/, хилийн 0214 дүгээр ангийн 3 дугаар застав /Бургастай/, Хилийн 0129 дүгээр ангийн 3, 5 дугаар заставын гэрээт хилчний байранд урсгал засвар, хилийн 0131 дүгээр ангийн 7 дугаар застав /Гашуун сухайт/-ын 4 айлын орон сууц, хилийн 0306 дугаар ангийн 1 дүгээр застав /Буйр/-ын заставын 6 айлын орон сууц, хилийн 0132 дугаар ангийн "Хавирга" автозамын шалган нэвтрүүлэх боомтод 8 айлын орон сууц, хилийн 0275 дугаар ангийн төв болон "Өвөртогтор"-ын заставын 4 айлын орон сууц, хилийн 0243 дугаар ангийн 2, 5 дугаар заставын 4, айлын, 0287 дугаар ангийн төвд 7 айлын, нийт 38 айлын орон сууцны барилгад урсгал засвар хийсэн.
		21.3.11	Хилийн заставуудыг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хангах /заставын тоогоор/	14	14			Хилийн 0165 дугаар ангийн Даян, хилийн 0129 дүгээр ангийн Элсэн даргавай, Харагчин, хилийн 0184 дүгээр ангийн Ламт, Баян-Овоо, хилийн 0146 дугаар ангийн Халтар хошуу, Хавцал булаг, хилийн 0198 дугаар ангийн Нөмрөг, хилийн 0275 дугаар ангийн Шивийн ам, Өвөр тогтор, Ямлах, Шар ус, Тарь, хилийн 0311 дүгээр ангийн Дерээгийн застав, нийт 14 заставт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2,896.7 сая төгрөгөөр 10 кВт-ын сэргээгдэх эрчим хүч суурилуулах ажлыг хийсэн.
		21.3.12	Хөшигийн хөндийн Олон улсын нисэх онгоцны шинэ буудалд хилийн хяналт, шалгалт, хамгаалалтын барилга, байгууламж барих /тоогоор/	3	1.8			Хөшигийн хөндийн олон улсын нисэх буудалд ажиллах хилийн хяналтын байгууллагуудын нэгдсэн нэг цэгийн үйлчилгээний цогцолбор барилга /40х18м хэмжээтэй 4 давхар, зоорьтой/, автомашины дулаан зогсоол /40х14м хэмжээтэй 1 давхар/, ажилчдын дотуур байр 24,6х14,4м хэмжээтэй 2 давхар/, эрэлч нохойн усанд оруулах байр /9х15м/, эрэлч нохойн сургалтын төвийн мал эмнэлгийн байр /18х12/, эрэлч нохойн өвлийн байр /90,4 х18/ барилга угсралтын ажил 60 хувийн гүйцэтгэлтэй. Хилийн 0119 дүгээр анги Гаалийн ерөнхий газартай гэрээ байгуулан барилга угсралтын ажлыг хийж, Хил хамгаалах ерөнхий газрын Хөрөнгө оруулалт барилгын алба захиалагчийн хяналт тавин ажиллаж байна.
	21.4	**Шүүхийн шийдвэр гүйцэтгэл**				**66,855.5**	**66,736.6**	
		21.4.1	Хоригдлын хөдөлмөр эрхлэлт /хувиар/	59	67			Тайлант хугацаанд хорих ангийн үйлдвэрт 896, аж ахуй үйлчилгээнд 1680, гэрээт хэсэгт 333 хоригдол хөдөлмөр эрхэлж байна. Нийт ял эдлэж буй хоригдлын 67 хувь нь ажлын байраар хангасан. Хорих анги, байгууллагын хэмжээнд нийт 1913 хоригдол 86,506,954,489 төгрөгийн хохирол төлбөртэй байна. Үүнээс: 1048 хоригдлыг хөдөлмөрийн хөлстэй ажлын байраар хангаж хөдөлмөрийн хөлснөөс 308,639,611 төгрөг, ар гэрээс 1,265,436,995, төрийн болон төрийн бус байгууллагаас 955,000 төгрөг нийт 1,575,031,606 төлбөрийг хохирол төлбөрт шилжүүлсэн.
		21.4.2	Мэргэжлийн сургалтад хамрагдах хоригдлын тоо	350	394			Мөн оёмол бүтээгдэхүүний оёдолчин, тогооч, арьсаар гар урлалын зүйл урлаач, гагнуурчин, мужаан, бетон арматурчин, барилгын сантехникч, цахилгаанчин, засал чимэглэлчин, өрөг угсрагч мэргэжлээр 405, 407, 409, 415, 421, 423, 429, 441 дугаар хорих анги болон СМДӨАЭХХГ, Орон сууц барилгын хэсэгт мэргэжлийн сургалтыг зохион байгуулж, нийт 394 хоригдолд "Чадамжийн гэрчилгээ" олгосон. 419, 423, 433, 439 дугаар хорих ангиас орон нутаг дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, Политехникийн коллежтой хамтран уулын ажлын техникч, хүлэмж, мал аж ахуйн фермер, барилгын өрөг угсрагч, гагнуурчин, бэлэг дурсгалын зүйл урлаач, сэргээгдэх тоног төхөөрөмжийн засварчин, уурын зуухны засварчин сантехникч мэргэжлээр мэргэжлийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулж, 63 хоригдолд мэргэжлийн үнэмлэх олгож, 49 хоригдлыг үргэлжлүүлэн сургалтад хамруулж байна.
		21.4.3	Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувь /хоёр төрлийн гүйцэтгэлийн дунджаар/	49	51.7			2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 39342 гүйцэтгэх баримт бичгийн 1.6 их наяд төгрөгөөс 20323 гүйцэтгэх баримт бичгийн 381.2 тэрбум төгрөгийг биелүүлж, 19019 гүйцэтгэх баримт бичгийн 1.3 их наяд төгрөгийн үлдэгдэлтэй, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бодит биелэлт 51.7 хувьтай.
		21.4.4	Яллагдагч, хоригдлыг хуяглан хүргэх, хуяглан харгалзах /хүнээр/	5600	10568			Тайлангийн хугацаанд нийт хорих анги, байгууллагаас давхардсан тоогоор 7,383 алба хаагч 10,568 хоригдогсдыг 2190 удаагийн тэвэрлэлтээр 338,544 км зам туулж хуяглан хүргэсэн. Тэвэрлэлтийн явцад байршил тогтоогч төхөөрөмж ашиглан хяналт тавьж ажилласан бөгөөд хоригдогсдыг хуяглан хүргэх ажиллагаа, шилжилт хөдөлгөөнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад хуяглан хүргэх ажиллагааг гүйцэтгэсэн алба хаагчийн тоо 1,773-аар буюу 19.3 хувиар, хоригдлын тоо 2,817-оор буюу 21 хувиар, туулсан зам 26,883 км-ээр буюу 7.3 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
		21.4.5	Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны бодит биелэлт /хувиар/	80	58.6	66,855.5	66,736.6	1. Хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн нийт 7806 ялтны ял эдлэлтийн байдалд хяналт тавьж ажилласнаас 4576 ялтны ялыг бүрэн биелүүлж, 3230 ялтанд холбогдох хяналтын хувийн хэргийн үлдэгдэлтэй байна. Ял тус бүрээр авч үзвэл: а/ Торгох ялаар шийтгүүлсэн 4980 ялтанд холбогдох 7.1 тэрбум төгрөгийн хяналтын хувийн хэрэгт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж 3407 ялтанд холбогдох 3.2 тэрбум төгрөгийг биелүүлж, 1573 ялтны 3.9 тэрбум төгрөгийн; Торгох ялаар шийтгүүлсэн 4 хуулийн этгээдэд холбогдох 70.0 сая төгрөгийн хяналтын хувийн хэрэгт шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж, 3 хуулийн этгээдэд холбогдох 63.4 сая төгрөгийг биелүүлж, 1 хуулийн этгээдийн 6.6 сая төгрөгийн тус тус үлдэгдэлтэй байна. б/. Нийтэд тустай ажил хийлгэх ялаар шийтгүүлсэн 1421 ялтны 427864 цагийн ялыг эдлүүлэхээс 942 ялтны 316979 цагийн ялыг эдлүүлж, 479 ялтны 110885 цагийн; в/. Эрх хасах ялаар шийтгүүлсэн 1401 ялтны 868801 хоногийн ял эдлэлтийн байдалд хяналт тавьж ажилласнаар 224 ялтны 220319 хоногийн ялыг эдлүүлж, 1177 ялтны 648482 хоногийн тус тус үлдэгдэлтэй байна. Өмнөх оны мөн үеэтэй харьцуулахад хяналт тавьж ажилласан ялтны тоо 389 буюу 5 хувиар өссөн үзүүлэлттэй. 2. Албадлагын арга хэмжээ авагдсан нийт 6374 хүн, хуулийн этгээдэд хяналт тавьж, эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулснаас шүүхээс хүлээлгэсэн үүрэг, хязгаарлалтыг биелүүлж, хяналтын хугацаа дуусан 1963, харьяаллын дагуу шилжүүлсэн 112, хугацаанаас өмнө ялаас чөлөөлсэн 12, шийдвэрийг хүчингүй болгож ял оногдуулсан 51, дахин гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн 60, нас барсан 15, тайлант хугацаанд шинээр эрэн сурвалжилсан 20, бусад 2, нийт 2235 этгээд хасагдаж, 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 4138 хүн, 1 хуулийн этгээд тус тус хяналтад байна. Өмнөх оны мөн үеэтэй харьцуулахад хяналт тавьж ажилласан этгээдийн тоо 1177 буюу 18.4 хувиар өссөн үзүүлэлттэй. 3. Зөрчлийн гүйцэтгэх баримт бичгийн нийт 5.5 тэрбум төгрөгийн 1486 гүйцэтгэх баримт бичгт зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж, гүйцэтгэх баримт бичгийн бодит биелэлт 44.4 хувь, мөнгөн дүнгийн биелэлт 29.3 хувийн үзүүлэлттэй байна. Хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн нийт 7417 ялтны ял эдлэлтийн байдалд хяналт тавьж ажилласнаар 4667 ялтны ялыг бүрэн биелүүлж, 2750 ялтны үлдэгдэлтэй байна.
		21.4.6	Хорих ял эдлэгсэд болон сэжигтний амбулаторийн нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь	43	72			2020 онд 401 дүгээр хаалттай хорих анги-Нэгдсэн эмнэлэг нь хуваарийн дагуу 20 хорих анги, байгууллагад нарийн мэргэжлийн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээг зохион байгуулж ажилласан ба давхардсан тоогоор 6178 хоригдол үзлэгт хамрагдсан. Үүнээс 4467 хоригдол буюу 72 хувьд өвчлөл илэрсэн бөгөөд 13А маягтаар 991 хоригдлыг хэвтэн эмчлүүлэхээр шийдвэрлэсэн.
	21.5	**Эрх зүй, нийгмийн хэв журам, аюулгүй байдлын судалгаа, шинжилгээ**				**887.5**	**875.9**	
		21.5.1	Сургалт, сурталчилгааны тоо	200	490	887.5	875.9	Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дэмжлүүлэх үндэсний хөтөлбөр -ийн хүрээнд www.e-khutuch.mn сайтын нээлт хийж, 18 аймагт "Эрх зүйн хөтөч бэлтгэх" сургалтыг 700 хүнд, Ерөнхий боловсролын 18 сургуулийн 510 сурагчид, 3 сургуулийн эцэг эх, асран хамгаалагч нарт, Хууль зүйн чиглэлийн 5 их дээд сургуулийн 10 оюутан, 25 багш нарт, БЗД-ийн Цагдаагийн 3-р хэлтсийн 20 албан хаагч, Өмгөөлөгчдийн холбооны гишүүн 20 өмгөөлөгч нарт тус тус цахимаар зохион байгууллаа. Мөн "Иргэдийн оролцоо-2" төсөлтэй хамтран сайн дурын "Залуучуудын эрх зүйн хөтөч" бэлтгэх сургалтыг 100 хүнд хийж гэрчилгээ олгосон төдийгүй e-khutuch.mn цахим хуудсыг таниулан сурталчлахаар 3000 ширхэг гарын авлагыг хэвлүүлж, нийтийн хүртээл болгосон. Стар ТВ -ээр 5 хуулийн хүрээнд 5 удаагийн нэвтрүүлэг, Монгол HD -ТВ ээр 1 удаагийн нэвтрүүлэг тус тус цацаж нийтийн хүртээл болгосон, Монголын радио FM-106,Таны радио FM-103.6 -д тус бүр хуулийн цагтай болж тогтмол мэдээлэл цацаж байна. Шинээр батлагдсан хууль тогтоомжийг сурталчлах "Шинэ хууль" зурагт постерийг 17 хуулиар, 6 хуулиар сургалтын слайд бэлтгэж цахим орчинд нийтийн хүртээл болгосон. Нийт 17 нэр төрлийн хуулийн холбогдолтой гарын авлага, ном товхимлын эх бэлтгэж 5100 хувийг хэвлэсэн бөгөөд 4 төрлийн номын нэлтийг хийж нийтэд сурталчилсан болно. Монголын үүрэн телефон Юнител, Мобиком ХХК-уудтай хамтран Мобикомын 200,000 хэрэглэгч, Юнителийн дараа төлберт 64,500 хэрэглэгчдэд legalinfo.mn, e-khutuch.mn, 1800-1202 тусгай дугаар, Хууль Зүйн Луужин 1 фейсбүүк пэйж хуудсыг сурталчлан таниулах масс мессежийг илгээсэн. Хуулийн хүрээнд бий болж байгаа цаг үеийн мэдээлэл бэлтгэн legalinfo.mn цахим хуудсанд 115 мэдээ, twitter.com/legalinfomn 839 мэдээ,www.facebook.com/pg/legalinfomn 953 мэдээ, nli.gov.mn цахим хуудсанд нийт 75 мэдээ, twitter.com/legalinstitute 155 мэдээ, www.facebook.com/ NLInstitute 165 мэдээ тус тус оруулсан. Мөн twitter.com/legalinfomn 3626, twitter.com/legalinstitute 4625, Хууль Зүйн Луужин 1 фейсбүүк пэйж хуудас 34309 дагагчидтай, www.facebook.com/pg/legalinfomn 46950, www.facebook.com/NLInstitute 26200 хэрэглэгчидтэй болсон байна. “Хууль Зүйн Луужин 1” фейсбүүк цахим хуудсаар дамжуулан 186 иргэний асуултад хариулан хууль зүйн зөвлөгөө, мэдээллийг өгсөн. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем legalinfo.mn цахим хуудсанд 305 акт,702 хавсралт шинээр оруулсан, 1073 актыг засварласан, мөн цахим хуудасны 11312513 утсанд холбогдсон 897 санал хүсэлт, гомдлыг тухай бүрд нь шийдвэрлэн хариу өгч ажилласан байна. Монгол Улсын хуулийн англи хэл дээрх 30 албан бус орчуулгыг холбогдох байгууллагуудаас авч хэлбэржилтийг засан, www.legalinfo.mn цахим хуудаст байршуулсан.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
		21.5.2	Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тоо	30	31			ХЗҮХ-ийн төлөвлөгөөнд тусгагдсан болон захиалгат 9 судалгааны ажлыг гүйцэтгэсэн. Олон улсын 4 хурал зөвлөгөөнд цахимаар давхардсан тоогоор 10 эрдэм шинжилгээний ажилтан оролцов. Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого 2050: эрх зүйн шинэтгэл" сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг ОУУБИС-тай хамтран зохион байгууллаа. Монгол улсад зохион байгуулж буй хууль эрх зүйн онол практикийн эрдэм шинжилгээний цахим хуралд тус хүрээлэнгийн болон ДХИС, ШШГЕГ-ын албан хаагчид 7 удаагийн илтгэл хэлэлцүүлсэн. Ахмад хуульч Г.Совд, Б.Чимид нарын нэрэмжит уралдаан тэмцээнийг зохион байгуулж, шилдэг илтгэл, өгүүллийг сэтгүүлд нийтлүүлсэн. Хууль зүйн эрдэм шинжилгээний цахим номын сан бүрдүүлэх ажлын хүрээнд www.library.nli.mn домэйн нэрээр Цахим номын санг бүтээж, цахим ном зүй, ном, гарын авлага, судалгааны эмхэтгэл, эрдэм шинжилгээний сэтгүүл, хуульч эрдэмтэд гэсэн үндсэн бүлэг булан үүсгэн хөгжүүлэлтийг хийсэн төдийгүй Цахим номын сангийн "Үйлчилгээний нөхцөл"-ийн төслийг боловсруулж батлуулснаар Хууль зүйн эрдэм шинжилгээ, судалгааны сан, цахим номын сан бий болгох ажлын 20 хувийг гүйцэтгэсэн. Номын ерөнхий дансанд 104 төрлийн 209 ш шинэ ном бүртгэн ном зүйн мэдээллийг интернэтэд байршуулж уншлагад гаргаснаар давхардсан тоогоор нийт 608 уншигчид 1076 ш үүнээс гэрээр 381 ш ном, гарын авлага олгож үйлчилсэн, ХЗҮХ, номын санг сурталчлах ажлын хүрээнд Esan-үндэсний цахим санд ХЗҮХ-ийн бүтээлүүд "Хууль дээдлэх ёс", "Судалгааны тайлан" 1-6 ботийг оруулан нийтэд түгээж байна. ХЗҮХ-ийн номын сангийн Facebook хуудсанд нийт 70 удаа мэдээ, мэдээллийг бэлтгэн олон нийтэд түгээсэн.
	21.6	**Шүүхийн шинжилгээ**				**12,604.9**	**12,618.6**	
		21.6.1	Эдийн засгийн шинжилгээний дүгнэлтийн тоо	230	300	12,604.9	12,618.6	Эдийн засгийн шинжээч нь Эдийн засгийн шинжилгээ хийх журмыг мөрдлөг болгон ажиллана. - Эдийн засгийн шинжилгээнд нь эрх бүхий байгууллагын шалгалтаар тогтоогдсон төлбөр, зөрчил, дутагдал, хохирлыг тооцсон акт, дүгнэлт нь үнэн зөв эсэхийг тогтоож дүгнэлт гаргах тул шинжилгээнд ирүүлсэн санхүү, нягтлан бодох бүртгэлийн хүчин төгөлдөр, үнэн зөв, бодит анхан шатны болон НББ-ийн баримт, хураангуй ба дэлгэрэнгүй бүртгэлийг дүгнэлт гаргахад үндэслэх, шаардлагатай баримтыг ажлын баримтад хувилж авсан байна. - Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид асуугдсан асуултад хариулахаар томилогдсон шинжээч өмнө нь эрх бүхий байгууллагын баримтын шалгалтаар тогтооосон төлбөр зөрчил, хохирол, дутагдлын акт, дүгнэлт үндэслэлтэй эсэхэд санхүү, НББ-ийн холбогдох баримтад үндэслэн мэргэшсэн нягтлан бодогчийн тусгай мэдлэгийн хүрээнд шүүхийн шинжилгээний зарчмуудыг баримтлан дүгнэлт гаргана. . Шинжээч томилсон тогтоол, шийдвэрт тавьсан асуултад үнэн зөв хариулт өгч дүгнэлт гаргахын тулд өмнөх шалгалтуудаар тогтоогдсон зөрчил төлбөр, хохирол дутагдал үнэн зөв эсэхийг санхүү, НББ-ийн үндсэн баримттай тохирч байгаа эсэхийг тулган шалгаж дүгнэлтэд хохирол дутагдлыг заана. - Дүгнэлтэд хохирол дутагдал гарсан шалтгааныг нотлох баримтын хүрээнд тодорхой тусгаж, холбогдох тооцоог хавсаргах ба хариуцах эзнийг заана. Шинжээч гаргасан дүгнэлтээ ЭЗШОТБМК-ын хурлаар хэлэлцүүлж мэргэжлийн зөвлөгөө авч болно.
		21.6.2	Шүүх эмнэлгийн шинжилгээний дүгнэлтийн тоо /мянгаар/	39	37			Гадна үзлэгээр цогцсын нас, хүйс, ерөнхий төрх байдал /биеийн урт, галбир, үс, нүд, хамар, ам, чих, хүзүү, их бие, дээд доод мөчдийн ерөнхий байдал/ , цогцсын эрт ба хожуу үеийн өөрчлөлт, /хөрөлт, хөшилт, хүүрийн толбо, хаталт, ялзралт, саванжилт, занданшилт/, цогцсын гадна хэсгийн гэмтэл ба эмгэг өөрчлөлт /зулгаралт, цус хуралт, шарх, хугарал, туурал, цэврүү, гүвдрүү/, сүвнүүдээс гарсан зүйлийн өнгө, шинж байдал, цогцсын онцлог шинж /сорви, мэнгэ, үү, шивээс, хуруу, гар, хөл мухар эсэх, хиймэл шуд, гар, хөлтэй эсэх/ зэргийг тодорхойлсон байна. - Гэмтлийн зэрэг тогтоох журмын дагуу үзлэг хийж дүгнэлт гаргана. Биед үүссэн гэмтлийн элементийн төрөл, гэмтэл үүсгэсэн хүчин зүйлийг тодорхойлж, гэмтлийн зэрэг тогтоох шалгуур шинжийг үнэлж, шаардлагатай үед хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоож дүгнэлтэд тусгана. - Шаардлагатай тохиолдолд нарийн мэргэжлийн эмчийн зөвлөгөө авч оношилгооны багажийн /КТГ, MRI, рентген, эхо гм/ шинжилгээг хийлгэн хариуг үнэлж дүгнэлтэд тусгасан байна. - Хэргийн материалтай шинжээчид бүрэн танилцаж, анхны дүгнэлт гаргасан шинжээчийн акт, тухайн хүний өвчний түүх, амбулаторийн шинжилгээний хариу зэргээс шаардлагатай хэсгийг актад тусган гэмтлийн зэрэг тогтоогдоогүй үед КТГ, рентген зургийг давтан уншуулж, хохирогчийг дахин үзэх, шаардлагатай үед нарийн мэргэжлийн эмчийн зөвлөгөө авах, нас барсан тохиолдолд эд эсийн шинжилгээг давтан хийлгэж, комиссын гишүүд зөвлөн дүгнэлт гаргасан байна. - Шинжилгээний оношт тавьж дүгнэлт гаргасан байна. Гистологийн лабораторид дээж материалыг бэхжүүлэх, усгүйжүүлэх, тосгүйжүүлэх дамжлагаар боловсруулж улмаар бичил зүслэг хийн үндсэн болон шаардлагатай бол тусгай будгийн аргаар будаж шинжилгээний шилийг бэлэн болгоно. Уг материалыг эд эсийн шинжээчид шинжээч эмчийн илгээлт бичгийн хамт шилжүүлж эд эсийн шинжээч шинжилгээг хийнэ.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
	21.6.3	Криминалистикийн шинжилгээний дүгнэлтийн тоо /мянгаар/		13	16.4			Шинжээч нь криминалистикийн уламжлалт гарын мөр, мөр судлал, галт зэвсэг, гар бичмэл, гарын үсгийн болон баримт бичгийн зэрэг шинжилгээг "Криминалистикийн шинжилгээ хийх журам"-ыг мөрдлөг болгон шинжлэх ухааны үндэслэлтэй хийж, хэрэг илрүүлж, нотлоход ач холбогдол бүхий дүгнэлтийг гаргана. Улсын хэмжээний шүүхийн шинжилгээний мэдээллийн нэгдсэн болон төрөлжсөн сан ашиглах журмуудыг мөрдлөг болгон "Илрээгүй гэмт хэргийн", "Галт зэвсгийн хонгио ба хошууны", "Гарын хээний" гэх мэт санг бүрдүүлж, шинжилгээ, судалгаанд ашиглах, шаардлагатай тохиолдолд эрх бүхий байгууллагын хүсэлтийн дагуу лавлагаа мэдээлэл гаргаж өгнө. Криминалистикийн шинжээч мэргэжилтэн нь мөрден байцаалтын туршилт, задлан шинжилгээ, эксгумацид оролцохдоо гэрэл зураг болон дүрс бичлэгийн камер ашиглаж ул мөр, эд мөрийн баримтыг бэхжүүлэх арга хэмжээ авсан байна. Задлан шинжилгээний үед цогцсын гарын хээний дардас, арчдасыг бэхжүүлж авахаас гадна шаардлагатай биологийн гаралтай бичил ул мөрийг /үс, хумс, шүлс, үрийн шингэн г.м/ бэхжүүлсэн байна. Лабораторийн шинжилгээ хийхэд байгууллагын үйл ажиллагаа, лабораторийн техник хэрэгсэл, арга аргачлалд тогтоосон улсын болон байгууллагын стандартыг мөрдлөг болгон ажиллаж, гэмт хэргийг илрүүлж нотлох ач холбогдол бүхий шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргасан байна.
21.7	**Төрийн архив, албан хэрэг хөтлөлт**					**4,778.4**	**4,039.3**	
	21.7.1	Бүрдүүлсэн хадгаламжийн нэгж /мянгаар/		15	16.8	4,778.4	4,039.3	Төрийн 25 байгууллага, 547 хуулийн этгээд, 83 иргэнээс нийт удирдлагын баримт 9396, кино баримт 15, дуу авианы баримт 16, дүрс бичлэгийн баримт 935, зураг төслийн баримт 6435 хадгаламжийн нэгжийн бүрдүүлсэн.
	21.7.2	Эрдэм шинжилгээ, судалгааны эмхэтгэлийн тоо		6	7			"Монголын архив" эрдэм шинжилгээ, арга зүйн сэтгүүл №2, /20/, №3, "Үндэсний төв архивын Улс төрийн нам олон нийтийн байгууллагын баримтын архивын хөмрөгийн тойм", "Үндэсний төв архивын Кино гэрэл зураг дуу авианы баримтын архивын баримтат киноны хөмрөгийн тойм", "Ноёд, тайж, лам нарын захидлын цуглуулга", "Дайчин гүрний түүхэн товчоон", "Монгол-Хятадын соёл, шинжлэх ухааны харилцаа 1946-1965" зэрэг эмхэтгэл, ном сэтгүүлийг бэлтгэн хэвлүүлсэн.
	21.7.3	Дахин боловсруулалт хийх хадгаламжийн нэгжийн тоо /мянгаар/		13.5	56.5			ҮТА-ын 96 хөмрөгийн 111 дансны 56.5 хадгаламжийн нэгжид дахин боловсруулалт нягтлан шалгалт хийсэн.
	21.7.4	Архивын сан хөмрөг баяжуулах /мянгаар/		10	23.5			Нийт 23.5 мянган хадгаламжийн нэгж удирдлагын болон зураг төслийн баримтаар сан хөмрөгийг баяжуулсан.
21.8	**Цагаачлал, гадаадын иргэний бүртгэлийн үйлчилгээ**					**19,157.9**	**18,133.7**	
	21.8.1	Гадаадын иргэнд олгох визийн тоо /мянган хүнээр/		21.8	6.7	7,379.0	6,354.9	Энэ оны виз, оршин суух зөвшөөрөл олголт, хасалт, сунгалт, түр ирэгчийн бүртгэл, хасалтыг 2019 онтой харьцуулахад визийн зөвшөөрөл олголт 75.3, виз олголт 77.8, хувийн урилга олголт 81.0, оршин суух зөвшөөрөл олголт 74.3, оршин суух зөвшөөрөл сунгалт 56.3, оршин суух зөвшөөрөл хасалт 24.3, түр ирэгчийн бүртгэл 85.8, түр ирэгчийн хасалт 82.9, визийн сунгалт 18.6 хувиар тус тус буурчээ. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газар, Улсын Онцгой комиссын шийдвэрээр энэ оны 02 дугаар сараас хилийн боомтуудын зорчих хөдөлгөөнд хязгаарлалт тогтоосонтой холбоотой буурсан байна.
	21.8.2	Хяналтад хамрагдас Монгол Улсад түр болон байнга оршин суух гадаадын иргэний тоо /мянгаар/		28.3	14.5			2020 оны дээрх тоон үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулахад зөрчил гаргасан гадаадын иргэн 23.4, зөрчил гаргасан уригч хуулийн этгээд 57.8, зөрчил гаргасан уригч иргэн 38.5, албадан гаргагдсан гадаадын иргэн 87.9 хувиар буурч, гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн 105.4 хувиар өссөн байна. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 9.14 дэх хэсэгт "хөл хорио, хөдөлгөөний хязгаарлалт тогтоосны улмаас Монгол Улсаас гарах боломжгүй болсон нь холбогдох баримтаар тогтоогдсон гадаадын иргэн, харьяалалгүй хүний Монгол Улсын визийн болон тус улсад оршин суух зөвшөөрлийн хугацааг тухайн нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар сунгах, хугацаа хэтрүүлсний төлбөр, торгуулиас чөлөөлөх асуудлыг шийдвэрлэнэ" гэж заасан нь гадаадын иргэний зөрчил буурах шалтгаан боллоо.
	21.8.3	Монгол Улсын хилээр шалган нэвтрүүлэх тээврийн хэрэгсэл болон гадаад иргэдийн тоо /мянгаар/		7	3882.6	11,778.9	11,778.8	Монгол Улсын хилээр 2020 онд 21 боомтоор 130 орны 1,316,062 зорчигч, 40 орны 2,566,857 тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлсэн.
21.9	**Дээд боловсрол**					**31,761.9**	**31,649.2**	
	21.9.1	Суралцагчийн тоо /мянган хүнээр/		2.2	2.2	31,761.9	31,649.2	Бакалавр, магистр, докторын 30 хөтөлбөрт нийт 2212 сонсогчдын сургалтыг хуваарийн дагуу зохион байгуулсан. Дотоод хэргийн их сургуулийн спорт цогцолбор, номын сангийн барилгыг ашиглалтад хүлээн авсан.
21.10	**Төлбөрийн чадваргүй яллагдагч, сэжигтэнд эрх зүйн туслалцаа үзүүлэх**					**1,316.3**	**1,190.2**	
	21.10.1	Эрх зүйн туслалцаа авсан иргэн, яллагдагчийн тоо /мянган хүн/		14	11.4	1,316.3	1,190.2	2020 оны жилийн эцсийн байдлаар 11445 иргэнд хууль зүйн зөвлөгөө өгч ажилласан. Хууль зүйн зөвлөгөөний мэдээллийн дийлэнх хувийг иргэний эрх зүйн маргаан болох тэтгэвэр тэтгэмж, хүүхдийн тэтгэлэг тогтоолгох, эд хөрөнгийн маргаантай холбоотой асуудал эзэлж байна. Хууль зүйн зөвлөгөөний тоон үзүүлэлтийг 2019 оны жилийн эцсийн тоон үзүүлэлттэй харьцуулахад 23 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд нийт 2747 эрүүгийн хэргийн 2921 холбогдогчдод үнэ төлбөргүй өмгөөлийн үйлчилгээ үзүүлсэн. Үүнээс 1805 эрүүгийн хэргийг шүүхээр бүрэн шийдвэрлүүлж, 86 хэргийг шүүхийн өмнөх шатанд тус тус шийдвэрлүүлсэн. Мөн 550 хэрэг шийдвэрлэх шатанд байгаа ба 303 хэрэгт татгалзсан буюу төлбөрийн чадвартай холбогдогч болох нь тогтоогдсон тул татгалзах шийдвэр гарасан байна. Төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагчид өмгөөллийн үйлчилгээ үзүүлсэн тоон мэдээллийг 2019 оны жилийн эцсийн тоон мэдээтэй харьцуулахад нийт хүлээн авсан хэрэг, холбогдогчийн тоо 8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.
21.11	**Оюуны өмчийн эрхийн баталгаажуулалт, улсын бүртгэл, мэдээлэл**					**1,306.6**	**1,279.0**	

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
		21.11.1	Оюуны өмчийн бүтээлийн сан бүрдүүлэлт /аж үйлдвэрийн өмч, зохиогчийн эрх, түүнд хамаарах эрх, оюуны өмчийн гэрээ, хэлэлцээрийн баталгаажилт /тоогоор/	4200	5920	1,306.6	1,279.0	Патентын тухай хуулийн 3.1.16,3.1.17 дахь заалт, 18.3 дахь хэсэг, 7,11 дүгээр зүйл, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 2,4 дүгээр бүлэгт заасны дагуу 4860 аж ахуйн нэгж иргэнд аж үйлдвэрийн өмчийн эрхийн баталгаажуулалтыг эрхийн хамгаалалт, баталгаажуулалт хийсэн. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн дагуу 1060 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхээр хамгаалагдах бүтээлийг ээлжлэн, ашиглах, захиран зарцуулах, хамгаалалтыг бүртгэж гэрчилгээ олгосон.
		21.11.2	Оюуны өмчийн мэдээлэл, сургалт хийх, лавлагаа гаргах /тоогоор/	70	49			Оюуны өмчийн газар нь 2020 онд нийт албан хаагчдад дотоод сургалт-10, Патентын тухай хууль, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль, Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, нэмэлт өөрчлөлт оруулах Оюуны өмчийн багц хуулийг дагалдан гарах 9 журмын төслийн хэлэлцүүлэг-7, бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан сургалт-19, орон нутгийн 7 аймгийн театр,музей, телевизийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийж 150 албан хаагчдад сургалт-7, ДОӨБ-тай хамтарсан сургалт, семинар-4, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Практик сургалтын төвийн Legis баг, Илтгэх урлаг, мэтгэлцээний Berkeley клубтэй хамтран их сургуулийн оюутнуудын дунд зарласан "Оюуны өмч-Оюунлаг залуус" сэдэвт мэтгэлцээн, уран илтгэл уралдааны хүрээнд сургалт-2 удаа тус тус зохион байгуулсан. "Коронавирусийн халдвар" гарсантай холбоотойгоор УОК шийдвэрийн хүрээнд танхимаар хийгдэх сургалт, олон нийтийг хамарсан үйл ажиллагааг зогсоосон. /Хурал зохион байгуулах хугацаа хойшлогдсон тул сургалтын тоо буурсан/ Мөн 94 иргэд, аж ахуйн нэгж байгууллагад 114 лавлагаа гаргаж өгч үйлчилсэн
		21.11.3	Оюуны өмчийн зөрчилд хяналт тавьж шийдвэрлэх /тоогоор/	450	540			Оюуны өмчийн газарт иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн 169 өргөдөл гомдол, 101 удаагийн төлөвлөгөөт шалгалтаар 540 зөрчилд хяналт хийж Зөрчлийн тухай хуулийн 8.3 дахь хэсгийн дагуу хянан шийдвэрлэсэн.
	21.12	**Улсын бүртгэл, мэдээлэл**				**47,864.0**	**47,686.5**	
		21.12.1	Цахим үнэмлэх олголт /мянган хүнээр/	350	224.3	47,864.0	47,686.5	Нийслэлийн хэмжээнд шинээр зохион байгуулагдсан 19 хороонд байнга оршин суух хаягийн бүртгэлд нь өөрчлөлт орсон 145573, орон нутагт аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор өөрчлөлт орсон 5823 иргэний хаягийг /Баян-өлгий аймагт 2042, Хэнтий аймагт 409, Баянхонгор аймагт 3372/ нэмэлт, өөрчлөлтийн бүртгэлээр мэдээллийн санд тусгаж ажилласан.
		21.12.2	Цахим хэлбэрт шилжүүлсэн архивын баримтын тоо /мянгаар/	9500	170.5			Иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн архивын цаасан баримтыг цахимжуулж хэрэглээнд нэвтрүүлж, нэмэлтээр хувийн хэрэгт орох баримтыг тухай бүр цахим санд оруулсан бөгөөд бүртгэлийн өдөр тутмын болон мэдээлэл, лавлагаанд ашиглаж байна.
		21.12.3	Бэлтгэсэн улсын бүртгэлийн маягт /мянгаар/	2357.7	2,849.8			ХЗДХ-ийн сайдын баталсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасны дагуу улсын мэдээллийн маягтыг бэлтгэсэн.
		21.12.4	Дүгнэлт гаргах хяналт шалгалтын тоо /мянгаар/	3	0.7			Зөрчлийн тухай хуулийн хүрээнд гарсан зөрчил дутагдлыг арилгах хүрээнд дүгнэлт гаргаж ажилласан.
		21.12.5	Төсвийн орлогын төлөвлөгөөг батлагдсан хуваарийн дагуу төвлөрүүлэх /сая төгрөг/	15697	11,621.1			Улсын хэмжээнд цар тахал ковид-19 өвчний хүрээнд Засгийн газар болон Улсын онцгой комиссоос авч хэрэгжүүлж байгаа хатуу хөл хорио, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотойгоор мөн Иргэний улсын бүртгэлийн хууль тогтоомжид заасны дагуу иргэнд цахимаар бүртгэлийн лавлагаа үйлчилгээг шуурхай хүргэх зорилгоор 2018 онд burtgel.mn цахим системийг нэвтрүүлж, иргэд 23 төрлийн лавлагааг үнэ төлбөргүй авах болсон зэргээс үүдэлтэй орлогын төлөвлөгөө тасарсан.
	21.13	**Эмнэлгийн тусламж үйлчилгээ**				**14,800.3**	**13,664.3**	
		21.13.1	Амбулаторийн тусламж үйлчилгээ /мянган хүнээр/	160	171	14,800.3	13,664.3	Амбулаторийн тусламж үйлчилгээг үзүүлэхдээ дотор, мэдрэлийн 12 кабинет, мэс заслын 9 кабинет, уламжлалт, сэргээн засах нийт 21 нэр төрлийн үзлэгийн кабинетаар нарийн мэргэжлийн эмч үзлэг хийж, зөвлөгөө өгдөг. Эмнэлгийн үйлчлүүлэгчийн хүлээгдлийн мэдээг 7 хоногийн даваа гариг бүр тооцон гаргаж, амбулаторийн хүлээгдэлтэй хэсэгт нэмэлт кабинетаар үзлэг хийн хүлээгдлийг бууруулан ажилласан. Эмнэлгийн амбулаторийн 1 эмчийн үзлэгийн интервал нь 15 минутаар өдерт 32 хүнд үйлчлэх хийх нормтой.
		21.13.2	Хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ /мянган хүнээр/	10	10			ЭМС-ын 2020 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн А/124 тоот тушаалаар тус эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх орны дээд хязгаарыг 8 тасагт 246 ортой байхаар баталсан. 2020 онд нийт 8 тасаг бүрэн хүчин чадлаараа ажиллаж байна. (Эхний хагас жилийн статистик мэдээнээс харахад төсөвт ор нийт 246, дундаж ор хоног 6.6, орны фонд ашиглалтын хувийг 84.0 байна).
		21.13.3	Өдрийн эмчилгээ /мянган хүнээр/	1	0.7			Өдрийн эмчилгээг 20 ортойгоор дэлгэн ажиллаж байна. 2020 онд коронавируст халдвар Covid-19 холбоотойгоор хөл хорионы дэглэм, шаардлагагүй тохиолдолд эмнэлгээр үйлчлүүлэхгүй байх зөвлөмжийн дагуу үйлчлүүлэгчийг хязгаарласантай холбоотойгоор зорилтод түвшинд хүрээгүй болно.
		21.13.4	Оношилгоо, шинжилгээ /мянган хүнээр/	195	233			Оношилгоо, шинжилгээнд эмнэлгийн хэмжээнд нийт 87 нэр төрлийн 181 багаж тоног төхөөрөмжийг тусламж үйлчилгээндээ ашиглаж байна. Барилга байгууламжид тушиглэсэн стандартын ерөө тасалгаатай болж үйл ажиллагаа жигдэрсэн нь оношилгоо шинжилгээний нэр төрөл олширч зорилтот түвшнээс давсан болно. Лабораторийн тусламж үйлчилгээнд эрүүл мэндийн лаборатори чанар ба чадавхаа шаардлага MNS ISO 15189:2015 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж чанартай тусламж үйлчилгээг үйлчлүүлэгчид үзүүлэн ажиллаж байна.
		21.13.5	Хилийн хөдөлгөөнт бүлгийн үзлэгийн тоо /мянгаар/	4	11			Хилийн хөдөлгөөнт 3 бүлэг томилогдон үүрэг гүйцэтгэсэн. 1-р бүлэг: Дэд хурандаа Б.Баттөмөр ахлагчтай 7 эмчийн бүрэлдэхүүнтэй баг Хилийн 0285, 0165, 0130, 0214 дугаар ангиудын, 1075 бие бүрэлдэхүүнд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийж үүнээс 1044 хүнд хэвлийн хэт авиан шинжилгээ, 378 хүнд зүрхний цахилгаан бичлэг, 94 хүнд жижиг мэс ажилбар хийсэн болно. 2-р бүлэг: хошууч Ч.Баянзул ахлагчтай 5 эмчийн бүрэлдэхүүнтэй баг бие 2445 бүрэлдэхүүнд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийж үүнээс 593 хүнд хэвлийн хэт авиан шинжилгээ хийсэн. 3-р бүлэг: хошууч Б.Цогзолмаа ахлагчтай 4 эмчийн бүрэлдэхүүнтэй баг Хилийн 0245, 0311, 0277 дугаар ангиудын, 3967 бие бүрэлдэхүүнд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийсэн байна.
22	**БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД**					**208,302.1**	**166,369.7**	
	22.1	**Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн бодлого, удирдлага**				**191,107.3**	**149,447.9**	

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
		22.1.1	Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн салбарын холбогдох хууль тогтоомжийн төслүүдийг Улсын Их Хуралд өргөн барих /хуулийн төслийн тоо/	10	10	62,017.2	41,050.4	1. Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын "Барилгын аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай" 1988 оны 167 дугаар конвенцод нэгдэн орох тухай хуулийн төсөл УИХ-аар 2020 оны 01 дүгээр сарын 30-нд соёрхон батлагдсан. 2. Орон сууцны тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл /Хууль санаачлагч нь өөрчлөгдсөн, шинээр байгуулагдсан ЗГ-ын саналыг авах шаардлагатай үндэслэлээр УИХ-ын 2020.10.08-ны 28 дугаар тогтоолоор буцсан. 3. Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2020.01.22-ны өдөр Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн. 4. Өвөрхангай аймгийн Арвайхээр, Тараагт, Баян-Өлгий аймгийн Бугат сумдын хилийн цэсэд өөрчлөлт оруулах тухай УИХ-ын тогтоолын төсөл 2020.01.22-ны өдөр Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн. 5. Төвлөрлийг бууруулахтай холбогдуулан Монгол Улсад 42 жилийн дараа анх удаа Майдар, Аеросити хот байгуулах тухай тогтоолын төсөл /2020.01.30-ны өдөр Засгийн газраас УИХ-д өргөн барив. 6. Газрын багц /5/ хуулийн төслийг өргөн мэдүүлэхэд бэлэн болгосон. Байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд хийгдсэн.
		22.1.2	Засгийн газраар батлуулах барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн салбарын холбогдох дүрэм, журмын тоо	5	5			1. Төрөөс орон сууц, нийтийн аж ахуйн талаар баримтлах бодлогын баримт бичгийг Засгийн газрын 2020 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. 2. 2018 оны 319 дүгээр тогтоолоор батлсан "Зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, хуулийн этгээдэд тавих шаардлага, бүртгэх журам"-ыг шинэчлэн батлах тухай; 3. Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолоор батлсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай; 4. Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор батлсан "Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх дүрэм"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай; 5. Засгийн газрын 2017 оны 68 дугаар тогтоолоор батлсан "Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох дүрэм"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолын төслүүдийг боловсруулж дуусган батлуулахад бэлэн болсон. Байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд хийгдсэн.
		22.1.3	Монгол Улсын хүн амын нутагшилт суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл боловсруулалтын хувь	45	60	1,787.6	1,080.0	Төслийн хүрээнд хийгдэх судалгааны ажил бүрэн дуусан. Хот байгуулалт иж бүрэн үнэлгээ хийгдэж байна. Төсөл боловсруулах аргачлалыг салбарын ШУТЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдсэн бөгөөд төслийн төлөвлөлтийг эхлүүлэх ажлыг зохион байгуулж байна.
		22.1.4	Шинээр барих болон шинэчлэх цэвэр усны шугам сүлжээний хэмжээ /км/	60	42	100,038.8	80,753.8	Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хуулиар батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалт болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн хүрээнд хэрэгжүүлсэн.
		22.1.5	Шинээр барих болон шинэчлэх бохир усны шугам сүлжээний хэмжээ /км/	25	64.8			
		22.1.6	Шинээр барих болон шинэчлэх дулааны шугам сүлжээний хэмжээ /км/	50	26.3			
		22.1.7	Шинээр барих болон шинэчлэх цахилгаан шугам сүлжээний хэмжээ /км/	25	32.3			
		22.1.8	Шинээр барих 9 цэвэрлэх байгууламжийн барилгын ажлын гүйцэтгэлийн хувь	30.0-100.0	75.6	27,263.7	26,563.7	Дорноговь аймгийн төв цэвэрлэх байгууламжийн гүйцэтгэл 40 хувь, Өмнөговь аймгийн төв цэвэрлэх байгууламжийн гүйцэтгэл 95 хувь, Булган аймгийн төв цэвэрлэх байгууламжийн гүйцэтгэл 98 хувь, Хэнтий аймгийн төв цэвэрлэх байгууламжийн гүйцэтгэл 65 хувь, Хөвсгөл аймгийн төв цэвэрлэх байгууламжийн гүйцэтгэл 95 хувь, Өвөрхангай аймгийн төв цэвэрлэх байгууламжийн гүйцэтгэл 100 хувь, Дархан хотын төв цэвэрлэх байгууламжийн гүйцэтгэл 68 хувь, Дундговь аймгийн төв цэвэрлэх байгууламжийн гүйцэтгэл 50 хувь, Сүхбаатар аймгийн төв цэвэрлэх байгууламжийн гүйцэтгэл 65 хувь тус тус байна.
	22.2	**Газрын зураглал, кадастр**				**17,194.8**	**17,044.0**	
		22.2.1	Газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын холбогдох хуулийн төслүүдийг Улсын Их Хуралд өргөн барих /хуулийн төслийн тоо/	6	6	**15,269.7**	**15,119.0**	Газрын багц /5/ хуулийн төслийг өргөн мэдүүлэхэд бэлэн болгосон. Үүнд: Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл /багцаар/; Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл /багцаар/; Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл /багцаар/; Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл /багцаар/;Нийгмийн зайлшгүй хэрэгцээнд зориулан газар чөлөөлөх тухай анхдагч хуулийн төсөл /багцаар/; Мөн Геодезийн тухай хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд хийгдсэн.
		22.2.2	Засгийн газраар батлуулах газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын холбогдох дүрэм, журмын тоо	3	3			1. ЗГ-ын 2016 оны 10 дугаар тогтоолоор баталсан "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /Засгийн газрын 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан/ 2. ЗГ-ын 2016 оны 10 дугаар тогтоолоор баталсан "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /Засгийн газрын 04 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан/ 3. Монгол Улсын иргэнд 2020 онд гэр бүлийн хэрэгцээнд үнэгүй өмчлүүлэх газрын хэмжээ, байршил зориулалтыг тогтоох тухай /ЗГ-ын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан/ 4. Газрын тухай хуулийн 18.1.1 дэх заалтын хүрээнд "Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" тогтоолын төсөл /ЗГ-ын 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан/ Байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд хийгдсэн.
		22.2.3	Төрийн архивыг цахимжуулах ажлын хэрэгжилтийн хувь	70	73	25.0	25.0	Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газраас төрийн архивын хадгаламжийн 5 төрлийн сан хөмрөгийн 2,451,818 хуудас баримтыг цахимжуулахаас 1,797,208 баримтыг цахим хэлбэрт шилжүүлсэн.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
		22.2.4	Аймаг, нийслэлийн газрын кадастрын мэдээллийн санг өндөр, тусгагчийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлж засварлан, улсын кадастрын нэгдсэн мэдээллийн системд холбож, үйлчилгээнд нэвтрүүлэх ажлын хэрэгжилтийн хувь	100	100	1,900.0	1,900.0	Энэ төслийн хүрээнд нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд 390,000 орчим бүртгэгдсэн нэгж талбарын 17,501 нэгж талбар газар нь газар дээрх талбайн хэмжээг сунгасан, 25,602 нэгж талбар газрын эрхийн бүртгэл хийгдээгүй, 130,000 нэгж талбар газрын эрхийн бүртгэл алдаатай бүртгэгдэж, 91,000 нэгж талбар газар нь топологийн хувьд зураглалын алдаатай, нэгж талбарын хувийн хэрэг нь захирамжаар үүссэн, ихэнх дүүргийн архивын өрөө тасалгаа стандартын бус, 6 төрлийн харилцаа уялдаагүй, нэгдсэн стандарттүй программ хангамж ашиглагдаж, ихэнх дүүргийн техник, тоног төхөөрөмж хуучирсан, кадастрын хэмжилт, зураглалын мэргэжлийн багаж хэрэгсэл дутагдалтай, асуудалтай байсныг энэхүү төслийн хүрээнд бүрэн шийдвэрлэж, Улсын кадастрын нэгдсэн системд холбох ажлыг хийж гүйцэтгэсэн болно. Мөн нийслэл, дүүргийн Газрын албадад нэгдсэн стандарт бүхий нэг систем ашиглаж, 30 гаруй төрлийн өргөдлийн бүртгэл, түүний шийдвэрлэлт, 41 төрлийн тайлан мэдээ автоматжиж, 10 гаруй төрлийн хяналт шалгалтыг автоматаар хийх боломжийг бүрдүүлээд байна. Нэгдсэн системд орсноор газрын кадастрын үнэн зөв, ил тод мэдээллээр түргэн шуурхай үйлчлэх, газрын харилцаатай холбоотой мэдээлэл, өргөдөл шийдвэрлэлтийн явцын талаарх мэдээлэл, өөрийн өмчлөл, эзэмшил, ашиглалтын газрын талаарх мэдээлэл, газрын үнэлгээний мэдээлэл, газрын төлбөр, татвар, лавлагаатай холбоотой үйлчилгээнүүдийг иргэд EGAZAR.GOV.MN сайт болон egazar апликэйшнийг интернэт, гар утас ашиглан авч байна. Мөн Татварын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газартай дундын мэдээллийн санг байгуулж, Газрын төлбөрийн тухай хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хуульд заасан асуудлуудыг бүрэн шийдвэрлэсэн болно.
23	**БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД**					**287,679.1**	**268,935.3**	
	23.1	**Батлан хамгаалах**				**287,679.1**	**268,935.3**	
		23.1.1	Бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан батлан хамгаалах чиглэлийн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх	Хэрэгжилтээр	Бүрэн хэрэгжсэн	287,679.1	268,935.3	"Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-нд Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан мэргэжлийн, чадварлаг зэвсэгт хүчнийг хөгжүүлэх" зорилгыг хэрэгжүүлэхээр 9 зорилтын хүрээнд 48 арга хэмжээг тусгасан бөгөөд 2020 онд хамаарах чиглэлээр тусгагдсан 4 арга хэмжээний хэрэгжилт 92.5 хувийн гүйцэтгэлтэй буюу "үр дүнтэй" гэж дүгнэж байна.
24	**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙД**					**1,738,055.5**	**1,564,034.7**	
	24.1	**Сургуулийн өмнөх боловсрол**				**472,600.0**	**414,170.0**	
		24.1.1	Суралцах хүүхдийн тоо	275676	247179	472,600.0	414,170.0	Ковид нөхцөл байдлын улмаас бэлэн байдлын зэрэг тогтоосноос 2020 оны хаврын улирал цэцэрлэг цахимаар хичээллэсэн.
		24.1.2	Хүүхдийн цэцэрлэгийн тоо	1545	1459			
		24.1.3	Хамран сургалтын хувь	86	85			Төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан
		24.1.4	Төрийн бус өмчийн цэцэрлэгийн тоо	554	525			БСШУСЯ-наас гаргасан удирдамжийн дагуу НМХГ, НБГ-тай хамтарч хувийн цэцэрлэгүүдэд үйл ажиллагааны явцын шалгалт хийсэн.
		24.1.5	Төрийн бус өмчийн цэцэрлэгт хамрагдах хүүхдийн тоо	41471	36141			2020 онд хүрсэн түвшнийг салбарын статистик мэдээнээс санхүүжих дундаж хүүхдийг тооцож гаргасан.
	24.2	**Тусгай хэрэгцээт боловсрол**				**4,360.0**	**4,000.0**	
		24.2.1	Тусгай хэрэгцээт боловсролд /хөгжлийн бэрхшээлтэй/ хамрагдах цэцэрлэг, сургуулийн хүүхдийн тоо	6223	92%	4,360.0	4,000.0	Төлөвлөөг хэрэгжүүлж ажилласан.
	24.3	**Ерөнхий боловсрол**				**836,430.0**	**803,600.0**	
		24.3.1	Суралцах хүүхдийн тоо	664407	686552	836,430.0	803,600.0	Ерөнхий боловсролын сургуульд хамрагдах хүүхдийг хамруулж ажилласан.
		24.3.2	Ерөнхий боловсролын сургуулийн тоо	840	860			Шинээр ашиглаптад орох сургуулиуд хойшлож шилжих барилгын жагсаалтад орсон.
		24.3.3	Хамран сургалтын хувь	96	96			Төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан
		24.3.4	Дотуур байранд хамрагдах хүүхдийн тоо	41205	35000			Салбарын статистик мэдээнээс санхүүжих дундаж хүүхдийг тооцож гаргасан.
		24.3.5	Удийн цай хөтөлбөрт хамрагдах хүүхдийн тоо	352790	356770			Салбарын статистик мэдээнээс санхүүжих дундаж хүүхдийг тооцож гаргасан.
		24.3.6	Төрийн бус өмчийн сургуулийн тоо	159	165			
		24.3.7	Төрийн бус өмчийн сургуульд хамрагдах хүүхдийн тоо	53246	48030			Салбарын статистик мэдээнээс санхүүжих дундаж хүүхдийг тооцож гаргасан.
	24.4	**Насан туршийн болон албан бус боловсрол**				**3,060.0**	**3,880.0**	
		24.4.1	Албан бус боловсролд хамрагдах хүүхдийн тоо	8888	5340	3,060.0	3,880.0	Тус зорилтот үзүүлэлтийг насан туршийн боловсролын бүх хэлбэрт хамрагдах суралцагчдын тоог төлөвлөдөг бөгөөд хичээлийн жилийн албан мэдээнд зөвхөн бичиг үсгийн боловсролд хамрагдсан хүүхдийн мэдээлэл орсон учраас бүрэн хамрагдах боломжгүй байна.
	24.5	**Дээд боловсрол**				**39,810.0**	**21,010.0**	
		24.5.1	Их, дээд сургуулийн тоо	94	88	39,810.0	21,010.0	Статистик мэдээгээр 88 сургууль байна.
		24.5.2	Дэлхийн шилдэг сургуульд суралцагчийн тоо	295	107			Боловсролын зээлийн сангийн төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр гарсан байна.
		24.5.3	Багш, инженерийн чиглэлийн суралцагчаас сургалтын төлбөрийн хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчийн тоо	2039	1239			Боловсролын зээлийн сангийн төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр гарсан байна.
		24.5.4	Багшлах дадлагад хамрагдсан суралцагчийн тоо	704	650			Боловсролын зээлийн сангийн төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр гарсан байна.
	24.6	**Шинжлэх ухаан, технологи**				**39,440.0**	**37,740.0**	
		24.6.1	Эрдэм шинжилгээний үндсэн судалгаанд зарцуулах зардлын эзлэх хувь	36.8	22.4	39,440.0	37,740.0	Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалж төлөвлөгөөт ажлууд удааширч, хойшлогдсон, хөл хорио бэлэн байдлын зэрэгт шилжсэн зэргээс гүйцэтгэл буурч гарсан.
		24.6.2	Хэвлүүлсэн бүтээлийн тоо	13000	7661			Улсын төсөвт эрдэм шинжилгээний ажлын зардал буурснаас шалтгаалан төслүүдийн санхүүжилт хугацаандаа хийгдэх боломжгүй болсон.
		24.6.3	Боловсруулсан технологи, бүтээгдэхүүний тоо	305	60			Боловсруулсан технологи, бүтээгдэхүүнийг бүртгэлжүүлж ажилласан нь тус үзүүлэлтэд хүрсэн.
25	**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД**					**279,244.4**	**253,959.2**	
	25.1	**Авто зам**				**270,217.7**	**245,185.0**	
		25.1.1	Байнгын ашиглалтад оруулах авто замын нийт хүчин чадал /км/	480	344	270,217.7	245,185.0	Сайжруулсан авто замын урт өмнөх оноос 344 км замаар уртасч нийт 11179.8 км болсон.
		25.1.2	Байнгын ашиглалтад оруулах гүүрний нийт хүчин чадал, урт /м/	350	648.9			648.9 урт /м гүүрийг шинээр ашиглалтад оруулж 35967.3 урт/м гүүртэй болсон
		25.1.3	Урсгал засвар, арчлалт хийх авто замын нийт хүчин чадал /км/	14918	14918			Төлөвлөснөөс авто замын арчлалтын ажил 100 хувь биелсэн.
		25.1.4	Урсгал засвар, арчлалт хийх гүүрний нийт хүчин чадал, урт /м/	13962.1	13962.1			Төлөвлөсөн хэмжээнд зорилтот түвшнийг биелүүлсэн.
		25.1.5	Эрдэм шинжилгээ, туршилт, судалгааны төслийн тоо	2	2			Төлөвлөсөн хэмжээнд зорилтот түвшнийг биелүүлсэн.
		25.1.6	Лабораторийн туршилт, шинжилгээний дүгнэлтийн тоо	900	1380			Зорилтот тоо хэмжээг 480 нэгж ажлаар давуулан биелүүлсэн
		25.1.7	Улсын чанартай авто замын сүлжээнд эзлэх хатуу хучилттай авто замын уртыг нэмэгдүүлэх /хувиар/	47	50			Төлөвлөсөн хэмжээнд зорилтот түвшнийг биелүүлсэн.
	25.2	**Авто тээврийн хяналт, зохицуулалт, нийтийн тээвэр**				**-**	**-**	

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
		25.2.1	Авто тээврийн хэрэгслийн үзлэг оношилгоог хийх /үзлэгт хамрагдах хувь/	80	61.6			Цар тахлын улмаас зорилтот түвшин биелээгүй
		25.2.2	Зорчигч эргэлт /өмнөх оны суурь үзүүлэлтээс өсгөх хувь/	3.0-аас доошгүй	-2.4% 2178 сая хүн км			Цар тахлын улмаас зорилтот түвшин биелээгүй
		25.2.3	Ачаа эргэлт /өмнөх оны суурь үзүүлэлтээс өсгөх хувь/	3.0-аас доошгүй	-36.8% 4685.3 сая тн.км			Цар тахлын улмаас зорилтот түвшин биелээгүй
	25.3	**Төмөр зам**				**709.5**	**708.5**	
		25.3.1	Шивээхүрэн-Сэхээ чиглэлийн боомтын төмөр зам барих /ажлын гүйцэтгэл хувиар/	**100.0**	0	709.5	708.5	
		25.3.2	Таван толгой – Гашуун сухайт чиглэлийн 267 км төмөр зам барих /ажлын гүйцэтгэл хувиар	80.0	78.4			Барилгын ажлын гүйцэтгэл 98 хувийн биелэлттэй байна.
		25.3.3	Эрдэнэт-Овоот чиглэлийн 542 км төмөр зам барих /ажлын гүйцэтгэл хувиар/	20.0	-			
		25.3.4	Зүүнбаян-Ханги чиглэлийн 281 км төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл, техникийн зураг төсөл, судалгаа боловсруулах /ажлын гүйцэтгэл хувиар/	100.0	45			Барилгын ажлын гүйцэтгэл 45 хувийн буюу эхлэлийн байдалтай байна.
		25.3.5	Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 414.6км төмөр зам барих/ ажлын гүйцэтгэл хувиар/	80.0	62,5			Барилгын ажлын гүйцэтгэл 78 хувийн буюу эхлэлийн байдалтай байна.
	25.4	**Агаарын тээвэр**				**3,058.6**	**3,041.4**	Барилгын ажлын гүйцэтгэл 78 хувийн буюу эхлэлийн байдалтай байна.
		25.4.1	Олон улсын өнгөрөлтийн нислэгийн тоо /мянгаар/	129	71.4	3,058.6	3,041.4	Төлөвлөгөөг 55.3 хувиар биелүүлсэн.
		25.4.2	Буулт, хөөрөлтийн тоо /мянгаар/	12.1	7.2			Төлөвлөгөөг 59 хувиар биелүүлсэн.
		25.4.3	Ачаа тээвэрлэлт /мянган тонн/	5.2	2.7			Төлөвлөгөөг 51 хувиар биелүүлсэн.
		25.4.4	Зорчигч тээвэрлэлт /мянган хүн/	1200	447.5			Төлөвлөгөөг 37 хувиар биелүүлсэн.
		25.4.5	Төсвийн орлогын төлөвлөгөөг батлагдсан хуваарийн дагуу төвлөрүүлэх	Орлогыг бүрэн төвлөрүүлсэн байх	75			75 тэрбум төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлэн төлөвлөсөн хэмжээг 100 хувийн гүйцэтгэлтэй биелүүлсэн.
	25.5	**Зам, тээврийн бодлого удирдлага**				**5,258.6**	**5,024.3**	
		25.5.1	Төсвийн орлогын төлөвлөгөөг батлагдсан хуваарийн дагуу төвлөрүүлэх	Орлогыг бүрэн төвлөрүүлсэн байх	75223.0 сая төгрөг	5,258.6	5,024.3	ИНЕГ-75,0 тэрбум,Далай 223.0 сая төгрөг төвлөрүүлсэн
26	**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙД**					**36,192.2**	**34,642.1**	
	26.1	**Уул уурхайн олборлолт**				**36,192.2**	**34,642.1**	
		26.1.1	Хувийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологи хайгуулын ажлын жилийн тайлангийн баталгаажуулалтын тоо	1400	1126	590.6	505.8	2020 оны гүйцэтгэлээр 2019 онд хувийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын 1126 тайланг цахимаар хүлээн авч, зардлын доод хэмжээ хэсэгт 948 тайлан хянагдаж 900 тайлангийн зардлын доод хэмжээг баталгаажуулсан ба 48 тайлан засварт буцсан төлөвтэй байна. Үлдсэн 178 тайлан Геологийн хэлтэст хянагдаж байна.
		26.1.2	Хувийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологи хайгуулын ажлын жилийн төлөвлөгөөний хяналтын тоо	1400	1162	590.6	505.8	Нийт хянасан төлөвлөгөөний тоо 1162, үүнээс хайгуулын тусгай зөвшөөрөл дээр 981, ашиглалтын тусгай зөвшөөрөл дээр 181, баталгаажсан төлөвт 1042, засварт буцаасан 91, илгээсэн төлөвт 29 байна. Хугацаа хоцорч ирүүлсэн 23 хайгуулын ажлын төлөвлөгөө байна.
		26.1.3	Хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд хувийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологи хайгуулын ажлын гүйцэтгэлд хийх шуурхай хяналтын тоо	60	18	655.3	568.2	Нийт 18 хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбайд 2019 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын тайланд тусгагдсан ажлуудыг газар дээр нь хэврийн шуурхай хяналт хийж баталгаажуулан, дүгнэлт гаргасан. Ашигт малтмалын хуулийн 33.3 дугаар зүйлийн дагуу хайгуулын ажилд зарцуулсан зардлын хэмжээ нь Ашигт малтмал, газрын тосны газарт ирүүлсэн хайгуулын ажлын 2019 оны жилийн тайлан мэдээнээс зөрж, газар дээр хийгдээгүй байсан, 48.1 дүгээр зүйлийн дагуу тайланг үнэн зөв гарган ирүүлэх зэрэг асуудалтай холбоотой тус илтгэх хуудасны дүгнэлт хэсгийн 4-д заасан тусгай зөвшөөрлүүдийн хайгуулын ажлын зардлын хэмжээ болон санхүүгийн тайланг төрийн захиргааны хэлтсээр дахин шалгуулах, ашигт малтмалын тухай хууль болон бусад холбогдох хуулийн дагуу арга хэмжээ авах асуудлаар Ашигт малтмал, газрын тосны газрын Хууль, эрхзүйн хэлтэст уламжлах зэрэг саналуудыг удирдлагад танилцуулан холбогдох арга хэмжээг авч ажилласан. Бусад хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбайд хийгдэх шуурхай хяналтын ажил нь Цар тахалтай /ковид-19/ холбоотойгоор томилолтын зардал хасагдсан тул шуурхай хяналт хийгдээгүй.
		26.1.4	Уулын ажлын тайлангийн хяналт, зөвшөөрлийн тоо	250	196	415.6	334.6	Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон баяжуулах үйлдвэрүүдээс 227 ашиглалтын үйл ажиллагааны тайлан ирүүлснээс 196 тайлан хянагдан баталгаажаад байна.
		26.1.5	Уулын ажлын төлөвлөгөөний хяналт, зөвшөөрлийн тоо	380	287	415.6	334.6	Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон баяжуулах үйлдвэрүүдээс 372 ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө ирүүлснээс 287 төлөвлөгөө хянагдан баталгаажаад байна.
		26.1.6	Уулын ажлын хэрэгжилтэд хяналт, шалгалт хийх тоо	200	94	434.3	355.9	2020 оны жилийн эцсийн байдлаар төвийн бүсийн төлөвлөгөөт албан томилолтоор ажилласан бөгөөд (Ковид-19) цар тахал, Засгийн газрын 114-р тогтоолтой холбоотойгоор томилолтын зардал хассан тул томилолтууд хойшлоод байна.
		26.1.7	Нүүрсний хэлтсийн уулын ажлын тайлан, төлөвлөөнд тавих хяналт /хяналт тавих тайлангийн тоо/	140	134	443.9	362.3	16 ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг холбогдох заавар журмын дагуу засвар хийн ирүүлэхгүй байгаа тул өнөөдрийн байдлаар хүлээн авч батлаагүй байна.
		26.1.8	1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажил /хамрах талбайн хэмжээ км2-аар/	32000	34,000.00	20,190.0	20,190.0	2020 онд 1:50000-ны масштабтай геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг 34 000 км2 талбайд гүйцэтгэж, холбогдох мэдээлэл, ажлын үр дүнг улсын санд хүлээлгэн өгөөд байна
		26.1.9	Хүнд үйлдвэрийн салбарт хэрэгжүүлэх төслийн техник, эдийн засгийн үндэслэлийн тайланг холбогдох зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн байх /тоогоор/	15	15	964.2	1,015.1	Хүнд үйлдвэрийн салбарт хэрэгжүүлэхээр мазут боловсруулах, катодын зэс, гумины бордоо, ган бөөрөнцөг, хүхрийн хүчил үйлдвэрлэх, өнгөт металл хайлах, хийн конденсат боловсруулж газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ашиглалтаас гарсан автомашин ангилах, дахин угсрах, засвар механикийн заводыг ергөтгөх, уурхай, металлурги, химийн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк байгуулах , хаягдал зэс, хайлш боловсруулах, ашигласан тос, хаягдал цэнэг хураагуур боловсруулах чиглэлийн 15 төслийг хэлэлцүүлсэн байна.
		26.1.10	Нүүрсний экспортын хэмжээг нэмэгдүүлэх /сая тонн/	42-д хүрсэн байх	2020 онд 40,984.5 мян.тн нүүрс борлуулснаас 31,177.8 мян.тн нүүрс экспортлоод байна.	1,098.2	1,022.5	2020 оны 9 сард тодотголоор нүүрсний экспортын хэмжээг 36.0 сая тонн болгон буулгасан. Шинэ төрлийн коронавирус цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан нүүрсний салбарын экспортын хэмжээ 2019 онд 36,809.0 мян.тн байснаас 2020 онд 31,177.8 мян.тн болж 15.3%-иар буурсан. Биелэлт 86.6%
		26.1.11	Зэсийн баяжмалын экспортын хэмжээг нэмэгдүүлэх /сая тонн/	1.2-д хүрсэн байх	1.4	1,053.4	950.9	Гаалийн ерөнхий газрын 1-12 дугаар сарын статистик мэдээнд тулгуурлан гүйцэтгэлийг гаргав. Биелэлт 116.31 %-тай байна.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
		26.1.12	Төмрийн хүдэр, баяжмалын экспортын хэмжээг нэмэгдүүлэх /сая тонн/	8.3-д хүрсэн байх	8.2	1,053.4	950.9	Гаалийн ерөнхий газрын 1-12 дугаар сарын статистик мэдээнд тулгуурлан гүйцэтгэлийг гаргав. Биелэлт 98.82 %-тай байна.
		26.1.13	Алтны олборлолтын хэмжээг нэмэгдүүлэх /тонн/	19.0-д хүрсэн байх	20.23 тн	1,061.2	936.3	2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 20.23 тн алт, үүнээс ААН нь 10.92 тн, иргэд 9.31 тн байна. (Стандарт, хэмжил зүйн газрын сорьцын мэдээгээр)
		26.1.14	Газрын тосны экспортын хэмжээг нэмэгдүүлэх /сая баррель/	6.6-д хүрсэн байх	4.1	4,535.2	4,125.5	2020.01.11-01.20-ны хооронд "Байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх гэрээ" байгуулах хэлэлцээрийн хугацаанд "Нутгаа аврах Чойбалсанчуудын нэгдэл" НҮТББ Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.6 дахь заалтыг илтэд зөрчих тээврийн замыг хаснаар Уул XIX, Тамсаг XXI талбайн газрын тосны экспорт зогссон. Мөн Дорнод аймгийн Онцгой комисс 2020 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр хуралдаж, "Баянхошуу, Бичигтийн боомтоор газрын тосны тээвэрлэлт хийх Монгол жолоочтой автомашинуудыг БНХАУ руу нэвтрүүлэхгүй байх, цаашид тур хугацаагаар тээвэрлэлтийг зогсоох, БНХАУ-ын харьяалал бүхий иргэн, тээврийн хэрэгслийг тур хугацаагаар Монгол Улс руу нэвтрүүлэхгүй байх" шийдвэр гаргаж, газрын тосны экспортын үйл ажиллагааг зогсоосон. Үүний улмаас Тосон-Уул XIX талбай 2020.04.21, Тамсаг XXI талбай 2020.04.13-ны өдрийг хүртэл олборлолт, экспортын үйл ажиллагаа зогссон. БХГ-97 талбайн экспортын үйл ажиллагаа короновирус гарсантай холбогдуулан Улсын онцгой комиссоос гарсан шийдвэрийн дагуу 2020.02.01-03.15-ны өдрийг хүртэл зогссон.
		26.1.15	Тусгай зөвшөөрлийн төлбөр төлөх үүрэг бүхий аж ахуйн нэгжүүдийг татварт бүрэн хамруулж орлогын төлөвлөгөөг биелүүлэх	Орлогыг бүрэн төлөрүүлсэн байх	32.7 тэрбум төгрөг төлөрүүлсэн.	1,472.4	1,368.5	Улсын төсөвт 30.0 тэрбум төгрөг төлөрүүлэхээс 32.7 тэрбум төгрөг төлөрүүлж, гүйцэтгэл 109.5 хувийн биелэлттэй байна.
		26.1.16	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийгдсэн орд газруудыг бүртгэлжүүлэн, улсын төсвөөс хайгуулын ажилд гарсан зардлыг нөхөн төлөх тухай гэрээний дагуу нөхөн төлбөрийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх	Орлогыг бүрэн төлөрүүлсэн байх	7.7 тэрбум төгрөг төлөрүүлсэн.	1,218.3	1,115.3	Тус орлогоор 6.6 тэрбум төгрөг төлөрүүлэхээс 7.7 тэрбум төгрөгийг улсын төсөвт төлөрүүлээд байна. Гүйцэтгэлээр 117 хувийн биелэлттэй байна.
27	**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД**					**2,379,867.5**	**2,229,805.4**	
	27.1	**Нийгмийн халамж**				**1,699,011.1**	**1,602,272.8**	
		27.1.1	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн олголтын хувь	95	95	Нийгмийн халамжийн тэтгэвэр 174,977.20 Асаргааны тэтгэмж 55,237.40 Амьжиргаг дэмжих мөнгөн тэтгэмж 36,154.69 Цаатан иргэний тэтгэмж 763.1	Нийгмийн халамжийн тэтгэвэр 162,825.79 Асаргааны тэтгэмж 58,429.90 Амьжиргаг дэмжих мөнгөн тэтгэмж 40,579.10 Цаатан иргэний тэтгэмж 745.82	2020 онд нийгмийн халамжийн тэтгэвэрт 59,110 иргэн хамрагдаж 162,8 тэрбум төгрөг, асаргааны тэтгэмжид 64,320 иргэн хамрагдаж, 58,4 тэрбум төгрөг, онцгой тохиолдлын болон амьжиргаг дэмжих мөнгөн тэтгэмжид 57,408 иргэн хамрагдаж, 40,5 тэрбум төгрөг, цаатан иргэнд олгох тэтгэмжид 397 иргэн хамрагдаж, 745,8 сая төгрөг тус тус зарцууллаа. Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлын үед хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа шаардлагатай иргэдийн нийгмийн хамгааллыг сайжруулах, орлогыг нэмэгдүүлэх II багц арга хэмжээг хэрэгжүүлэхээр Монгол Улсын Засгийн газраас шийдвэрлэсэн. Энэ хүрээнд нийгмийн халамжийн сангаас олгож байгаа халамжийн тэтгэврийн хэмжээг 2020 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 1 дүгээр сарын 01-ний өдөр хүртэлх хугацааны сар бүр 288.000 төгрөгт хүргэж нэмэгдүүлэхээр шийдвэрлэж, нийгмийн халамжийн сангаас 188,0 мянган төгрөгийн тэтгэвэр, амьжиргаг дэмжих мөнгөн тэтгэмж авдаг дараах бүлгийн иргэд хамрагдсан.
		27.1.2	Зорилтот бүлэгт хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний хамрагдалт	93	93	57,728.6	52,520.7	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын "Тушаал, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 2018 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/13 дугаар тушаалаар нийслэлд өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн 292.5 ба түүнээс доош, аймагт 310.0 ба түүнээс доош босго оноотой байгаа нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн иргэнд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээг үзүүлж байна. 2020 оны жилийн эцсийн байдлаар хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 44,348 өрхийн нийт 241,988 иргэн, үүнээс том хүн 123,514 хүүхэд 118,474 хамруулж, 52,5 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 05 сарын 06-ны өдрийн 167 дугаар тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 05 сарын 08-ны өдрийн А/117 дугаар тушаалаар 2020 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01 хүртэлх хугацаанд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэдэд олгох хүнсний эрхийн бичгийн мөнгөн дүнг 2 дахин нэмэгдүүлэн олгохоор заасан. 2020 оны 09 дүгээр сарын 30-ны Засгийн Газрын дугаар 126 дугаар Тогтоолоор 2020 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 01 дүгээр сарын 01 хүртэлх насанд хүрсэн иргэнд олгох хүнсний эрхийн бичгийн мөнгөн дүнг 32000 төгрөгөөр, нэг хүүхэд 8000 төгрөгөөр олгохоор өөрчлөн тогтоосон. Хүнсний цаасан эрхийн бичгийг цахим эрхийн бичигт шилжүүлэх ажлыг зохион байгуулж, тус үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэд хүнсний эрхийн бичгийг үйлчилгээг 100 хувь цахим хэлбэрээр авч байна.
		27.1.3	Ахмад настнуудад насны хишиг олгох /хувь/	96	96	22,883.7	22,734.2	Ахмад настны тухай хуулийн 12.2-т заасны дагуу 65 ба түүнээс дээш насны ахмад настанд Цагаан сар, Ардын хувьсгалын ойн баяр наадмыг тохиолдуулан жилд 2 удаа Насны хишиг олгохоор хуульчилсан. 2020 оны жилийн эцсийн байдлаар 141,765 ахмад настанд 21,7 тэрбум төгрөгийн тэтгэмжийг олгоод байна.
		27.1.4	Цалинтай ээж хөтөлбөр буюу 0-3 насны хүүхэд асарсны тэтгэмж /хувь/	96	96	110,685.90 /ихэр хүүхдийн тэтгэмж, өрх толгойлсон эх эцгийн тэтгэмжийг оролцуулан/	89,940.8	Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эхэд тэтгэмж олгох тухай хууль, Засгийн газрын 2017 оны 340 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу дараах тэтгэмжийг олгож байна. Эх, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хууль, журмын хэрэгжилтийг хангах хүрээнд 2020 оны жилийн эцсийн тайлангийн дүнгээр 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжид 196,944 иргэнийг хамруулж, 89,9 тэрбум төгрөг олгосон байна. Нийгмийн халамжийн үйлчилгээг үе шаттайгаар цахим хэлбэрт шилжүүлж, төрийн үйлчилгээг ил тод, шуурхай, хүртээмжтэй, хүнд сурталгүй хүргэж ажиллах хүрээнд Эх, олон хүүхэдтэй эх, эцэгт олгох тэтгэмжийг 2020 оны 8 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн Халамжийн нэгдсэн систем /ehalamj.mn/-ээр дамжуулан олгож байна.
	27.2	**Нийгмийн даатгал**				**413,056.8**	**401,411.3**	
		27.2.1	Нийгмийн даатгалд хамрагдсан ажил олгогчийн тооны өсөлт /өмнөх жилд харьцуулсан хувиар/	5.5	2.2			2020 оны жилийн эцсийн байдлаар 49,284 ААНБ хамрагдаж өмнөх оныхтой харьцуулахад 2,2 хувиар өссөн байна. 2020 оны ажил олгогчоос төлөх шимтгэлийн орлогын батлагдсан төсөв 714.2 тэрбум төгрөг, гүйцэтгэл 753.7 тэрбум төгрөг байна. Цар тахлын нөхцөл байдлын улмаас эдийн засаг бүхэлдээ хүндэрсэнтэй холбоотойгоор ажил олгогч, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа доголдож, орлого буурч, ажлын байрыг цөөлсөн нь нийгмийн даатгалын хамрагдалтад нөлөөлсөн.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
		27.2.2	Нийгмийн даатгалд даатгуулсан даатгуулагчийн тооны өсөлт /өмнөх жилд харьцуулсан хувиар/	2.5	(0.9)	413,056.8	401,411.3	2019 оны байдлаар нийгмийн даатгалд 1,157,232 иргэн нийгмийн даатгалд хамрагдсан бол 2020 оны жилийн эцсийн байдлаар 1,146,499 иргэн хамрагдав өмнөх оныхтой харьцуулахад 0.9 хувиар буурсан байна. 2020 оны даатгуулагчаас төлөх шимтгэлийн орлогын баталгдсан төсөв 645.2 тэрбум төгрөг, гүйцэтгэл 663.7 тэрбум төгрөг байна. Цар тахлын нөхцөл байдлын улмаас эдийн засаг бүхэлдээ хүндэрсэнтэй холбоотойгоор ажил олгогч, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа доголдож, орлого буурч, ажлын байрыг цөөлсөн нь нийгмийн даатгалын хамрагдалтад нөлөөлсөн.
		27.2.3	Нийгмийн даатгалын үйлчилгээ авсан хүний тоо /давхардсан тоогоор мянган хүн/	707.3	657.2			2020 оны жилийн эцсийн байдлаар нийгмийн даатгалын 4 төрлийн сангаас нийт давхардсан тоогоор 657,2 мянган иргэн үйлчилгээ авсан байна. 2020 онд тэтгэвэр, тэтгэмж, тусламж үйлчилгээний зардалд 2.466.8 сая төгрөг зарцуулахаар баталснаас 2.425.0 сая төгрөг зарцуулсан байна.
	27.3	**Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөр**				**30,243.1**	**26,168.1**	
		27.3.1	Хүүхэд хамгаллын анхан шатны үйлчилгээ авсан хүүхдийн эзлэх хувь	5.5	Төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан	30,243.1	26,168.1	Байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэл насны хүүхэд тус тус хамрагдлаа.
		27.3.2	Хүүхдийн асуудлаар хүлээн авсан өргөдөл, гомдлын шийдвэрлэлт /хувь/	99	Төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан			Төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан
		27.3.3	Гэр бүлийн хөгжил, ахмад настны төвөөр үйлчлүүлсэн хүний тоо /хувь/	45	Төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан			Төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан
		27.3.4	Залуучуудын хөгжлийн төвөөр үйлчлүүлсэн хүний тоо /хувь/	45	Төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан			Төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан
		27.3.5	Ахмад настны хөгжил, хамгааллын талаарх төрийн бодлого, үйл ажиллагааны сургалт, сурталчилгаанд хамрагдаж байгаа ахмад настны эзлэх хувь	90	Төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан			Төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан
		27.3.6	Сэргээн засах үйлчилгээнд хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эзлэх хувь	11.5	Төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан			Төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан
	27.4	**Хөдөлмөр, нийгмийн хамгааллын бодлого, удирдлага**				**10,250.1**	**9,018.4**	
		27.4.1	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын бодлого, стратеги, хууль тогтоомж, тогтолцоог боловсронгуй болгож, үр дүнтэй хэрэгжүүлэх	Салбарын үйл ажиллагааны хэрэгжилтээр	Төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан	10,250.1	9,018.4	1.Нийгмийн даатгалын багц хуулийн төсөл: -Засгийн газар тэтгэврийн шинэчлэл хийх, олон давхаргат тэтгэврийн тогтолцоог бүрдүүлэх хувийн тэтгэврийн нэмэлт даатгалын тогтолцоог нэвтрүүлэх, хөгжүүлэх зорилт тавин ажиллаж байна. · Монгол Улсын Засгийн газар шинэчлэн байгуулагдаж, Монгол Улсын Их Хурлаас 2020 онд баталсан “Алсын хараа-2050”, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” зэрэг бодлогын баримт бичгүүд батлагдсантай холбогдуулан Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг дахин боловсруулахаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 10 дугаар сарын 07-ны А/197 дугаар тушаалаар ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. · Ажлын хэсэг байгуулагдсанаас хойш 20 гаруй удаа хуралдаж хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг шинэчлэн боловсруулж 12 дугаар сарын 3-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн сайд болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд хамтран батлаад байна. · Түүнчлэн Нийгмийн даатгалын ерөнхий (Нийгмийн даатгалын ерөнхий хуулийг дагалдах 10 хуулийн төсөл), Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалсан евчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулиудын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу боловсруулж, хуулийн төслүүдийн үр нөлөөний, зардлын тооцооны судалгаат дахин боловсруулж ажиллаж байна. 2.Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл: -Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгэр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”–ийн 2.5.7-д “Өрхийн амьжиргааны түвшнийг тогтоох аргачлалыг боловсронгуй болгож, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг туушгай бууруулна” гэсэн зорилт тусгагдсан. · Монгол Улсын Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн шинэчлэн байгуулагдаж, Монгол Улсын Их Хурлаас 2020 онд баталсан “Алсын хараа-2050”, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр” зэрэг бодлогын баримт бичгүүд батлагдсантай холбогдуулан Нийгмийн халамжийн тухай хуулийн төслийг дахин боловсруулахаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 12 дугаар сарын 24-ны А/243 дугаар тушаалаар ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан.
		27.4.2	Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн 3 талт ажиллагааны хүрээнд хийгдсэн ажил	Салбарын үйл ажиллагааны хэрэгжилтээр	Төлөвлөгөөг хэрэгжүүлж ажилласан			Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний Хорооны 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолоор Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт 2019-2020 оны Улсын хэлэлцээрийн хэрэгжилт 88,6 хувьтай дүгнэгдсэн байна. Хэлэлцээрт бүрэн хэрэгжсэн 26 заалт, 80-90 хувийн хэрэгжилттэй 13, 60-70 хувийн хэрэгжилттэй 8, 20-40 хувийн хэрэгжилттэй 2 заалт байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, нийгэмд тогтвортой байдлыг хадгалах, хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин орлогыг нэмэгдүүлэх, ажиллагчдын цалин хөлс, нийгмийн баталгаат хангах, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн хамгааллыг сайжруулах, нийгмийн түншлэлийг хөгжүүлэхэд энэхүү хэлэлцээр ач холбогдлоо өгнө гэж үзэж байна. Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооны хурлыг 3 удаа зохион байгууллаа. Засгийн газрын төлөөлөл, МАОЭНХ, МҮЭХ-нд хэлэлцээрийн хэрэгжилтийн биелэлт болон хэлэлцээр эхлэх тухай албан тоотуудыг хүргүүлсэн ба 2021-2022 оны Улсын хэлэлцээрийг эхлүүлэд байна.

№	Төсвийн өрөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
								НҮБ-ын нийгмийн хөгжлийн хороонд 38 дугаар чуулганд 2020 оны 02 дугаар сард ХНХ-ын дэд сайд С.Менгөнчимэг тэргүүтэй төлөөлөгчид оролцсон. -Нэгдсэн Үндэстний Байгууллагын Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенцын хэрэгжилтийн тухай Монгол Улсын Засгийн газрын тайланг 2020 оны I улиралд багтаан, МУ-ын ЗГ-аар хэлэлцүүлж, НҮБ-ын конвенцын хороонд хүргүүлсэн. -Монгол Улсын Засгийн газар нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүн амын сан, Хүүхдийн сан, Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага болон Хүнс, хөдөө, аж ахуйн байгууллагатай хамтран малчдын нийгмийн даатгалын талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, тэдний бизнесийн санаа, хоршооны үйл ажиллагааг сайжруулах, хэрэгжүүлэх, шинэ технологи, инновацыг ашиглах замаар хамрагдалтыг нэмэгдүүлж, малчин өрхийн ган, зуд гэх мэт байгалийн гамшиг, цочролд бэлэн байдлыг нэмэгдүүлэх, цочролын дараах нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах зорилгоор "Малчдын нийгмийн даатгалыг өргөжүүлж, цочролд бэлэн байдлыг нэмэгдүүлэх нь" төслийг 2020-2022 онд хэрэгжүүлж эхлээд байна. -"Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс хоорондын хэлэлцээр"-ийн төслийг хэлэлцэх шинжээчдийн 5 дугаар хэлэлцээг 2020 оны 6 дугаар сарын 30-ны өдөр цахим хэлбэрээр мөн 6 дугаар хэлэлцээг 10 дугаар сарын 19-ний өдрүүдэд тус тус цахим хэлбэрээр зохион байгууллаа. 3-р шатны хэлэлцээг 12 дугаар сарын 21-ны өдөр цахимаар зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Дээрх хэлэлцээнүүдийг зохион байгуулахад тушаал боловсруулах, орчуулагчийн гэрээ байгуулах, Казахстаны талтай бэлтгэл ажлын асуудлаар холбогдох зэрэг ажлыг гүйцэтгэлээ. -"Ажиллангаа амрах зохицуулалтын тухай Монгол Улс, Австрали Улс хоорондын Санамж бичиг"-ийн төсөлд бичвэрийн өөрчлөлт оруулж, Санамж бичигт ойрын хугацаанд гарын үсэг зурахыг хүссэн Австралийн хүсэлтийг Гадаад харилцааны яамаар дамжуулан хүлээж авсан. Айлын талын хүссэн өөрчлөлтийг оруулахыг зөвшөөрч, 4 дүгээр сарын эхээр санамж бичигт гарын үсэг зурах саналыг Гадаад харилцааны яамаар дамжуулан Австралийн талд тавьсан. Ковид-19 цар тахлын тархалттай холбогдуулан гарын үсэг зурах асуудлыг хойшлуулах тухай Австралийн талын саналыг Монгол Улсаас Австрали Улсад суугаа элчин сайдын яамнаас E/17/20/249 тоот цахим шуудангаар 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр ирүүлэзд байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа Австрали Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Дэвид Воусэнтэй 2020 оны 07 дугаар сарын 30-ны өдөр
	27.5	**Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих**				**89,014.2**	**68,901.6**	
		27.5.1	Ажилгүйдлийн түвшин /хувиар/	7.8	7.6	89,014.2	68,901.6	Ажилгүйдлийн түвшин 2019 онд ажил эрхлээгүй нийт хүн амаар тооцсон ажилгүйдлийн улсын дундаж түвшин 10 хувь, 2020 оны IV улиралд 7,6 хувь байна. Хүйсээр авч үзвэл эрэгтэйчүүдийн ажилгүйдлийн түвшин 7,3 хувь, эмэгтэйчүүдийнх 7,9 хувьтай байна. Улаанбаатар хотын хүн амын ажилгүйдлийн түвшин 6,3 хувь буюу улсын дунджаас 1,3 пунктээр дээгүүр байна. Ажилгүйдлийн түвшин Баруун бүсэд 8,8 хувь, Зүүн бүсэд 10,8 хувь, Төвийн бүс 8,1 хувь, Хангайн бүсэд 7,9 хувь байна. Мөн ажиллах хүчний оролцооны түвшин буюу хөдөлмөрийн насны нийт хүн амд эзэлж байгаа ажиллах хүчний хувь хэмжээ 2020 оны IV улирлаар 57 хувь ба 2019 онд 60.5 хувьд хүрсэн үзүүлэлттэй байна.
		27.5.2	Хөдөлмөр эрхлэлтийн түвшин /хувиар/	56.6	52.7			Хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2019 онд 54,4 хувь, 2020 оны IV улирлаар 52,7 хувь ба хүйсээр авч үзвэл эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин 60,4 хувь, эмэгтэйчүүдийнх 46,1 хувьтай байна. Улаанбаатар хотын хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшин 48,9 хувь буюу улсын дунджаас 3,8 пунктээр доогуур байна. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин баруун бүсэд 54,6 хувь, зүүн бүсэд 57,8 хувь, төвийн бүс 56,8 хувь, хангайн бүсэд 56,5 хувь байна. 2019 оны жилийн эцэстэй харьцуулахад эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин 0,4 пунктээр, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2,6 пунктээр буурч, улсын хэмжээний нийт хөдөлмөр эрхлэлтийн түвшин 52,7 хувьд хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,7 хувиар буурсан байна.
		27.5.3	Шинээр бий болсон ажлын байрны тоо /мянган хүн/	40	31.8			Улсын хэмжээнд 2020 оны 12 сард нийт 31,800 ажлын шинэ байр бий болж, түүнд ажилгүй иргэдийг байршуулсан байна. Ажлын шинэ байрны бүртгэлийг аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтсүүдийн ажлын байрны бүртгэл хариуцсан мэргэжилтнүүд Ажил олгогч байгууллагуд болон аж ахуйн нэгжтэй холбогдон хамтран бүртгэх ажлыг хийж гүйцэтгэж байна. Ажлын шинэ байранд ажилд орсон иргэдийг өмнөх оны мөн үетэй харьцуулан авч үзвэл 1,525 хүнээр буюу 4.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна.
		27.5.4	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зээл авсан иргэний тоо /мянган хүн/	10	1.05			Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж байгаа Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн хүрээнд 2020 онд бичил бизнес эрхлэгчдэд жижиг зээл олгох ажлыг 21 аймаг, УБ хотын 9 дүүрэгт Төрийн банк, ХААН банкаар дамжуулан зохион байгууллаа. Үүнд нийт 8.73 тэрбум төгрөгийн зээлийг 21 аймгийн 986 бичил бизнес эрхлэгчид, 694.1 сая төгрөгийн зээлийг УБ хотын 69 бичил бизнес эрхлэгч тус тус олгов. Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээнд нийт 599 иргэн хамрагдав. Жижиг зээлээр дамжуулан улсын хэмжээнд 1,269 ажлын байрыг хадгалж, 844 ажлын байрыг шинээр бий болгосон үр дүнтэй ажиллалаа.
	27.6	**Мэргэжлийн боловсрол**				**135,410.8**	**119,384.9**	
		27.6.1	Мэргэжлийн боловсрол эзэмшсэн төгсөгчийг ажлын байраар хангах /хувиар/	67	51.5			Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын байгууллагуудад 2019-2020 оны хичээлийн жилд статистик мэдээгээр 18,887 суралцагч төгссөн. Төгсөгчдийн 8,737 буюу 46.3% нь төгсөнгүүтээ шууд ажлын байртай, 987 буюу **5.2%** нь дараагийн шатны сургалтын байгууллагад дэвшин суралцсан байна. Нийт төгсөгчдийн 14,263 буюу 75.5 хувь нь мэргэжлийн боловсрол, 2460 буюу 13.0 хувь нь техникийн боловсрол, 2,164 буюу 11.5 хувь нь мэргэжлийн сургалтад суралцаж төгссөн байна. 2020 онд төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт бага байгаа нь коронавирус цар тахлын улмаас хорио цээр тогтоосноос үүдэлтэйгээр аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаа хэвийн бус болсноос шалтгаалж байна

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
		27.6.2	Мэргэжлийн боловсролын байгууллагын дадлагын болон сургалтын баазыг шинэчлэх /тоогоор/	15	15	Улсын төсөв 14.9 тэрбум төгрөг Гадаадын тесел 9.7 сая доллар	Улсын төсөв 5.8 тэрбум төгрөг Гадаадын тесел 8.2 сая доллар	Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2020 онд санхүүжүүлэх төсөл арга хэмжээнд нийтдээ 9 мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дотуур байр, хичээлийн байр завсарлах, барих, тоног төхөөрөмж худалдан авахаар 14.9 тэрбум төгрөг батлагдсанаас 2020 онд 5.8 тэрбум төгрөгийн санхүүжүүлж хөрөнгө оруулалт, засвар үйлчилгээ хийгдэд байна. Төсөл хөтөлбөрийн хүрээнд Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй "Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дэшлүүлэх" төслийн хүрээнд барилга, зам тээвэр, хөдөө аж ахуйн салбарын мэргэжлээр сургалтын үйл ажиллагаа эрхлэн явуулж буй 19 сургалтын байгууллагын 15 мэргэжлийн чиглэлээр дадлагын сургалтын орчныг 2015 оноос эхлэн барьж сайжруулах ажлын хүрээнд 6 дадлагын байр, 9 өвлийн хүлэмж /залгаа барилгын хамт/, 11 худаг, 6 цахилгааны подстанц, 3 дулааны ялтсан солилцуур, 2 халаалтын зуух барьж, суулгаж угсраад байна. 2020 оны хувьд COVID-19 цар тахлын амаргүй нөхцөлд төслийн нийт хөрөнгө оруулалтын 80 гаруй хувь нь хийгдсэн.
	27.7	**Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг сайжруулах**				**2,159.4**	**2,001.5**	
		27.7.1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр шинэчлэн боловсруулах дүрэм, журам, стандарт	3	3	2,159.4	2,001.5	ХАБЭА-н Үндэсний хорооны 2020 оны 01 тогтоолоор "Ажлын байранд короновирусын халдвараас урьдчилан сэргийлэх шалгах хуудас"-ны загварыг батлуулж, салбарын яамд, МХЕГ, аймаг, дүүргийн ХХҮГ-уудад хүргүүлсэн. "Хязгаарлагдмал орчинд ажиллах аюулгүй ажиллагааны заавар"-ын төслийг боловсруулсан. "Ажлын байран дахь тоосны өртөлтөөс ажилтны эрүүл мэндийг хамгаалахад мөрдөх тоосны техникийн зохицуулалтын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар батлуулахаар ЗГХЭГ-т хүргүүлсэн.
		27.7.2	Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэсэн ажлын байрны тоо	1700	1832			Сайдын 2015 оны А/223 тоот тушаалаар батлагдсан "Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журам" –ын 2.1-д зааснаар аж ахуйн нэгж байгуллага нь ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлөө сайжруулах, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор стандартын асуудал эрхэлсэн байгууллагын итгэмжлэл бүхий мэргэжлийн байгууллагаар хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгүүлэх үүрэгтэй. Энэ хүрээнд итгэмжлэл бүхий 4 байгуллага хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг 2020 онд нийт 225 аж ахуй нэгж, байгуллагын 1832 ажлын байранд хийсэн байна.
	27.8	**Хөдөлмөр эрхлэлтийн судалгаа, шинжилгээ**				**722.0**	**646.8**	
		27.8.1	Хөдөлмөрийн салбарын хүрээнд хийсэн судалгааны тоо	6	6	148.0	147.7	"Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгаанд нийт 2,269 ААНБ хамрагдсан. Судалгааны мэдээлэлд үндэслэсэн хөдөлмөрийн зах зээлийн богино хугацааны буюу 2021 оны эрэлтийг тодорхойлж, зөвлөмжийг боловсруулсан. "Тегсегчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа":Судалгааны арга аргачлалыг боловсруулан, судалгааны мэдээлэл цуглуулалтад 3,671 хүн хамрагдсан. "Барилгын салбарын ажиллах хүчний онлайн судалгаа": Улаанбаатар хот болон орон нутагт судалгааны сургалтыг зохион байгуулж, 706 ААНБ-ын төлөөллийг хамруулсан. Хөдөлмөрийн зах зээлийн дунд, урт хугацааны таамаглал, загварчлалыг хөгжүүлэх: -Австрали улсын Бодлогын судалгааны төв (Center of Policy Studies)-өөс хүлээн авсан Монгол Улсын эдийн засгийн динамик суурь загварт COVID-19 цах тахлын нөлөөг агуулсан симуляци хийсэн. ХХҮЕГ-ын 2015-2020 оны шинэ ажлын байранд зуучлагдсан иргэдийн тоон мэдээлэлд үндэслэн 2020-2024 он хүртэлх шинэ ажлын байрны таамаглал, Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн барометрийн судалгааны 2014-2019 оны дата ашиглан 2020-2024 онд шинээр бий болох ажлын байрны таамаглалыг ЭЗҮАС-аар тус тус боловсруулсан. "Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын тохиолдлын тоон шинжилгээ": ХНХЯ-ны Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын захиалгын дагуу Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын судалгааны хөтөлбөрийг боловсруулсан. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын судалгааны хөтөлбөрийг боловсруулсан. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын судалгааны хөтөлбөрийг боловсруулсан. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын судалгааны хөтөлбөрийг боловсруулсан. Хөдөлмөр, нийгмийн хамгаллын салбарын статистик-2019 эмхэтгэл гаргав.
28	**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САИД**					**362,942.2**	**347,881.2**	
	28.1	**Мал аж ахуй**				**49,883.3**	**40,904.1**	
		28.1.1	Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ /сая толгой, давхардсан тоогоор/	82.6	69.9	49,883.3	40,904.1	Малын халдварт болон халдварт өвчинтэй тэмцэхэд 7 нэр төрлийн вакциныг давхардсан тоогоор 23.4 гаруй сая толгой малыг, архаг халдварт бруцеллёзоос сэргийлэх вакцин 14.7 сая толгой охин төлийг, гоц халдварт өвчинтэй 24.7 сая толгой мал хамрагдсан байна. Малын эрүүл мэндийн тухай хууль батлагдсанаар малын халдварт 19 нэр төрлийн вакциныг улсын төсвөөс дааж хамруулж байсан болон 7 нэр төрлийн вакцин болгон багассанаас шалтгаалж малын тоо буурсан.
		28.1.2	Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх /өссөн хувиар/	20	20			2020 оны жилийн эцсийн байдлаар 2004 аж ахуйн нэгж сүүний чиглэлийн 97.3 мянган толгой сүүний чиглэлийн үхэр, 594 аж ахуйн нэгж махны чиглэлийн 28.6 мянган толгой үхэр, 3045 аж ахуйн нэг мах, ноосны чиглэлийн 512.2 мянган толгой хонь, 83 аж ахуйн нэгж, 754 өрх 22.3 мянган толгой гахайн эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.
		28.1.3	Бэлчээрийн ургамал хамгаалал /мянган га/	1390	1366			Бэлчээрийн хортон мэрэгчидтэй тэмцэх ажлыг улсын төсвийн хөрөнгөөр 2020 онд 1300 мянган га талбайд үлийн цагаан оготно, 66.0 мянган га талбайд царцаатай тэмцэх ажлыг зохион байгуулж ажилласан.
	28.2	**Газар тариалан**				**28,818.8**	**20,206.3**	
		28.2.1	Буудайн үйлдвэрлэлийг дэмжих /мянган тонн/	440	430.3	28,818.8	20,206.3	2019 онд 242,8 мянган тонн хүнсний улаанбуудай ХААДСан болон гурилын үйлдвэрүүдэд нийлүүлсэн 797 иргэн, аж ахуйн нэгжид олгосон мөнгөн урамшуулал. /Статистикийн урьдчилсан мэдээ/
		28.2.2	Төмс, хүнсний ногоо /мянган тонн/	270	365.5			2020 оны ургацын балансаар төмс 244.3 мянган тонн, хүнсний ногоо 121.2 мянган тонныг хураан авлаа.
	28.3	**Хүнсний үйлдвэрлэл**				**5,395.0**	**318.7**	
		28.3.1	Хүн амын сүүний хэрэглээг үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан сүүгээр хангах /сая литр/	150	171.1	5,395.0	318.7	Үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүний хэмжээ 2020 оны жилийн эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр 171.1 сая.литр сүү, сүүн бүтээгдэхүүнийг үйлдвэрийн аргаар боловсруулахаар байна. Засгийн газрын 2020 оны 130 дугаар тогтоол "Сүү боловсруулах үйлдвэр цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд мөнгөн урамшуулал олгох журам"-ын дагуу сүү боловсруулах 8 үйлдвэр, цехэд 11 дүгээр сард 1,939,944 литр үнээний шингэн сүү бэлтгэн нийлүүлсэн 2375 малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд мөнгөн урамшуулал олгосон.

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
		28.3.2	Үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан махны хэрэглээг нэмэгдүүлэх /мянган тонн/	20	21.2			2019-2020 онд ХХБ, Голомт, Хаан, Капитрон, Төрийн банкны шаардлага хангасан 12 аж ахуйн нэгжийн нийт 8.8 мянган тонн нөөцийн мах бэлтгэхээр авсан 46.7 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн хөнгөлөлт. 2020-2021 онд ХХБ, Голомт, Хаан, Капитрон, Төрийн банкны шаардлага хангасан 16 аж ахуйн нэгжийн нийт 12.4 мянган тонн нөөцийн мах бэлтгэхээр авсан 68.3 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн хөнгөлөлт /2020 оны төлбөр/
	28.4	**Хөдөө аж ахуй, газар тариалангийн бодлого, удирдлага**				**267,176.5**	**267,506.6**	
		28.4.1	Улсын Их Хурал, Засгийн газраас баталсан шийдвэр, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх /тоогоор/	5	5	267,176.5	267,506.6	Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2020 оны үндсэн чиглэл, Улсын Их Хурлаар батлагдсан Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, Төрөөс малчдын талаар баримтлах бодлого, Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого, УИХ, Засгийн газраас батлагдсан Монгол мал, Сав баглаа боодол, Малын эрүүл мэнд, Хүнсний ногоо, Жимс, жимсгэнэ, Үйлдвэржилт 21:100, Ноолуур үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ үнэлгээ хийж ЗГХЭГ-т хүргүүлж ажилласан.
	28.5	**Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн судалгаа шинжилгээ**				**47.6**	**35.0**	
		28.5.1	Салбарын хэмжээнд хэрэгжүүлж дуусан нийгэм, эдийн засгийн чухал ач холбогдолтой, импортыг орлох, экспортыг дэмжих төслийн үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх	2	5	47.6	35.0	ХХААХҮСайдын 2020 оны А-231 дүгээр тушаалаар салбарын шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх ач холбогдол бүхий судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэхээр баталсан.
	28.6	**Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх, ажлын байр олгох**				**11,620.9**	**18,910.5**	
		28.6.1	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төслийн тоо	200-250	249	11,620.9	18,910.5	2020 онд жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор олгосон зээл нь 10 салбарт нийт 811 ажлын байр хадгалж, 1497 ажлын байр шинээр нэмэгдүүлсэн.
		28.6.2	Зээлийн батлан даалтын сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх /зээлдэгчийн тоо/	100-150	839			2020 оны жилийн эцсийн байдлаар Зээлийн батлан даалтын сан 839 иргэн, аж ахуйн нэгжид 231.0 тэрбум төгрөгийн зээлд 112.4 тэрбум төгрөгийн батлан даалт олгосон байна. /Зээлийн батлан даалтын сангаас өгсөн мэдээлэл/
29	**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД**					**1,058,645.3**	**986,939.9**	
	29.1	**Эмнэлгийн тусламж үйлчилгээ**				**490,356.2**	**490,304.5**	
		29.1.1	Эхийн эндэгдлийн харьцаа /100000 амьд төрөлтөд/	25	30.2	490,356.2	490,304.5	Жирэмсэнтэй хавсарсан эмгэгийн шалтгаант эхийн эндэгдэл нэмэгдсэнтэй холбоотойгоор эхийн эндэгдлийн харьцаа 2020 оны зорилтот түвшинд хүрээгүй байна.
		29.1.2	Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлтөд/	15	14			2020 оны жилийн эцсийн байдлаар эх, хүүхдийн эндэгдлийн түвшин 2019 оны мөн үеэс буурсан тедийгүй зорилтот түвшингээс доогуур үзүүлэлттэй байна.
		29.1.3	Нялхсын эндэгдлийн түвшин /1000 амьд төрөлтөд/	13	11.5			2020 оны жилийн эцсийн байдлаар эх, хүүхдийн эндэгдлийн түвшин 2019 оны мөн үеэс буурсан тедийгүй зорилтот түвшингээс доогуур үзүүлэлттэй байна.
		29.1.4	Зүрх судасны өвчний шалтгаант нас баралтын түвшин /10000 хүн амд ногдох/	17.2	16.2			10000 хүн амд ногдох Зүрх судасны өвчний шалтгаант нас баралтын түвшин 17.2 байгаа нь 2019 онд хүрэх зорилтот түвшингээс 0.1 пунктээр бага байгаа нь зорилтот түвшиндээ хүрсэн байна.
		29.1.5	Хорт хавдар өвчний шалтгаант нас баралтын түвшин /10000 хүн амд ногдох/	10.5	13.2			Хорт хавдрын өвчлөл жил бүр нэмэгдэх хандлагын дагуу нас баралтын түвшин нэмэгдсэн. Хорт хавдрын нас баралтын түвшнийг бууруулахад хавдрын эрт үеийн оношилгоог нэмэгдүүлж, хавдрын урьдчилан сэргийлэх үзлэгт иргэд идэвхтэй оролцох чухал байна
		29.1.6	Вируст гепатит өвчний тохиолдлын түвшин	1.6	1.1			10,000 хүн амд ногдох вируст гепатит өвчний тохиолдлын түвшин 1.1 байгаа нь 2020 онд хүрэх зорилтот түвшингээс 0.5 пунктээр бага буюу зорилтот түвшиндээ хүрсэн байна.
		29.1.7	Жирэмсний эрт үеийн хяналтын хувь	88.1-ээс доошгүй	89.9			Жирэмсний эрт үеийн хяналтын хувь 2020 оны жилийн эцсийн байдлаар 89.9 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.2 хувиар, зорилтот түвшнээс 1.8 хувиар тус тус дээгүүр үзүүлэлттэй байна.
		29.1.8	Амбулаторийн нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь /өрх, сумын эрүүл мэндийн төвийн түвшин/	30.0-аас доошгүй	46.7			Амбулаторийн нийт үзлэгт урьдчилан сэргийлэх үзлэгийн эзлэх хувь 46.7 байгаа нь 2020 онд хүрэх зорилтот түвшингээс 16.7 хувиар өндөр байна.
	29.2	**Нийгмийн эрүүл мэнд**				**107,550.0**	**107,547.5**	
		29.2.1	Товлолт дархлаажуулалтын хамралтын хувь	98.5	96.4	107,550.0	107,547.5	Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжийн дагуу товлолт дархлаажуулалтын хамралтын хувийг 2 хүртэлх насанд Улаанбурхан-гахайн хавдар-улаануд өвчний эсрэг дархлаажуулалтын 2 дугаар тунд хамрагдсан хүүхдийн хувиар тооцсон бөгөөд 2020 оны зорилтод түвшиндээ хүрсэн үзүүлэлттэй байна.
		29.2.2	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн хамралтын хувь	75	44.7			Бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдал шилжсэнтэй холбоотойгоор иргэдийн хөдөлгөөн хязгаарлагдаж, эрт илрүүлгийн хамралт буурсан.
		29.2.3	Чихрийн шижин өвчний эрт илрүүлгийн хамралтын хувь	80	88.7			Эрт илрүүлэг хийх насны ангилалд өөрчлөлт орсонтой холбоотойгоор илрүүлгийн хувь тооцоолох аргачлалд өөрчлөлт орсон.
		29.2.4	Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн хамралтын хувь	60	39			Бүх нийтийн болон өндөржүүлсэн бэлэн байдал шилжсэнтэй холбоотойгоор иргэдийн хөдөлгөөн хязгаарлагдаж, эрт илрүүлгийн хамралт буурсан.
	29.3	**Эрүүл мэндийн бодлого, удирдлага**				**60,419.7**	**59,596.3**	
		29.3.1	Эмч, сувилагчийн харьцаа	0.000711806	0.0007	60,419.7	59,596.3	Шалгуур үзүүлэлт зорилтот түвшиндээ хүрээгүй боловч өмнөх оны түвшинд хадгалагдаж байна.
		29.3.2	Төгсөлтийн дараах сургалтад хамрагдсан эмч, сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтний тоо	12663	6488			Коронавируст халдварын цар тахлын улмаас улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжих, хөл хорио тогтоосон зэргээс шалтгаалан төлөвлөсөн зарим сургалтууд зохион байгуулагдаагүй болно.
		29.3.3	Гадаадад мэргэжил дээшлүүлсэн эмнэлгийн мэргэжилтний тоо	70	0			Коронавируст халдварын цар тахлын улмаас хөл хорио тогтоож хил хаасантай холбоотойгоор 2020 онд гадаадын улс орнуудад эмнэлгийн мэргэжилтэн суралцуулаагүй болно.
	29.4	**Эрүүл мэндийн даатгал**				**400,319.4**	**329,491.6**	
		29.4.1	Эрүүл мэндийн даатгалд даатгуулагчийн тооны өсөлт /өмнөх жилтэй харьцуулсан хувиар/	3.3	3	400,319.4	329,491.6	КОВИД-19 цар тахлын үед иргэн, аж ахуйн нэгжийн орлого, эдийн засгийн үзүүлэлт буурсан зэргээс шалтгаалан эрүүл мэндийн даатгалын хамрагдалт буурсан байна.
		29.4.2	Эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээ авсан хүний тоо /давхардсан тоогоор сая хүн/	7.5	8.6			КОВИД-19 цар тахлын үед хөдөлгөөний хязгаарлалт болон бусад нөхцөл байдлаас шалтгаалан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авсан хүний тоо буурсан.
30	**ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД**					**61,924.4**	**45,457.2**	
	30.1	**Дулаан хангамжийн өргөтгөл, шинэчлэлт**				**27,060.9**	**19,864.8**	

№	Төсвийн ерөнхийлөн захирагч, түүний хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн үзүүлэлт			2020 оны зорилтот түвшин	2020 онд хүрсэн түвшин	Батлагдсан төсөв /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	Тайлбар, танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/
		30.1.1	Дулааны шугам сүлжээний өргөтгөл /шинээр хийгдэх ажлын тоо, хүчин чадал км/	2/7.4 км	3/8.4 км	20,744.7	15,228.2	2020 онд "Халаалтын зуухнуудын төвлөрсөн дулааны холболт" төсөл арга хэмжээний хүрээнд дараах 2 багц ажлыг хийснээс багц-2 болох "ДЦС-4" ТӨХК-иас Яармаг хүртэлх дулааны 2ф600мм голчтой 2.3 км дулааны шугамын барилга угсралтын ажил бүрэн дуусаж ашиглалтад орсон бол 2020 оны төсвийн тодотголоор 2020 онд анх батлагдсан санхүүжилтийг 3.0 тэрбум төгрөгөөр бууруулснаас болж багц 1 "У-18 цэгээс 7и магистраль ДХ-7138 дугаар цэг хүртэл шинээр 2Ф700мм голчтой 3.3 км дулааны шугамын барилга угсралтын ажил"-ын ажлын гэрээ сунгагдаж барилга угсралтын ажил хийгдэж байна. Мөн Улаанбаатар хотын 12А магистраль дулааны шугам 4.9 км шугамын улсын комисс ажиллаж хүлээн авсан.
		30.1.2	Халаалтын зуухыг буулгаж төвлөрсөн дулаан хангамжид холбох /шинээр хийгдэх ажлын тоо, төвлөрсөн дулаан хангамжийн системд холбох техникийн нөхцөл бүрдүүлэх/	70	74	6,316.2	4,636.6	2020 онд "Нийслэлийн агаарын орчны бохирдлыг бууруулах" хөтөлбөрийн хүрээнд "Халаалтын зуухнуудын төвлөрсөн дулааны холболт" төсөл арга хэмжээг хийж төвлөрсөн дулааны системд 1 хороололд 25 зуух, Баянхошууд 53 зуух нийт 78 ширхэг халаалтын зуух татан буугдаж холбогдоход бэлэн болоод байна. Мөн Хувийн хэвшлийн барилга, орон сууцууд олноор төвлөрсөн дулааны системд холбогдсон мэдээлэл байна.
	30.2	**Цахилгаан эрчим хүчний хангамж**				**34,863.5**	**25,592.4**	
		30.2.1	Улаанбаатар хотын цахилгаан хангамжийн дамжуулах, түгээх сүлжээний өргөтгөл, шинэчлэлт /цахилгаантай болох айл, өрхийн тоо/	6103	6103	8,793.3	6,454.9	2020 онд Төвийн эрчим хүчинд холбогдоогүй айл, өрхүүдийг холбохоор Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүрэг, 7, 9, 24, 25 дугаар хорооны 852 айл өрхийн цахилгаан хангамжийг шийдвэрлэсэн бол УБ хотын "Сонгино" 220/110/35 кВ-ын 2х125 МВа дэд станц, 220 кВ-ын 5,8 км ЦДАШ, Сонгино дэд станцаас 110 кВ-ын Зайсан дэд станц хүртэлх 110 кВт-ын 44 км, хоёр хэлхээт ЦДАШ-ын ажлын зураг, барилга угсралтын ажлыг бүрэн дуусгаж ашиглалтад оруулснаар Улаанбаатар хотын зарим захын дүүргүүдийн айл өрхүүдийн хүчдэлийн уналтыг сайжруулсан.
		30.2.2	Орон нутгийн цахилгаан хангамжийн дамжуулах түгээх сүлжээний өргөтгөл, шинэчлэлт /шинээр хамрагдах сумын тоо/	30	27	26,070.2	19,137.5	2020 онд Томоохон баг, суурин газруудыг эрчим хүчээр хангах, сумдын 0.4 кВ-ын шугамын өргөтгөл, шинэчлэлт /Улсын хэмжээнд/ төсөл, арга хэмжээний хүрээнд нийт 17 багц ажил хийгдсэнээс гэрээний дагуу 2020 онд хийгдэх "Тайшир-Алтай ус төслийн барилга, байгууламжийн цахилгаан хангамжийн ажил", "Цогт сумаас Баянтоорой баг руу 15 кВ-ын ЦДАШ, дэд станц барих ажил", "Баянтоорой багийн нарны цахилгаан станцын өргөтгөлийн ажил" гэсэн 3 ажлыг бүрэн дуусгаж улсын комиссыг ажиллуулсан. Ховд аймгийн Жаргалант сумын Баянбулаг хүүхдийн зуслангийн цахилгаан хангамжийг шийдвэрлэсэн бол Баянтөс сумаас Тэс сум хүртэлх 15 кВ-ын 45 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц ашиглалтад оруулж тус сумыг төвийн эрчим хүчнээр хангаад байна. Увс аймгийн Наранбулаг сумын 35 кВ-ын 80,2 км цахилгаан дамжуулах шугам, дэд станцыг барьж ашиглалтад оруулсан бөгөөд тус аймгийн Улаангом,Түргэн, Наранбулаг, Бөхмөрөн сумдын 0.4 кВ-ын шугамыг бүрэн шинэчилсэн. Хөвсгөл аймгийн Төмөрбулаг, Их-Уул сумын Мандал, Сараалж багийг цахилгаантай болгосон байна. Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 2,7 дугаар багуудын айл, өрхүүдийн цахилгааны хүчдэлийг сайжруулж, ухаалаг 2 тарифт тоолуураар хангасан байна.
31	**ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ УЛСЫН КОМИССЫН ДАРГА**					**54,374.4**	**54,357.9**	
	31.1	**Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах үйл ажиллагаа**				**54,374.4**	**54,357.9**	
		31.1.1	Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн боловч хэрэг материал нь олдохгүй байгаа аймгуудын архивд байгаа 322, Тагнуулын ерөнхий газрын тусгай архивд байгаа хэргийг шалгаж дуусгах	228	1176	54,374.4	54,357.9	Аймаг, нийслэлийн салбар комиссуудаас энэ онд хийсэн ажлын дүн мэдээг нэгтгэн улсын комиссын гишүүдэд танилцуулж, Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллалаа. Салбар комиссын ажилтнуудад хуулийн нэмэлт өөрчлөлтийг таниулан сурталчлах , тэдэнд тулгамдаж байгаа асуудлын талаарх санал бодлыг сонсох, болоцоотой асуудлыг газар дээр нь хуулийн хүрээнд шийдвэрлэлээ. Мөн цагаатгагдаагүй иргэдийн
		31.1.2	Өөрөө хэлмэгдсэн болон хэлмэгдэгчийн эхнэр /нөхөр/-т орон сууцны дэмжлэг үзүүлэх	1	0			
		31.1.3	Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчид олгох нөхөх олговрыг үргэлжлүүлэн олгох	20	882			Хуулийн 13.2.2 дугаар зүйл заалтын шаардлага хангасан хэлмэгдэгчид батлагдсан төсөвт багтаан нөхөх олговрын мөнгийг олгосон.
		31.1.4	Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн 13.2.1, 13.2.2 дахь заалтыг үндэслэн нөхөх олговор олгох	963	901			ОХУ болон хөдөө орон нутагт байгаа хэлмэгдүүлэлттэй холбоотой түүх соёлын дурсгалт зүйлсийг сэргээн засварласан.
		31.1.5	Оросын Холбооны Улс болон хөдөө орон нутагт байгаа хэлмэгдүүлэлттэй холбоотой түүх соёлын дурсгалт зүйлсийг сэргээн засварлах	4	1			Улс төрийн хэлмэгдэгсдийн дурсгал мөнжүүлэх ажилтай холбогдсон эрдэм шинжилгээний бүтээл хэвлүүлсэн.
32	**СОЕЛЫН САЙД**					**180,810.8**	**129,486.6**	
	32.1	**Соёл урлаг**				**180,810.8**	**129,486.6**	
		32.1.1	Соёл, урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчийн тоо /хүн амд эзлэх хувиар/	75	2.354	180,810.8	129,486.6	Үндэсний статистикийн хорооны мэдээгээр Монгол Улсын хүн амын тоо 3,253,283. Соёл, урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчдийн нийт тоо 7,659,621 (үүнд урлагийн байгууллагаар үйлчлүүлэгчид 3,486,883; музейн үзэгчдийн тоо 336,872; номын сангийн байгнын уншигчдын тоо 328,581; соёлын төв, соёлын ордноор үйлчлүүлэгчдийн тоо 2,228,319, кино үзвэрийн байгууллагаар үйлчлүүлэгчдийн тоо 1,278,966) байгаа нь Монгол Улсын хүн амын нэг хүнд ногдох соёл, урлагийн байгууллагын үйлчилгээ 2.3 дахин буюу нэг хүн давхардсан тоогоор 2.3 удаа соёл, урлагийн үзвэр, үйлчилгээ авсан гэсэн үзүүлэлт юм. (Нийт хүн амын 75 хувь нь 2,439,962 хүн)
		32.1.2	Нийтийн номын сангийн байгнын уншигч /хүн амд эзлэх хувиар/	15	10.1			Үндэсний статистикийн хорооны мэдээгээр Монгол Улсын хүн амын тоо 3,253,283. Улсын хэмжээний байгнын уншигчийн тоо 328,581 байгааг нийт хүн амд эзлэх хувиар тооцоход 10.1% байна.
		32.1.3	Жилийн эцэст хүрсэн байх музейн үзмэрийн тоо /мянгаар/	280	247			2020 оны тайлан, мэдээгээр музейн үзмэрийн тоо 246,971 ширхэг байгаа нь Үндэсний статистикийн хорооноос зарласан 2019 оны тайлан, мэдээгээр 244,918 ширхэг үзмэр байсантай харьцуулахад 2,053 ширхгээр нэмэгдсэн.
		32.1.4	10000 хүнд ногдох номын тоо /мянган ширхэг/	30	19.3			Үндэсний статистикийн хорооны мэдээгээр Монгол Улсын хүн амын тоо 3,253,283. Улсын хэмжээний номын сан хөмрөгт нийт 6,275,591 ном байгааг 10 мянган хүнд ногдохоор тооцоход 19,290 ном байна.
		32.1.5	10000 хүнд ногдох соёлын төвийн суудлын тоо	350	278			Нийт соёлын төв /ордон/-ийн суудлын тоо 90,368 бөгөөд 10 000 хүн тутамд 278 суудал ногдож байна.